

Нийгмийн даатгалын
ерөнхий газар

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХУУЛЬ, ТОГТООМЖ, ДҮРЭМ, ЖУРАМ, ЗААВАР, АРГАЧЛАЛ, ЗӨВЛӨМЖ

ЦАХИМ ЭМХЭТГЭЛ

Нийгмийн даатгалын байцаагч, ажилтнуудын албан хэрэгцээнд зориулав.

2024 он

ӨМНӨТГӨЛ

Нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн даатгалын хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, даатгуулагч, ажил олгогчдыг нийгмийн даатгалд хамруулах, сангийн орлогыг бүрдүүлэх, зарлагын гүйцэтгэлийг хангах, даатгуулагч иргэдийнхээ нийгмийн даатгалын талаарх хууль, эрхзүйн мэдлэгийг дээшлүүлэх, мэдээллийн технологийн дэмжлэгтэйгээр нийгмийн даатгалын цахим үйлчилгээг хөгжүүлэх, даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хуулиар тогтоосон хугацаанд олгох чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгыг батлан 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж байна.

Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн үзэл баримтлал нь нийгмийн даатгалын харилцааг зөвхөн нийгмийн даатгалын хууль тогтоомжоор зохицуулах, хамрах хүрээг өргөтгөх, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, даатгуулагчийн төрлийг нарийвчлан тодорхойлох, ажил олгогчид шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, шимтгэлийг нөхөн төлөх, нийгмийн даатгалын сангийн менежментийг сайжруулах, мэдээллийн ил тод байдлыг хангах зэрэг асуудлууд юм.

Мөн тэтгэврийн олон давхаргат тогтолцоог нэвтрүүлэх, санхүүжилтийн хуваарилалтын зарчмаас хагас хуримтлалын тогтолцоонд шилжих, даатгуулагч тэтгэврийн нөөц сангийн хуримтлалтай болох, хуримтлалаа эрүүл мэнд, боловсрол, орон сууцны ипотекийн санхүүжилтэд зарцуулах, тэтгэврийн тусгай зохицуулалтын дагуу нэмэлт тэтгэвэр авах, тэтгэврийг жил бүр инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх, тэтгэвэр бодох цалин хөлсөнд итгэлцүүр хэрэглэх, тэтгэмж авах нөхцөлийг сайжруулах, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх зэрэг харилцааг зохицуулсан.

Цахим эмхэтгэлд Нийгмийн даатгалын ерөнхий хууль, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарсан тогтоол, тушаал, шийдвэр, зөвлөмж, чиглэлүүдийг цахимаар (pdf-файлаар) эмхэтгэж, нийгмийн даатгалын ажилтнууд Та бүхэнд хүргэж байна.

Энэхүү цахим эмхэтгэлийг холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт орсон тохиолдол тухай бүрд шинэчлэн хүргүүлэх болно.

Та бүхнийг нийгмийн даатгалын хууль тогтоомжийг нэг мөр ойлголтоор хэрэгжүүлэх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхэд энэхүү цахим эмхэтгэл дэмжлэг болно гэдэгт найдаж байна.

Цахим эмхэтгэлтэй холбоотой санал, хүсэлт байвал Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газарт ирүүлнэ үү.

Цахим эмхэтгэлийг хэрэглэхдээ агуулга хэсэг дэх тушаал, шийдвэрийн холбоос (линк) дээр дарахад тухайн тушаал, шийдвэр рүү очих бөгөөд албан хэрэгцээнд ашиглана.

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗАР

АГУУЛГА

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ

Байнгын хорооны тогтоолоор батлагдсан

1. НДЕХ 35.16 Үндэсний зөвлөлийн дүрэм болон ажил олгогч, даатгуулагчийн төлөөллийн байгууллага нээлттэй сонгон шалгаруулах журам
   УИХ-ын Байнгын хороо батална
2. НДЕХ 35.19 Үндэсний зөвлөлийн гишүүнд олгох урамшууллын дээд хэмжээг тогтоох
   УИХ-ын Байнгын хороо батална

Засгийн газрын тогтоолоор батлагдсан

3. НДЕХ 13.4 Засгийн газрын болон Монголбанкны үнэт цаас худалдан авах хөрөнгийн хэмжээг батлах
   Засгийн газрын 2024 оны 01 сарын 10-ны өдрийн 14 дүгээр тогтоол
4. НДЕХ 13.9 Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах журам
   Засгийн газрын 2024 оны 06 сарын 06-ны өдрийн 254 дүгээр тогтоол
5. НДЕХ 21.30 Нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбогдсон харилцааг зохицуулсан журам
   Засгийн газрын 2023 оны 12 сарын 27-ны өдрийн 470 дугаар тогтоол
6. НДЕХ 21.31 Ноосны, сүүний, арьс ширний, улаан буудайн урамшууллаас нийгмийн даатгалын шимтгэл төлөх харилцааг зохицуулсан журам
   Засгийн газрын 2023 оны 9 сарын 26-ны өдрийн 361 дүгээр тогтоол
7. НДЕХ 23.2 Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцох журам
   Засгийн газрын 2023 оны 11 сарын 29-ны өдрийн 416 дугаар тогтоол
8. НДЕХ 29.8 Тэтгэврийн нөөц санд хөрөнгө төвлөрүүлэх, бүртгэх, хуваарилах, байршуулах, мэдээлэх, хөрөнгө оруулах, өвлүүлэх, хяналт тавих журам
   Засгийн газрын 2024 оны 06 сарын 06-ны өдрийн 256 дугаар тогтоол
9. НДЕХ 37.15 Нийгмийн даатгалын байгууллага, байцаагчийн дүрэм
   Засгийн газрын 2023 оны 12 сарын 27-ны өдрийн 469 дүгээр тогтоол
10. НДЕХ 42.12 Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн дүрэм
    Засгийн газрын 2023 оны 09 сарын 26-ны өдрийн 362 дугаар тогтоол
11. НДЕХ 43.4 Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм, зөвлөлийн бүрэлдэхүүнд олгох цагийн хөлсний хэмжээг батлах
    Засгийн газрын 2023 оны 12 сарын 13-ны өдрийн 448 дугаар тогтоол

Хөдөлмөр, нийгмийн хамгаллын сайдын тушаалаар батлагдсан

12. НДЕХ 8.2 Даатгуулагчийн хөдөлмөр эрхлэлтийн мэдээлэл, шимтгэл төлөх сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээ, шимтгэл төлөх хугацаа, талуудын эрх, үүрэг, хариуцлага, гэрээ байгуулах, гэрээний хугацааг сунгах, цуцлах, дуусгавар болох зэрэг харилцааг зохицуулсан журам болон сайн дураар даатгуулах гэрээний загвар батлах
    ХНХ-ын сайдын 2023 оны 12 сарын 25-ны өдрийн А/200 дугаар тушаал
13. НДЕХ 17.4 Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, хадгалах, ашиглах, мэдээлэлд хяналт тавих, нууцлал, аюулгүй байдлыг хангах журам, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний мэдээллийн санг бүрдүүлэх, боловсруулах, түгээх ашиглах, хянах, хадгалах, хамгаалах журам
    ХНХ-ын сайдын 2024 оны 05 сарын 31-ний өдрийн А/113 дугаар тушаал
14. НДЕХ 22.3 Итгэлцүүрийг хэрэглэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан журам
    ХНХ-ын сайдын 2023 оны 12 сарын 25-ны өдрийн А/202 дугаар тушаал
15. НДЕХ 24.4 Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх харилцааг зохицуулсан журам
    ХНХ-ын сайдын 2023 оны 12 сарын 25-ны өдрийн А/199 дүгээр тушаал
16. НДЕХ 38.8 Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрхийг олгох, баталгаажуулах, түдгэлзүүлэх, цуцлахтай холбогдсон харилцааг зохицуулсан журам, улсын байцаагчийн үнэмлэх, тэмдгийн загвар батлах
    ХНХ-ын сайдын 2023 оны 12 сарын 01-ны өдрийн А/170 дугаар тушаал
17. НДЕХ 40.3 Нийгмийн даатгалын улсын байцаагчид мэргэшлийн зэргийг тогтоох, түдгэлзүүлэх, зэргийн нэмэгдэл олгох журам
    ХНХ-ын сайдын 2023 оны 10 сарын 06-ны өдрийн А/137 дугаар тушаал
18. НДЕХ 42.11 Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн бүрэлдэхүүнд олгох цагийн хөлсний хэмжээ, олгох журам
    ХНХ-ын сайдын 2023 оны 11 сарын 09-ны өдрийн А/154 дүгээр тушаал

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд хамтран баталсан

19. НДЕХ 15.2 Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн анхан шатны маягтын загвар, түүнийг хөтлөх аргачлал
    Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2024 оны 03 сарын 06-ны А/44, А/40 дүгээр тушаал
20. НДЕХ 21.29 Монгол Улсаас хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газрын ажилтны адилтгах албан тушаалын жагсаалт, нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр тэтгэмж тогтооход баримтлах жишиг хөдөлмөрийн хөлсний жишиг хэмжээг батлах
    Гадаад харилцааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2023 оны 10 сарын 02-ны А/69, А/132 дугаар тушаал
21. НДЕХ 37.12 Мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн ажиллах дүрэм
    Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын хамтарсан
22. НДЕХ 43.5 Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохиуулалт хийхэд баримтлах өвчний заавар
    Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2024 оны 06 сарын 27-ны өдрийн А/293, А/133 дугаар тушаал
23. НДЕХ 43.5 Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний жагсаалт батлах
    Хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2023 оны 12 сарын 15-ны А/441, А/192 дугаар тушаал

Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн тогтоолоор баталсан

24. НДЕХ 13.7 Олон нийтийн хяналтын зөвлөлийн дүрэм

25. НДЕХ 18.4 Хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад ажиллаж байгаа Монгол Улсын иргэний төлөх шимтгэлийн хэмжээг тогтоох
    НДҮЗ-ийн 2023 оны 12 сарын 04-ны 09 дүгээр тогтоол
26. НДЕХ 27.7 Нэрийн дансны 2023 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай
    НДҮЗ-ийн 2023 оны 12 сарын 21-ний 15 дугаар тогтоол
27. НДЕХ 27.10 Нэрийн дансыг нээх, бүртгэх, хөтлөх, даатгуулагчийн гарааны үлдэгдлийг тооцох зэрэг харилцааг зохицуулсан журам
    НДҮЗ-ийн 2024 оны 03 сарын 05-ны 01 дүгээр тогтоол
28. НДЕХ 35.19 Үндэсний зөвлөлийн ажлын албаны бүтэц, ажиллах журам, эрсдэлийн удирдлага, актуар тооцоолол хийх, хөрөнгө оруулалт, аудитын орон тооны бус мэргэжлийн хорооны гишүүнд олгох урамшууллын хэмжээг батлах
    Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл батална

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар баталсан

29. НДЕХ 7.4, 18.1 “Даатгуулагчийн төрлийн код нэмж батлах тухай”
    НДЕГ-ын даргын 2024 оны 4 сарын 2-ны өдрийн А/43 дугаар тушаал
30. НДЕХ 12.4 НДЕХ-ийн 12.3 /Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн даатгалын сан тус бүрийн орлогын зарцуулагдаагүй үлдэгдлийг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын холбогдох дансанд сар бүр төвлөрүүлнэ/-т заасныг үндэслэн Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журам.
    НДЕГ-ын даргын 2023 оны 12 сарын 26-ны А/183 дугаар тушаал
31. НДЕХ 15.3 Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэх маягтын загвар, тэдгээрийг хэвлүүлэх, үнэ тогтоох, зарцуулах, тайлагнах журам
    НДЕГ-ын даргын 2024 оны 02 сарын 08-ны А/19 дүгээр тушаал
32. НДЕХ 16.5 Нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан хүлээн авах, хянах, залруулга хийх, баталгаажуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан журам
    НДЕГ-ын даргын 2023 оны 11 сарын 13-ны А/147 дугаар тушаал
33. НДЕХ 20.5 Бүртгэлийн дугаар олгох, хэрэглэх болон хувийн хэрэг нээх, бүртгэх, хөтлөх, шилжүүлэх журам, холбогдох маягтын загвар
    НДЕГ-ын даргын 2023 оны 12 сарын 27-ны А/190 дүгээр тушаал
34. НДЕХ 26.2 “Илүү төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох журам”
    НДЕГ-ын даргын 2024 оны 06 сарын 18-ны А/107 дугаар тушаал
35. НДЕХ 38.9 Нийгмийн даатгалын шимтгэлийн ногдуулалт, төлөлтөд хяналт шалгалт хийх журам
    Батлагдаагүй

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ

36. НДСОТЭТ 5.3 газрын доор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт, хэрэглэх журам
ХНХ-ын сайдын 2023 оны 12 сарын 28-ны өдрийн А/221 дүгээр тушаал
37. НДСОТэТХ 8.3 Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл тогтоох /жил бүр/
НДҮЗ-ийн 2023 оны 12 сарын 21-ны өдрийн 20 дугаар тогтоол
38. НДСОТэТ 21.1 Тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэврийн доод хэмжээг тогтоох
Батлагдаагүй
39. НДСОТЭТ 22.3 Тэтгэвэр тогтоолгох, тэтгэврийн хэмжээг өөрчлөхөд бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэвэр олгохтой холбогдсон бусад харилцааг зохицуулсан журам
“Журам батлах тухай” Засгийн газрын 2023 оны 12 сарын 20-ны өдрийн 450 дугаар тогтоол
40. НДСОТЭТ 20.6 Тэтгэвэр тогтоолгох үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалинг батлах
ХНХ-ын сайдын 2023 оны 10 сарын 05-ны өдрийн А/136 дугаар тушаал
41. НДЕХ 21.29 Монгол Улсаас хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газрын ажилтны адилтгах албан тушаалын жагсаалт, нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр тэтгэмж тогтооход баримтлах жишиг хөдөлмөрийн хөлсний жишиг хэмжээг батлах
Гадаад харилцааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2023 оны 10 сарын 02-ны А/69, А132 дугаар тушаал
42. НДСОТэТХ 20.7 Тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох,
НДЕГ-ын даргын 2023 оны 10 сарын 24-ны А/139 дүгээр тушаал
43. НДСОТэТХ 22.4 Тэтгэвэр тогтоолгох өргөдлийн маягтын загвар, тэтгэвэр тогтоолгох баримт бичгийн бүрдэлд хяналт тавих, тэтгэврийн хувийн хэрэг бүрдүүлэх, бүртгэх журам, тэтгэвэр бодох заавар
Батлагдаагүй
44. НДСОТЭТ 27.2 “Аргачлал батлах тухай” Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх аргачлал
ЗГ-ийн 2024 оны 09 сарын 11-ний өдрийн 75 дугаар тогтоол

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ

45. НДСОТТХ 5.6 Эмнэлгийн хуудасны маягтын загвар, даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох журам
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд , Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2023 оны 12 сарын 07-ны А/177, А/433 дугаар тушаал
46. НДСОТТХ 8.3 Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг тогтоох
НДҮЗ-ийн 2023 оны 12 сарын 04-ны өдрийн 08 дугаар тогтоол
47. НДСОТТХ 13.3 Ажил олгогчид ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх журам, Ажил олгогчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, хяналт тавих журам
НДҮЗ-ийн 2024 оны 09 сарын 06-ны өдрийн 06 дугаар тогтоол
48. НДСОТТХ 15.2 Даатгуулагч тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэмж олгохтой холбогдсон бусад харилцааг зохицуулсан журам
“Журам батлах тухай” Засгийн газрын 2023 оны 12 сарын 13-ны өдрийн 438 дугаар тогтоол
49. НДСОТТХ 15.3 Тэтгэмж тогтоолгох өргөдлийн маягтын загвар, тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн бүрдэлд хяналт тавих, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийг авах эрх бүхий иргэн, албан тушаалтныг тодорхойлох журам, тэтгэмж бодох аргачлал, заавар
НДЕГ-ын даргын 2023 оны 12 сарын 28-ны А/194 дүгээр тушаал

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ТӨЛБӨРИЙН ТУХАЙ

50. НДСОҮОМШӨТТТТХ 3.4 Мэргэжлээс шалтгаалсан өвчний жагсаалт, хувь, хугацааг батлах
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2023 оны 11 сарын 07-ны А/152, А/388 дугаар тушаал
51. НДСОҮОМШӨТТТТХ 11.3 Тэтгэмж, тэтгэвэр, төлбөр, зардал авах өргөдөл гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон төлбөр, зардал тэтгэмж, тэтгэвэр олгохтой холбоотой бусад харилцааг зохицуулсан журам
Засгийн газрын 2023 оны 12 сарын 13-ны өдрийн 439 дүгээр тогтоол
52. НДСОҮОМШӨТТТТХ 13.3 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг сонгох, арга хэмжээний зардлын төлбөрийг санхүүжүүлэх, хяналт тавих журам
НДҮЗ-ийн 2024 оны 09 сарын 06-ны өдрийн 07 дугаар тогтоол

53. НДСОҮОМШӨТТТТХ 14.2 Протез, ортопедийн жишиг үнийг батлах
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд , Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2023 оны 10 сарын 26-ны А/143, А/376 дугаар тушаал
54. НДСОҮОМШӨТТТТХ 14.7 Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох хэмжээг тогтоох
НДҮЗ-ийн 2023 оны 12 сарын 04-ны өдрийн 10 дугаар тогтоол
55. НДСОҮОМШӨТТТТХ 14.10 Даатгуулагч төлбөр авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон төлбөрийг олгох, санхүүжүүлэхтэй холбогдсон бусад харилцааг зохицуулсан журам
Засгийн газрын 2023 оны 11 сарын 29-ны өдрийн 422 дугаар тогтоол
56. НДСОҮОМШӨТТТТХ 14.9 Даатгуулагчид тусламж, үйлчилгээ үзүүлэх, сэргээн засах төв болон сувиллыг сонгох, гэрээ байгуулах, санхүүжүүлэх, тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих журам
НДҮЗ-ийн 2023 оны 12 сарын 04-ны өдрийн 11 дүгээр тогтоол
57. НДСОҮОМШӨТТТТХ 15.4 Үйлдвэрлэлийн ослын улмаас сул зогссон хугацааг тогтоох
Батлагдаагүй
58. НДСОҮОМШӨТТТТХ 16.4 ҮОМШӨ-ний даатгалын мэдээллийн санг бүрдүүлэх, боловсруулах, түгээх, ашиглах, хянах, хадгалах, хамгаалах журам
ХНХ-ын сайдын 2024 оны 05 сарын 31-ний өдрийн А/113 дугаар тушаал
59. НДСОҮОМШӨТТТТХ 18.2 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэл төлөх ажил мэргэжлийн жагсаалт, шимтгэлийн хувь хэмжээ, хэрэглэх журам
“Журам батлах тухай” Засгийн газрын 2023 оны 12 сарын 27-ны өдрийн 471 дүгээр тогтоол

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 01 сарын 10 өдөр Дугаар 14 Улаанбаатар хот

Засгийн газрын болон Монголбанкны үнэт цаас худалдан авах хөрөнгийн хэмжээг батлах тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13.4, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын урт хугацаат (нэг жил болон түүнээс дээш) бонд, Монголбанкны үнэт цаас худалдан авахад 2024 онд зарцуулах хөрөнгийн хэмжээг 300.0 (гурван зуун) тэрбум төгрөгөөр баталсугай.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Сангийн сайд Б.Жавхлан нарт тус тус даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД Х.БУЛГАНТУЯА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 06 сарын 06 өдөр Дугаар 254 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13.9-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах журам"-ыг хавсралт ёсоор батлагдсугай.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгаалллын сайд Х.Булгантуяад, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Л.Мөнхзул)-т тус тус үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД Х.БУЛГАНТУЯА

Засгийн газрын 2024 оны 06 дугаар
сарын 06-ны өдрийн 254 дүгээр
тогтоолын хавсралт

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЧӨЛӨӨТ ҮЛДЭГДЛИЙГ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЭЛД ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл (цаашид "сангийн чөлөөт үлдэгдэл" гэх)-ийг найдвартай, үр өгөөжтэй, хариуцлагатай, ил тод, хараат бус байх зарчмыг баримтлан санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах үйл ажиллагааг зохицуулахад энэ журмыг баримтална.

1.2.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (цаашид "Нийгмийн даатгалын ерөнхий газар" гэх) нь сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулахдаа Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Банкны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон энэ журмыг баримтална.

Хоёр.Сангийн чөлөөт үлдэгдлийн хөрөнгө оруулалтын төрөл, үйл ажиллагаа

2.1.Нийгмийн даатгалын ерөнхий газар сангийн чөлөөт үлдэгдлийг Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13.1-д заасны дагуу дараах санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулна:

2.1.1.Засгийн газрын үнэт цаас худалдан авах;

2.1.2.Монголбанкны үнэт цаасны арилжаанд оролцох;

2.1.3.Төрийн сангийн нэгдсэн дансанд хугацаатай мөнгөн хадгаламж байршуулах;

2.1.4.Банкны тухай хуулийн 3.1.20-д заасан банкны системд нөлөө бүхий арилжааны банк (цаашид "арилжааны банк" гэх)-д хугацаатай мөнгөн хадгаламж байршуулах.

2.2.Нийгмийн даатгалын ерөнхий газар жил бүрийн 1 дүгээр сард Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 4.1.9-д заасны дагуу сангийн чөлөөт үлдэгдлийг тооцон, энэ журмын 2.1-д заасан санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах саналыг хөдөлмөр, нийгмийн хамгаллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2.3.Хөдөлмөр, нийгмийн хамгаллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүрийн 2 дугаар сард багтаан энэ журмын 3.1-д заасан шийдвэрийг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлнэ.

2.4.Нийгмийн даатгалын ерөнхий газар жил бүрийн эхний улиралд багтаан хөдөлмөр, нийгмийн хамгаллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн шийдвэрийн дагуу энэ журмын 2.1-д заасан санхүүгийн

хэрэгсэл тус бүрд хөрөнгө оруулах тооцооллыг дахин хийж, саналаа доор дурдсан мэдээлэл, баримт бичгийн хамт Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын албанд хүргүүлнэ:

2.4.1.энэ журмын 2.1.1, 2.1.2-т заасан үнэт цаас худалдан авах хөрөнгийн хэмжээг тогтоосон Засгийн газрын шийдвэр;

2.4.2.энэ журмын 2.1.3-т заасан мөнгөн хадгаламж байршуулах талаар өгсөн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр;

2.4.3.энэ журмын 2.1.4-т заасан арилжааны банкнуудын талаарх Монголбанкнаас авсан мэдээлэл;

2.4.4.санхүүгийн хэрэгсэл тус бүрд хөрөнгө оруулах сангийн чөлөөт үлдэгдлийн тооцоолол, санал, танилцуулга, тогтоолын төсөл.

2.5.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын алба саналтай танилцан, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 35.17-д заасан Мэргэжлийн хороо (цаашид "Мэргэжлийн хороо" гэх)-нд хүргүүлнэ.

2.6.Мэргэжлийн хороо энэ журмын 2.1-д заасан саналыг хүлээн авч ажлын 10 өдрийн дотор холбогдох тооцооллыг хийж, санал, дүгнэлт гаргаж Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын албанд хүргүүлнэ.

2.7.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл Мэргэжлийн хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэж, сангийн чөлөөт үлдэгдлийг нийгмийн даатгалын төрөл тус бүрийн бие даасан сангуудын эх үүсвэр тус бүрээр энэ журмын 2.1-д заасан санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах шийдвэрийг гаргана.

2.8.Нийгмийн даатгалын ерөнхий газар энэ журмын 2.7-д заасан шийдвэрийг хэрэгжүүлнэ.

2.9.Нийгмийн даатгалын ерөнхий газрын хэрэгжүүлж буй санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13.3-т заасан олон нийтийн хяналтын зөвлөл "Орон тооны бус олон нийтийн хяналтын зөвлөлийн дүрэм"-д заасны дагуу хяналт тавина.

Гурав.Сангийн чөлөөт үлдэгдлийг Засгийн газрын үнэт цаасанд хөрөнгө оруулах

3.1.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн энэ журмын 2.2-т заасан тооцоолол, саналыг үндэслэн, энэ журмын 2.1.1, 2.1.2-т заасан үнэт цаас худалдан авах хөрөнгийн хэмжээг тогтоох саналыг боловсруулж, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

3.2.Нийгмийн даатгалын ерөнхий газар энэ журмын 2.7, 3.1-д заасан шийдвэрийн дагуу Засгийн газрын үнэт цаасыг худалдан авах, худалдах үйл ажиллагаанд оролцоно.

3.3.Нийгмийн даатгалын ерөнхий газар Засгийн газрын үнэт цаасны арилжаанд дараах байдлаар оролцож болно:

3.3.1.нээлттэй хэлбэрээр арилжаалагдах Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаанд оролцох;

3.3.2.хаалттай хэлбэрээр гаргасан Засгийн газрын үнэт цаасыг худалдан авах.

3.4.Нийгмийн даатгалын ерөнхий газар энэ журмын 3.3.1-д заасны дагуу Засгийн газрын үнэт цаас худалдан авахад санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай "Засгийн газрын үнэт цаас худалдах, худалдан авах гэрээ" байгуулах бөгөөд гэрээний дагуу үнэт цаасны арилжааны төлбөр, тооцоог гүйцэтгэнэ.

Дөрөв.Сангийн чөлөөт үлдэгдлийг Монголбанкны үнэт цаасанд хөрөнгө оруулах

4.1.Нийгмийн даатгалын ерөнхий газар "Төв банкны үнэт цаасны арилжааны журам"-д заасны дагуу Монголбанкны үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаанд оролцоно.

Тав.Сангийн чөлөөт үлдэгдлийг Төрийн сангийн нэгдсэн дансанд хадгаламж хэлбэрээр байршуулах

5.1.Нийгмийн даатгалын ерөнхий газар энэ журмын 2.7-д заасныг үндэслэн сангийн чөлөөт үлдэгдлийг Төрийн санд хугацаатай байршуулах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

5.2.Нийгмийн даатгалын ерөнхий газар санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай "Төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулах мөнгөн хадгаламжийн гэрээ"-г байгуулна.

5.3.Энэ журмын 5.2-т заасан Төрийн сангийн хадгаламжийн гэрээнд хадгаламжийн хэмжээ, хугацаа, хүү, эрх, үүрэг зэргийг тусгасан байна. Мөнгөн хадгаламжийн нэг жилийн хүүгийн хэмжээ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13.5-д заасны дагуу гэрээ байгуулах тухайн үеийн Засгийн газрын үнэт цаасны хүүгийн хэмжээтэй тэнцүү байна.

5.4.Сангийн чөлөөт үлдэгдлийг Төрийн санд байршуулах хугацаа нь 12 сараас хэтрэхгүй байна. Гэрээний хугацаа дуусгахаас өмнө талууд гэрээний нөхцөлүүдийг харилцан тохиролцсон тохиолдолд гэрээг анх байгуулсан хугацаанаас хэтрүүлэхгүй нэг удаа сунгаж болно.

5.5."Төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулах мөнгөн хадгаламжийн гэрээ"-нд хадгаламжийн нөхцөлөөс өөр бусад нэмэлт нөхцөл тусгахыг хориглоно.

5.6."Төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулах мөнгөн хадгаламжийн гэрээ" дуусгавар болсон тухай бүр гэрээг дүгнэн, хоёр тал баталгаажуулна.

5.7.Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Төрийн сангийн нэгдсэн дансанд байршиж байгаа нийгмийн даатгалын сангийн харилцах дансны үлдэгдэлд сар бүр хүү тооцож олгоно. Хүүгийн хэмжээ нь Монголбанкнаас Төрийн сангийн нэгдсэн дансны үлдэгдэлд тооцож олгодог хүүгийн хэмжээтэй тэнцүү байна.

Зургаа.Сангийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банканд хадгаламж хэлбэрээр байршуулах

6.1.Нийгмийн даатгалын ерөнхий газар сангийн чөлөөт үлдэгдлийг энэ журмын 2.1.4-т заасны дагуу арилжааны банканд байршуулах ажлыг зохион байгуулна.

6.2.Нийгмийн даатгалын ерөнхий газар энэ журмын 2.7-д заасан шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногийн дотор энэ журмын 2.1.4-т заасан арилжааны банкнуудад сангийн чөлөөт үлдэгдлийг хугацаатай хадгаламж хэлбэрээр байршуулах саналыг хүргүүлнэ.

6.3.Арилжааны банк байршуулах хадгаламжийн дүн, хүү, хугацааны саналыг дараах баримт бичгийн хамт Нийгмийн даатгалын ерөнхий газарт тогтоосон хугацаанд ирүүлнэ:

6.3.1."Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам"-д заасны дагуу Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтүүдийг хангасан тухай сүүлийн нэг жилийн хугацааны тайлан;

6.3.2.өмнөх оны жилийн эцсийн аудитлагдсан болон өмнөх сарын санхүүгийн байдлын дэлгэрэнгүй тайлан, орлого үр дүнгийн тайлан;

6.3.3.хадгаламжийн дүн, байршуулах хугацаа, хүүгийн хэмжээний саналыг тусгасан албан бичиг.

6.4.Дараах шаардлагыг хангасан арилжааны банканд мөнгөн хадгаламжийг байршуулна. Үүнд:

6.4.1.сүүлийн нэг жилийн санхүүгийн тайлангаар Монголбанкнаас тогтоосон "Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам"-д заасан шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байх;

6.4.2.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоосон мөнгөн хадгаламжийн хүүгийн хэмжээнээс багагүй хүүг санал болгосон байх;

6.4.3.Монголбанкнаас "банкны системд нөлөө бүхий банк" гэдгийг тогтоосон шийдвэр байх.

6.5.Нийгмийн даатгалын ерөнхий газар нь энэ журмын 6.3-т заасан арилжааны банкнуудаас ирүүлсэн хадгаламж байршуулах саналыг судлан, холбогдох тооцооллыг хийн банк тус бүрээр хадгаламж байршуулах шийдвэр гаргана.

6.6.Нэг арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламжийн хэмжээ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13.6-д заасан хэмжээнээс ихгүй байна. Арилжааны банкны өөрийн хөрөнгийн хэмжээг "Мөнгөн хадгаламжийн гэрээ" байгуулах үеийн тухайн арилжааны банкны өмнөх сарын баталгаажсан тайланг үндэслэн тодорхойлно.

6.7.Мөнгөн хадгаламжийн хүүгийн доод хэмжээг Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13.8-д заасан аргачлалын дагуу тооцон Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална.

6.8.Нийгмийн даатгалын ерөнхий газар "Мөнгөн хадгаламжийн гэрээ"-г харилцан тохиролцож арилжааны банктай байгуулах бөгөөд уг гэрээнд байршуулах хадгаламжийн хэмжээ, хугацаа, хүүгийн хувь, эрсдэлээс хамгаалах арга хэрэгслийг тусгаж, мөрдөнө.

6.9.Арилжааны банканд сангийн чөлөөт үлдэгдэл байршуулах хугацаа нь 12 сараас хэтрэхгүй байна. Гэрээний хугацаа дуусгахаас өмнө талууд гэрээний нөхцөлүүдийг харилцан тохиролцсон тохиолдолд гэрээг анх байгуулсан хугацаанаас хэтрүүлэхгүй нэг удаа сунгаж болно.

6.10.Арилжааны банктай байгуулах "Мөнгөн хадгаламжийн гэрээ" дуусгавар болсон тухай бүр гэрээг дүгнэн, хоёр тал баталгаажуулна.

6.11.Мөнгөн хадгаламжийн гэрээнд хадгаламжийн нөхцөлөөс өөр санхүүгийн гэрээ, орон сууцны баталгаа гэх зэрэг бусад нэмэлт нөхцөл тусгахыг хориглоно.

Долоо.Хөрөнгө оруулалтын бүртгэл, тайлан, ил тод байдал

7.1.Нийгмийн даатгалын ерөнхий газар сангийн чөлөөт үлдэгдлийг хөрөнгө оруулалтад оруулсан хөрөнгийн хэмжээ, эргэн төлөлт, хүүгийн орлогын тооцооны бүртгэлийг хөтөлж, улирал бүр талуудтай тооцоо нийлж баталгаажуулна.

7.2.Сангийн чөлөөт үлдэгдэл, хөрөнгө оруулалтад оруулсан хөрөнгө, хүүгийн орлогыг нийгмийн даатгалын сан тус бүрээр бүртгэнэ.

7.3.Нийгмийн даатгалын ерөнхий газар сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж, төвлөрсөн орлогыг нягтлан бодох бүртгэлийн стандарт, холбогдох журмын дагуу бүртгэж, сар, улирал бүр нэгтгэн нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайланд тайлагнана.

7.4.Сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулсан талаарх мэдээллийг улирал бүр shilen.gov.mn цахим хуудсаар олон нийтэд ил тод мэдээлнэ.

Найм.Хөрөнгө оруулалтын эрсдэлийн удирдлага, хяналт

8.1.Нийгмийн даатгалын ерөнхий газар сангийн чөлөөт үлдэгдэл байршуулсан энэ журмын 2.1.4-т заасан банкны үйл ажиллагаанд шаардлагатай тохиолдолд хяналт тавих эрхтэй байна.

8.2.Хадгаламж байршуулахтай холбогдон гарч болох эрсдэлийн удирдлагыг Нийгмийн даатгалын ерөнхий газар, арилжааны банкны хооронд байгуулах гэрээгээр зохицуулна.

8.3.Арилжааны банк мөнгөн хадгаламжийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд тухайн банкны Монголбанк дахь харилцах данснаас байршуулсан мөнгөн хөрөнгийг үл маргах журмаар суутган авах эрхийг Нийгмийн даатгалын ерөнхий газарт олгох бөгөөд уг асуудлыг "Мөнгөн хадгаламжийн гэрээ"-нд тусгана.

8.4.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх Мэргэжлийн хороо нь сангийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банканд байршуулах, санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулахад шаардлагатай судалгаа, тооцоолол хийж, эрсдэлийг үнэлж, дүгнэлт гаргана.

8.5.Олон нийтийн хяналтын зөвлөл сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах үйл ажиллагаа болон энэ журмын биелэлтэд хяналт тавьж, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд танилцуулна.

Ес.Бусад

9.1.Энэ журмын 2.7-д заасан шийдвэрийн дагуу санхүүгийн хэрэгслийн аль нэгэнд нь хөрөнгө оруулах боломжгүй болсон тохиолдолд Нийгмийн даатгалын ерөнхий газар нь бусад санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах саналыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд танилцуулан шийдвэрлүүлнэ.

9.2.Нийгмийн даатгалын ерөнхий газар нь сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд оруулсан талаарх мэдээллийг хагас жил тутам Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд танилцуулна.

Арав.Хариуцлага

10.1.Энэ журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

----o0o----

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 27 өдөр Дугаар 470 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21.30-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Нийгмийн даатгалын шимтгэл төлөх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ тогтоолд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Л.Мөнхзул)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД Х.БУЛГАНТУЯА

Засгийн газрын 2023 оны 12 дугаар
сарын 27 -ны өдрийн 470 дугаар
тогтоолын хавсралт

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын "Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээр"-ийн дагуу хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч шимтгэл төлөх, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21.26, 21.27-д заасны дагуу цэргийн байгууллагад алба хаасан жилийг энгийн жилд шилжүүлж шимтгэл төлөх, дипломат төлөөлөгчийн газарт ажиллагчдын цаг уурын хүнд нөхцөл бүхий улсад ажилласан жилийн нэмэгдэл хугацааны нийгмийн даатгалын шимтгэл төлөх, Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооноос батлан мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур цалин, хөлс орлогоос нийгмийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагчийн шимтгэл төлсөн хугацааг шилжүүлэн тооцоход энэ журмыг баримтална.

Хоёр.Шимтгэлийг төлөх, бүртгэх, шилжүүлэх

2.1.Нийгмийн даатгалын байгууллага Бүгд Найрамдах Солонгос Улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа Монгол Улсын иргэдийг тэтгэврийн даатгалд хамруулж шимтгэлийг төлүүлэн, нийгмийн даатгалын мэдээллийн санд даатгуулагч бүрээр бүртгэнэ.

2.2.Хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч нь нийгмийн даатгалын санд "Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл"-өөс баталсан шимтгэлийн хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын санд өөрөө хариуцан төлнө.

2.3.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21.26, 21.27-д заасан хугацааны шимтгэлийг холбогдох аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газрын зохих сангийн дансанд шилжүүлэх бөгөөд тухайн аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газар (байцаагч) нь шимтгэл төлөлтийг нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд даатгуулагч бүрээр бүртгэнэ.

2.4.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21.26, 21.27-д заасан хугацааны шимтгэлийг тооцох, шилжүүлэх чиг үүргийг нийгмийн даатгалын байгууллага дараах байдлаар хэрэгжүүлнэ:

2.4.1.аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газар дипломат төлөөлөгчийн газарт ажиллагчдын цаг уурын хүнд нөхцөл бүхий улсад ажилласан жилийн нэмэгдэл хугацаа, цэргийн байгууллагад алба хаасан жилийг энгийн жилд шилжүүлэн тооцсон тооцоолол, ажилласан хугацааны цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын тодорхойлолт, лавлагааны хамт цахим, эсхүл цаасан хэлбэрээр нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ;

2.4.2.нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь холбогдох баримтыг хянаж, тооцооллыг нэгтгэн нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад нэхэмжлэл хүргүүлнэ;

2.4.3.нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь нэхэмжлэлийг хянаж, нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын холбогдох дансанд шимтгэлийн мөнгийг тухай бүр шилжүүлнэ;

2.4.4.нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шилжүүлсэн шимтгэлийн мөнгийг аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газрын холбогдох сангийн харилцах дансанд шилжүүлнэ.

Гурав.Шимтгэл төлсөн хугацааг сард шилжүүлэн тооцох

3.1.Ажил олгогч цагаар ажилласан, тухайн сарын нийт өдөр бүтэн ажиллаагүй ажилтанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур дүнгээр тооцож олгосон цалин хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэл төлсөн бол шимтгэл төлсөн хугацааг дор дурдсанаар тооцно:

3.1.1.даатгуулагчийн тухайн сарын орлогыг Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооноос баталсан цагийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд хуваж тухайн сард ажилласан нийт цагийг тодорхойлно;

3.1.2.даатгуулагчийн тухайн сард ажилласан нийт цагийг 8 цаг (ердийн ажлын өдөрт ажиллах хугацаа)-т хуваж, тухайн сард ажилласан ажлын өдрийг тодорхойлно;

3.1.3.хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур цалин, хөлс авсан сар бүрийн ажилласан ажлын өдрийг энэ журмын 3.1.1, 3.1.2-т заасны дагуу тодорхойлж, гарсан хугацааг нэмж, тухайн даатгуулагчийн шимтгэл төлсөн нийт хугацааг сар, өдрөөр тодорхойлно.

Дөрөв.Бусад

4.1.Энэ журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

2023 оны 09 сарын 26 өдөр Дугаар 361 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн 5.1-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Төрөөс олгох урамшууллаас иргэний эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа нарт тус тус даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД Х.БУЛГАНТУЯА

Засгийн газрын 2023 оны 09 дүгээ
сарын 26 -ны өдрийн 361 дүгээр
тогтоолын хавсралт

ТӨРӨӨС ОЛГОХ УРАМШУУЛЛААС ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ СУУТГАН ТӨЛӨХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Төрөөс олгох ноосны, сүүний, арьс, ширний, улаан буудайн, хүнсний ногооны урамшуулал (цаашид "төрөөс олгох урамшуулал" гэх) авах эрх үүссэн иргэн (цаашид "иргэн" гэх)-ий төлбөл зохих эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл (цаашид "шимтгэл" гэх)-ийг тухайн төрөөс олгох урамшууллаас нь суутган төлөхтэй холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Иргэний төлбөл зохих шимтгэлийг төрөөс олгох урамшууллаас нь суутган төлөхөд Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хууль, Хонь, тэмээний ноос бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам, Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгох журам, Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам, Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгох, мөнгөн бус дэмжлэг үзүүлэх журам, Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулахад баримтлах журмыг тус тус баримтална.

1.3.Энэ журмын 1.1-д заасан "эрх үүссэн иргэн" гэдэгт Засгийн газрын 2019 оны 343 дугаар тогтоолоор батлсан "Хонь, тэмээний ноос бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам", Засгийн газрын 2020 оны 130 дугаар тогтоолоор батлсан "Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгох журам", Засгийн газрын 2013 оны 394 дүгээр тогтоолоор батлсан "Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам", Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Сангийн сайдын 2022 оны А/218/А/146 дугаар хамтарсан тушаалаар батлсан "Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгох мөнгөн бус дэмжлэг үзүүлэх журам"-ын дагуу төрөөс олгох ноосны, сүүний, арьс, ширний, улаан буудайн, хүнсний ногооны урамшуулал авах эрх үүсэн иргэн хамаарна.

Хоёр.Шимтгэлээ төрөөс олгох урамшууллаас суутган тооцуулах иргэнд тавигдах шаардлага, иргэн хүсэлт гаргах

2.1.Шимтгэлээ төрөөс олгох урамшууллаас суутган тооцуулах иргэн Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн 4.1-д заасны дагуу дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1, 2, 3, 7 дахь хэсэг, Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан тэтгэвэр тогтоолгоогүй байх;

2.1.2.нийгмийн даатгалд албан журмаар даатгуулаагүй байх.

2.2.Шимтгэлээ төрөөс олгох урамшууллаас суутган тооцуулах иргэн нийгмийн даатгалд сайн дураар даатгуулж, харьяа аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)-тай гэрээ байгуулсан байна.

2.3.Журмын 2.2-т заасан гэрээг аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд байршуулна.

2.4.Иргэн шимтгэлээ төрөөс олгох урамшууллаас суутган тооцуулах хүсэлтээ хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахимаар гаргана.

2.5.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь урамшууллын цахим системд хүсэлт гаргаж байгаа иргэнээс нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх хүсэлтийг цахимаар хүлээн авч, энэ журмын 2.3-т заасан мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэлд үндэслэн шалгана.

Гурав.Төрөөс олгох урамшууллаас шимтгэлийг суутгах

3.1.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 2.2-т заасан хүсэлт гаргасан иргэний жагсаалтыг гаргаж, эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тухай бүр цахимаар тус тус хүргүүлнэ.

3.2.Эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ журмын 3.1-д заасан жагсаалтыг үндэслэн эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл шилжүүлэхэд шаардагдах мөнгөн дүн бүхий мэдээлэл (банкны нэр, код, дансны дугаар, регистрийн дугаар)-ийг хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахимаар тухай бүр хүргүүлнэ.

3.3.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 3.2-т заасан мэдээллийн дагуу төрөөс олгох урамшууллаас шимтгэлийг суутган тооцож, эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагын холбогдох сангийн харилцах дансанд тухай бүр шилжүүлнэ.

3.4.Төрөөс олгох урамшууллаас дараах байдлаар иргэний төлөх шимтгэлийг суутган төлнө:

3.4.1.энэ журмын 2.4-т заасан хүсэлт гаргасан иргэний эрүүл мэндийн даатгалын шимтгэл;

3.4.2.нийгмийн даатгалын байгууллагатай байгуулсан гэрээний хугацаан, ногдох нийгмийн даатгалын шимтгэлийн төлөгдөөгүй нийт шимтгэлийг тус тус суутган.

3.5.Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 4.2-т "Монгол Улсын иргэн эрүүл мэндийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлээ хуваалцах зорилгоор эрүүл мэндийн албан журмын даатгалд заавал даатгуулна" гэж заасны дагуу төрөөс олгох урамшууллаас тэргүүн ээлжид иргэний эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг суутгана.

3.6.Төрөөс олгох урамшууллаас шимтгэлээ суутган тооцуулах хүсэлтээ гаргасан даатгуулагч шимтгэлээ илүү төлсөн бол дараагийн сар, улирал, жилийн төлбөл зохих шимтгэлд шилжүүлэн тооцуулах, эсхүл илүү төлсөн шимтгэлийг буцаан олгох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Дөрөв.Эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг бүртгэх, тооцоо нийлэх, тайлагнах

4.1.Эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл төлсөн иргэний шимтгэл төлөлтийг мэдээллийн санд даатгуулагч тус бүрээр бүртгэнэ.

4.2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь шилжүүлсэн шимтгэлийн дүн, хүлээн авсан дүнг хагас жил тутам тооцоо нийлж, баталгаажуулна.

4.3.Эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл төлсөн иргэний тайланг хагас жил тутам гаргаж, харьяалах төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Тав.Хяналт, хариуцлага

5.1.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь урамшуулалд хамрагдах, эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь шимтгэл суутган тооцох даатгуулагчийг тодорхойлох, бүртгэх, шимтгэл суутган тооцох үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

5.2.Энэ журмыг зөрчсөн иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Зургаа.Бусад

6.1.Нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эрүүл мэндийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн

захиргааны төв байгууллага нь энэ журмын хэрэгжилтийг зохион байгуулах зорилгоор холбогдох мэдээллийг харилцан солилцож болно.

6.2.Төрөөс олгох урамшууллаас шимтгэл суутган төлөхтэй холбоотой үүссэн асуудал, иргэнээс гаргасан гомдлыг холбогдох байгууллага хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 11 сарын 29 өдөр Дугаар 416 Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 23.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцох журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Л.Мөнхзул)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 60 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД Х.БУЛГАНТУЯА

Засгийн газрын 2023 оны 11 дүгээр
сарын 29-ний өдрийн 416 дугаар
тогтоолын хавсралт

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛСНӨӨР ТООЦОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Даатгуулагчийн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 23 дугаар зүйлд заасан хугацааг нийгмийн даатгалын шимтгэл (цаашид “шимтгэл” гэх) төлсөн хугацаанд оруулан тооцоход энэ журмыг баримтална.

1.2.Даатгуулагчийн шимтгэл төлснөөр тооцох хугацааг энэ журмын 2 дахь хэсэгт дурдсан баримт бичигт үндэслэн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаанд оруулан тооцно.

Хоёр.Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцох хугацааг тодорхойлох

2.1.Ажилтны 1991 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хөдөлмөрийн гэрээгээр ажилласан хугацааг тодорхойлохдоо хөдөлмөрийн дэвтрийг, эсхүл ажилд орсон, ажлаас чөлөөлсөн тухай шийдвэрийн архивын лавлагааг, архивын баримтаар нотлогдохгүй тохиолдолд ажилласан жилийг сэргээн тогтоосон шүүхийн шийдвэрийг үндэслэнэ.

2.2.Ажилтны төр, хувийн өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага, хөдөө аж ахуйн нэгдэл, хоршоолол, шашны байгууллагад 1991 оны 07 дугаар сарын 01-ээс 1995 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл ажиллаж, цалин хөлсний сангаас нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлохдоо энэ журмын 2.1-д заасан баримт бичиг болон байгууллага нь цалингийн сангаас 13.5 хувиар тэтгэврийн санд шимтгэл төлсөн тухай аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газрын архивын лавлагааг тус тус үндэслэнэ.

2.3.Иргэний 1995 оноос өмнө цэргийн жинхэнэ болон хугацаат цэргийн алба хаасан хугацааг тодорхойлохдоо цэргийн жинхэнэ алба хаасан хугацааг цэргийн байгууллагын архивын лавлагаа, хугацаат цэргийн алба хаасан хугацааг цэргийн батлах (үнэмлэх), эсхүл цэргийн байгууллагын архивын лавлагаа, алба хаасан хугацааг тогтоосон шүүхийн шийдвэрийг үндэслэнэ.

2.4.Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 10-аас доошгүй жил төлсөн, төрүүлсэн болон гурав хүртэл настайд нь үрчлэн авсан хүүхдээ зургаан нас хүртэл өсгөсөн эхийн төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэд бүрийн тоогоор нэг жил зургаан сараар тооцсон хугацааг хүүхдийн төрсний гэрчилгээ, эсхүл шүүхийн шийдвэр, эрх бүхий байгууллагын лавлагааг үндэслэн тодорхойлно.

2.5.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгох даатгуулагчийн цэргийн жинхэнэ алба хаасан нэг жилийг тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн нэг жил зургаан сараар тооцсон хугацааг цэргийн батлах (үнэмлэх), эсхүл цэргийн байгууллагын архивын лавлагаа, алба хаасан хугацааг тогтоосон шүүхийн шийдвэрийг үндэслэнэ.

2.6.1995 оноос өмнө ажилласан хугацааг холбогдох хуулийн дагуу нөхөн тооцож баталгаажуулсан хугацааг нийгмийн даатгалын байгууллагаас олгосон “Баталгаажилтын хуудас”, эсхүл лавлагааг үндэслэн тодорхойлно.

2.7.Даатгуулагчийн Дипломат албаны тухай хуулийн дагуу цаг уурын хүнд нөхцөл бүхий улсад ажилласан нэг жилийг нэг жил зургаан сараар тооцсон хугацааг тодорхойлохдоо гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас дипломат албан тушаалд томилсон тушаал, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолтыг үндэслэнэ.

Гурав.Бусад

3.1.Энэхүү журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

----o0o----

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 06 сарын 06 өдөр Дугаар 256 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29.8-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Тэтгэврийн нөөц санд хөрөнгө төвлөрүүлэх, бүртгэх, хуваарилах, байршуулах, мэдээлэх, хөрөнгө оруулах, өвлүүлэх, хяналт тавих журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяад, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Л.Мөнхзул)-т тус тус үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД Х.БУЛГАНТУЯА

Засгийн газрын 2024 оны 06 дугаар
сарын 06-ны өдрийн 256 дугаар
тогтоолын хавсралт

ТЭТГЭВРИЙН НӨӨЦ САНД ХӨРӨНГӨ ТӨВЛӨРҮҮЛЭХ, БҮРТГЭХ, ХУВААРИЛАХ, БАЙРШУУЛАХ, МЭДЭЭЛЭХ, ХӨРӨНГӨ ОРУУЛАХ, ӨВЛҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Тэтгэврийн нөөц санд хөрөнгө төвлөрүүлэх, бүртгэх, хуваарилах, байршуулах, мэдээлэх, хөрөнгө оруулах, өвлүүлэх, хяналт тавихад энэ журмыг баримтална.

Хоёр.Тэтгэврийн нөөц санд хөрөнгө төвлөрүүлэх

2.1.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (цаашид "Нийгмийн даатгалын ерөнхий газар" гэх) нь энэ журмын дагуу Төрийн сан болон Банкны тухай хуулийн 3.1.20-д заасан арилжааны банканд тэтгэврийн нөөц сангийн хөрөнгө төвлөрүүлэх данстай байна.

2.2.Энэ журмын 2.1-д заасан тэтгэврийн нөөц сангийн дансанд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29.3-т заасан орлогыг төвлөрүүлнэ.

2.3.Энэ журмын 2.2-т заасан орлогыг дараах байдлаар тэтгэврийн нөөц сангийн дансанд шилжүүлнэ:

2.3.1.Нийгмийн даатгалын ерөнхий газар Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29.3.1-д заасан тухайн сарын шимтгэлийн орлогыг дараа сарын 15-ны өдрийн дотор;

2.3.2.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (цаашид "Сангийн яам" гэх) нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29.3.2-т заасан орлогыг тэтгэврийн нөөц санд хуваарилах Засгийн газрын шийдвэр гарснаас хойш ажлын 14 өдрийн дотор.

2.4.Ажил олгогч, даатгуулагч энэ журмын 2.3.1-д заасан шимтгэлийн орлогыг төлсөн эсэхээс хамаарч дараах байдлаар шимтгэлийн орлогыг тэтгэврийн нөөц санд төвлөрүүлнэ:

2.4.1.ажил олгогч, даатгуулагч тэтгэврийн даатгалын шимтгэлээ тухайн сард багтаан бүрэн төлсөн буюу шимтгэлийн өргүй бол тэтгэврийн нөөц санд бүрэн төвлөрүүлнэ;

4.17.Энэ дүрмийн 4.16-д заасны дагуу татгалзах эрхээ хэрэгжүүлээгүйгээс гаргасан зөвлөлийн шийдвэрийг хүчингүйд тооцож, дахин зөвлөлийн хуралдаан товлоно.

4.18.Төв зөвлөл гомдол гаргагчийн гомдол, хүсэлт нь хууль зүйн үндэслэлтэй гэж үзвэл салбар зөвлөлийн шийдвэрийг өөрчлөх, хэвээр үлдээх, эсхүл хүчингүй болгох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

4.19.Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь зөвлөлийн тухайн жилийн үйл ажиллагааны тайлан, зөвлөлийн шийдвэр, хурлын тэмдэглэл, гомдол гаргагчийн ирүүлсэн гомдол, хүсэлт, холбогдох баримт бичиг, хуралд оролцсон цагаар хөлс олгосон санхүүгийн баримт бичгийг нэгтгэн архивын нэгж үүсгэн тухайн нийгмийн даатгалын байгууллагын архивд жил бүр хүлээлгэн өгнө.

Тав.Мэдээллийн сан

5.1.Төв болон салбар зөвлөл нь үйл ажиллагаандаа ашиглах Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн мэдээллийн нэгдсэн сан (цаашид “мэдээллийн сан” гэх)-тай байна.

5.2.Мэдээллийн сан нь төв болон салбар зөвлөлийн үйл ажиллагааг цахимаар зохион байгуулах, ил тод болгох, үйл ажиллагаанд хяналт тавих, судалгаа, шинжилгээ, үнэлгээ хийх, тайлан, мэдээ гаргах, хяналт шалгалт хийх боломжийг бүрдүүлсэн байна.

5.3.Мэдээллийн санд төв болон салбар зөвлөлөөс гаргасан бүх шийдвэрийг бүртгэж, хөтөлнө.

5.4.Мэдээллийн санд гомдол гаргагчийн доор дурдсан мэдээллийг тусгана:

5.4.1.ажил олгогчийн нэр, регистрийн дугаар, нийгмийн даатгалын дугаар, хаяг, цахим шуудангийн хаяг, холбоо барих утасны дугаар, шаардлагатай үед холбоо барих хүний холбогдох мэдээлэл;

5.4.2.даатгуулагчийн овог, нэр, хаяг, харьяалал, холбоо барих утасны дугаар, цахим шуудангийн хаяг, шаардлагатай үед холбоо барих хүний утасны дугаар;

5.4.3.төв болон салбар зөвлөлд хандан гаргасан гомдол, хүсэлттэй холбоотой баримт бичиг болон бусад нотлох баримт бичиг.

5.5.Гомдол гаргагч өөрт хамаарал бүхий мэдээллийг зөвлөлийн мэдээллийн сангаас авч болно.

5.6.Төв болон салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга нь тухайн зөвлөлийн шийдвэрийг тухай бүр мэдээллийн санд оруулж, үнэн зөв байдлыг хариуцах бөгөөд бусад шаардлагатай мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авч оруулж болно.

5.7.Төв болон салбар зөвлөл нь энэ дүрмийн 5.4, 5.6-д заасан мэдээллийн нууцлалыг хадгалах, хамгаалах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч ажиллана.

Зургаа.Тайлагнах

6.1.Салбар зөвлөл үйл ажиллагаагаа төв зөвлөлд хагас, бүтэн жилээр, төв зөвлөл үйл ажиллагаагаа нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаар дамжуулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд жил бүрийн эхний улиралд багтаан тус тус тайлагнана.

Долоо.Хариуцлага

7.1.Төв болон салбар зөвлөлийн гишүүн хуралд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 3-аас дээш удаа оролцоогүй, ажил, албан тушаал өөрчлөгдсөн, чөлөөлөгдөх талаар хүсэлтээ өгсөн, ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдсон бол энэ дүрмийн 2.8-д заасны дагуу гишүүнээс чөлөөлнө.

7.2.Төв болон салбар зөвлөлийн дарга, гишүүн, нарийн бичгийн дарга энэ дүрмийг зөрчсөн, ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2024.02.21 № 01/351
танай _____-ны № _____-т

АЙМАГ, ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН МАГАДЛАЛЫН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА НАРТ

Тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “Дүрэм батлах тухай” 448 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм”-ийг хүргүүлж байна.

Уг дүрмийг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас хийсэн процессын дахин инженерчлэлийн санал, дүгнэлтийн дагуу даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгааныг тогтоох, сунгах, цуцлах, ажлын цаг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөх асуудлыг Эмнэлэг хяналтын комиссын хурлаар хэлэлцүүлэхгүй, Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хуралд биечлэн ирүүлэхгүйгээр цахимаар болон эрүүл мэндийн баримт бичигт үндэслэн магадлах зэрэг саналуудыг тусгаж боловсруулав.

Түүнчлэн төв болон салбар, аймаг, дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүн, тэдгээрийн томилгоонд өөрчлөлт оруулж, даатгуулагч, хүнд эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааг чирэгдэлгүй хүргэх, гомдол маргааныг шуурхай шийдвэрлэх, хяналтыг сайжруулах, үйл ажиллагааг цахимжуулах үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх зэрэг заалтыг шинээр нэмж тусгав.

Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс нийт аймаг, дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дарга, гишүүдэд тус дүрмийг танилцуулах уулзалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан болно.

Иймд шинэчлэн баталсан “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм”-ийг хэрэгжүүлэн ажиллахад анхаарах дараах чиглэлийг хүргүүлж байна. Үүнд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд орсон өөрчлөлтийн талаар:

1.1 Хуулийн 37 дугаар зүйлийн 37.2.2-т “18 ба түүнээс дээш насны хүний хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг эрүүл мэндийн магадлалын зөвлөл тогтооно” гэж 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх;

2. Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүний талаар:

2.1. “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм”-ийн 2 дахь, хэсгийн 2.4-2.12-т заасныг тус тус үндэслэн холбогдох газруудаас /Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооноос бусад/ санал авах ажлыг шуурхай зохион байгуулах;

2.2 Аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнд ажиллах төрөлжсөн мэргэшлийн эмч нарыг тус дүрмийн 2 дахь хэсгийн 2.15 дахь заалтад

заасан ерөнхий шаардлагыг хангасан эсэхийг харгалзан аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газартай зөвшилцөн санал авах;

2.3 Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнд шинээр томилогдох гишүүдийн саналыг нэгтгэн холбогдох баримт бичгийн хамт 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн дотор Нийгмийн даатгалын ерөнхий газарт ирүүлэх;

2.4 Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томилох хүртэл хугацаанд одоогийн бүрэлдэхүүнээр хуралдаж ажиллах;

3. Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааны талаар:

3.1 Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгааныг тогтоох, сунгах, цуцлах, ажлын цаг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөх асуудлыг шийдвэрлэхдээ Эрүүл мэндийн байгууллагын дэргэдэх Эмнэлэг хяналтын комиссын хурлаар хэлэлцүүлэхгүй байх;

3.2 Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагаа нь хурал хэлбэртэй байх ба даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг даатгуулагч, хүнийг байлцуулахгүйгээр холбогдох баримт, бичигт үндэслэж болон цахим хэлбэрээр шийдвэрлэх; /Нүүдлийн хурал зохион байгуулахгүй/

Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг дээрх 2 хэлбэрээр шийдвэрлэх боломжгүй болон даатгуулагч, хүн өөрөө хүссэн тохиолдолд биеэр байлцуулан магадлах;

3.3 Төрөлжсөн мэргэшлийн болон хяналтын эмч нь даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох, сунгах, цуцлах, ажлын цаг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл солих талаар мэдээллийг магадлалын зөвлөл хуралдахаас 1-5 хоногийн өмнө салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөлд цахимаар хүргүүлэх;

3.4 Даатгуулагч, хүн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоолгох, сунгуулах, цуцлуулах, ажлын цагийг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл солих асуудлыг шийдвэрлүүлэхдээ төрөлжсөн мэргэшлийн эмч болон хяналтын эмчид хүсэлтээ гаргах ба төрөлжсөн мэргэшлийн эмч болон хяналтын эмч холбогдох баримт бичиг, оношийг баталгаажуулах шинжилгээ, оношилгоог бүрдүүлж, үечилсэн дүгнэлт, саналыг Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хуралд танилцуулах;

3.5 Даатгуулагч, хүн нь ердийн өвчин болон ахуйн осол, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд ажлын 66-132 өдрөөс хэтрэхгүй хугацаатай эмчийн хяналтад эмчлүүлэх бөгөөд эмчилгээний үр дүн, өвчний явц, үе шат, хүндрэлийн талаарх баталгаажсан оношилгоо, шинжилгээний үр дүнд үндэслэн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгааныг тогтоолгох эсэх асуудлыг шийдвэрлүүлэх;

3.6 Даатгуулагч, хүний эрхтэн, бие махбодийн тогтоц, үйл ажиллагаа нь эргэшгүй өөрчлөлтөд орж, хүндээр гэмтсэний улмаас өөрөө өөртөө үйлчлэх чадваргүй, бусдын асаргаа сувилгаа шаардлагатай болсон, байнгын хэвтэрт байгаа тохиолдол болон хорт хавдар өвчний III, IV үед энэ дүрмийн 4.2-д заасан хугацааг болон эмчийн хяналтад орсон, эмчлүүлсэн эсэхийг нь үл харгалзан хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгааныг тогтоох;

3.7 Салбар, аймаг, дүүрэг, сумын магадлалын зөвлөл даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгааныг тогтоох, сунгах, цуцлах,

ажлын цагийг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөхдөө оношилгоо, шинжилгээ, төрөлжсөн мэргэшлийн болон хяналтын эмчийн дүгнэлт, саналыг үндэслэх ба үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн тохиолдолд, хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчийн баталгаажуулсан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэсэн акт, саналыг тус тус үндэслэх;

3.8 Шүүхээр ял эдэлж буй ялтанд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгааныг тогтоох, сунгах, цуцлах асуудлыг зөвхөн хорихын нэгдсэн эмнэлгийн төрөлжсөн мэргэшлийн эмчийн дүгнэлт, саналыг үндэслэн хорих байгууллагын харьяалах аймаг, дүүргийн магадлалын зөвлөл, эсхүл салбар зөвлөл шийдвэрлэх;

3.9 Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгааныг шинээр тогтооход салбар, аймаг дүүргийн магадлалын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн өдрөөс эхлэн тооцох ба хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд энэ хугацаа хамаарахгүй;

3.10 Даатгуулагч, хүн нь өөрийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоолгох, сунгуулах, цуцлуулах, ажлын цагийг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл өөрчлүүлэх асуудлыг магадлан шийдвэрлэхэд шаардлагатай эрүүл мэндтэй холбоотой баримт, бичиг, шинжилгээ, оношилгооны дүн, дүгнэлт, холбогдох лавлагаа зэрэг мэдээллийг үнэн зөвөөр бүрдүүлж төрөлжсөн мэргэшлийн эмч болон хяналтын эмчид хүлээлгэн өгөх;

3.11. Төрөлжсөн мэргэшлийн эмч болон хяналтын эмч нь даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоолгох, сунгуулах, цуцлуулах, ажлын цагийг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөх асуудлыг магадлан шийдвэрлэхэд эрүүл мэндтэй холбоотой баримт, бичиг, шинжилгээ, оношилгооны дүн, дүгнэлт, холбогдох лавлагаа зэрэг шаардлагатай мэдээллийг бүрэн бүрдүүлэх, тэдгээрийн үндэслэлийг нягталж, үнэн зөв байдлыг хариуцах;

3.12. Салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн шийдвэрээр хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь, хугацааг буруулах, цуцалсантай холбоотой даатгуулагч, хүний гаргасан гомдлыг 6 сар ба түүнээс дээш хугацаа өнгөрсөн тохиолдолд Төв зөвлөл хүлээн авч шийдвэрлэхгүй ба эмчилгээ, оношилгоо хийлгэсний дараа дахин хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоох эсэх асуудлыг салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөл шийдвэрлэх;

3.13. Төв зөвлөлийн хамтарсан болон дахин магадлал, эрх бүхий байгуулагын хяналт шалгалтад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хамрагдаагүй бол хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийг түр түдгэлзүүлж, холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд цуцлах арга хэмжээ авч ажиллах;

3.14. Бүсийн оношилгоо эмчилгээний төв, аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагын төрөлжсөн мэргэшлийн эмч, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн хяналтын эмч нь даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоох, сунгах, цуцлах, ажлын цаг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөх асуудлыг энэ дүрмийн 4.12.1–д заасан хугацаанд багтаан Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэх;

3.15.Төв зөвлөлийн хамтарсан болон дахин магадлалын үед даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг биеэр байлцуулан магадлах ба шаардлагатай тохиолдолд баримт бичгээр болон цахим хэлбэрээр шийдвэрлэх;

3.16. Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоох, сунгах, цуцлах, ажлын цаг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөх асуудлаар иргэнээс хамааралгүйгээр магадлалын зөвлөлийн хуралд мэдээллийг хугацаанд нь үнэн зөв бүртгэж илгээгээгүй, хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлүүлэх хугацаа хэтэрч хуралд хэлэлцүүлснээс иргэнд учирсан тэтгэвэр, тэтгэмж болон бусад төлбөр, зардал, хөнгөлөлттэй холбоотой хохирлыг төрөлжсөн мэргэшлийн болон хяналтын эмч нь барагдуулж, хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх зэрэг шинээр нэмэгдсэн болон өөрчилсөн заалтуудыг сайтар судлан хэрэгжүүлэх;

4. Эрүүл мэндийн магадлалын программын талаар:

4.1. Мэдээллийн системийн шинэчлэл хийгдэж байгаа ба нэвтрүүлж эхлэх хүртэл хугацаанд одоогийн программыг ашиглах;

5. Цагийн хөлс, урамшууллын талаар:

5.1. Дүрмийн 10.4-т заасан магадлагч эмчид олгох мөнгөн тэтгэмжийн төсвийг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын үйл ажиллагааны дараа оны төсөвт тусган, шийдвэрлэж байх;

Цаашид уг дүрмийг үндэслэн “Магадлагч эмчийн дүрэм”, “Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн хамтарсан болон дахин магадлал хийх заавар” зэрэг холбогдох тушаал шийдвэрүүдийг шинэчлэн батлахаар ажиллаж байна.

Мөн эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд цахимаар хяналт тавих, төрийн байгууллага хооронд мэдээлэл солилцох зэрэг цахим үйлчилгээг үе шаттайгаар хэрэгжүүлэх юм.

Иймд энэхүү дүрмийг эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд оролцогч талууд болох орон нутгийн удирдлага, эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн байгууллагууд, иргэд, даатгуулагчдад сургалт, сурталчилгаа хийж, магадлалын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хяналт, хариуцлагыг сайжруулах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран, хэрэгжилтийг ханган ажиллана уу.

Хавсралтаар Засгийн газрын 2023 оны “Дүрэм батлах тухай” 448 дугаар тогтоолыг хүргүүлэв.

Хувийг Мэргэжлээс шалтгаалсан өвчний болон Сэтгэцийн өвчний салбар зөвлөлд.

Хавсралт 11 хуудастай.

ДАРГА Л.МӨНХЗУЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 13 өдөр Дугаар 448 Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 43.4 дэх хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 37.5-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2.Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн мэдээллийн нэгдсэн санд даатгуулагчийн болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээллийг цахимаар хүргүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, эрүүл мэндийн даатгалын мэдээллийг цахимаар хүргүүлж ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (Л.Бямбасүрэн)-т тус тус үүрэг болгосугай.

3.Аймаг, дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, сэргээн засах, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, аймаг, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4.Энэ тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Л.Мөнхзул), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг нарт тус тус үүрэг болгосугай.

5.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Дүрэм шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2021 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 67 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

6.Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД Х.БУЛГАНТУЯА

Засгийн газрын ....2023 оны ....12 дугаар
сарын ....13 -ны өдрийн ....448 дугаар
тогтоолын хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН МАГАДЛАЛЫН ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлан тогтоох, сунгах, цуцлах, ажлын цаг богиносгох, хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх хяналт тавих, оролцогч талуудын үйл ажиллагаа, эрх, үүргийг тодорхойлох, цагийн хөлс, урамшуулал олгох, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах, маргааныг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэхтэй холбоотой харилцааг энэ дүрмээр зохицуулна.

1.2.Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөл (цаашид “Магадлалын төв зөвлөл” гэх) нь нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд, Эрүүл мэндийн магадлалын зөвлөл (цаашид “аймаг, дүүргийн магадлалын зөвлөл” гэх) нь аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэд тус тус ажиллана.

1.3.Магадлалын төв зөвлөлийн дэргэд орон тооны бус Сэтгэцийн өвчний салбар зөвлөл, Мэргэжлээс шалтгаалсан өвчний салбар зөвлөл (цаашид “салбар зөвлөл” гэх) тус тус ажиллана.

1.4.Сэтгэцийн өвчний салбар зөвлөл нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв байгууллагыг, Мэргэжлээс шалтгаалсан өвчний салбар зөвлөл нь нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэдэх Мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийг тус тус түшиглэн ажиллана.

1.5.Төв болон салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөл үйл ажиллагаандаа Нийгмийн даатгалын хууль тогтоомж, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон энэ дүрмийг мөрдөнө.

1.6.Төв болон салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөл хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.

1.7.Төв болон салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөл эрх, үүргийн хүрээнд шийдвэр гаргах ба энэ нь акт, албан шаардлага, шийдвэр, дүгнэлт, зөвлөмж хэлбэртэй байна.

1.8.Төв болон салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг нийгмийн даатгалын байгууллагын төсөвт тусгаж санхүүжүүлнэ.

Хоёр.Төв болон салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүн, тавигдах шаардлага, томилж, чөлөөлөх

2.1.Төв зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, нийгмийн даатгалын байгууллагын магадлагч эмч 10, мэдээллийн технологийн мэргэжилтэн 1, шинжээч эмч 6, даатгуулагч, ажил олгогчийн төлөөлөл тус бүр 1, нийт 21 хүний бүрэлдэхүүнтэй байна. Төв зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, магадлагч эмч, мэдээллийн технологийн мэргэжилтэн орон тооны байна.

2.2.Төв зөвлөлийн бүрэлдэхүүнийг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга доор дурдсан байдлаар томилж, чөлөөлнө:

2.2.1.дарга, нарийн бичгийн дарга, магадлагч эмч, мэдээллийн технологийн мэргэжилтнийг холбогдох хууль тогтоомжийг үндэслэн;

2.2.2.орон тооны бус шинжээч эмчийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн;

2.2.3.даатгуулагч болон ажил олгогчийн төлөөллийг Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо, ажил олгогчийн олонхын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан байгууллагын саналыг үндэслэн.

2.3.Салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн гишүүнийг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга томилж, чөлөөлнө.

2.4.Сэтгэцийн өвчний салбар зөвлөл нь орон тооны бус байх бөгөөд дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, төрөлжсөн мэргэшлийн эмч 4, нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын болон хөгжлийн бэрхшээлтэй хүний төлөөлөл тус бүр 1, нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй байна.

2.5.Сэтгэцийн өвчний салбар зөвлөлийн дарга нь Төв зөвлөлийн нарийн бичгийн дарга, эсхүл магадлагч эмч, орлогч дарга нь Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв байгууллагын ерөнхий захирал, нарийн бичгийн дарга нь Сэтгэцийн эрүүл мэндийн төв байгууллагын эрүүл мэндийн бүртгэл мэдээллийн ажилтан, нийгмийн халамжийн байгууллагын төлөөлөл нь нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан мэргэжилтэн, хөгжлийн бэрхшээлтэй хүний төлөөлөл нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагын төлөөлөл тус тус байна.

2.6.Мэргэжлээс шалтгаалсан өвчний салбар зөвлөл нь орон тооны бус байх бөгөөд дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, төрөлжсөн мэргэшлийн эмч 4, ажил олгогч, үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл болон хөгжлийн бэрхшээлтэй хүний төлөөлөл тус бүр 1, нийт 10 хүний бүрэлдэхүүнтэй байна.

2.7.Мэргэжлээс шалтгаалсан өвчний салбар зөвлөлийн дарга нь Төв зөвлөлийн нарийн бичгийн дарга, эсхүл магадлагч эмч, орлогч дарга нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллагын Мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн дарга, нарийн бичгийн дарга нь Мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын

төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн эрүүл мэндийн бүртгэл мэдээллийн ажилтан тус тус байна.

2.8.Салбар зөвлөлийн гишүүнийг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга доор дурдсан байдлаар томилж, чөлөөлнө:

2.8.1.үйлдвэрчний эвлэлийн төлөөллийг Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооноос, ажил олгогчийн төлөөллийг Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооноос нэр дэвшүүлсэн саналыг тус тус үндэслэн;

2.8.2.хөгжлийн бэрхшээлтэй хүний төлөөллийг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагын саналыг үндэслэн;

2.8.3.төрөлжсөн мэргэжлийн эмчийг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв байгууллагын болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллагын саналыг үндэслэн, Төв зөвлөлийн даргатай зөвшилцөн.

2.8.4.нийгмийн халамжийн байгууллагын төлөөллийг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн.

2.9.Аймаг, дүүргийн магадлалын зөвлөл нь орон тооны бус байх бөгөөд дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, магадлагч эмч тус бүр 1, төрөлжсөн мэргэшлийн эмч 3, нийгмийн халамжийн байгууллага, үйлдвэрчний эвлэлийн болон хөгжлийн бэрхшээлтэй хүний төлөөлөл тус бүр 1, нийт 10 хүний бүрэлдэхүүнтэй байна.

2.10.Аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн дарга нь аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга, орлогч дарга нь аймгийн бүсийн оношилгоо эмчилгээний төв, нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагын эмчилгээ эрхэлсэн орлогч дарга тус тус байна.

2.11.Аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн нарийн бичгийн дарга нь аймгийн бүсийн оношилгоо эмчилгээний төв, нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагын эрүүл мэндийн бүртгэл мэдээллийн ажилтан, магадлагч эмч нь аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын магадлагч эмч, нийгмийн халамжийн байгууллагын төлөөлөл нь аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар (хэлтэс)-ын хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан мэргэжилтэн тус тус байна.

2.12.Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дарга нь доор дурдсан байдлаар зөвлөлийн бүрэлдэхүүний саналыг холбогдох байгууллагаас авч, нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ. Үүнд:

2.12.1.аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн төрөлжсөн мэргэжлийн эмч нарыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газартай зөвшилцөн ирүүлсэн саналыг;

2.12.2.аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн хөгжлийн бэрхшээлтэй хүний төлөөллийг аймаг, дүүргийн Засаг дарга тухайн орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах зорилгоор тэдний харьяалагдах төрийн бус байгууллагын саналыг авч, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах орон тооны бус салбар зөвлөлөөр хэлэлцүүлсний үндсэн дээр ирүүлсэн саналыг;

2.13.Аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн үйлдвэрчний эвлэлийн төлөөллийг томилуулахдаа Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооноос нэр дэвшүүлсэн саналыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

2.14.Шинжээч эмч, төрөлжсөн мэргэшлийн эмчийг 3 жилийн хугацаагаар томилох бөгөөд ажлын үр дүн, туршлагыг нь харгалзан үзэж хугацааг 1 удаа 3 жилийн хугацаагаар улиралаж болно.

2.15.Шинжээч эмч, төрөлжсөн мэргэшлийн эмч нь дараах ерөнхий шаардлагыг хангасан байна:

2.15.1.мэргэжил (мэргэшил)-ээрээ 3-аас доошгүй жил ажилласан, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй их эмч;

2.15.2.ял шийтгүүлж байгаагүй;

2.15.3.мэргэжлийн алдаа, ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй;

2.15.4.ашиг сонирхлын зөрчилгүй, багаар ажиллах чадвартай;

2.15.5.нийтийн эрх ашиг, шударга ёсыг дээдэлдэг, ажлын хамт олондоо нэр хүндтэй байх.

2.16.Төв болон салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүн нь эрх бүхий байгууллагаас магадлан итгэмжлэгдсэн сургалтын байгууллагын хөдөлмөрийн чадвар алдсан даатгуулагч, хүн тэдгээрийн онцлог хэрэгцээ, эрхийн чиглэлээр зохих сургалтад хамрагдсан байна.

2.17.Төв болон салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүн нь нийтийн эрх ашиг, шударга ёсыг дээдэлж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, харилцан бие биеэ хүндэтгэж, үндэслэл бүхий шийдвэр гаргана.

Гурав.Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагааны төрөл, хэлбэр, дэг

3.1.Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагаа нь хурал хэлбэртэй байх ба даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг дараах хэлбэрээр шийдвэрлэнэ:

3.1.1.даатгуулагч, хүнийг байлцуулахгүйгээр холбогдох баримт бичигт үндэслэн;

3.1.2.цахим хэлбэрээр.

3.2.Энэ дүрмийн 3.1.1-д заасан хэлбэрээр шийдвэрлэх тохиолдолд даатгуулагч, хүнийг биечлэн ирүүлэхгүйгээр холбогдох баримт бичигт үндэслэн оношилгоо, шинжилгээ, эмчилгээ, сэргээн засах тусламж үйлчилгээний үр дүн, эрүүл мэндийн байдал, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоох, сунгах, цуцлах, ажлын цаг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөх асуудлыг магадална.

3.3.Энэ дүрмийн 3.1.2-т заасан хэлбэрээр шийдвэрлэх тохиолдолд даатгуулагч, хүнийг биечлэн ирүүлэхгүйгээр мэдээлэл, технологийн шийдлийг ашиглан зайн үзлэг хийж, оношилгоо, шинжилгээ, эмчилгээ, сэргээн засах тусламж үйлчилгээний үр дүн, эрүүл мэндийн байдал, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоох, сунгах, цуцлах, ажлын цаг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөх асуудлыг магадална.

3.4.Энэ дүрмийн 3.1.1, 3.1.2-т заасан хэлбэрээр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг шийдвэрлэх боломжгүй болон даатгуулагч, хүн өөрөө хүссэн тохиолдолд биеэр байлцуулан магадалж болно.

3.5.Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгааныг тогтоох, сунгах, цуцлах, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөх, ажлын цаг богиносгох асуудлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу баталсан өвчний жагсаалтыг баримтлан шийдвэрлэнэ.

3.6.Салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөл нь 7 хоногт 1 удаа хуралдах бөгөөд шаардлагатай тохиолдолд 1-ээс дээш удаа хуралдаж шийдвэрийг олонхын саналаар гаргана.

3.7.Дараах тохиолдолд магадлалын зөвлөлийн хурлыг хойшлуулж хуралдсан тохиолдолд хүчингүйд тооцно:

3.7.1.төв болон салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн нийт гишүүдийн ирц гуравны хоёрт хүрээгүй тохиолдолд;

3.7.2.төв зөвлөлийн хуралд дарга, нарийн бичгийн дарга, салбар, зөвлөлийн хуралд дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга нэгэн зэрэг оролцоогүй тохиолдолд;

3.7.3.аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн хуралд дарга, магадлагч эмч, нарийн бичгийн дарга нэгэн зэрэг оролцоогүй тохиолдолд.

3.8.төв болон салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн дарга, тухайн өдрийн хуралд оролцоогүй тохиолдолд, орлогч дарга тухайн хурлыг даргалан зөвлөлийн хурлыг удирдан явуулна.

3.9.Төв болон салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн дарга, орлогч дарга, гишүүд тус бүр саналын эрхтэй байх бөгөөд Төв зөвлөл болон Сэтгэцийн өвчний салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга саналын эрхтэй байна.

3.10.Салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөл даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг хэлэлцэн шийдвэрлэхэд тухайн зөвлөлийн нарийн бичгийн даргын гаргасан хурлын дарааллыг баримтална.

3.11.Төрөлжсөн мэргэшлийн болон хяналтын эмч нь даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох, сунгах, цуцлах, ажлын цаг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл солих талаар мэдээллийг магадлалын зөвлөл хуралдахаас 1-5 хоногийн өмнө салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөлд цахимаар хүргүүлнэ.

3.12.Салбар болон орон нутгийн комисс даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох, сунгах, цуцлах, ажлын цаг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл солих асуудлыг ажлын 5 хүртэл хоногт багтаан шийдвэрлэнэ.

3.13.Төв болон салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөлөөс даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоох, сунгах, цуцлах, ажлын цаг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн актыг эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн тусгай программаар үйлдэх ба актад хуралд оролцсон бүх гишүүд гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулна.

Дөрөв.Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэх үйл ажиллагаа

4.1.Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоолгох, сунгуулах, цуцлуулах, ажлын цагийг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл солих асуудлыг шийдвэрлүүлэхдээ төрөлжсөн мэргэшлийн эмч болон хяналтын эмчид хүсэлтээ гаргах ба төрөлжсөн мэргэшлийн эмч болон хяналтын эмч холбогдох баримт бичиг, оношийг баталгаажуулах шинжилгээ, оношилгоог бүрдүүлж, үечилсэн дүгнэлт, саналыг Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хуралд танилцуулна.

4.2.Даатгуулагч, хүн нь ердийн өвчин болон ахуйн осол, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд 66-132 өдрөөс хэтрэхгүй хугацаатай эмчийн хяналтад эмчлүүлэх бөгөөд эмчилгээний үр дүн, өвчний явц, үе шат, хүндрэлийн талаарх баталгаажсан оношилгоо, шинжилгээний үр дүнд үндэслэн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоолгох эсэх асуудлыг шийдвэрлүүлнэ.

4.3.Даатгуулагч, хүний эрхтэн, бие махбодийн тогтоц, үйл ажиллагаа нь эргэшгүй өөрчлөлтөд орж, хүндээр гэмтсэний улмаас өөрөө өөртөө үйлчлэх чадваргүй, бусдын асаргаа сувилгаа шаардлагатай болсон, байнгын хэвтэрт байгаа тохиолдол болон хорт хавдар өвчний III, IV үед энэ дүрмийн 4.2-т заасан хугацааг болон эмнэлгийн хуудас авсан, эмчийн хяналтад орсон, эмчлүүлсэн эсэхийг нь үл харгалзан хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоож болно.

4.4.Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгааныг ердийн өвчин, ахуйн осол болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас гэж тус тус ангилна.

4.5.Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг доор дурдсанаар ангилна:

4.5.1.бүрэн буюу 70 ба түүнээс дээш хувиар алдсан;

4.5.2.хагас (хэсэгчлэн) буюу 70 хүртэл хувиар алдсан.

4.6.Салбар, аймаг, дүүрэг, сумын магадлалын зөвлөл даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоох, сунгах, цуцлах, ажлын цагийг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөхдөө оношилгоо, шинжилгээ, төрөлжсөн мэргэшлийн болон хяналтын эмчийн дүгнэлт, саналыг үндэслэх ба үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн тохиолдолд, хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчийн баталгаажуулсан

үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэсэн акт, саналыг тус тус үндэслэнэ.

4.7.Хүн амын тоо, нягтрал, байршил зэргийг харгалзан сумын нийгмийн даатгалын тасгийн дэргэд сумын Эрүүл мэндийн магадлалын зөвлөлтэй тохиолдолд даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг сумын эрүүл мэндийн төвийн хяналтын эмч хариуцан шийдвэрлүүлнэ.

4.8.Гадаад улсад хорт хавдар, сүрьеэ, эрхтэн шилжүүлэх болон бусад өвчний шалтгаанаар 132 хоногоос дээш хугацаагаар эмчлүүлж байгаа даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг шийдвэрлэхдээ үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдсан, эмчлүүлж байгаа талаарх тухайн улсын эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт, биеийн эрүүл мэндийн байдлын талаарх дүгнэлтийн эх хувь болон тухайн улсад суугаа Монгол Улсын Элчин сайдын яам, эсхүл Консулын газрын тодорхойлолт, итгэмжлэл, хүний хувийн хүсэлтэд үндэслэн салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

4.9.Энэ дүрмийн 4.7, 4.8-д заасан даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоох, сунгах, цуцлах асуудлыг мөн дүрмийн 3.1.1, 3.1.2-т заасан хэлбэрээр хуралдан шийдвэрлэнэ.

4.10.Шүүхээр ял эдэлж буй ялтанд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоох, сунгах, цуцлах асуудлыг зөвхөн хорихын нэгдсэн эмнэлгийн төрөлжсөн мэргэшлийн эмчийн дүгнэлт, саналыг үндэслэн хорих байгууллагын харьяалах аймаг, дүүргийн магадлалын зөвлөл, эсхүл салбар зөвлөл шийдвэрлэнэ.

4.11.Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгааныг тогтоох үйл ажиллагааг дараах байдлаар зохион байгуулна:

4.11.1.ердийн өвчин, ахуйн болон үйлдвэрлэлийн ослын шалтгаантай хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоолгох даатгуулагч, хүний өвчний түүх, оношилгоо, шинжилгээний өөрчлөлт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаарх мэдээлэл, хөдөлмөрийн чадвар алдалтад хүргэсэн үндсэн болон хавсарсан өвчний онош, өвчний үе шат, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа зэргийг тусгасан дүгнэлт, санал, хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчийн баталгаажуулсан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэсэн актыг бүсийн оношилгоо эмчилгээний төв, аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн байгууллага, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн төрөлжсөн мэргэшлийн болон хяналтын эмч нь аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн хуралд танилцуулна;

4.11.2.нийслэлийн дүүрэгт оршин сууж буй сэтгэцийн өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоолгох даатгуулагч, хүний өвчний түүх, оношилгоо, шинжилгээний өөрчлөлт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаарх мэдээлэл, хөдөлмөрийн чадвар алдалтад хүргэсэн үндсэн болон хавсарсан өвчний онош, үе шат, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа зэргийг тусгасан үечилсэн дүгнэлт, саналыг төрөлжсөн мэргэшлийн эмч болон хяналтын эмч нь сэтгэцийн өвчний салбар зөвлөлийн хуралд танилцуулна;

4.11.3.мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын шалтгаантай хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоолгох даатгуулагч, хүний өвчний түүх, оношилгоо, шинжилгээний өөрчлөлт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаарх

мэдээлэл, хөдөлмөрийн чадвар алдалтад хүргэсэн үндсэн болон хавсарсан өвчний онош, өвчний үе шат, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа зэргийг тусгасан үечилсэн дүгнэлт, санал (мэргэжлээс шалтгаалсан өвчний үед хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчийн баталгаажуулсан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэсэн акт, хөдөлмөрийн нөхцөлийн тодорхойлолт)-ыг Мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн төрөлжсөн мэргэшлийн эмч болон хяналтын эмч, мэргэжлээс шалтгаалсан өвчний салбар зөвлөлийн хуралд танилцуулна;

4.11.4.салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөл нь даатгуулагч, хүний биеийн эрүүл мэндийн байдал, шинжилгээ, оношилгооны өөрчлөлт, өвчний үе шат, хүндрэл, дэлгэрэнгүй онош, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаарх мэдээллийг тусгасан төрөлжсөн мэргэшлийн эмч болон хяналтын эмчийн дүгнэлт, саналыг үндэслэн хувь, хугацаа, шалтгааныг тогтооно;

4.11.5.салбар, орон нутгийн комисс нь даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг тогтоох асуудлыг дахин магадлах шаардлагатай гэж үзвэл холбогдох баримт бичгийг бүрэн бүрдүүлж, үзлэг оношилгоог давтан хийсний үндсэн дээр шийдвэрлэнэ;

4.11.6.салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөл нь даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоох, сунгах үндэслэлгүй гэж үзвэл шийдвэр гаргахгүйгээр үндэслэл бүхий хариу өгнө;

4.11.7.хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг шинээр тогтооход салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн өдрөөс эхлэн тооцох ба хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд энэ хугацаа хамаарахгүй;

4.11.8.хоёр буюу түүнээс дээш тооны өвчнөөр өвчилсөн даатгуулагч, хүний үндсэн өвчнийг сонгон хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг тогтоож, хавсарсан өвчний үе шат, явц, биеийн ерөнхий байдал зэргийг харгалзан хөдөлмөрийн чадвар алдалтыг тав хүртэл хувиар нэмж тогтоож болох ба үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдсан тохиолдолд даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг тооцоход ердийн өвчний хувийг нэмж тооцохгүй.

4.12.Салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөл нь даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг сунгах, цуцлах үйл ажиллагааг дараах байдлаар зохион байгуулна:

4.12.1.даатгуулагч, хүн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг сунгуулахдаа өмнөх шийдвэрийн хугацаа дуусахаас 14 хоногийн өмнө, эсхүл уг хугацаа дууссанаас хойш 14 хоногийн дотор магадлалын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн тохиолдолд өмнөх шийдвэрийн хугацаа дууссанаас хойш үргэлжлүүлэн сунгана. Харин энэ хугацаа өнгөрсөн тохиолдолд хурлаар хэлэлцсэн өдрөөс эхлэн сунгаж шийдвэрлэнэ;

4.12.2.даатгуулагч, хүн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ дүрмийн 4.12.1-д заасан хугацаанаас хойш 6 сарын дотор сунгуулах хүсэлт гаргасан бол хүндэтгэн үзэх шалтгааныг нотлох баримтад үндэслэн салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн өдрөөс эхлэн тооцож, ердийн

өвчин бол 2 сараас, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчин бол 6 сараас илүүгүй хугацаагаар тус тус нөхөн сунгаж болно;

4.12.3.даатгуулагч, хүн өөрөө хүсэлт гаргасан тохиолдолд хөдөлмөрийн чадвар алдалт тогтоосон хувь, хугацаа хүчинтэй үед өвчний хүндрэл, үе шатыг харгалзан хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг дахин магадлан өөрчилж, цуцалж болно;

4.12.4.даатгуулагч, хүн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг шийдвэрлэсэн хугацаа дууссанаас хойш 6 сарын дотор магадлуулаагүй тохиолдолд даатгуулагч, хүнд, эсхүл түүний асран хамгаалагчид мэдэгдэж, хөдөлмөрийн чадвар алдалтыг цуцлах шийдвэр гаргана.

4.13.Салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөл хөдөлмөрийн чадвар алдалтыг хугацаагүй тогтоолгосон даатгуулагч, хүний эрүүл мэндийн байдал, түүнд үзүүлж байгаа тусламж, үйлчилгээний талаарх судалгааг хагас, бүтэн жилээр харьяалагдах өрх болон сумын эмчээс авч, хяналт тавьж ажиллана.

4.14.Даатгуулагч, хүний биеийн эрүүл мэндийн байдлаас шалтгаалан хөдөлмөрийн чадвар алдалт, бууралт нь цаашид даамжрах төлөвтэй, дадаж мэргэшсэн ажлаа хөдөлмөрийн тогтоосон цагт тоо, чанарын хувьд бүрэн хийж чадахгүйд хүрсэн бол тухайн даатгуулагч, хүнийг сувилуулах, эмчлүүлэхэд зориулж ажлын цагийг тодорхой хугацаагаар богиносгох шийдвэрийг салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөл даатгуулагч, хүний хүсэлтийг үндэслэн гаргана.

4.15.Даатгуулагч, хүний ажлын цагийг богиносгох, хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх асуудлыг энэ дүрмийн 3.5-д заасан эрх бүхий байгууллагаас баталсан өвчний жагсаалтыг үндэслэн салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөл шийдвэрлэнэ.

Тав.Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд оролцогч талуудын нийтлэг эрх, үүрэг

5.1.Төв болон салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөл болон эрүүл мэндийн байгууллага, оролцогч талууд нь дараах нийтлэг эрхтэй байна:

5.1.1.төв болон салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн шийдвэрийг алдаагүй, үндэслэлтэй гаргах зорилгоор төрөлжсөн мэргэжлийн эмч, мэргэжилтнийг татан оролцуулах;

5.1.2.эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагаанд алдаа, дутагдал гаргасан, төрийн албан хаагчийн болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн төв болон салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, гишүүн, албан хаагчдад хариуцлага хүлээлгэх талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлэл хүргүүлж, шийдвэрлүүлэх;

5.1.3.аливаа алдаа, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн санг эрсдэлээс хамгаалах чиглэлээр үр дүнтэй ажилласан ажилтныг урамшуулах;

5.1.4.даатгуулагч, хүнийг нөхөн сэргээх эмчилгээ, үйлчилгээнд хамруулах саналыг хүргүүлэх.

5.2.Хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэх үйл ажиллагаанд оролцогч талууд болох төв болон салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөл болон эрүүл мэндийн байгууллага, даатгуулагч, хүн нь дараах нийтлэг үүрэгтэй байна:

5.2.1.даатгуулагч, хүн нь өөрийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоолгох, сунгуулах, цуцлуулах, ажлын цагийг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл өөрчлүүлэх асуудлыг магадлан шийдвэрлэхэд шаардлагатай эрүүл мэндтэй холбоотой баримт бичиг, шинжилгээ, оношилгооны дүн, дүгнэлт, холбогдох лавлагаа зэрэг мэдээллийг үнэн зөвөөр бүрдүүлж төрөлжсөн мэргэшлийн эмч болон хяналтын эмчид хүлээлгэн өгөх;

5.2.2.төрөлжсөн мэргэшлийн эмч болон хяналтын эмч нь даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоолгох, сунгуулах, цуцлуулах, ажлын цагийг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөх асуудлыг магадлан шийдвэрлэхэд эрүүл мэндтэй холбоотой баримт бичиг, шинжилгээ, оношилгооны дүн, дүгнэлт, холбогдох лавлагаа зэрэг шаардлагатай мэдээллийг бүрэн бүрдүүлэх, тэдгээрийн үндэслэлийг нягталж, үнэн зөв байдлыг хариуцах;

5.2.3.эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдох хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих;

5.2.4.авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагааг даатгуулагч, хүнд шударга, чанартай, түргэн шуурхай, чирэгдэлгүй, тэгш хүртээмжтэй үзүүлэх, үнэн зөв мэдээллээр хангах;

5.2.5.даатгуулагч, хүнийг хөдөлмөрийн чадвар алдахаас урьдчилан сэргийлэх, сэргээн засах үйл ажиллагааг дэмжих, энэ чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулах;

5.2.6.даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвараа бүрэн болон хагас (хэсэгчлэн) алдсан хувь, хугацаа, шалтгааныг тогтоох, сунгах, цуцлах, хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх, ажлын цагийг богиносгох шийдвэр гаргах;

5.2.7.даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд судалгаа, шинжилгээ, шалгалт хийх, илэрсэн зөрчлийг арилгах;

5.2.8.төрийн албаны болон нийгмийн даатгалын хууль тогтоомж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөж ажиллах;

5.2.9.эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, тусламж, үйлчилгээг сайжруулах талаар арга хэмжээ авах, санал боловсруулж шийдвэрлүүлэх;

5.2.10.албан үүргээ гүйцэтгэх явцад ашиг сонирхлын зөрчил үүссэн болон үүсэж болзошгүй тохиолдолд зохих журмын дагуу мэдэгдэл, тайлбар гаргах бөгөөд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг мөрдөж ажиллах.

Зургаа.Төв зөвлөлийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа

6.1.Төв зөвлөл нь салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд хяналт тавих, эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар санал боловсруулж, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх үндсэн чиг үүрэгтэй бөгөөд дараах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана:

6.1.1.эрүүл мэндийн магадлалтай холбоотой маргааныг шинжээч эмчийн болон эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөлийн дүгнэлт, эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй, магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын үзлэг, оношилгоо, шинжилгээний дүнг үндэслэн гомдол гаргагч даатгуулагч, хүнийг биеэр байлцуулан шийдвэрлэх ба гаргасан шийдвэрийг зөвшөөрөөгүй тохиолдолд гомдлоо шүүхэд гаргаж болно;

6.1.2.салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, давтан сургах, сургалтад хамруулах талаар санал боловсруулж, шийдвэрлүүлэх;

6.1.3.салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, гаргасан шийдвэр нь хууль тогтоомжид нийцээгүй бол өөрчлөх, цуцлах арга хэмжээ авч, илэрсэн зөрчлийг арилгуулах, буруутай этгээдэд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага тооцох, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх талаарх саналыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага бусад холбогдох байгууллагад хүргүүлэх;

6.1.4.аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах, дэвшилтэт техник, технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, төсвийн төлөвлөлтийг сайжруулах, хөдөлмөрийн чадвар алдалтын талаар тооцоо, судалгаа, шинжилгээ хийх, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, тогтмол сайжруулах, ашиглах, хууль тогтоомжийн хүрээнд харилцан мэдээлэл солилцох чиглэлээр зохих арга хэмжээ авах;

6.1.5.эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслийн зардлын төсвийн төслийг нарийвчилсан хуваарийн саналын хамт хуульд заасан хугацаанд боловсруулж, нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлэх;

6.1.6.мэргэжлээс шалтгаалсан өвчний сувиллын үйл ажиллагаа, үр дүн, тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах;

6.1.7.энэ дүрмийн 7.1.8-д заасны дагуу салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөлөөс ирүүлсэн тайлан, мэдээг улсын хэмжээнд хагас, бүтэн жилээр нэгтгэн дүгнэж, нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх, шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн байгууллага, бусад мэргэжлийн байгууллагатай хамтран хяналт шалгалт хийх;

6.1.8.энэ дүрмийн 6.1.7-д заасан тайланд хөдөлмөрийн чадвар алдалтын байдлыг улсын хэмжээнд, аймаг, дүүрэг, сум, хороо, тосгоноор ангилан өвчний

оношоор бүлэглэж, хүн амд харьцуулсан судалгааг боловсруулан тусгаж, дүгнэлт гаргах.

6.2.Төв зөвлөл нь шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн байгууллагын байр, багаж хэрэгсэл, лаборатори, эм, урвалжийг оношилгоо, магадалгаа хийх зорилгоор үнэ төлбөргүй ашиглаж болно.

6.3.Төв зөвлөл нь эрүүл мэндийн магадлалтай холбоотой хууль тогтоомж, дүрэм, журмын талаар болон зөвлөлийн үйл ажиллагааны талаар иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх, сурталчлан таниулах ажлыг зохион байгуулан ажиллана.

6.4.Салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн шийдвэрээр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг бууруулах, цуцалсантай холбоотой даатгуулагч, хүний гаргасан гомдлыг 6 сар ба түүнээс дээш хугацаа өнгөрсөн тохиолдолд төв зөвлөл хүлээн авч шийдвэрлэхгүй ба эмчилгээ, оношилгоо хийлгэсний дараа дахин хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоох эсэх асуудлыг салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөл шийдвэрлэнэ.

6.5.Төв зөвлөлийн хамтарсан болон дахин магадлал, эрх бүхий байгууллагын хяналт шалгалтад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хамрагдаагүй бол хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийг түр түдгэлзүүлж, холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд цуцлах арга хэмжээ авч ажиллана.

Долоо.Салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа

7.1.Салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөл дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллана:

7.1.1.даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвараа алдсан хувь, хугацаа, шалтгааныг тогтоох, сунгах, цуцлах, ажлын цагийг богиносгох, хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх асуудлыг төрөлжсөн мэргэшлийн эмч болон хяналтын эмчийн дүгнэлт, саналыг үндэслэн тогтоох;

7.1.2.эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй, магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын үзлэг, оношилгоо, шинжилгээний дүнг үндэслэн эрүүл мэндийн магадлал хийх;

7.1.3.хөдөлмөрийн нөхцөл нь биеийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж, өвчин эмгэг нь даамжран, цаашид хүндрэх төлөвтэй даатгуулагч, хүний хөдөлмөрийн нөхцөлийг эхний удаа 6 сар хүртэл хугацаагаар өөрчлөх, шаардлагатай тохиолдолд хөдөлмөрийн нөхцөлийг хугацаагүйгээр өөрчлөх шийдвэр гаргах;

7.1.4.биеийн эрүүл мэндийн байдлын улмаас хөдөлмөрийн чадварын бууралт нь цаашид даамжрах төлөвтэй, тогтоосон хөдөлмөрийн цагт бүрэн хөдөлмөрлөх боломжгүй болсон даатгуулагч, хүний ажлын цагийг богиносгох шийдвэр гаргах;

7.1.5.тухайн аймаг, дүүргийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтын мэдээллийн цахим санг тогтмол хөтөлж, бүрдүүлэх, шинэчлэх арга хэмжээ авч

мэдээллийн хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг хангаж ажиллах, хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд судалгаа, дүгнэлт хийх;

7.1.6.тухайн аймаг, дүүргийн иргэний бүртгэлийн байгууллагатай хамтран хөдөлмөрийн чадвараа алдсан иргэдийн шилжилт хөдөлгөөн, нас баралтын мэдээллийг сар бүр тулгах, нягтлах, холбогдох өөрчлөлтийг мэдээллийн санд тогтмол оруулах;

7.1.7.салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгах;

7.1.8.үйл ажиллагааны хагас жилийн тайлан, мэдээг жил бүрийн 07 дугаар сарын 10-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайлан, мэдээг дараа жилийн 01 дүгээр сарын 10-ны өдөр дотор багтаан Магадлалын төв зөвлөлд хүргүүлж, тайлан, мэдээний үнэн зөвийг хариуцах;

7.1.9.үйл ажиллагааны зардал, хөрөнгө оруулалтын төсвийг хуульд заасан хугацаанд боловсруулан магадлалын төв зөвлөлд хүргүүлэх;

7.1.10.үйлдвэрлэлийн осол, хурц хордлого болон мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдсан даатгуулагч, хүнд үзүүлж буй мэргэжлээс шалтгаалсан өвчний сувилах, сэргээн засах тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид хяналт тавих;

7.1.11.даатгуулагч, хүний гаргасан өргөдөл гомдлыг холбогдох хуульд заасан хугацаанд шийдвэрлэж, хариу өгч ажиллах;

7.1.12.магадлалын төв зөвлөлөөс өгсөн хууль тогтоомжид нийцсэн үүрэг, даалгаврыг шуурхай биелүүлэх;

7.1.13.хуурамч баримт бичиг бүрдүүлсэн даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоох, сунгах асуудлыг шийдвэрлэхгүй бөгөөд хуурамч баримт бичиг бүрдүүлэн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоолгосон шийдвэрийг цуцалж, буруутай этгээдээр хохирлыг барагдуулах арга хэмжээ авах;

7.1.14.хөдөлмөрийн чадвар алдсан даатгуулагч, хүн, түүний гэр бүлд эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээний талаар мэдээлэл, сургалт сурталчилгаа, зөвлөгөө зөвлөмж өгч ажиллах.

7.2.Салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөлөл нь энэ дүрмийн 7.1-д зааснаас гадна хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагч, хүний эрх ашиг зөрчигдөж байгаа эсэхэд хяналт тавьж, холбогдох төрийн захиргааны байгууллага, түүний харьяа хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах орон тооны бус зөвлөлд мэдээлэх, тайлагнах, төрийн байгууллагын болон иргэдийн уялдаа холбоог сайжруулах чиглэлээр идэвх санаачилга гарган ажиллах, шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

7.3.Салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн нийгмийн халамжийн байгууллагын төлөөлөл нь энэ дүрмийн 7.1-д зааснаас гадна даатгуулагч, хүнд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, дэмжлэг туслалцаа

үзүүлэх үйл ажиллагаанд хамруулах талаар зөвлөлгөө өгөх, сургалт сурталчилгаа хийх, ажилд зуучлах, хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.3.Даатгуулагч гэрээний хугацаандаа гурав хүртэлх насны хүүхдээ асарч буй эх, малчин, туслах малчин, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа ажил хөдөлмөр эрхлээгүй эх /эцэг/-ийн даатгуулагчийн нөхцөлөөр даатгуулах хүсэлт гаргасан тохиолдолд түүний гэрээг шинэчлэн байгуулна. Энэ тохиолдолд өмнөх гэрээний шимтгэл төлөлтийн тооцоог бүрэн барагдуулж, гэрээг дуусгавар болгоно

Тав. Маргааныг шийдвэрлэх, хүлээх хариуцлага

5.1.Гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдсон маргаантай асуудлыг хоёр тал харилцан зөвшилцөн шийдвэрлэх зарчим баримтлах бөгөөд шаардлагатай бол Маргаан хянан шийдвэрлэх зөвлөл, эсхүл шүүхээр шийдвэрлүүлнэ.

5.2.Энэхүү гэрээгээр хүлээсэн үүрэг болон нийгмийн даатгалын хууль тогтоомжийг зөрчвөл холбогдох хуульд заасны дагуу зохих хариуцлага хүлээнэ.

Зургаа.Бусад

6.1.Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж нэг хувийг Нийгмийн даатгалын байгууллагад, нөгөө хувийг гэрээ байгуулсан даатгуулагчид өгөх ба хувь тус бүр хүчин төгөлдөр байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Нийгмийн даатгалын байгууллагыг төлөөлж:	Сайн дураар даатгуулагчийг төлөөлж:
.....аймаг /дүүрэг/, сумын нийгмийн даатгалын байцаагч ..... / ...../ /гарын үсэг/ /гарын үсгийн тайлал/	..... аймаг /дүүрэг/, сумын .....хороо /баг/-ын оршин суугч ..... / ...../ /гарын үсэг/ /гарын үсгийн тайлал/
Утас: ..... Э-шуудангийн хаяг:	Утас: ..... Утас:..... Э-шуудангийн хаяг: .....
202 . . . оны . . . сарын . . . өдөр	202 . . . оны . . . сарын . . . өдөр

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/200 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

ГУРАВ ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДЭЭ АСАРЧ БУЙ ЭХИЙН НИЙГМИЙН ДААТГАЛД САЙН ДУРААР ДААТГУУЛСАН ТУХАЙ ГЭРЭЭ

Дугаар . . . . . .

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасны дагуу нийгмийн даатгалд сайн дураар даатгахаар нэг талаас..... аймаг (хот)-ийн ..... дүүрэг (сум)-ийн нийгмийн даатгалын газар (тасаг)-ийг төлөөлж, байцаагч ..... эцэг (эх)-ийн нэр .....өөрийн нэр (цаашид “нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)” гэх), нөгөө талаас иргэн .....эцэг (эх)-ийн нэр ..... өөрийн нэр (цаашид “даатгуулагч” гэх) нар (цаашид “талууд” гэх) харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

1.2.Даатгуулагч эхийн иргэний бүртгэлийн дугаар:

1.3.Гурав хүртэлх насны хүүхдийн регистрийн дугаар

1.4.Даатгуулагч эхийн төрөл: (тохирох хэсгийн ард (√) тэмдэглэнэ

1.	Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх үүссэн, 3 хүртэлх настай хүүхдээ асарч буй эх	
2.	Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх үүсээгүй, 3 хүртэлх настай хүүхдээ асарч буй эх	

Нийгмийн даатгалын шимтгэл ногдуулж төлөх орлогын хэмжээ, хувь, хугацаа

1.5.Гэрээний хүчинтэй байх хугацаа: . . . .

/эхлэх / (он, сар,өдөр) /дуусах/ (он, сар,өдөр)

Тайлбар: Гэрээний хугацаа нь гэрээ байгуулсан сараас эхлэн хүүхдийг 3 нас хүртэл хугацаанд хүчинтэй байна.

1.6.Нийгмийн даатгалын шимтгэл ногдуулж төлөх сарын цалин хөлс, орлого: . . . . төгрөг.

Түүнд ногдуулж сар бүр өөрөө хариуцан төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн дүн: ..... төгрөг
Тэтгэмжийн даатгалын сангаас (улсын төсвөөс) хариуцан сард төлөх дүн ..... төгрөг байна.

1.6.1.Даатгуулагчийн энэхүү гэрээний 1.6-д заасан өөрөө мэдүүлсэн шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын цалин хөлсний доод хэмжээ нь тухайн мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй, дээд хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 7 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна. Гэрээний хугацаанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ эрх бүхий байгууллагын шийдвэрээр шинэчлэн тогтоогдсон тохиолдолд уг шийдвэрийг хэрэгжих хугацаанаас нь эхлэн дагаж, мөрдөнө.

1.6.2.Гэрээний 1.6-д заасан орлого нь шинэчлэн баталсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага тохиолдолд уг шийдвэрийг дагаж мөрдөх хугацаанаас эхлэн өөрчлөгдсөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр, дээд хэмжээ нь багассан тохиолдолд шинэчлэгдсэн дээд хэмжээгээр өөрчлөгдсөнд тооцно.

1.6.3.Энэ гэрээний 1.6-д заасан нийгмийн даатгалын шимтгэл ногдуулж, төлж буй сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээ нь энэхүү гэрээний 1.6.2-т зааснаас бусад тохиолдолд 12 сарын дотор өөрчлөгдөхгүй.

1.6.4.Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээг гэрээ байгуулснаас хойш 12 сар тутамд нэг удаа өөрчилж болно.

1.7.Энэ гэрээний 1.6-д заасан сарын цалин хөлснөөс тэтгэврийн даатгалын санд 11.5 хувь, тэтгэмжийн даатгалын санд 1.0 хувь, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд 1.0 хувиар тооцож нийт 13.5 хувийн нийгмийн даатгалын шимтгэл төлнө.

1.8.Гэрээний хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт орж, энэ гэрээний 1.7-д заасан шимтгэлийн хувь хэмжээ өөрчлөгдсөн тохиолдолд уг хуулийн хэрэгжих хугацаанаас эхлэн шинээр тогтоосон хувь хэмжээгээр тооцож шимтгэлийг төлөх бөгөөд үүнээс үүсэх шимтгэлийн зөрүүг тухайн даатгуулагч хариуцаж санд нөхөн төлнө.

1.9.Даатгуулагч энэ гэрээний 1.6-д заасан цалин хөлснөөс мөн гэрээний 1.7-д заасан хувь хэмжээгээр тооцсон нийгмийн даатгалын шимтгэлийг даатгалын санд сар бүр төлөх үүрэг хүлээх бөгөөд урьдчилан төлж болно.

1.10.Даатгуулагч эхийн гэрээг хүүхдийг нь 3 нас хүртэл хугацаагаар байгуулна. Харин даатгуулагч эх уг гэрээний хугацаанд дахин хүүхэд төрүүлбэл шинээр төрсөн хүүхдийн мэдээлэлд үндэслэн гэрээг шинэчлэн байгуулна. Энэ тохиолдолд өмнөх гэрээний шимтгэлийн тооцоог бүрэн хийж, шинэ гэрээг байгуулна.

1.11.Гэрээг цаасаар болон цахим хэлбэрээр байгуулж, сунгаж болно.

1.12.Даатгуулагч гэрээг байгуулах хүсэлтийн дагуу сард ногдох шимтгэлээ төлснөөр, төлбөр төлсөн сараас эхлэн уг гэрээг хэрэгжиж эхэлсэнд тооцно. (Гэрээний сунгалт, өөрчлөлт нэгэн адил хамаарна).

1.13.Даатгуулагч энэхүү гэрээнд заасан төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлээ санд бүрэн төлж дууссан тохиолдолд гэрээний хугацааг сунгуулах тухай хүсэлтээ нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)-д өөрийн биеэр эсхүл цахимаар гаргаж болно.

1.14.Даатгуулагч өмнө нь байгуулсан гэрээний хугацаа дууссаны дараагийн сард багтаан шимтгэл төлсөн тохиолдолд гэрээний хугацааг өмнөх гэрээний нөхцөлөөр үргэлжлүүлэн сунгасанд тооцно. Даатгуулагч өмнө нь байгуулсан гэрээний нөхцөлөө өөрчлөх тохиолдолд хүсэлтээ нийгмийн даатгалын байгууллагад гаргаж холбогдох өөрчлөлтийг тусган гэрээний хугацааг сунгана.

1.15.Даатгуулагч гэрээний хугацаагаа сунгах хүсэлт гаргасан боловч өмнөх гэрээ дууссанаас хойш 1 ба түүнээс дээш сарын дараа шимтгэл төлсөн бол шимтгэл төлсөн сараас нь эхлэн гэрээг шинээр байгуулсанд тооцно. Гэрээг шимтгэл төлсөн сараас эхлэн үргэлжлүүлэн баталгаажуулж, уг шимтгэлийг нь зохих саруудад бүртгэж, нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд оруулна.

1.16.Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь батлагдсан маягтын дагуу даатгуулагчтай байгуулсан гэрээг 2 хувь үйлдэж, нийгмийн даатгалын байцаагч, даатгуулагч тус тус гарын үсэг зурснаар уг гэрээ баталгаажна. Даатгуулагч цахимаар гэрээ байгуулж буй тохиолдолд гэрээний нөхцөлтэйгөө танилцаж, “гэрээний нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна” сонголтыг сонгосноор байцаагч болон даатгуулагчийг уг гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулснаар тооцно.

Хоёр. Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)-ийн эрх, хүлээх үүрэг

2.1.Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь гэрээ хүчин төгөлдөр болсон сараас эхлэн энэ гэрээний 1.6-д заасан өөрөө хариуцан төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг бүрэн төлж буй эсэхэд хяналт тавих бөгөөд шимтгэлийн төлбөрийг бэлэн бусаар төлүүлнэ.

2.2.Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь сайн дураар даатгуулах болон гэрээний хугацааг сунгуулах тухай хүсэлтээ гаргасан даатгуулагч (иргэн)-ийг уг хүсэлт гаргасан сарын шимтгэлээ нийгмийн даатгалын сангийн харилцах дансанд төлсөн тохиолдолд түүнтэй нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан тухай гэрээг хэрэгжиж эхэлсэнд тооцож, нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, шимтгэл төлөлтийн тооцоог хийж хянасны үндсэн дээр баталгаажуулна.

2.3.Даатгуулагч шимтгэлээ энэ гэрээний 1.9-д тохирсон хугацаандаа төлөөгүй, эсвэл дутуу төлсөн тохиолдолд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн

44.1.2-т заасны дагуу дутуу төлсөн буюу хугацаандаа төлөөгүй нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлж, уг шимтгэлийн дүнгээс хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 0.3 хувийн алданги ногдуулна. Өмнө нь дуусгавар болсон гэрээний хугацаанд шимтгэлээ бүрэн төлөөгүй даатгуулагчийн тухайн төлөгдөөгүй хугацааны шимтгэлийг нөхөн төлүүлэхгүй.

2.4.Тухайн жилд гэрээний маягт шинэчлэн батлагдсан тохиолдолд өмнө нь байгуулсан гэрээний хугацаанд гэрээг хуучин маягтаар нь үргэлжлүүлнэ. Харин гэрээг сунгах эсхүл гэрээний хугацаа дууссан бол шинэ маягтын дагуу даатгуулагчтай гэрээг шинээр байгуулна.

2.5.Нийгмийн даатгалын байгууллага нь гэрээний хугацаа нь дуусаж, сунгалт хийгдээгүй, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, нас барсан сайн дураар даатгуулагчийн гэрээг дуусгавар болгож, шимтгэл төлөлтийн тооцоог эцэслэн дуусгаж, хувийн хэрэг, холбогдох баримт бичгийг архивт шилжүүлэн хадгална.

2.6.Сайн дурын даатгалд даатгуулсан хугацаанд хөдөлмөрийн гэрээгээр ажилласан тохиолдолд сайн дурын даатгалын шимтгэлийг даатгуулагчид буцаан олгоно. Даатгуулагчийн илүү төлсөн шимтгэлийг буцаан олгох, эсхүл дараагийн сар, улирал, жилийн төлбөл зохих шимтгэлд шилжүүлэн тооцоход нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан “Илүү төлсөн шимтгэлийг буцаан олгох харилцааг зохицуулсан журам”-ыг баримтална.

2.7.Гэрээний хугацаанд нийгмийн даатгалын байгууллага хооронд шилжих хүсэлт гаргасан даатгуулагчийн шимтгэл төлөлтийн тооцоог бүрэн хийснээр уг хүсэлтийг шийдвэрлэж, сайн дурын даатгалын хувийн хэрэг, холбогдох баримт бичгийг шилжүүлсэн нийгмийн даатгалын байгууллагын архивт хадгална.

2.8.Даатгуулагч урьд нь байгуулсан гэрээний хугацаа дуусахаас өмнө нийгмийн даатгалын байгууллага хооронд шилжиж ирсэн тохиолдолд даатгуулагчийг өмнөх гэрээнд заасан нөхцөлөөр нь шимтгэлийг үргэлжлүүлэн төлүүлж, шилжиж ирсэн нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) хувийн хэрэг нээж холбогдох тооцоог хийнэ.

2.9.Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь даатгуулагчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг бэлэн мөнгөөр авахыг хориглоно.

Гурав. Даатгуулагч эхийн эрх, хүлээх үүрэг

3.1.Даатгуулагч нь гэрээний хугацаанд мөрдөгдөх нийгмийн даатгалын шимтгэл тооцох сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоо өөрөө тодорхойлж, түүнд ногдох шимтгэлийг энэхүү гэрээний 1.7-д заасан хувь хэмжээгээр тооцож, 1.9-д заасан хугацаагаар бэлэн бусаар нийгмийн даатгалын санд төлнө.

3.2.Даатгуулагч шимтгэлээ энэ гэрээний 1.9-д заасан хугацаандаа төлөөгүй, эсвэл дутуу төлсөн тохиолдолд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 44.1.2-т

заасны дагуу дутуу төлсөн буюу хугацаандаа төлөөгүй, дутуу төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлж, уг шимтгэлийн дүнгээс хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 0.3 хувийн алданги төлнө. Өмнө нь дуусгавар болсон гэрээний хугацаанд шимтгэлээ бүрэн төлөөгүй даатгуулагчийн тухайн төлөгдөөгүй хугацааны шимтгэлийг нөхөн төлүүлэхгүй.

3.3.Гэрээний хугацаанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ өөрчлөгдөн батлагдаж хэрэгжиж эхлэх хугацаанаас даатгуулагчийн мэдүүлсэн шимтгэл төлөх сарын цалин хөлс нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага тохиолдолд даатгуулагч нь гэрээний 1.6-д заасан шимтгэл ногдуулж төлөх сарын цалин хөлсийг шинэчлэн батлагдсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр өөрчлүүлж, үүнээс үүссэн шимтгэлийн зөрүүг даатгалын санд нөхөж төлнө.

3.4.Сайн дурын даатгуулагч нь Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээгээр ажилласан бол албан журмаар даатгуулж давхар шимтгэл төлж болно. Бусад тохиолдолд албан журмын даатгалтай давхардуулан сайн дураар даатгуулахгүй.

3.5.Даатгуулагч Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд заасан болзол, нөхцөлийг хангасан бол тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардал авах эрхтэй.

3.6.Даатгуулагч гэрээний хүчинтэй хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-7.5-д заасан албан журмаар даатгуулж ажилласан боловч энэхүү гэрээний 1.5-д заасан хугацаа дуусахаас өмнө албан журмын харилцаа дуусгавар болсон бол уг гэрээг үргэлжлүүлэн нийгмийн даатгалын шимтгэл төлж, даатгуулж болно. Хэрэв сайн дурын даатгалын гэрээний хугацаа дуусахад албан журмаар даатгуулагчийн харилцаа үргэлжилсэн хэвээр байвал гэрээг үргэлжлүүлэн сунгахгүй, 1.5-д заасан хугацаагаар дуусгавар болсонд тооцно.

Дөрөв.Гэрээ дуусгавар болгох, хүчингүйд тооцох

4.1.Даатгуулагчийн гэрээний хугацаа дараах тохиолдолд дуусгавар болно:

4.1.1.гэрээгээр тохирсон хугацаа дуусгавар болсон;

4.1.2.даатгуулагч гэрээний хугацааг дуустал хугацаагаар хөдөлмөрийн гэрээгээр ажил хөдөлмөр эрхэлсэн бол тухайн сараас;

4.1.3.гэрээний хугацаанд дахин хүүхэд төрүүлж, шинээр төрсөн хүүхдийн мэдээллээр гэрээг шинэчлэх хүсэлт гаргасан сараас;

4.1.4.Хүүхэд нь 3 насанд хүрсэн эсхүл 3 нас хүрээгүй байхдаа бусдад үрчлэгдсэн, нас барсан бол түүний дараагийн сараас;

4.1.5.өндөр насны тэтгэвэр тогтоолгосон сараас;

4.1.6.даатгуулагч нас барсан сараас.

4.2.Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах гэрээг дараах тохиолдолд хүчингүйд тооцно:

4.2.1.гэрээг хуурамчаар үйлдсэн нь тогтоогдсон бол;

4.2.2.гэрээг 2 талын аль нэг нь зөвшөөрөөгүй бол.

Тав. Маргааныг шийдвэрлэх, хүлээх хариуцлага

5.1.Гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдсон маргаантай асуудлыг хоёр тал харилцан зөвшилцөн шийдвэрлэх зарчим баримтлах бөгөөд шаардлагатай бол Маргаан хянан шийдвэрлэх зөвлөл, эсхүл шүүхээр шийдвэрлүүлнэ.

5.2.Энэхүү гэрээгээр хүлээсэн үүрэг болон нийгмийн даатгалын хууль тогтоомжийг зөрчвөл холбогдох хуульд заасны дагуу зохих хариуцлага хүлээнэ.

Зургаа.Бусад

6.1.Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж нэг хувийг Нийгмийн даатгалын байгууллагад, нөгөө хувийг гэрээ байгуулсан даатгуулагчид өгөх ба хувь тус бүр хүчин төгөлдөр байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Нийгмийн даатгалын байгууллагыг төлөөлж:	Даатгуулагч эхийг төлөөлж:
.....аймаг /дүүрэг/, сумын нийгмийн даатгалын байцаагч	..... аймаг /дүүрэг/, сумын .....хороо /баг/-ын оршин суугч
..... / ...../	..... / ...../
/гарын үсэг/ /гарын үсгийн тайлал/	/гарын үсэг/ /гарын үсгийн тайлал/
Утас:	Утас: ..... Утас:.....
Э-шуудангийн хаяг:	Э-шуудангийн хаяг: .....
202 . . . оны . . . сарын . . . өдөр	202 . . . оны . . . сарын . . . өдөр

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/ 800 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

МАЛЧИН, ТУСЛАХ МАЛЧНЫ НИЙГМИЙН ДААТГАЛД САЙН ДУРААР ДААТГУУЛСАН ТУХАЙ ГЭРЭЭ

Дугаар . . . . . .

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасны дагуу нийгмийн даатгалд сайн дураар даатгахаар нэг талаас..... аймаг (хот)-ийн ..... дүүрэг (сум)-ийн нийгмийн даатгалын газар (тасаг)-ийг төлөөлж, байцаагч ..... эцэг (эх)-ийн нэр .....өөрийн нэр (цаашид "нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)" гэх), нөгөө талаас иргэн .....эцэг (эх)-ийн нэр ..... өөрийн нэр (цаашид "даатгуулагч" гэх) нар (цаашид "талууд" гэх) харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

1.2.Даатгуулагчийн иргэний бүртгэлийн дугаар:

1.3. Даатгуулагчийн төрөл: (тохирох хэсгийн ард (√) тэмдэглэнэ

1.	Малчин (малчин өрхийн мал маллаж буй гишүүн)	
2.	Туслах малчин	

Нийгмийн даатгалын шимтгэл ногдуулж төлөх орлогын хэмжээ, хувь, хугацаа

1.4.Гэрээний хугацаа нь 1-12 сар байна: ..... сар

Тайлбар: Улсын төсвөөс хариуцан төлөх нийт хугацаа 5 жил байна.

1.5.Гэрээний хүчинтэй байх хугацаа: ....

/эхлэх/ (он, сар, өдөр) /дуусах/ (он, сар, өдөр)

1.6.Нийгмийн даатгалын шимтгэл ногдуулж төлөх сарын хөдөлмөрийн хөлс, орлого: . . . . төгрөг.

Түүнд ногдуулж сар бүр өөрөө хариуцан төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн дүн: ..... төгрөг

Улсын төсвөөс хариуцан сард төлөх дүн ..... төгрөг байна.

1.6.1.Даатгуулагчийн энэхүү гэрээний 1.6-д заасан өөрөө мэдүүлсэн шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын цалин хөлсний доод хэмжээ нь тухайн мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй, дээд хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 7 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна. Гэрээний хугацаанд хөдөлмөрийн хөлсний доод

хэмжээ эрх бүхий байгууллагын шийдвэрээр шинэчлэн тогтоогдсон тохиолдолд уг шийдвэрийг хэрэгжих хугацаанаас нь эхлэн дагаж, мөрдөнө.

1.6.2.Гэрээний 1.6-д заасан орлого нь шинэчлэн баталсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага тохиолдолд уг шийдвэрийг дагаж мөрдөх хугацаанаас эхлэн өөрчлөгдсөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр, дээд хэмжээ нь багассан тохиолдолд шинэчлэгдсэн дээд хэмжээгээр өөрчлөгдсөнд тооцно.

1.6.3.Энэ гэрээний 1.6-д заасан нийгмийн даатгалын шимтгэл ногдуулж, төлж буй сарын цалин хөлсний хэмжээ нь энэхүү гэрээний 1.6.2-т зааснаас бусад тохиолдолд өөрчлөгдөхгүй.

1.7.Энэ гэрээний 1.6-д заасан сарын цалин хөлснөөс тэтгэврийн даатгалын санд 11.5 хувь, тэтгэмжийн даатгалын санд 1.0 хувь, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд 1.0 хувиар тооцож нийт 13.5 хувийн нийгмийн даатгалын шимтгэл төлнө.

1.8.Гэрээний хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт орж, энэ гэрээний 1.7-д заасан шимтгэлийн хувь хэмжээ өөрчлөгдсөн тохиолдолд уг хуулийн хэрэгжих хугацаанаас эхлэн шинээр тогтоосон хувь хэмжээгээр тооцож шимтгэлийг төлөх бөгөөд үүнээс үүсэх шимтгэлийн зөрүүг тухайн даатгуулагч хариуцаж санд нөхөн төлнө.

1.9.Даатгуулагч энэ гэрээний 1.6-д заасан цалин хөлснөөс мөн гэрээний 1.7-д заасан хувь хэмжээгээр тооцсон нийгмийн даатгалын шимтгэлийг даатгалын санд сар бүр төлөх үүрэг хүлээх бөгөөд урьдчилан төлж болно.

1.10.Малчин, туслах малчнаар сайн дурын даатгалын гэрээ байгуулж буй даатгуулагч дараах бичиг баримтыг цаасаар болон цахимаар хавсаргана.

1.10.1.гэрээ байгуулахын өмнөх жилийн мал, тэжээвэр амьтад, малын хашаа, худгийн тооллогын маягт (цаашид “мал тооллогын “А” данс” гэх);

1.10.2.малчин өрхийн мал малладаг гишүүн бол малчин өрхийн бүртгэлд малчнаар бүртгэгдсэн баримт бичиг;

1.10.3.туслах малчин малчинтай байгуулсан хөдөлмөрийн гэрээ, малчны мал тооллогын А-данс.

1.11.Гэрээг цаасаар болон цахим хэлбэрээр байгуулж, сунгаж болно.

1.12.Энэхүү гэрээ нь даатгуулагчийн шилжүүлсэн шимтгэл нийгмийн даатгалын харилцах дансанд орсон сараас хэрэгжиж эхэлнэ. (Гэрээний сунгалт, өөрчлөлт нэгэн адил хамаарна).

1.13.Даатгуулагч өмнө нь байгуулсан гэрээний хугацаа дууссаны дараагийн сард багтаан шимтгэл төлсөн тохиолдолд гэрээний хугацааг өмнөх гэрээний нөхцөлөөр үргэлжлүүлэн сунгасанд тооцно. Даатгуулагч өмнө нь байгуулсан гэрээний нөхцөлөө өөрчлөх тохиолдолд хүсэлтээ нийгмийн даатгалын байгууллагад гаргаж холбогдох өөрчлөлтийг тусган гэрээний хугацааг сунгана.

1.14.Даатгуулагч гэрээний хугацаагаа сунгах хүсэлт гаргасан боловч өмнөх гэрээ дууссанаас хойш 1 ба түүнээс дээш сарын дараа шимтгэл төлсөн бол шимтгэл төлсөн сараас нь эхлэн гэрээг шинээр байгуулсанд тооцно. Гэрээг шимтгэл төлсөн сараас эхлэн үргэлжлүүлэн баталгаажуулж, уг шимтгэлийг нь зохих саруудад бүртгэж, нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд оруулна.

1.15.Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь батлагдсан маягтын дагуу даатгуулагчтай байгуулсан гэрээг 2 хувь үйлдэж, нийгмийн даатгалын байцаагч, даатгуулагч тус тус гарын үсэг зурснаар уг гэрээ баталгаажна. Даатгуулагч цахимаар гэрээ байгуулж буй тохиолдолд гэрээний нөхцөлтэйгөө танилцаж, "гэрээний нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна" сонголтыг сонгосноор байцаагч болон даатгуулагчийг уг гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулснаар тооцно.

1.16. Малчин болон малчин өрхийн мал маллаж буй гишүүнийг мал тооллогын "А" дансанд малчнаар бүртгэгдсэн нэр, регистр (иргэний бүртгэлийн дугаар), малчинтай ямар хамааралтайг нотлох баримт бичиг, туслах малчин, малчин хооронд байгуулсан хөлсөөр ажиллах гэрээ болон малчны мал тооллогын "А" дансны баримтыг байцаагч хянан, шалгаснаар гэрээ баталгаажна. Малчин гэдгийг нотлох баримт бичиг бүрдээгүй байхад шимтгэл төлсөн хугацааг тухайн даатгуулагчийг малчнаар даатгуулсан хугацаанд тооцохгүй.

Хоёр. Нийгмийн даатгалын байгууллага
(байцаагч)-ийн эрх, хүлээх үүрэг

2.1.Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь гэрээ хүчин төгөлдөр болсон сараас эхлэн энэ гэрээний 1.6-д заасан өөрөө хариуцан төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг бүрэн төлж буй эсэхэд хяналт тавих бөгөөд шимтгэлийн төлбөрийг бэлэн бусаар төлүүлнэ.

2.2.Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь сайн дураар даатгуулах болон гэрээний хугацааг сунгуулах тухай хүсэлтээ гаргасан даатгуулагч (иргэн)-ийг уг хүсэлт гаргасан сарын шимтгэлээ нийгмийн даатгалын сангийн харилцах дансанд төлсөн тохиолдолд түүнтэй нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан тухай гэрээг хэрэгжиж эхэлсэнд тооцож, нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, шимтгэл төлөлтийн тооцоог хийж хянасны үндсэн дээр баталгаажуулна.

2.3.Даатгуулагч шимтгэлээ энэ гэрээний 1.9-д тохирсон хугацаандаа төлөөгүй, эсвэл дутуу төлсөн тохиолдолд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 44.1.2-т заасны дагуу дутуу төлсөн буюу хугацаандаа төлөөгүй нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлж, уг шимтгэлийн дүнгээс хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 0.3 хувийн алданги ногдуулна. Өмнө нь дуусгавар болсон гэрээний хугацаанд шимтгэлээ бүрэн төлөөгүй даатгуулагчийн тухайн төлөгдөөгүй хугацааны шимтгэлийг нөхөн төлүүлэхгүй.

2.4.Тухайн жилд гэрээний маягт шинэчлэн батлагдсан тохиолдолд өмнө нь байгуулсан гэрээний хугацаанд гэрээг хуучин маягтаар нь үргэлжлүүлнэ. Харин гэрээг сунгах эсхүл гэрээний хугацаа дууссан бол шинэ маягтын дагуу даатгуулагчтай гэрээг шинээр байгуулна.

2.5.Нийгмийн даатгалын байгууллага нь гэрээний хугацаа нь дуусаж, сунгалт хийгдээгүй, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, нас барсан сайн дураар даатгуулагчийн гэрээг дуусгавар болгож, шимтгэл төлөлтийн тооцоог эцэслэн дуусгаж, хувийн хэрэг, холбогдох баримт бичгийг архивт шилжүүлэн хадгална.

2.6.Сайн дурын даатгалд даатгуулсан хугацаанд хөдөлмөрийн гэрээгээр ажилласан тохиолдолд сайн дурын даатгалын шимтгэлийг даатгуулагчид буцаан олгоно. Даатгуулагчийн илүү төлсөн шимтгэлийг буцаан олгох, эсхүл дараагийн сар, улирал, жилийн төлбөл зохих шимтгэлд шилжүүлэн тооцоход нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан “Илүү төлсөн шимтгэлийг буцаан олгох харилцааг зохицуулсан журам”-ыг баримтална.

2.7.Гэрээний хугацаанд нийгмийн даатгалын байгууллага хооронд шилжих хүсэлт гаргасан даатгуулагчийн шимтгэл төлөлтийн тооцоог бүрэн хийснээр уг хүсэлтийг шийдвэрлэж, сайн дурын даатгалын хувийн хэрэг, холбогдох баримт бичгийг шилжүүлсэн нийгмийн даатгалын байгууллагын архивт хадгална.

2.8.Даатгуулагч урьд нь байгуулсан гэрээний хугацаа дуусахаас өмнө нийгмийн даатгалын байгууллага хооронд шилжиж ирсэн тохиолдолд даатгуулагчийг өмнөх гэрээнд заасан нөхцөлөөр нь шимтгэлийг үргэлжлүүлэн төлүүлж, шилжиж ирсэн нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) хувийн хэрэг нээж холбогдох тооцоог хийнэ.

2.9.Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь даатгуулагчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг бэлэн мөнгөөр авахыг хориглоно.

Гурав. Даатгуулагчийн эрх, хүлээх үүрэг

3.1.Даатгуулагч нь энэ гэрээний 1.10-д заасан малчин, туслах малчныг нотлох холбогдох баримт бичгийг үнэн зөв бүрдүүлж өгнө.

3.2.Даатгуулагч нь гэрээний хугацаанд мөрдөгдөх нийгмийн даатгалын шимтгэл тооцох сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоо өөрөө тодорхойлж, түүнд ногдох шимтгэлийг энэхүү гэрээний 1.7-д заасан хувь хэмжээгээр тооцож, 1.9-д заасан хугацаагаар бэлэн бусаар нийгмийн даатгалын санд төлнө.

3.3.Даатгуулагч шимтгэлээ энэ гэрээний 1.9-д заасан хугацаандаа төлөөгүй, эсвэл дутуу төлсөн тохиолдолд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 44.1.2-т заасны дагуу дутуу төлсөн буюу хугацаандаа төлөөгүй, дутуу төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлж, уг шимтгэлийн дүнгээс хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 0.3 хувийн алданги төлнө. Өмнө нь дуусгавар болсон гэрээний хугацаанд шимтгэлээ

бүрэн төлөөгүй даатгуулагчийн тухайн төлөгдөөгүй хугацааны шимтгэлийг нөхөн төлүүлэхгүй.

3.4.Гэрээний хугацаанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ өөрчлөгдөн батлагдаж хэрэгжиж эхлэх хугацаанаас даатгуулагчийн мэдүүлсэн шимтгэл төлөх сарын цалин хөлс нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага тохиолдолд даатгуулагч нь гэрээний 1.6-д заасан шимтгэл ногдуулж төлөх сарын цалин хөлсийг шинэчлэн батлагдсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр өөрчлүүлж, үүнээс үүссэн шимтгэлийн зөрүүг даатгалын санд нөхөж төлнө.

3.5. Сайн дурын даатгуулагч нь Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээгээр ажилласан бол албан журмаар даатгуулж давхар шимтгэл төлж болно. Бусад тохиолдолд албан журмын даатгалтай давхардуулан сайн дураар даатгуулахгүй.

3.6.Даатгуулагч Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд заасан болзол, нөхцөлийг хангасан бол тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардал авах эрхтэй.

3.7.Даатгуулагч гэрээний хүчинтэй хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-7.5-д заасан албан журмаар даатгуулж ажилласан боловч энэхүү гэрээний 1.5-д заасан хугацаа дуусахаас өмнө албан журмын харилцаа дуусгавар болсон бол уг гэрээг үргэлжлүүлэн нийгмийн даатгалын шимтгэл төлж, даатгуулж болно. Хэрэв сайн дурын даатгалын гэрээний хугацаа дуусахад албан журмаар даатгуулагчийн харилцаа үргэлжилсэн хэвээр байвал гэрээг үргэлжлүүлэн сунгахгүй, 1.5-д заасан хугацаагаар дуусгавар болсонд тооцно.

Дөрөв.Гэрээ дуусгавар болгох, хүчингүйд тооцох

4.1.Даатгуулагчийн гэрээний хугацаа дараах тохиолдолд дуусгавар болно:

4.1.1.гэрээгээр тохирсон хугацаа дуусгавар болсон;

4.1.2.даатгуулагч гэрээний хугацааг дуустал хугацаагаар хөдөлмөрийн гэрээгээр ажил хөдөлмөр эрхэлсэн бол тухайн сараас;

4.1.3.малчнаас өөр хэлбэрээр ажил эрхэлсэн сараас;

4.1.4.туслах малчны гэрээ цуцлагдсан, гэрээний хугацаа дууссан дараагийн сараас;

4.1.5.өндөр насны тэтгэвэр тогтоолгосон сараас;

4.1.6.даатгуулагч нас барсан сараас.

4.2.Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах гэрээг дараах тохиолдолд хүчингүйд тооцно:

4.2.1.гэрээг хуурамчаар үйлдсэн нь тогтоогдсон бол;

4.2.2.гэрээг 2 талын аль нэг нь зөвшөөрөөгүй бол.

Тав. Маргааныг шийдвэрлэх, хүлээх хариуцлага

5.1.Гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдсон маргаантай асуудлыг хоёр тал харилцан зөвшилцөн шийдвэрлэх зарчим баримтлах бөгөөд шаардлагатай бол Маргаан хянан шийдвэрлэх зөвлөл, эсхүл шүүхээр шийдвэрлүүлнэ.

5.2.Энэхүү гэрээгээр хүлээсэн үүрэг болон Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг зөрчвөл холбогдох хуульд заасны дагуу зохих хариуцлага хүлээнэ.

Зургаа.Бусад

6.1.Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж нэг хувийг Нийгмийн даатгалын байгууллагад, нөгөө хувийг гэрээ байгуулсан даатгуулагчид өгөх ба хувь тус бүр хүчин төгөлдөр байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Нийгмийн даатгалын байгууллагыг төлөөлж:	Даатгуулагчийг төлөөлж:
.....аймаг /дүүрэг/, сумын нийгмийн даатгалын байцаагч	..... аймаг /дүүрэг/, сумын .....хороо /баг/-ын оршин суугч
..... / ...../	..... / ...../
/гарын үсэг/ /гарын үсгийн тайлал/	/гарын үсэг/ /гарын үсгийн тайлал/
Утас:	Утас: ..... Утас:.....
Э-шуудангийн хаяг:	Э-шуудангийн хаяг: .....
202 . . . оны . . . сарын . . . өдөр	202 . . . оны . . . сарын . . . өдөр

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/200 дугаар тушаалын тавдугаар хавсралт

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДЭЭ АСАРЧ БАЙГАА АЖИЛ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЭГҮЙ ЭХ /ЭЦЭГ/-ИЙН НИЙГМИЙН ДААТГАЛД САЙН ДУРААР ДААТГУУЛСАН ТУХАЙ ГЭРЭЭ

Дугаар . . . . . .

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасны дагуу нийгмийн даатгалд сайн дураар даатгахаар нэг талаас..... аймаг (хот)-ийн ..... дүүрэг (сум)-ийн нийгмийн даатгалын газар (тасаг)-ийг төлөөлж, байцаагч ..... эцэг (эх)-ийн нэр .....өөрийн нэр (цаашид “нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)” гэх), нөгөө талаас иргэн .....эцэг (эх)-ийн нэр ..... өөрийн нэр (цаашид “даатгуулагч” гэх) нар (цаашид “талууд” гэх) харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

1.2.Даатгуулагчийн иргэний бүртгэлийн дугаар:

1.3. 18 хүртэлх насны хүүхдийн регистрийн дугаар

1.4.Даатгуулагчийн төрөл:

1.	Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч ажил хөдөлмөр эрхлээгүй эх /эцэг/	

Нийгмийн даатгалын шимтгэл ногдуулж төлөх орлогын хэмжээ, хувь, хугацаа

1.5.Гэрээний хүчинтэй байх хугацаа: . . . .

/эхлэх / (он, сар,өдөр) /дуусах/ (он, сар,өдөр)

Тайлбар: Гэрээний хугацаа нь гэрээ байгуулсан сараас эхлэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тодорхойлолтод заасан хугацаагаар байна.

1.6.Нийгмийн даатгалын шимтгэл ногдуулж төлөх сарын хөдөлмөрийн хөлс, орлого: . . . . төгрөг.

Түүнд ногдуулж сар бүр өөрөө хариуцан төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн дүн: ..... төгрөг

Улсын төсвөөс хариуцан сард төлөх дүн ..... төгрөг байна.

1.6.1.Даатгуулагчийн энэхүү гэрээний 1.6-д заасан өөрөө мэдүүлсэн шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын цалин хөлсний доод хэмжээ нь тухайн мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй, дээд хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 7 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна. Гэрээний хугацаанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ эрх бүхий байгууллагын шийдвэрээр шинэчлэн тогтоогдсон тохиолдолд уг шийдвэрийг хэрэгжих хугацаанаас нь эхлэн дагаж, мөрдөнө.

1.6.2.Гэрээний 1.6-д заасан орлого нь шинэчлэн баталсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага тохиолдолд уг шийдвэрийг дагаж мөрдөх хугацаанаас эхлэн өөрчлөгдсөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр, дээд хэмжээ нь багассан тохиолдолд шинэчлэгдсэн дээд хэмжээгээр өөрчлөгдсөнд тооцно.

1.6.3.Энэ гэрээний 1.6-д заасан нийгмийн даатгалын шимтгэл ногдуулж, төлж буй сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээ нь энэхүү гэрээний 1.6.2-т зааснаас бусад тохиолдолд 12 сарын дотор өөрчлөгдөхгүй.

1.6.4.Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээг гэрээ байгуулснаас хойш 12 сар тутамд нэг удаа өөрчилж болно.

1.7.Энэ гэрээний 1.6-д заасан сарын цалин хөлснөөс тэтгэврийн даатгалын санд 11.5 хувь, тэтгэмжийн даатгалын санд 1.0 хувь, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд 1.0 хувиар тооцож нийт 13.5 хувийн нийгмийн даатгалын шимтгэл төлнө.

1.8.Гэрээний хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт орж, энэ гэрээний 1.7-д заасан шимтгэлийн хувь хэмжээ өөрчлөгдсөн тохиолдолд уг хуулийн хэрэгжих хугацаанаас эхлэн шинээр тогтоосон хувь хэмжээгээр тооцож шимтгэлийг төлөх бөгөөд үүнээс үүсэх шимтгэлийн зөрүүг тухайн даатгуулагч хариуцаж санд нөхөн төлнө.

1.9.Даатгуулагч энэ гэрээний 1.6-д заасан цалин хөлснөөс мөн гэрээний 1.7-д заасан хувь хэмжээгээр тооцсон нийгмийн даатгалын шимтгэлийг даатгалын санд сар бүр төлөх үүрэг хүлээх бөгөөд урьдчилан төлж болно.

1.10.Гэрээг цаасаар болон цахим хэлбэрээр байгуулж, сунгаж болно.

1.11.Даатгуулагч гэрээг байгуулах хүсэлтийн дагуу сард ногдох шимтгэлээ төлснөөр, төлбөр төлсөн сараас эхлэн уг гэрээг хэрэгжиж эхэлсэнд тооцно. (Гэрээний сунгалт, өөрчлөлт нэгэн адил хамаарна).

1.12.Даатгуулагч энэхүү гэрээнд заасан төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлээ санд бүрэн төлж дууссан тохиолдолд гэрээний хугацааг сунгуулах тухай

хүсэлтээ нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)-д өөрийн биеэр эсхүл цахимаар гаргаж болно.

1.13.Даатгуулагч өмнө нь байгуулсан гэрээний хугацаа дууссаны дараагийн сард багтаан шимтгэл төлсөн тохиолдолд гэрээний хугацааг өмнөх гэрээний нөхцөлөөр үргэлжлүүлэн сунгасанд тооцно. Даатгуулагч өмнө нь байгуулсан гэрээний нөхцөлөө өөрчлөх тохиолдолд хүсэлтээ нийгмийн даатгалын байгууллагад гаргаж холбогдох өөрчлөлтийг тусган гэрээний хугацааг сунгана.

1.14.Даатгуулагч гэрээний хугацаагаа сунгах хүсэлт гаргасан боловч өмнөх гэрээ дууссанаас хойш 1 ба түүнээс дээш сарын дараа шимтгэл төлсөн бол шимтгэл төлсөн сараас нь эхлэн гэрээг шинээр байгуулсанд тооцно. Гэрээг шимтгэл төлсөн сараас эхлэн үргэлжлүүлэн баталгаажуулж, уг шимтгэлийг нь зохих саруудад бүртгэж, нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд оруулна.

1.15.Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь батлагдсан маягтын дагуу даатгуулагчтай байгуулсан гэрээг 2 хувь үйлдэж, нийгмийн даатгалын байцаагч, даатгуулагч тус тус гарын үсэг зурснаар уг гэрээ баталгаажна. Даатгуулагч цахимаар гэрээ байгуулж буй тохиолдолд гэрээний нөхцөлтэйгөө танилцаж, “гэрээний нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна” сонголтыг сонгосноор байцаагч болон даатгуулагчийг уг гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулснаар тооцно.

Хоёр. Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)-ийн эрх, хүлээх үүрэг

2.1.Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь гэрээ хүчин төгөлдөр болсон сараас эхлэн энэ гэрээний 1.6-д заасан өөрөө хариуцан төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг бүрэн төлж буй эсэхэд хяналт тавих бөгөөд шимтгэлийн төлбөрийг бэлэн бусаар төлүүлнэ.

2.2.Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь сайн дураар даатгуулах болон гэрээний хугацааг сунгуулах тухай хүсэлтээ гаргасан даатгуулагч (иргэн)-ийг уг хүсэлт гаргасан сарын шимтгэлээ нийгмийн даатгалын сангийн харилцах дансанд төлсөн тохиолдолд түүнтэй нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан тухай гэрээг хэрэгжиж эхэлсэнд тооцож, нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, шимтгэл төлөлтийн тооцоог хийж хянасны үндсэн дээр баталгаажуулна.

2.3.Даатгуулагч шимтгэлээ энэ гэрээний 1.9-д тохирсон хугацаандаа төлөөгүй, эсвэл дутуу төлсөн тохиолдолд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 44.1.2-т заасны дагуу дутуу төлсөн буюу хугацаандаа төлөөгүй нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлж, уг шимтгэлийн дүнгээс хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 0.3 хувийн алданги ногдуулна. Өмнө нь дуусгавар болсон гэрээний хугацаанд шимтгэлээ бүрэн төлөөгүй даатгуулагчийн тухайн төлөгдөөгүй хугацааны шимтгэлийг нөхөн төлүүлэхгүй.

2.4.Тухайн жилд гэрээний маягт шинэчлэн батлагдсан тохиолдолд өмнө нь байгуулсан гэрээний хугацаанд гэрээг хуучин маягтаар нь үргэлжлүүлнэ. Харин гэрээг сунгах эсхүл гэрээний хугацаа дууссан бол шинэ маягтын дагуу даатгуулагчтай гэрээг шинээр байгуулна.

2.5.Нийгмийн даатгалын байгууллага нь гэрээний хугацаа нь дуусаж, сунгалт хийгдээгүй, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, нас барсан сайн дураар даатгуулагчийн гэрээг дуусгавар болгож, шимтгэл төлөлтийн тооцоог эцэслэн дуусгаж, хувийн хэрэг, холбогдох баримт бичгийг архивт шилжүүлэн хадгална.

2.6.Сайн дурын даатгалд даатгуулсан хугацаанд хөдөлмөрийн гэрээгээр ажилласан тохиолдолд сайн дурын даатгалын шимтгэлийг даатгуулагчид буцаан олгоно. Даатгуулагчийн илүү төлсөн шимтгэлийг буцаан олгох, эсхүл дараагийн сар, улирал, жилийн төлбөл зохих шимтгэлд шилжүүлэн тооцоход нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан “Илүү төлсөн шимтгэлийг буцаан олгох харилцааг зохицуулсан журам”-ыг баримтална.

2.7.Гэрээний хугацаанд нийгмийн даатгалын байгууллага хооронд шилжих хүсэлт гаргасан даатгуулагчийн шимтгэл төлөлтийн тооцоог бүрэн хийснээр уг хүсэлтийг шийдвэрлэж, сайн дурын даатгалын хувийн хэрэг, холбогдох баримт бичгийг шилжүүлсэн нийгмийн даатгалын байгууллагын архивт хадгална.

2.8.Даатгуулагч урьд нь байгуулсан гэрээний хугацаа дуусахаас өмнө нийгмийн даатгалын байгууллага хооронд шилжиж ирсэн тохиолдолд даатгуулагчийг өмнөх гэрээнд заасан нөхцөлөөр нь шимтгэлийг үргэлжлүүлэн төлүүлж, шилжиж ирсэн нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) хувийн хэрэг нээж холбогдох тооцоог хийнэ.

2.9.Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь даатгуулагчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг бэлэн мөнгөөр авахыг хориглоно.

Гурав. Даатгуулагчийн эрх, хүлээх үүрэг

3.1.Даатгуулагч нь гэрээний хугацаанд мөрдөгдөх нийгмийн даатгалын шимтгэл тооцох сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоо өөрөө тодорхойлж, түүнд ногдох шимтгэлийг энэхүү гэрээний 1.7-д заасан хувь хэмжээгээр тооцож, 1.9-д заасан хугацаагаар бэлэн бусаар нийгмийн даатгалын санд төлнө.

3.2.Даатгуулагч шимтгэлээ энэ гэрээний 1.9-д заасан хугацаандаа төлөөгүй, эсвэл дутуу төлсөн тохиолдолд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 44.1.2-т заасны дагуу дутуу төлсөн буюу хугацаандаа төлөөгүй, дутуу төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлж, уг шимтгэлийн дүнгээс хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 0.3 хувийн алданги төлнө. Өмнө нь дуусгавар болсон гэрээний хугацаанд шимтгэлээ бүрэн төлөөгүй даатгуулагчийн тухайн төлөгдөөгүй хугацааны шимтгэлийг нөхөн төлүүлэхгүй.

3.3.Гэрээний хугацаанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ өөрчлөгдөн батлагдаж хэрэгжиж эхлэх хугацаанаас даатгуулагчийн мэдүүлсэн шимтгэл төлөх сарын цалин хөлс нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага тохиолдолд даатгуулагч нь гэрээний 1.6-д заасан шимтгэл ногдуулж төлөх сарын цалин хөлсийг шинэчлэн батлагдсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр өөрчлүүлж, үүнээс үүссэн шимтгэлийн зөрүүг даатгалын санд нөхөж төлнө.

3.4.Сайн дурын даатгуулагч нь Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээгээр ажилласан бол албан журмаар даатгуулж давхар шимтгэл төлж болно. Бусад тохиолдолд албан журмын даатгалтай давхардуулан сайн дураар даатгуулахгүй.

3.5.Даатгуулагч Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд заасан болзол, нөхцөлийг хангасан бол тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардал авах эрхтэй.

3.6.Даатгуулагч гэрээний хүчинтэй хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-7.5-д заасан албан журмаар даатгуулж ажилласан боловч энэхүү гэрээний 1.5-д заасан хугацаа дуусахаас өмнө албан журмын харилцаа дуусгавар болсон бол уг гэрээг үргэлжлүүлэн нийгмийн даатгалын шимтгэл төлж, даатгуулж болно. Хэрэв сайн дурын даатгалын гэрээний хугацаа дуусахад албан журмаар даатгуулагчийн харилцаа үргэлжилсэн хэвээр байвал гэрээг үргэлжлүүлэн сунгахгүй, 1.5-д заасан хугацаагаар дуусгавар болсонд тооцно.

Дөрөв.Гэрээ дуусгавар болгох,
хүчингүйд тооцох

4.1.Даатгуулагчийн гэрээний хугацаа дараах тохиолдолд дуусгавар болно:

4.1.1.гэрээгээр тохирсон хугацаа дуусгавар болсон;

4.1.2.даатгуулагч гэрээний хугацааг дуустал хугацаагаар хөдөлмөрийн гэрээгээр ажил хөдөлмөр эрхэлсэн бол тухайн сараас;

4.1.3.байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тодорхойлолтын хугацаа дуусгавар болсон, цуцлагдсан, 18 нас хүрсэн эсхүл 18 нас хүрээгүй байхдаа бусдад үрчлэгдсэн, нас барсан бол түүний дараагийн сараас;

4.1.4.өндөр насны тэтгэвэр тогтоолгосон сараас;

4.1.5.даатгуулагч нас барсан сараас.

4.2.Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах гэрээг дараах тохиолдолд хүчингүйд тооцно:

4.2.1.гэрээг хуурамчаар үйлдсэн нь тогтоогдсон бол;

4.2.2.гэрээг 2 талын аль нэг нь зөвшөөрөөгүй бол.

Тав. Маргааныг шийдвэрлэх, хүлээх хариуцлага

5.1.Гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдсон маргаантай асуудлыг хоёр тал харилцан зөвшилцөн шийдвэрлэх зарчим баримтлах бөгөөд шаардлагатай бол Маргаан хянан шийдвэрлэх зөвлөл, эсхүл шүүхээр шийдвэрлүүлнэ.

5.2.Энэхүү гэрээгээр хүлээсэн үүрэг болон нийгмийн даатгалын хууль тогтоомжийг зөрчвөл холбогдох хуульд заасны дагуу зохих хариуцлага хүлээнэ.

Зургаа.Бусад

6.1.Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж нэг хувийг Нийгмийн даатгалын байгууллагад, нөгөө хувийг гэрээ байгуулсан даатгуулагчид өгөх ба хувь тус бүр хүчин төгөлдөр байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Нийгмийн даатгалын байгууллагыг төлөөлж:	Даатгуулагчийг төлөөлж:
.....аймаг /дүүрэг/, сумын нийгмийн даатгалын байцаагч	..... аймаг /дүүрэг/, сумын .....хороо /баг/-ын оршин суугч
..... / ...../	..... / ...../
/гарын үсэг/ /гарын үсгийн тайлал/	/гарын үсэг/ /гарын үсгийн тайлал/
Утас:	Утас: ..... Утас:.....
Э-шуудангийн хаяг:	Э-шуудангийн хаяг: .....
202 . . . оны . . . сарын . . . өдөр	202 . . . оны . . . сарын . . . өдөр

МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 31 өдөр Дугаар А/113 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэг, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, хадгалах, ашиглах, мэдээлэлд хяналт тавих, нууцлал, аюулгүй байдлыг хангах журмыг нэгдүгээр, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний мэдээллийн санг бүрдүүлэх, боловсруулах, түгээх, ашиглах, хянах, хадгалах, хамгаалах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Б.Батжаргал), хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Л.Мөнхзул)-т тус тус үүрэг болгосугай.

Х.БУЛГАНТУЯА

151240350
D: 2024 on 05 sar tushaal

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2024 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн
А/113 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГ БҮРДҮҮЛЭХ, АШИГЛАХ, НУУЦЛАЛ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмаар нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сан (цаашид "мэдээллийн нэгдсэн сан" гэх)-г бүрдүүлэх, ашиглах, мэдээлэлд хяналт тавих, хадгалах, нууцлал, аюулгүй байдлыг хангах, мэдээллийн нэгдсэн сангаас ажил олгогч, даатгуулагч, хүн, хуулийн этгээдэд лавлагаа, тодорхойлолт, мэдээлэл гаргах, дамжуулах, үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2.Нийгмийн даатгалын ерөнхий газар, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газар, гадаад улстай байгуулсан Монгол Улсын нийгмийн хамгааллын олон улсын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий нийгмийн даатгалын байгууллагын салбар нэгж, сум, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, тасаг, байцаагч, ажилтан (цаашид "нийгмийн даатгалын байгууллага" гэх) үйл ажиллагаандаа энэ журмыг мөрдөж ажиллана.

Хоёр.Мэдээллийн нэгдсэн сангийн бүрэлдэхүүн

2.1.Мэдээллийн нэгдсэн сан нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасан мэдээллийг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасны дагуу болон нийгмийн даатгалын хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан дүрэм, журмын дагуу бүрдүүлсэн дараах мэдээллээс тус тус бүрдэнэ. Үүнд:

2.1.1.Шимтгэл төлөгч ажил олгогч, даатгуулагчийн, тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр авагчийн, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын, шимтгэлийн хөнгөлөлт авсан ажил олгогчийн, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны болон холбогдох бусад мэдээлэл;

2.1.2.Ажил олгогчийн шимтгэл төлөлт, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тоо, мэдээлэл, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн болон эрсдэлийн үнэлгээ, ажил олгогчид үзүүлсэн хөнгөлөлт, чөлөөлөлт, даатгуулагчид олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөр болон холбогдох бусад мэдээлэл;

2.2.Нийгмийн даатгалын үйлчилгээг үзүүлэхэд мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдээгүй, шаардлагатай баримт бичгийг ажил олгогч, даатгуулагчаас цаасан эсхүл цахим хэлбэрээр авч болно.

2.3.Нийгмийн даатгалын байгууллага мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл бүртгэх, мэдээллийг үнэн зөв бүрдүүлэх, баяжуулах үүргийг хэрэгжүүлнэ.

Гурав.Мэдээллийн нэгдсэн санг ашиглах, үйлчилгээ үзүүлэх

3.1.Нийгмийн даатгалын байгууллага Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд мэдээллийн нэгдсэн санг ашиглаж, үйлчилгээ үзүүлнэ.

3.2.Нийгмийн даатгалын байгууллага мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэлд үндэслэн ажил олгогч, даатгуулагчид дараах лавлагаа, тодорхойлолт, мэдээллийг цахим эсхүл цаасан хэлбэрээр олгоно. Үүнд:

3.2.1.ажил олгогчид:

3.2.1.а.ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт.

3.2.2.даатгуулагчид:

3.2.2.а.нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт;

3.2.2.б.нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй тухай тодорхойлолт;

3.2.2.в.тэтгэврийн даатгалын нэрийн дансны лавлагаа;

3.2.2.г.өндөр насны тэтгэвэр тогтоолтын хуудас;

3.2.2.д.тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолтын хуудас;

3.2.2.е.хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэвэр тогтоолтын хуудас;

3.2.2.ё.хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон акт.

3.3.Ажил олгогч, даатгуулагч нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй, өөрт хамааралтай энэ журмын 3.2-т зааснаас бусад мэдээллийг цахим эсхүл цаасан хэлбэрээр авч болно.

3.4.Ажил олгогч, даатгуулагч нь энэ журмын 3.2-т заасан лавлагаа, тодорхойлолтыг бусдаар төлөөлүүлэн авах эрхтэй бөгөөд төлөөлөх бүрэн эрх олгосон итгэмжлэл нь Иргэний хуулийн 64 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байвал зохино.

3.5.Энэ журмын 3.2-т заасан лавлагаа, тодорхойлолтыг цаасаар олгохдоо QR код бүхий тодорхойлолт эсхүл Нийгмийн даатгалын ерөнхий газрын Тамгын газрын дарга, Санхүү бүртгэлийн газрын дарга, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын даргын гарын үсгээр баталгаажуулна.

3.6.Мэдээллийн нэгдсэн сангаас дараах мэдээллийг нээлттэй өгөгдөл болгон цахим хуудас болон төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системд нийтэлнэ. Үүнд:

3.6.1.нийгмийн даатгалын шимтгэл төлөгч ажил олгогчийн тоон мэдээлэл;

3.6.2.албан журмын болон сайн дурын даатгуулагчийн тоон мэдээлэл;

3.6.3.тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авагчийн тоон мэдээлэл;

3.6.4.ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тооцооны мэдээлэл /нийт дүнгээр болон салбарын ангиллаар/;

3.6.5.нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын тоон мэдээлэл.

3.7.Мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй ажил олгогч, даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой албаны нууцад хамаарах мэдээллийг Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд заасан журмын дагуу үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журам хамгаалах, хууль дээдлэх үндсэн зарчмыг сахиулахтай холбогдсон төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлж буй, хуулиар эрх нь олгогдсон байгууллага, албан тушаалтан прокурорын шийдвэрт заасан хугацаанд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгт заасан үндсэн системээр дамжуулан авч болно.

3.8.Төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлж буй, хуулиар эрх нь олгогдсон байгууллага, албан тушаалтан энэ журмын 3.7-д заасан мэдээллийг шаардлагатай тохиолдолд цаасаар гаргуулан авч болно.

3.9.Мэдээлэл хариуцагч байгууллагын суурь болон төрөлжсөн мэдээллийн санд бүртгэгдсэн мэдээллийг ашиглах тохиолдолд үндсэн системээр дамжуулан ашиглана.

3.10.Энэ журмын 3.2.2.а, 3.2.2.б, 3.2.2.в, 3.2.2.ё-т заасан лавлагаа, тодорхойлолтын маягтын загварыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга батална.

Дөрөв.Хувийн мэдээллийг хамгаалах

4.1.Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг болон Нийгмийн даатгалын байгууллагын албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад заасны дагуу ажил олгогчийн цалингийн сан, өр авлага, даатгуулагчийн цалингийн мэдээлэл, тэтгэвэр, тэтгэмжийн дүн нийгмийн даатгалын байгууллагын албаны нууцад хамаарна.

4.2.Мэдээлэл хариуцагч нь энэ журмын 3.6-3.8-д зааснаас бусад тохиолдолд ажил олгогч, даатгуулагчийн хувийн мэдээлэл болон байгууллагын албаны нууцад хамаарах мэдээллийг гуравдагч этгээдэд гаргаж өгөхийг хориглоно.

Тав.Мэдээллийг хадгалах, нууцлал, аюулгүй байдлыг хангах

5.1.Нийгмийн даатгалын ерөнхий газар нь мэдээллийн нэгдсэн санг хадгалах, байршуулах, нууцлал, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаатай холбоотой зориулалтын сервер болон сервер байршуулах тусгай өрөөтэй байна.

5.2.Мэдээллийн аюулгүй, найдвартай байдлыг хангах, гуравдагч этгээдэд ашиглуулах зорилгоор даатгуулагч, ажил олгогчтой холбоотой мэдээллийн нэгдсэн сан, түүний нөөцийг Үндэсний дата төвд хадгална.

5.3.Нийгмийн даатгалын ерөнхий газар нь байгалийн гамшиг, гал усны болон гэнэтийн бусад аюул, халдлага, устаж үрэгдэж болзошгүй бусад нөлөөллөөс хамгаалах зорилгоор мэдээллийн нэгдсэн санд байгаа өгөгдөл, мэдээллийг жил бүр нөөцөлж, аюулгүй байдлын болон техникийн шаардлага хангасан газарт хадгална.

5.4.Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх мэдээллийн технологийн үйл ажиллагаа хариуцсан нэгж (цаашид “Мэдээллийн технологийн үйл ажиллагаа

хариуцсан нэгж" гэх) нь онцгой нөхцөл үүссэн үед мэдээллийн нэгдсэн сан, мэдээллийн системийг нөхөн сэргээх төлөвлөгөөтэй байна.

5.5.Мэдээллийн нэгдсэн санг хадгалах, хамгаалах, нууцлал аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг Мэдээллийн технологийн үйл ажиллагаа хариуцсан нэгж хариуцна.

5.6.Мэдээллийн технологийн үйл ажиллагаа хариуцсан нэгж нь мэдээллийн нэгдсэн сангийн хадгалалт, хамгаалалт, нөөцлөлт, нууцлал, аюулгүй байдлыг хангах чиглэлээр дотоод журмыг баталж мөрдөнө.

Зургаа.Бусад зүйл

6.1.Нийгмийн даатгалын ерөнхий газар нь мэдээллийн нэгдсэн сангийн аюулгүй байдал, хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг хангах, программ болон техник хангамжийг шинэчлэх, нэгдсэн сүлжээг өргөжүүлэх, засвар, үйлчилгээ хийх зэрэг үйл ажиллагаанд шаардагдах зардлын төсвийг жил бүрийн төсөвт тусган батлуулна.

6.2.Мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн мэдээллийг хувийн зорилгоор ашиглах болон бусдад дамжуулахыг хориглоно.

6.3.Мэдээллийн технологийн үйл ажиллагаа хариуцсан нэгж нь мэдээллийн нэгдсэн санг холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу бүрдүүлэх, ашиглах, үйлчилгээ үзүүлэх, хяналт тавихад мэдээллийн технологиор дэмжиж ажиллана.

Долоо.Хяналт, хариуцлага

7.1.Нийгмийн даатгалын ерөнхий газрын хяналт шалгалт, дотоод аудит хариуцсан зохион байгуулалтын нэгж нь мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийн үнэн зөв бүрдүүлэлт, ашиглалтад хяналт тавьж ажиллана.

7.2.Энэхүү журмыг зөрчсөн этгээд, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2024 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн А.1.113
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ДААТГАЛЫН МЭДЭЭЛЛИЙН САНГ БҮРДҮҮЛЭХ, БОЛОВСРУУЛАХ, ТҮГЭЭХ, АШИГЛАХ, ХЯНАХ, ХАДГАЛАХ, ХАМГААЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмаар Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын мэдээллийн сан /цаашид "мэдээллийн сан" гэх/-г бүрдүүлэх, боловсруулах, түгээх, ашиглах, хянах, хадгалах, хамгаалах үйл ажиллагааг зохицуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2.Мэдээллийн сан нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ, судалгаа, тооцоолол хийх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

1.3.Мэдээллийн сан нь нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сангийн бүрэлдэхүүн хэсэг байна.

Хоёр.Мэдээллийн санг бүрдүүлэх, боловсруулах, түгээх, ашиглах

2.1.Мэдээллийн сан хариуцагч нь Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд мэдээллийн санг ашиглаж, үйлчилгээ үзүүлнэ.

2.2.Мэдээллийн сан нь Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 16.1, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.6[1]-д заасан мэдээллийн сангийн мэдээлэл болон эдгээр хууль тогтоомжтой нийцүүлэн гаргасан дүрэм, журмын дагуу бүрдүүлсэн дараах мэдээллээс бүрдэнэ. Үүнд:

2.2.1.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тоо, мэдээлэл, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн болон эрсдэлийн үнэлгээ, ажил олгогчид, үзүүлсэн хөнгөлөлт, чөлөөлөлт, даатгуулагчид олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөр болон холбогдох бусад мэдээлэл;

2.2.2.хөдөлмөрийн хортой, аюултай нөхцөл бүхий ажлын байрны мэдээлэл болон холбогдох бусад мэдээлэл;

2.3.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 16 дугаар зүйлийн 16.3.1, 16.3.2, 16.3.3-т заасан байгууллага (цаашид "Мэдээллийн сан хариуцагч" гэх)-ууд холбогдох мэдээллийн санг үнэн зөв бүрдүүлэх үүргийг хэрэгжүүлнэ.

Гурав.Мэдээллийн санг ашиглах

3.1. Мэдээллийн сангийн мэдээллийг нээлттэй өгөгдөл болгон цахим хуудас болон төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системд нийтэлнэ.

3.2.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 16 дугаар зүйлийн 16.3.2, 16.3.3-т заасан байгууллага нь нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад холбогдох мэдээллийг цахимаар авах боломжийг бүрдүүлэн өгч, хамтран ажиллана.

3.3.Мэдээллийн санг төрийн мэдээлэл солилцооны системээр дамжуулан бусад мэдээлэл хариуцагчид ашиглуулна.

3.4.Мэдээллийн санг даатгуулагчид тэтгэвэр, тэтгэмж тогтоох, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн төлбөр, зардал олгох болон мэдээллийн боловсруулалт, хяналт шинжилгээ, үнэлгээ, судалгаа, тооцоолол хийх, олон нийтэд түгээх, мэдээлэхэд ашиглана.

Дөрөв.Мэдээллийн санг хадгалах, хамгаалах, хянах

4.1.Энэ журмын 2.3-т заасан үүрэг бүхий байгууллага нь өөрсдийн чиг үүргийн хүрээнд үүсгэсэн мэдээллийг хадгалах, хамгаалах, нөөцлөх, аюулгүй байдлыг хангах ажлыг хариуцна.

4.2.Мэдээллийн санг бүрдүүлэх, боловсруулах, түгээх, ашиглах асуудлаар энэ журмын 2.3-т заасан үүрэг бүхий байгууллага нь өөрсдийн чиг үүргийн дагуу хяналт тавьж ажиллана.

4.3.Төрийн болон бусад байгууллагын ажилтан энэ журамд заасан мэдээллийг албаны бус зориулалтаар ашиглах, хуулбарлах, бусдад дамжуулах, задруулахыг хориглоно.

Тав.Бусад зүйл

5.1.Энэ журмыг зөрчсөн, ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024.01.25 № 1/342

танай 2023.12.26-ны № 03/3429-т

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД Х.БУЛГАНТУЯА
ТАНАА

"Журам батлах тухай" Хөдөлмөр, нийгмийн хамгаалын сайдын 2023 оны А/202 дугаар тушаалыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн .....6564..... дугаарт бүртгэж хүргүүлэв.

Б.ЭНХБАЯР

151600172

Doc.yam a5.2024

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2024 оны 01 сарын 27-ны өдрийн 6566 дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 25 өдөр Дугаар А/202 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Итгэлцүүр хэрэглэх журам"-ыг хавсралтаар батлуулсугай.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Б.Батжаргал), хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Л.Мөнхзул)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2012 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн "Журам, аргачлал батлах тухай" А/64 дүгээр тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Х.БУЛГАНТУЯА

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ХУУЛЬ ЗҮЙН ГАЗАР
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН БАРИМТ БИЧГИЙН ДААРГА
Гарын үсэг
2023 оны 12 сар 26 өдөр

151230562

D: 2023 on 12 sar tushaal

Хөдөлмөр, нийгмийн хамгаалллын сайдын
2023 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн
А/306 дугаар тогтоолын хавсралт

ИТГЭЛЦҮҮР ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Даатгуулагчийн шимтгэл төлөх болон тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын үнэ цэнийг тодорхойлох итгэлцүүрийг хэрэглэхтэй холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Итгэлцүүр хэрэглэх

2.1.Дараах тохиолдолд итгэлцүүрийг хэрэглэнэ. Үүнд:

2.1.1.Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 21 дүгээр зүйлийн 21.26-д заасан үндэслэлээр;

2.1.2.Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 24 дүгээр зүйлийн 24.1-д заасан үндэслэлээр;

2.1.3.Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 28 дугаар зүйлийн 28.2.1-д заасан үндэслэлээр;

2.1.4.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 20 дугаар зүйлийн 20.3-т заасан үндэслэлээр.

2.2.Энэ журмын 2.1.1-д зааснаар цэргийн алба хаагч нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгох бол цэргийн алба хаасан хугацааны шимтгэлийг авч байсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг итгэлцүүрээр өсгөн тооцсон дүнгээс тэтгэврийн даатгалын шимтгэлийг ажил олгогчийн төлөх хувь хэмжээгээр тооцож нийгмийн даатгалын зохих санд төлүүлнэ.

2.3.Энэ журмын 2.1.2-т заасны дагуу нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тохиолдолд шимтгэл ногдох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг итгэлцүүрээр өсгөн тооцсон цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос дараах байдлаар тооцон зохих нийгмийн даатгалын санд төлүүлнэ.

2.3.1.ажил олгогч нийгмийн даатгалын шимтгэл ногдох цалин хөлсний сан түүнтэй адилтгах орлогыг нуусан буюу хэмжээг нь санаатайгаар бууруулсан нь нийгмийн даатгалын байгууллагын хяналт шалгалтын байцаагчийн гаргасан шийдвэрээр нотлогдсон тохиолдолд байцаагчийн гаргасан шийдвэрээр баталгаажсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг итгэлцүүрээр өсгөн тооцож, уг дүнгээс ногдуулсан шимтгэлийн хувь хэмжээгээр;

2.3.2.ажил олгогч нь хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлээ төлөөгүй, эсхүл дутуу төлсөн тохиолдолд ажил олгогчийн ирүүлсэн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд үндэслэн төлөөгүй, эсхүл дутуу төлсөн шимтгэлийг итгэлцүүрээр өсгөн тооцсон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос ногдуулсан хувь хэмжээгээр;

2.3.3.даатгуулагч нь сайн дураар даатгуулах гэрээгээр тохирсон хугацаанд төлбөл зохих шимтгэлийг төлөөгүй тохиолдолд тухайн даатгуулагчийн хүчинтэй гэрээг үндэслэн, шимтгэл төлөхөөр өөрөө мэдүүлсэн орлогыг итгэлцүүрээр өсгөн тооцсон дүнгээс төлөх шимтгэлийн хувь хэмжээгээр;

2.3.4.даатгуулагчийн хууль бусаар ажлаас халагдсан хугацааг шүүхийн шийдвэрээр тогтоосон бол уг хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг шүүхийн шийдвэрт заасан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг итгэлцүүрээр өсгөн тооцсон дүнгээс, хэрэв шүүхийн шийдвэрт заагаагүй бол түүний ажлаас халагдахын өмнө авч байсан сүүлийн сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг итгэлцүүрээр өсгөн тооцсон дүнгээс ажил олгогчийн болон даатгуулагчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээгээр;

2.3.5.даатгуулагчийн хилс хэргээр мөрдөгдсөн, хилс хэргээр хорих ял эдэлсэн хугацааг шүүхийн шийдвэрээр тогтоосон бол уг хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг хилс хэргээр мөрдөгдөхийн болон ял эдлэхийн өмнө авч байсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг итгэлцүүрээр өсгөн тооцсон дүнгээс ажил олгогчийн болон даатгуулагчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээгээр.

2.4.Энэ журмын 2.1.3-т заасны дагуу Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгох даатгуулагчийн 1995 оноос өмнө цэргийн алба хаасан хугацааны шимтгэлийг албан хаасан хугацаанд авч байсан цалин хөлсийг итгэлцүүрээр өсгөн тооцсон цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос даатгуулагчийн болон ажил олгогчийн төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээгээр тооцож, холбогдох журмын дагуу нэрийн дансны орлогод бүртгэнэ.

2.5.Энэ журмын 2.1.4-т заасны дагуу цалинд үндэслэсэн аргаар өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох болон Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу тэтгэвэр тогтоолгохоор сонгосон цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг итгэлцүүрээр өсгөн тооцсон дүнг тооцохдоо энэ журмын 2.7, 2.8-д заасныг баримтална.

2.6.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоох, даатгуулагчийн шимтгэл нөхөн төлөх цалин хөлсний 2024 онд баримтлах итгэлцүүрийг Засгийн газрын 2023 оны 238 дугаар тогтоолоор тогтоосноор, 2025 оноос хойших хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий хууль

/шинэчилсэн найруулга/-ийн 22 дугаар зүйлийн 22.2-т заасны дагуу Засгийн газраас тогтоосон итгэлцүүрийг тус тус мөрдөнө.

2.7.Даатгуулагчийн шимтгэл төлөх, нөхөн төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох итгэлцүүрээр өсгөн тооцсон цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг дараах байдлаар тооцно. Үүнд:

2.7.1. 2013 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд "Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2011 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 01 дүгээр тогтоолд заасан сарын дүнг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар;

2.7.2. 2013 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оныг дуустал хугацаанд Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооноос батлсан тухайн үеийн сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар;

2.7.3. 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн албан журмын даатгуулагчийн хувьд Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооноос батлсан тухайн үеийн сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин, сайн дураар даатгуулагчийн хувьд 7 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар.

2.8.Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн дагуу тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлсөн малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэвэр тогтоолгох хөдөлмөрийн хөлсийг тодорхойлоход Засгийн газраас тогтоосон шийдвэрийн 2011 онд харгалзах итгэлцүүрийг хэрэглэнэ.

Гурав. Хяналт, хариуцлага

3.1.Энэхүү журмын хэрэгжилтэд нийгмийн даатгалын байгууллага болон хуулиар тогтоосон чиг үүрэг бүхий бусад байгууллага хяналт тавина.

3.2.Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

- - - oOo - - -

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ТӨЛӨГӨӨ ТЭЭГҮҮГ ХУУЛБАР ҮЗЭН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН АРХИВЫН ДАРГА
Гарын үсэг:
2023 оны 12 сар 26 өдөр

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024.02-16 № 1/715

танай 2024.01.26-ны № 03/208-т

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД Х.БУЛГАНТУЯА
ТАНАА

"Журам батлах тухай" Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/199 дүгээр тушаалыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 6625 дугаарт бүртгэж хүргүүлэв.

Б.ЭНХБАЯР

151600528
Doc.yam a5.2024

МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 15 өдөр Дугаар А/199 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэг, Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, Даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, төрөлд залруулга хийснийг мэдүүлэх маягт”-ыг хоёрдугаар хавсралтаар, “Даатгуулагчийн үндсэн мэдээлэлд залруулга хийснийг мэдүүлэх маягт”-ыг гуравдугаар хавсралтаар, “Ажил олгогчийн цалингийн жагсаалт”-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэхүү тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Л.Мөнхзул)-т үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Батжаргал/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Мөнхзул/-т тус тус даалгасугай.

4.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/182 дугаар тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Х.БУЛГАНТУЯА

151230553

D: 2023 on 12 sar tushaal

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн
А/199 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨЛТИЙГ ТАЙЛАГНАХ, ШИМТГЭЛИЙГ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь нийгмийн даатгалын шимтгэл төлөгч аж ахуй нэгж, байгууллага /цаашид "ажил олгогч" гэх/-аас нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан (НД-7), даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан (НД-8), /цаашид "тайлан" гэх/-г илгээх, түүнд тавигдах шаардлага, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газар (байцаагч, ажилтан) /цаашид "Нийгмийн даатгалын байгууллага" гэх/ хүлээн авах, хянах баталгаажуулах, мэдээллийн санд бүртгэх, хугацаа хоцроосон тайлан хүлээн авах, шимтгэл нөхөн төлүүлэх, шимтгэлийн өр барагдуулах, тайланд залруулга хийх, даатгуулагчийн үндсэн мэдээллийг засах, хариуцлага тооцох зэрэг харилцааг зохицуулахад оршино.

1.2.Тайлан (НД-7) нь нийгмийн даатгалын байгууллага болон ажил олгогч хоорондын нийгмийн даатгалын шимтгэлийн ногдуулалт, төлөлт, авлага, өглөгийг баталгаажуулсан тооцооны үндсэн баримт болно.

1.3.Тайлан (НД-8) нь ажил олгогчдод ажиллаж буй даатгуулагч бүрийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, түүнд ногдуулсан шимтгэлийн талаарх мэдээллийг харуулна.

1.4.Тайланд залруулга хийснийг мэдүүлэх тайлан /цаашид "залруулгын тайлан" гэх/ нь тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна.

Хоёр.Тайлан илгээх, тайланд тавигдах шаардлага

2.1.Ажил олгогч тайланг энэ журмын 2.2-т заасан шаардлагад нийцүүлэн бэлтгэж, Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 25 дугаар зүйлийн 25.1-д заасан хугацаанд харьяалах нийгмийн даатгалын байгууллагад цахимаар илгээнэ.

2.2.Ажил олгогч нь төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 18 дугаар зүйлд заасан хувь хэмжээгээр тооцож, дараах шаардлагыг хангасан тайланг гаргаж баталгаажуулан ирүүлнэ. Үүнд:

2.2.1.Даатгуулагчид олгосон цалин хөлс, түүнтэй адилтгах орлого нь Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 19 дүгээр зүйлд тусгагдсан орлогоос бүрдсэн байх;

2.2.2.Даатгуулагчид нэгтгэн олгосон цалин хөлс, түүнтэй адилтгах орлого болон ээлжийн амралтын олговрыг уг даатгуулагчийн аль сард ногдох орлого болохыг тодорхойлж, тухайн саруудын тайланд тусгах;

2.2.3.Тайланг сараар гаргаж, шимтгэлийн тооцоог төгрөг, мөнгөөр илэрхийлсэн байх;

2.2.4.Нийгмийн даатгалын сангийн харилцах дансанд төлсөн шимтгэлийн дүн тухайн сарын тайланд тусгасан төлсөн шимтгэлийн дүнтэй тохирсон байх;

2.2.5.Тайланд даатгуулагчийн иргэний бүртгэлийн дугаар, эцэг/эхийн нэр, өөрийн нэр зэрэг үндсэн мэдээллийг үнэн зөв оруулсан байх;

2.2.6. Тайланд даатгуулагчийн төрөл, цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээ, улсын кодыг үнэн зөв оруулсан байх;

2.2.7.Тайланд даатгуулагчийн ажил, мэргэжлийн ангилалыг "Үндэсний ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолт"-д заасан стандартын дагуу зөв сонгож тайлагнасан байх;

2.2.8. Ажил олгогчийн хүний нөөцийн ажилтан нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 5 дугаар зүйлийн 5.1.7, 5.3-т дурдсан нөхцөлд хамаарах ажил, мэргэжлээр ажиллаж байгаа ажилтны тухайн ажилд томилсон, чөлөөлсөн тушаалын хуулбарыг хавсаргах, бусад ажилтны ажилд томилсон, чөлөөлсөн, өөрчлөлт орсон зэрэг хөдөлмөр эрхлэлттэй холбоотой тушаалын мэдээллийг тухай бүр цахим системд бүртгэсэн байх.

2.3.Тайлангийн үнэн зөв, бодит байдлыг ажил олгогчийн дарга /захирал/, нягтлан бодогч хариуцна.

2.4.Ажил олгогч нь тайлангийн өглөг, авлагын үлдэгдлийг сар бүр хянаж, жил бүрийн 06 дугаар сарын 30, 12 дугаар сарын 31-ний өдрийн дүнгээр нийгмийн даатгалын байцаагчтай цахимаар тооцоо нийлж баталгаажуулна.

Гурав.Тайлан хүлээн авах, хянах баталгаажуулах, мэдээллийн санд бүртгэх

3.1.Ажил олгогч нь тайланг нийгмийн даатгалын байгууллагад илгээснээр хариуцсан байцаагч хянаж хүлээн авах бөгөөд тайлангийн ирүүлсэн хугацааг тооцно.

3.2.Ажил олгогчийн баталгаажуулан "**Илгээсэн"** тайланг хариуцсан байцаагч энэ журмын 2.2-т заасан шаардлагын дагуу ажлын 8 цагийн дотор шалгаж, "**Шалгасан**" төлөвт оруулах бөгөөд алдаатай, эсхүл зөрүүтэй тайланг "**Буцаасан**" төлөвт оруулж, шалтгааныг тайлбар хэсэгт бичиж, ажил олгогчид илгээнэ.

3.3.Буцаасан тайланг ажил олгогч нь ажлын 3 өдрийн дотор засварлан дахин илгээнэ. Ажлын 3 өдрийн хугацаа нь энэ журмын 2.1-д заасан хугацаанаас өмнө байвал журамд заасан хугацааг баримтална. Хэрэв ажил олгогч дээрх хугацаанд

тайланг засаж илгээгээгүй бол дахин илгээх хүсэлт явуулна. Энэ тохиолдолд тайланг хугацаа хоцроосонд тооцож энэ журмын 4-т заасны дагуу шийдвэрлэнэ.

3.4.Энэ журмын 2.1-д заасан хугацаанаас өмнө илгээсэн тайланг "**Шалгасан"** төлөвтэй байгаа үед засварлан дахин илгээж болно. Энэ тохиолдолд тайлан "**Илгээсэн**" төлөвт шилжинэ.

3.5.Алдаагүй, зөрүүгүй **"Шалгасан"** төлөвтэй тайланг хуулийн хугацаа дуусмагц систем автоматаар **"Баталгаажсан"** төлөвт шилжүүлнэ.

3.6.Ажил олгогчийн илгээсэн тайланг нийгмийн даатгалын байгууллага хүлээн авч баталгаажуулан "**Баталгаажсан"** төлөвт шилжсэний дараа ажил олгогч нь баталгаажсан тайланд залруулга хийх тохиолдолд энэ журмын 7-д заасныг баримтална.

3.7.Ажил олгогч тухайн сард үйл ажиллагаа эрхлээгүй, даатгуулагчид цалин хөлс, түүнтэй адилтгах орлого олгоогүй тохиолдолд тайлан илгээхгүй тухай мэдэгдлийг энэ журмын 2.1-д заасан хугацаанд Нийгмийн даатгалын байгууллагад цахимаар ирүүлнэ.

3.8.Тоон гарын үсгээр баталгаажуулсан тайланг ажил олгогч тус бүрээр жилийн эцэст цалингийн жагсаалт /хавсралт№03/-аар хэвлэж хариуцсан байцаагч, нэгжийн дарга гарын үсэг зурж, тэмдэгээр баталгаажуулан, хадгаламжийн нэгж үүсгэн архивт хүлээлгэн өгнө.

3.9.Тоон гарын үсгээр баталгаажуулаагүй тухайн жилийн 1-6 дугаар сарын тайланг 07 дугаар сарын 05, 7-12 дугаар сарын тайланг дараа оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн дотор ажил олгогчийн дарга /захирал/, нягтлан бодогч гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажуулан нийгмийн даатгалын байгууллагад ирүүлэх бөгөөд хариуцсан байцаагч мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн тайлантай тулган гарын үсэг, тэмдэгээр баталгаажуулж, хадгаламжийн нэгж үүсгэн архивт хүлээлгэн өгнө.

Дөрөв. Хугацаа хоцроосон тайлан хүлээн авах

4.1.Ажил олгогч нь энэ журмын 2.1-д заасан хугацаанд тайлангаа ирүүлээгүй тохиолдолд нийгмийн даатгалын байгууллага холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэсний дараа хугацаа хоцроосон тайланг хүлээн авна.

4.2.Нийгмийн даатгалын байгууллага нь хугацаа хоцроосон тайланг хүлээн авахдаа тайлан хоцроосон шалтгааныг дурдсан албан бичгийг цаасан эсхүл цахим хэлбэрээр авч анхан шатны баримт /аудитын дүгнэлт, татварын тайлан, санхүүгийн баталгаажуулсан тайлан, цалингийн хүснэгт гэх мэт/-ыг үндэслэн дараах шийдвэрийг гаргана. Үүнд:

4.2.1.Тухайн тайлант улирлын /улирлын 3 сар/ хугацаанд хоцроосон хүсэлт ирүүлсэн бол орлого, шимтгэлийн байцаагч үндэслэлийг шалган хуулийн

дагуу холбогдох хариуцлага тооцсоны дараа хугацаа хоцроосон тайланг илгээх эрхийг нэгжийн дарга нээнэ.

4.2.2.Тайлант хугацаанаас өмнөх хугацааны тайлан илгээх хүсэлт ирүүлсэн бол хяналт шалгалтын байцаагч шалган хуулийн дагуу улсын байцаагчийн акт тогтоож системд бүртгэнэ. Орлого шимтгэлийн нэгжийн дарга хяналт шалгалтын байцаагчийн гаргасан шийдвэрийг үндэслэн хоцроосон тайланг илгээх эрхийг нээнэ.

Тав. Шимтгэлийг нөхөн төлүүлэх

5.1.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр шимтгэлийг дараах баримт бичигт үндэслэн нөхөн төлүүлнэ. Үүнд:

5.1.1.ажил олгогч нийгмийн даатгалын шимтгэл ногдох цалин хөлсний сан түүнтэй адилтгах орлогыг нуусан буюу хэмжээг нь санаатайгаар бууруулсан нь нийгмийн даатгалын байгууллагын хяналт шалгалтын байцаагчийн гаргасан шийдвэр;

5.1.2.ажил олгогч нь хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлээ төлөөгүй эсхүл дутуу төлсөн тохиолдолд ажил олгогчийн ирүүлсэн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан;

5.1.3.даатгуулагч нь сайн дураар даатгуулах гэрээгээр тохирсон хугацаанд төлбөл зохих шимтгэлийг төлөөгүй тохиолдолд тухайн даатгуулагчийн хүчинтэй гэрээ;

5.1.4.даатгуулагчийн хууль бусаар ажлаас халагдсан хугацааг тогтоосон шүүхийн шийдвэр;

5.1.5.даатгуулагчийн хилс хэргээр мөрдөгдсөн, хилс хэргээр хорих ял эдэлсэн хугацааг тогтоосон шүүхийн шийдвэр.

5.2.Энэ журмын 5.1.1, 5.1.4, 5.1.5 дахь заалтын дагуу шимтгэл нөхөн төлүүлэх тохиолдолд ажил олгогч тайлан ирүүлнэ.

5.3.Ажил олгогч нь тайланд даатгуулагчийг орхигдуулсан тохиолдолд энэ журмын 4.2-т заасан баримтыг тайлангийн хамт нийгмийн даатгалын байгууллагад албан бичгээр ирүүлнэ. Дээрх тохиолдолд энэ журмын 4.2.1, 4.2.2-т заасны дагуу шийдвэрлэнэ.

Зургаа. Шимтгэлийн өр барагдуулах

6.1.Нийгмийн даатгалын байгууллага нь шимтгэл, алданги, торгуулийн өрийн хэмжээг Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

6.1.1.Тайлан (НД-7)-д тусгагдсан нийгмийн даатгалын шимтгэлийн үлдэгдлийн хэмжээгээр;

6.1.2.Улсын байцаагчийн актаар төлүүлэхээр тогтоосон төлөгдөөгүй нийгмийн даатгалын шимтгэл, алданги, торгуулийн хэмжээгээр;

6.1.3.Шүүхийн шийдвэрээр төлүүлэхээр тогтоосон төлөгдөөгүй нийгмийн даатгалын шимтгэл, алданги, торгуулийн хэмжээгээр;

6.2.Ажил олгогчийн нийгмийн даатгалын санд төлсөн төлбөрөөс шимтгэл, алданги, торгуулийг дор дурдсан дарааллын дагуу суутган тооцож өрийг барагдуулна. Үүнд:

6.2.1.Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэлийн хуудсаар ногдуулсан торгууль;

6.2.2.Улсын байцаагчийн акт, шүүхийн шийдвэрээр тогтоосон алданги;

6.2.3.Тайлан (НД-7)-гаар тооцсон шимтгэл;

6.3.Ажил олгогчийн тухайн сард төлсөн шимтгэлийг хамгийн их хоногийн насжилттай өрөөс суутган тооцно.

6.4.Шимтгэлийн өрийн насжилтыг Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т заасан хугацааны дараагийн сарын 01-ний өдрөөс эхлэн тооцно.

6.5.Нийгмийн даатгалын байгууллага нь энэ журмын 6.1-д заасан ажил олгогчийн шимтгэлийн өрийг 6.4-т заасан хугацаанаас хойш төлөгдөөгүй хугацаагаар нь дараах байдлаар ангилна. Үүнд:

6.5.1. 30 хүртэл хоногийн насжилттай өр;

6.5.2. 31-90 хүртэл хоногийн насжилттай өр;

6.5.3. 91-180 хоногийн насжилттай өр;

6.5.4. 181-270 хоногийн насжилттай өр;

6.5.5. 271-1 хүртэл жилийн насжилттай өр;

6.5.6. 1-2 хүртэл жилийн насжилттай өр;

6.5.7. 2-3 хүртэл жилийн насжилттай өр;

6.5.8. 3-4 хүртэл жилийн насжилттай өр;

6.5.9. 4-5 хүртэл жилийн насжилттай өр;

6.5.10. 5 жилээс дээш насжилттай өр;

6.6.Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

6.6.1.30 хүртэл хоногийн шимтгэлийн өрийг тухайн сард нь багтаан төлөхийг сануулах /боломжит мэдээллийн суваг ашиглах/;

6.6.2.31-90 хоногийн насжилттай шимтгэлийн өртэй ажил олгогчдод өр барагдуулах, алданги тооцох тухай, нийгмийн даатгалын улсын байцаагчийн албан шаардлага болон нийгмийн даатгалын сангаас ажилтнуудад тэтгэвэр, тэтгэмж олгохгүй (эрх үүсэхгүй) тухай мэдэгдлийг тус тус хүргүүлэх;

6.6.3.91-180 хоногийн насжилттай шимтгэлийн өртэй ажил олгогчдын банкин дахь харилцах дансдын зарлагын гүйлгээг түр зогсоох тухай мэдэгдэл (данс хаах)-ийг ажил олгогч харилцагч арилжааны банкуудад хүргүүлж, өрийг тухайн ажил олгогчийн банкин дахь данснаас үл маргах журмаар гаргуулах;

6.6.4.181-270 хоногийн насжилттай шимтгэлийн өртэй ажил олгогчийн удирдлагатай уулзалт хийж, өр төлөх нарийвчилсан хуваарь, тэмдэглэл, гэрээ үйлдэн баталгаажуулах;

Санамж: 1.Гэрээг 12 хүртэл сарын хугацаагаар байгуулна.

Санамж: 2.Гэрээ байгуулсан нь банкин дахь дансны зарлагын гүйлгээг нээх, даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж, төлбөр зардал олгох, алданги торгуулиас чөлөөлөх үндэслэл болохгүй.

6.6.5.271 ба түүнээс дээш хоногийн насжилттай шимтгэлийн өр болон 6.6.4-т заасан гэрээний хугацаанд шимтгэлийн өрийг барагдуулаагүй тохиолдолд хуулийн байгууллагад хандан шийдвэрлүүлэх;

6.7.Үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа ажил олгогчийн үйл ажиллагааны чиглэлийн онцлог, ажлын гүйцэтгэлийн үр дүнгээр санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхой хугацаагаар хойшлогдсон, шимтгэлийн өрийг барагдуулах боломжтой зэрэг нь холбогдох баримтаар нотлогдож байвал аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газрын даргын шийдвэрээр энэ журмын 6.6.4-т заасан гэрээг 6 хүртэл сарын хугацаагаар нэг удаа сунган шийдвэрлэж болно.

6.8.Шимтгэлийн өртэй ажил олгогчийн мэдээллийг “Монголбанкны зээлийн мэдээллийн санд ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх мэдээллийг хүргүүлэхэд баримтлах журам”-д зааснаар Монголбанкны зээлийн мэдээллийн санд хүргүүлнэ.

6.9.Нийгмийн даатгалын байгууллага нь шимтгэлийн өр үүсгэсэн ажил олгогчид авч хэрэгжүүлсэн арга хэмжээний холбогдох баримт бичгийг тухайн ажил олгогчийн хувийн хэрэгт хавсарган, мэдээллийн системд бүртгэнэ.

Долоо.Тайланд залруулга хийх

7.1.Ажил олгогч нь нийгмийн даатгалын байгууллагын баталгаажуулсан тайланд залруулга хийлгэх тохиолдолд хүсэлтийг энэ журмын 4.2-т заасан анхан шатны баримтын хамт нийгмийн даатгалын байгууллагад цаасан эсхүл цахим хэлбэрээр ирүүлнэ.

7.2.Ажил олгогч нь тухайн тайлант хугацаанд багтаан залруулга хийлгэх хүсэлтийг ирүүлсэн бол нийгмийн даатгалын байгууллагын орлого шимтгэлийн нэгжийн даргын зөвшөөрснөөр байцаагч залруулгын тайланг хүлээн авч, мэдээллийн санд бүртгэн баталгаажуулна.

7.3.Ажил олгогч нь тайлант хугацаанаас өмнөх хугацааны тайланд залруулга хийлгэх хүсэлтээ ирүүлсэн бол нийгмийн даатгалын байгууллагын хяналт шалгалтын байцаагч, нэгжийн даргын гаргасан шийдвэрийг үндэслэн орлого шимтгэлийн байцаагч залруулгын тайланг хүлээн авч, мэдээллийн санд бүртгэн баталгаажуулна.

7.4.Шимтгэлийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой хийгдэх залруулгыг хяналт шалгалтын байцаагчийн шийдвэрийг үндэслэн нийгмийн

даатгалын байгууллагын санхүү бүртгэл хариуцсан нэгжийн даргын зөвшөөрлөөр орлого шимтгэлийн нэгжийн дарга хийнэ.

7.5. Тайланг залруулсан нь хууль тогтоомжид заасны дагуу алданги, торгууль оногдуулахгүй байх үндэслэл болохгүй.

7.6. Тайланд залруулга хийхдээ Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д заасны дагуу хариуцлага тооцно.

7.7. Залруулга хийсэн тайлан болон энэ журмын 7.1-д заасан баримт бичгийг тухайн ажил олгогчийн хувийн хэрэгт хавсаргана.

Найм. Даатгуулагчийн үндсэн мэдээллийг засах

8.1.Ажил олгогч нь нийгмийн даатгалын байгууллагын баталгаажуулсан тайланд энэ журмын 2.2.5-д дурдсан даатгуулагчийн үндсэн мэдээллийг засах тохиолдолд энэ тухай хүсэлтийг нотлох баримтын хамт нийгмийн даатгалын байгууллагад цаасан эсхүл цахим хэлбэрээр ирүүлнэ.

8.2. Даатгуулагчийн үндсэн мэдээллийг засах эрх бүхий ажилтныг аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газрын даргын тушаалаар томилно.

8.3.Даатгуулагчийн үндсэн мэдээллийг засахад нотлох баримтыг улсын бүртгэлийн мэдээллийн сантай тулган шалгасны дараа засна.

8.4.Тухайн газарт бүртгэгдсэн мэдээллийн санд даатгуулагчийн регистрийн дугаарыг 2 өөрөөр бүртгэсэн тохиолдолд зөв регистрийн дугаарт нэгтгэх үйлдлийг энэ журмын 8.2-т заасан ажилтан гүйцэтгэнэ.

8.5.Даатгуулагчийн регистрийн дугаарыг буруу бүртгэсэн нь тогтоогдсон, буруу регистрийн дугаарыг улсын бүртгэлийн мэдээллийн сангаас шалгаж өөр даатгуулагчтай давхардаж байвал уг регистрийн дугаарыг засварлах болон өөр регистрийн дугаартай нэгтгэх үйлдэл хийхийг хориглоно. Энэ тохиолдолд даатгуулагчийн мэдээллийг иргэний бүртгэлийн мэдээллийн сан, иргэний хүчин төгөлдөр баримтыг үндэслэн залруулсны дараа нэгтгэх үйлдлийг хийж шийдвэрлэнэ.

8.6.Даатгуулагчийн үндсэн мэдээлэлтэй холбоотой мэдээллийг буруу нэгтгэсэн, засварласан тохиолдолд сэргээх үйлдлийг энэ журмын 8.2-т заасан ажилтан хариуцан хийх бөгөөд энэ тухай системд тэмдэглэл үйлдэн нотлох баримтыг ажил олгогчийн хувийн хэрэгт хавсарган хадгална.

Ёс. Хяналт

9.1.Тайлан илгээх, хүлээн авах, хянах, баталгаажуулах үйл ажиллагаанд нийгмийн даатгалын байгууллага болон холбогдох эрх бүхий байгууллага хяналт тавьж ажиллана.

Арав.Хариуцлага

10.1.Энэ журмыг зөрчсөн ажил олгогч, нийгмийн даатгалын байгууллага, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---o0o---

Хөдөлмөр, нийгмийн хамгаалллын сайдын
2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн
А/1199 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

МАЯГТ№01

.....ажил олгогчийн .....оны .... сарын шимтгэлийн тайланд
даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, даатгуулагчийн төрөлд залруулга хийснийг мэдүүлэх тайлан

Шимтгэл төлөгчийн дугаар .....

Он	Сар	Буруу тайлагнасан							Залруулж тайлагнасан							Зөрүү		Тайлбар
		Овог нэр	Иргэний бүртгэлийн дугаар /Регистр/	Цалин	Даатгуулагчийн төрөл	Тооцсон шимтгэл			Овог нэр	Иргэний бүртгэлийн дугаар /Регистр/	Цалин	Даатгуулагчийн төрөл	Тооцсон шимтгэл			Цалин	Шимтгэл	
						Ажил олгогч	Даатгуулагч	Бүгд					Ажил олгогч	Даатгуулагч	Бүгд			
Дүн																		

Энэхүү маягтыг цахимаар хөтөлж болно.

Дарга /захирал/...../ /
/гарын үсэг, тамга/

Зөвшөөрсөн:
Санхүү бүртгэлийн нэгжийн дарга
...../гарын үсэг, тамга/

Нягтлан бодогч...../ /
/гарын үсэг, тамга/

Залруулга хийсэн
Орлого шимтгэлийн нэгжийн дарга
...../ /
/гарын үсэг, тамга тэмдэг/

Нийгмийн даатгалын байцаагч
...../ /
/гарын үсэг, тамга тэмдэг/

202.... оны .... сарын .... өдөр

Хөдөлмөр, нийгмийн хамгаалллын сайдын
2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн
А/1199 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

МАЯГТ№02

..... ажил олгогчийн .....оны .... сарын тайланд
даатгуулагчийн үндсэн мэдээлэлд залруулга хийснийг мэдүүлэх тайлан

Д/д	Мэдээллийн санд бүртгэгдсэн үндсэн мэдээлэл			Залруулсан үндсэн мэдээлэл			Тайлбар
	Овог	Нэр	Иргэний бүртгэлийн дугаар /Регистр/	Овог	Нэр	Иргэний бүртгэлийн дугаар /Регистр/	
Нийт дүн							

Энэхүү маягтыг цахимаар хөтөлж болно.

Дарга /захирал/...../ /
/гарын үсэг, тамга/

Залруулга хийсэн:

Нягтлан бодогч...../ /
/
/гарын үсэг, тамга/

Нийгмийн даатгалын байцаагч...../
/гарын үсэг, тамга тэмдэг/

20.....оны ..... сарын ....өдөр

Хөдөлмөр, нийгмийн хамгаалллын сайдын
2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн
А/499 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

МАЯГТ№03

..... ажил олгогчийн 20 .... оны нийт цалингийн жагсаалт

Шимтгэл төлөгчийн дугаар .....

№	Нэр	Овог	Иргэний бүртгэлийн дугаар /Регистр/	Сарууд											
				1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Дүн															

Бэлтгэсэн: Нийгмийн даатгалыг байцаагч ...../ /
Хянасан: Нэгжийн дарга...../ /

МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 01 өдөр Дугаар А/170 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрхийг олгох, баталгаажуулах, түдгэлзүүлэх, цуцлах журмыг нэгдүгээр, улсын байцаагчийн үнэмлэхийн загварыг хоёрдугаар, улсын байцаагчийн тэмдгийн загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Б.Батжаргал)-т, хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Л.Мөнхзул)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/27 дугаар тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн, 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/140 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэхүү тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

САЙД Х.БУЛГАНТУЯА

151230461

D: 2023 on 11 sar tushaal

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2023 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн
А/.170 дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт

НИЙГМИЙН ДААТГАЛЫН УЛСЫН БАЙЦААГЧИЙН ЭРХИЙГ ОЛГОХ, БАТАЛГААЖУУЛАХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ЦУЦЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмаар нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын газар (цаашид “нийгмийн даатгалын байгууллага” гэх)-ын ажилтанд нийгмийн даатгалын улсын байцаагч (цаашид "улсын байцаагч" гэх), нийгмийн даатгалын улсын ахлах байцаагч (цаашид "ахлах байцаагч" гэх)-ийн эрхийг олгох, баталгаажуулах, түдгэлзүүлэх, цуцлахтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2.Энэхүү журамд Төрийн албаны тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль, тогтоомжийг удирдлага болгоно.

Хоёр. Улсын байцаагчийн эрхийг олгох, баталгаажуулах

2.1.Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 38 дугаар зүйлийн 38.6-д заасан шалгалтад тэнцсэн ажилтанд улсын байцаагч, улсын ахлах байцаагчийн эрх олгоно.

2.2.Энэ журмын 2.1-д заасан шалгалтад тэнцсэн байцаагчийн улсын байцаагчийн болон улсын ахлах байцаагчийн эрхийг баталгаажуулна.

2.3.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ журмын 2.1-д заасан шалгалтад тэнцсэн ажилтанд нийгмийн даатгалын улсын байцаагч, улсын ахлах байцаагчийн эрхийг олгох, баталгаажуулах, түдгэлзүүлэх, цуцлах саналыг Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 38 дугаар зүйлийн 38.4-т зааснаар шийдвэрлүүлнэ.

Гурав. Улсын байцаагчийн эрх түдгэлзүүлэх, цуцлах

3.1.Дараах тохиолдолд байцаагчийн улсын болон ахлах байцаагчийн эрхийг түдгэлзүүлнэ. Үүнд:

3.1.1.хүүхэд асрах чөлөөтэй байгаа хугацаанд;

3.1.2.нийгмийн даатгалын байгууллага хооронд, эсхүл байгууллага дотроо албан тушаалын тодорхойлолтод зааснаар улсын байцаагч, улсын ахлах байцаагч байх шаардлагагүй албан тушаалд сэлгэн болон шилжин ажиллаж байх хугацаанд;

3.1.3.гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлангийн үнэлгээгээр

“Хангалтгүй” дүгнүүлсэн бол дараагийн “Маш сайн, Хэвийн” үнэлгээ авах хүртэл хугацаанд (эсвэл энэ хугацаанаас өмнө улсын байцаагчийн эрхийг олгох шалгалт авах бол шалгалтад орж тэнцэх хүртэл хугацаа);

3.1.4.хүндэтгэн үзэх шалтгаанаар 1-ээс дээш удаа шалгалтад ороогүй бол.

3.2.Энэ журмын 3.1-д заасан хугацаа дуусаж, албан тушаалын тодорхойлолтод зааснаар улсын байцаагч, улсын ахлах байцаагч байх шаардлагатай албан тушаалд томилогдсон ажилтанд улсын болон ахлах байцаагчийн эрхийг сэргээн олгоно.

3.3.Дараах тохиолдолд байцаагчийн улсын болон ахлах байцаагчийн эрхийг цуцална. Үүнд:

3.3.1.Төрийн албаны тухай хууль, нийгмийн даатгалын хууль тогтоомж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчсөн;

3.3.2.төрийн захиргааны албан хаагчийн болон Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-д заасан байцаагчийн эрх үүрэг, хориглох зүйл, ажилтны ёс зүйн хэм хэмжээг ноцтой буюу удаа дараа зөрчсөн, эсхүл мэргэжлийн алдаа гаргасан;

3.3.3.албан тушаалын тодорхойлолтод заасан албан үүргээ удаа дараа хангалтгүй биелүүлсэн, хуулиар олгосон улсын байцаагчийн эрхийг хэтрүүлсэн;

3.3.4.торгууль шийтгэлийн төлбөр болон маягт, үнэт цаас, ажил үйлчилгээний хураамжийн орлогыг хувьдаа завшсан нь дотоодын хяналт болон холбогдох хууль, хяналтын байгууллагаар тогтоогдсон;

3.3.5.гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон;

3.2.6.хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 38 дугаар зүйлийн 38.6-д заасан шалгалтад ороогүй тохиолдолд дараагийн шалгалтад тэнцэх хүртэл хугацаанд;

3.3.7.ажлаас чөлөөлөгдсөн болон халагдсан;

3.3.8.тэтгэвэрт гарсан, өөр байгууллагад шилжин ажилласан;

3.3.9.нас барсан.

3.4.Энэ журмын 3.1-3.3-т заасан шалтгаанаар улсын болон ахлах байцаагчийн эрх түдгэлзүүлэх, сэргээх, цуцлах тухай саналыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тавьж шийдвэрлүүлнэ.

3.5.Энэ журмын 3.1, 3.3-т заасны дагуу улсын болон ахлах байцаагчийн эрх түдгэлзүүлсэн, эрх цуцлагдсан ажилтны хэрэглэж байсан үнэмлэх, тэмдгийг харьяалах газар болон аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын газрын дарга акт үйлдэн хураан авч, нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Тамгын газрын дотоод ажил хариуцсан ажилтанд хүлээлгэн өгнө.

3.6.Улсын болон ахлах байцаагчийн эрх нь түдгэлзсэн, цуцлагдсан ажилтны

үнэмлэх, тэмдэг, акт, албан шаардлагын маягт, торгууль шийтгэлийн хуудсыг хурааж аваагүй, тушаагаагүй тохиолдолд тухайн газрын даргаар үнэмлэх, тэмдэг, маягт, үнэт цаасны үнийг гурав дахин нэмэгдүүлэн төлүүлж, хүчингүй болгуулах арга хэмжээ авна.

---oOo---

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2023 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн
А/170 дугаар тушаалын гуравдугаар
хавсралт

УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН БОЛОН УЛСЫН БАЙЦААГЧИЙН ТЭМДГИЙН ЗАГВАР

Улсын ахлах байцаагчийн тэмдгийн загвар

Улсын байцаагчийн тэмдгийн загвар

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2023.11.02 №01/1990.

танай_____-ны №_____-т

АЙМАГ (НИЙСЛЭЛ), ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС (ГАЗАР)-ИЙН ДАРГА НАРТ

Шийдвэр хүргүүлэх тухай

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн “Журам батлах тухай” А/137 дугаар тушаалыг хүргүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсэгт заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/137 дугаар тушаалаар “Нийгмийн даатгалын улсын байцаагчид мэргэшлийн зэргийг тогтоох, түдгэлзүүлэх, зэргийн нэмэгдэл олгох журам”-ыг шинэчлэн баталсан байна.

Энэхүү журмыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөх бэлтгэл ажлын хүрээнд байцаагч, ажилтнуудад танилцуулан мэргэжил арга зүйгээр хангах ажлыг зохион байгуулж ажиллана уу.

Хавсралт 5 хуудастай.

ДАРГА Л.МӨНХЗУЛ

My doc.BHSG A-4 /23.11/ sar

1523071948

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2023.10.25 № 1/5527

танай 2023.10.10-ны № 03/2561-т

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД Х.БУЛГАНТУЯА
ТАНАА

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын "Журам батлах тухай" 2023 оны А/137 дугаар тушаалыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзээд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн ..6459.... дугаарт бүртгэж хүргүүлэв.

Б.ЭНХБАЯР

151904380
Doc.yam a5.2023

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2023 оны 10 сарын 25-ны өдрийн 6459 дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ

2023 оны 10 сарын 06 өдөр Дугаар А/137 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 40 дүгээр зүйлийн 40.3 дах хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийгмийн даатгалын улсын байцаагчид мэргэшлийн зэргийг тогтоох, түдгэлзүүлэх, зэргийн нэмэгдэл олгох журмыг хавсралтаар батлалсугай.

2.Энэ тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгаллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Батжаргал/-т, мэргэшлийн зэргийн нэмэгдлийг нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны жил бүрийн төсөвт тусгаж, хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газарт тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгаллын сайдын 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/73 дугаар тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэхүү тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

САЙД Х.БУЛГАНТУЯА

151230351

D: 2023 on 09 sar tushaal

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн
А/137 дугаар тушаалын хавсралт

НИЙГМИЙН ДААТГАЛЫН УЛСЫН БАЙЦААГЧИД МЭРГЭШЛИЙН ЗЭРГИЙГ ТОГТООХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ЗЭРГИЙН НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Нийгмийн даатгалын улсын байцаагчид мэргэшлийн зэргийг тогтоох, түдгэлзүүлэх, зэргийн нэмэгдэл олгох харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.Нийгмийн даатгалын улсын байцаагч нь Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт заасан мэргэшлийн зэрэгтэй байна.

1.3.Мэргэшлийн зэрэг нь нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын газар, сум, дүүргийн тасаг /цаашид "нийгмийн даатгалын байгууллага" гэх/-т ажиллаж байгаа улсын ахлах болон улсын байцаагчийн эрхтэй байцаагч /цаашид "улсын байцаагч" гэх/-д хамаарна.

1.4.Итгэмжит зөвлөх мэргэшлийн зэрэг авсан улсын байцаагчид 20 хувийн, зөвлөх мэргэшлийн зэрэг авсан улсын байцаагчид 15 хувийн, тэргүүлэх мэргэшлийн зэрэг авсан улсын байцаагчид 10 хувийн нэмэгдлийг албан тушаалын үндсэн цалингаас тооцож сар бүр олгоно. Мэргэшлийн зэргийн нэмэгдлийг нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны жил бүрийн төсөвт тусгаж батлуулна.

1.5.Итгэмжит зөвлөх, зөвлөх, тэргүүлэх мэргэшлийн зэргийг Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 40 дүгээр зүйлийн 40.2-т заасны дагуу хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр олгож, түдгэлзүүлнэ.

Хоёр.Мэргэшлийн зэрэг олгох шалгуур үзүүлэлт

2.1.Тэргүүлэх мэргэшлийн зэргийг улсын байцаагчийн шалгалтад 2 ба түүнээс дээш удаа дараалан тэнцсэн доор дурдсан шалгуур хангасан улсын байцаагчид олгоно. Үүнд:

2.1.1.нийгмийн даатгалын байгууллагад 6-аас доошгүй жил ажилласан байх;

2.1.2.төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээр сүүлийн 1 жилийн хугацаанд "А буюу маш сайн", "В буюу Сайн" үнэлгээтэй дүгнүүлсэн байх;

2.1.3.сүүлийн 1 жил ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй, сахилгын шийтгэл хүлээгээгүй байх.

2.2.Зөвлөх мэргэшлийн зэргийг доор дурдсан шалгуур хангасан улсын байцаагчид олгоно. Үүнд:

2.2.1.энэ журмын 2.1-д заасан мэргэшлийн зэрэг хүчинтэй байх;

2.2.2.нийгмийн даатгалын байгууллагад 10-аас доошгүй жил ажилласан байх;

2.2.3.төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээр сүүлийн 2 жилийн хугацаанд "А буюу маш сайн", "В буюу Сайн" үнэлгээтэй дүгнүүлсэн байх;

2.2.4.сүүлийн 2 жил ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй, сахилгын шийтгэл хүлээгээгүй байх.

2.3.Итгэмжит зөвлөх мэргэшлийн зэргийг доор дурдсан шалгуур хангасан улсын байцаагчид олгоно. Үүнд:

2.3.1.энэ журмын 2.2-т заасан мэргэшлийн зэрэг хүчинтэй байх;

2.3.2.нийгмийн даатгалын байгууллагад 15-аас доошгүй жил ажилласан байх;

2.3.3.төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг сүүлийн 3 жилийн хугацаанд "А буюу маш сайн", "В буюу Сайн" үнэлгээтэй дүгнүүлсэн байх;

2.3.4.сүүлийн 3 жил ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй, сахилгын шийтгэл хүлээгээгүй байх.

Гурав.Мэргэшлийн зэрэг тогтоох, түдгэлзүүлэх

3.1.Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын газар нь улсын байцаагчид мэргэшлийн зэрэг тогтоолгох саналыг жил бүрийн 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад цахимаар ирүүлэх бөгөөд дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

3.1.1.энэ журмын 2.1-2.3-т заасан шалгуур хангасныг нотлох баримт бичиг;

3.1.2.энэ журмын 3.1.1-д заасан нотлох баримт бичгийг үндэслэн хамт олны хурлаар хэлэлцэж гаргасан шийдвэр.

3.2.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь мэргэшлийн зэрэг тогтоолгох байцаагчийн баримт бичгийг шалгаж нэгтгэн, судалгааг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 04 дүгээр сарын 20-ны өдрийн дотор хүргүүлнэ.

3.3.Мэргэшлийн зэргийг тогтоох асуудлыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь жил бүрийн 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор шийдвэрлэнэ.

3.4.Мэргэшлийн зэргийг дараах тохиолдолд түдгэлзүүлнэ. Үүнд:

3.4.1.албан хаагч төрийн албанаас түр чөлөөлөгдсөн бол ажилдаа эргэн орох хүртэл;

3.4.2.хүүхэд асрах чөлөөтэй байгаа хугацаанд.

3.5.Нийгмийн даатгалын байгууллага хооронд шилжин эсхүл сэлгэн ажиллах хугацаанд тухайн албан хаагчийн мэргэшлийн зэрэг хэвээр хадгалагдана.

3.6.Улсын байцаагч нь төрийн албанаас чөлөөлөгдсөн, халагдсан, нас барсан, ес зүйн болон мэргэжлийн алдаа гаргасан нь нотлогдож ёс зүйн болон сахилгын шийтгэл хүлээсэн бол мэргэшлийн зэргийг тухай бүр хүчингүй болгоно.

3.7.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага мэргэшлийн зэргийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай саналыг тухай бүр хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тавьж шийдвэрлүүлнэ.

Дөрөв.Зэргийн нэмэгдэл олгох

4.1.Энэ журмын 2.1-2.3-т заасан шалгуур хангасан улсын байцаагчид шат дараалан мэргэшлийн зэргийг олгоно. Мэргэшлийн зэргийг шат дараалан олгох доод хугацаа 1 жил байна.

4.2.Мэргэшлийн зэргийн нэмэгдлийг нийгмийн даатгалын байгууллагад улсын байцаагчийн эрхтэйгээр төрийн жинхэнэ албан хаагчаар ажиллаж байгаа хугацаанд олгоно.

Тав.Бусад зүйл

5.1.Энэ журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---o0o--

МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 11 сарын 09 өдөр Дугаар А/154 Улаанбаатар хот

Цагийн хөлсний хэмжээ, олгох
журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 42 дугаар зүйлийн 42.11 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн гишүүнд олгох цагийн хөлсний хэмжээг Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооноос баталсан тухайн онд мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний нэг цагийн доод хэмжээг дөрөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар тогтоосугай.

2.Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн гишүүнд цагийн хөлс олгох журмыг хавсралт ёсоор баталсугай.

3.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Батжаргал/-т, цагийн хөлс олгох зардлын хэмжээг нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны жил бүрийн төсөвт тусгаж, хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Л.Мөнхзул/-т тус тус үүрэг болгосугай.

4.Энэ тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

САЙД Х.БУЛГАНТУЯА

151230426

D: 2023 on 11 sar tushaal

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн А/1154 дугаар тушаалын хавсралт

МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД ЦАГИЙН ХӨЛС ОЛГОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг зүйл

1.1.Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 42 дугаар зүйлийн 42.10 дахь хэсэгт заасан маргаан хянан шийдвэрлэх төв зөвлөл болон салбар зөвлөл (цаашид "зөвлөл" гэх)-ийн дарга, гишүүн, салбар зөвлөлийн нарийн бичгийн даргад хуралд оролцсон цагийг харгалзан цагийн хөлс олгоход энэхүү журмыг баримтална.

Хоёр.Цагийн хөлс олгох

2.1.Зөвлөлийн дарга, гишүүн, салбар зөвлөлийн нарийн бичгийн даргад хуралд оролцсон цагийг харгалзан баталсан хэмжээгээр хөлс олгоно.

2.2.Энэ журмын 2.1-д заасан хөлсийг цагаар тооцож олгох бөгөөд гишүүдийн хуралд оролцсон нийт цагийг бүртгэх, гишүүдэд цагийн хөлс олгох, хувь хүний орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах, холбогдох тайлан гаргах үйл ажиллагааг зөвлөлийн нарийн бичгийн дарга гүйцэтгэнэ.

2.3.Цагийн хөлсийг зөвлөлийн гишүүдийн хуралд оролцсон цагийн нотлох баримтад тулгуурлан олгож байгаа эсэхэд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл болон Зөвлөлийн дарга тус тус хяналт тавьж ажиллана.

2.4.Зөвлөлийн гишүүдийн цагийн бүртгэл олон нийтэд нээлттэй байна.

Гурав.Бусад

3.1.Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД,
САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2024 оны 03 дугаар сарын 06-ны өдөр | Дугаар А/44, / А/40 | Улаанбаатар хот

Маягтын загвар, аргачлал батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 15 дугаар зүйлийн 15.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалтад заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн анхан шатны маягтын загвар"-ыг нэгдүгээр, "Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн анхан шатны бүртгэлийн маягт хөтлөх аргачлал"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалыг хэрэгжүүлж, холбогдох программд өөрчлөлт оруулан, ажил олгогч, даатгуулагч, иргэдэд мэдээлэл өгч ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Л.Мөнхзул)-т даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Б.Батжаргал)-т үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын "Маягт журам батлах тухай" 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 246/А/245 хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД

Х.БУЛГАНТУЯА

САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд,
Сангийн сайдын 2024 оны 03 дугаар
сарын 06-ны өдрийн А/144, А/110 дугаар
хамтарсан тушаалын нэгдүгээр
хавсралт

Б-НД-1.1

ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВЭР ТОГТООЛТЫН МАЯГТ /цалинд үндэслэсэн/

(QR код нь хувийн хэргийн дугаартай ижил байна)

1. Өндөр насны тэтгэвэр тогтоосон нөхцөл, болзол

Хөдөлмөрийн хэвийн
- Бүрэн.....1
- Хувь тэнцүүлсэн.....2

Хөнгөлөлттэй нөхцөл
- Газрын доор.....3
- Халуун.....4
- Хортой.....5
- Хүнд.....6
- Хүүхдийн.....7
- Урлагийн.....8
- Төмөр замын цэрэгжүүлсэн хамгаалалтын....9
- Малчин.....10

Цэргийн албаа хаасны.....11

2. Эцэг/эх-ийн нэр:..... Нэр: .....

3. Төрсөн он: ☐☐☐☐ сар: ☐☐ өдөр: ☐☐ 4. Нас... 5. Хүйс: 1. Эрэгтэй 2. Эмэгтэй

6. Иргэний бүртгэлийн дугаар: .....

7. Оршин суугаа хаяг: .....аймаг /нийслэл .....

сум /дүүрэг.....баг/хороо.....

Тэтгэвэр тогтоолт

1	Хуулийн зүйл, заалт:			
2	Төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчилж авсан хүүхдийн тоо:			
3	Шимтгэл төлсөн нийт хугацаа (жил, сар, өдөр):			
4	Тэтгэвэр бодох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлого (төгрөгөөр)			
5	Бүрэн тэтгэвэр	Бодох хувь:		
		Ногдох хэсэг:		
		Нэмэгдэл: (шимтгэлийг 20 жилээс илүү төлсөн жилд ногдох)		
		Бодох хувь:		
		Ногдох хэсэг:		
		Тогтоосон тэтгэврийг хөдөлмөрийн чадвар бүрэн алдсан жил тутамд нь 1%-иар нэмэгдүүлэх:		
		Бодогдсон тэтгэврийн бодит хэмжээ (төгрөгөөр)		
6	Хувь тэнцсэн	Шимтгэл төлбөл зохих	Сарын тоо:	
			Сард ногдох нь:	
		Шимтгэл төлсөн	Сарын тоо:	
			Хугацаанд ногдох нь:	
		Бодогдсон тэтгэврийн бодит хэмжээ (төгрөгөөр):		
7	Засгийн газраас тогтоосон тэтгэврийн доод хэмжээ (төгрөгөөр):			
8	Сард олгох тэтгэврийн хэмжээ (төгрөгөөр):			
9	Тэтгэвэр тогтоосон он, сар, өдөр:			
10	Тэтгэвэр эхэлж олгох он, сар, өдөр:			

Тэтгэвэр тогтоолт / өөрчлөлт хийсэн:

Нийгмийн даатгалын байцаагч.....( )

Хянасан:

Хяналтын байцаагч.....( )

Тасгийн дарга .....( )

Зөвшөөрсөн:

Дарга .....( )

Ахлах нягтлан бодогч .....( )

Б-НД-1.2

ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВЭР ТОГТООЛТЫН МАЯГТ /нэрийн дансны/

(QR код нь хувийн хэргийн дугаартай ижил байна)

1. Нэрийн дансны аргаар өндөр насны тэтгэвэр тогтоосон нөхцөл, болзол

Хөдөлмөрийн хэвийн

Нэрийн дансны үлдэгдлээр.....1

Нэрийн дансны үлдэгдэл болон мөнгөжүүлсэн орлогын нийлбэрээр.....2

Хөдөлмөрийн хэвийн бус

Газрын доор.....3

Халуун.....4

Хортой.....5

Хүнд.....6

Хүүхдийн.....7

Урлагийн.....8

Төмөр замын цэрэгжүүлсэн хамгаалалтын.....9

Малчин.....10

Цэргийн алба хаасны.....11

2. Эцэг/эх-ийн нэр:..... Нэр: .....

3. Төрсөн он: ☐☐☐☐сар: ☐☐ өдөр: ☐☐ 4. Нас.... 5. Хүйс: 1. Эрэгтэй 2. Эмэгтэй

6. Иргэний бүртгэлийн дугаар: .....

7. Оршин суугаа хаяг: .....аймаг /нийслэл .....

сум /дүүрэг.....баг/хороо.....

Тэтгэвэр тогтоолт

1	Хуулийн зүйл, заалт	
2	Шимтгэл төлсөн нийт хугацаа (жил, сар, өдөр)	
3	Тэтгэвэр тогтоолгохын өмнөх нэрийн дансны нийт үлдэгдэл:	
4	Тэтгэвэр тогтоолгохын өмнөх мөнгөжүүлсэн орлогын нийт үлдэгдэл:	
5	Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл:	
6	Засгийн газраас тогтоосон тэтгэврийн доод хэмжээ /төгрөгөөр/:	
7	Сард олгох тэтгэврийн хэмжээ (төгрөгөөр)	
8	Тэтгэвэр тогтоосон он, сар, өдөр:	
9	Тэтгэвэр эхэлж олгох он, сар, өдөр:	

Тэтгэвэр тогтоолт / өөрчлөлт хийсэн:

Нийгмийн даатгалын байцаагч.....( )

Хянасан:

Хяналтын байцаагч.....( )

Тасгийн дарга .....( )

Зөвшөөрсөн:

Дарга .....( )

Ахлах нягтлан бодогч .....( )

Б-НД-1.3

ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР АЛДСАНЫ ТЭТГЭВЭР ТОГТООЛТЫН МАЯГТ

(QR код нь хувийн хэргийн дугаартай ижил байна)

1. Хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан:

Ердийн өвчин.....1

Үйлдвэрлэлийн осол.....2

Мэргэжлээс шалтгаалсан өвчин.....3

Цэргийн албан үүргээ биелүүлэхтэй холбогдолтой.....4

Цэргийн албан үүргээ биелүүлэхтэй холбогдолгүй.....5

2. Эцэг/эх-ийн нэр:..... Нэр: .....

3. Төрсөн он: ☐☐☐☐сар: ☐☐ өдөр: ☐☐ 4. Нас.... 5. Хүйс: 1. Эрэгтэй 2. Эмэгтэй

6. Иргэний бүртгэлийн дугаар: .....

7. Оршин суугаа хаяг: .....аймаг /нийслэл .....

сум /дүүрэг.....баг/хороо.....

Тэтгэвэр тогтоолт

1	Хуулийн зүйл, заалт			
2	Төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчилж авсан хүүхдийн тоо			
3	Эрүүл мэндийн магадлалын зөвлөлөөс тогтоосон хөдөлмөрийн чадвар алдалтын хувь:			
4	Шимтгэл төлсөн нийт хугацаа (жил, сар, өдөр)			
5	Сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлого (төгрөгөөр)			
6	Бүрэн тэтгэвэр	Бодох хувь:		
		Нэмэгдэл (шимтгэлийг 20 жилээс илүү төлсөн жилд ногдох)		
		Ногдох хэсэг нь:		
		Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ:		
		Ногдох хэсэг нь:		
		Бодогдсон тэтгэврийн бодит хэмжээ /төгрөгөөр/:		
7	Хувь тэнцсэн	Шимтгэл төлбөл зохих	Сарын тоо:	
			Сард ногдох нь:	
		Шимтгэл төлсөн	Сарын тоо:	
			Хугацаанд ногдох нь:	
		Бодогдсон тэтгэврийн бодит хэмжээ (төгрөгөөр)		
8	Засгийн газраас тогтоосон тэтгэврийн доод хэмжээ (төгрөгөөр)			
9	Сард олгох тэтгэврийн хэмжээ (төгрөгөөр)			
10	Тэтгэвэр тогтоосон он, сар, өдөр:			
11	Тэтгэвэр эхэлж олгох он, сар, өдөр:			

Тэтгэвэр тогтоолт / өөрчлөлт хийсэн:

Нийгмийн даатгалын байцаагч..... .....( )

Хянасан:

Хяналтын байцаагч.....( )

Тасгийн дарга .....( )

Зөвшөөрсөн:

Дарга .....( )

Ахлах нягтлан бодогч .....( )

Б-НД-1.4

ТЭЖЭЭГЧЭЭ АЛДСАНЫ ТЭТГЭВЭР ТОГТООЛТЫН МАЯГТ

(QR код нь хувийн хэргийн дугаартай ижил байна)

Тэтгэвэр тогтоолгогчийн мэдээлэл (Тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгогч)

1. Эцэг /эх/-ийн нэр: ..... Нэр: ..... 2. Нас: .....
3. Хүйс: 1.Эрэгтэй 2.Эмэгтэй 4. Иргэний бүртгэлийн дугаар: .....
5. Оршин суугаа хаяг: .....аймаг /нийслэл .....
сум /дүүрэг.....баг/хороо.....
6. Тэжээгчтэй /тэжээгчийн гэр бүлтэй/ ямар хамааралтай болох: .....
7. Гэрлэлтийн гэрчилгээний дугаар: .....

Тэтгэвэр тогтоолгогчийн мэдээлэл (Тэжээгчээ алдсаны тэтгэвэрийг хуваааж тогтоох бол)

1. Эцэг /эх/-ийн нэр: ..... Нэр: ..... 2. Нас: .....
3. Хүйс: 1.Эрэгтэй 2.Эмэгтэй 4. Иргэний бүртгэлийн дугаар: .....
5. Оршин суугаа хаяг: .....аймаг /нийслэл .....
сум /дүүрэг.....баг/хороо.....
6. Тэжээгчтэй /тэжээгчийн гэр бүлтэй/ ямар хамааралтай болох: .....
7. Гэрлэлтийн гэрчилгээний дугаар: .....

Тэжээгчийн мэдээлэл

1. Нас барсан шалтгаан
   Ердийн өвчин.....1
   Үйлдвэрийн осол.....2
   Мэргэжлээс шалтгаалах өвчин.....3
   Цэргийн албан үүргээ биелүүлэхтэй холбогдолтой.....4
   Цэргийн албан үүргээ биелүүлэхтэй холбогдолгүй.....5
2. Эцэг /эх/-ийн нэр: ..... Нэр: .....
3. Төрсөн он: ☐☐☐☐ сар: ☐☐ өдөр: ☐☐ 4. Нас... 5. Хүйс: 1. Эрэгтэй 2. Эмэгтэй

Тэтгэвэр тогтоолт

1	Хуулийн зүйл, заалт			
2	Төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчилж авсан хүүхдийн тоо:			
3	Гэр бүлийн гишүүдийн тоо:			
4	Тэжээгчийн шимтгэл төлсөн нийт хугацаа:			
5	Тэжээгчийн сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлого (төгрөгөөр)			
6	Бүрэн тэтгэвэр	Бодох хувь		
		Нэмэгдэл (шимтгэлийг 20 жилээс илүү төлсөн жил)		
		Ногдох хэсэг		
		Хөдөлмөрийн чадваргүй хүний тоонд харгалзсан хувь хэмжээ		
		Ногдох хэсэг		
		Тогтоосон тэтгэврийг хөдөлмөрийн чадвар бүрэн алдсан жил тутамд нь 1 хувиар нэмэгдүүлэх		
		Бодогдсон тэтгэврийн бодит хэмжээ (төгрөгөөр)		
7	Хувь тэнцсэн	Шимтгэл төлбөл зохих:	Сарын тоо:	
			Сард ногдох нь:	
		Шимтгэл төлсөн нь:	Сарын тоо:	
			Хугацаанд ногдох нь:	
		Бодогдсон тэтгэврийн бодит хэмжээ (төгрөгөөр)		
8	Засгийн газраас тогтоосон тэтгэврийн доод хэмжээ (төгрөгөөр)			
9	Сард олгох тэтгэврийн хэмжээ (төгрөгөөр)			
10	Тэтгэвэр тогтоосон он, сар, өдөр:			
11	Тэтгэвэр эхэлж олгох он, сар, өдөр:			

Тэтгэвэр тогтоолт / өөрчлөлт хийсэн:

Нийгмийн даатгалын байцаагч.....( )

Хянасан:

Хяналтын байцаагч.....( )

Тасгийн дарга .....( )

Зөвшөөрсөн:

Дарга .....( )

Ахлах нягтлан бодогч .....( )

Б-НД-1.5

НАС БАРАГЧИЙН АСРАМЖИД БАЙСАН ГЭР БҮЛИЙН ГИШҮҮДИЙН БҮРТГЭЛ

МД	Тэтгэвэр тогтоолгогчийн мэдээлэл			Гэр бүлийн гишүүдийн мэдээлэл						
	Эцэг/эх-ийн нэр	Нэр	Иргэний бүртгэлийн дугаар	Эцэг/эх-ийн нэр	Нэр	Нас барагчийн хамаарал	Төрсөн он, сар, өдөр	Хүйс	Тэтгэвэр олгох хугацаа	
									Эхлэх он, сар, өдөр	Дуусах он, сар, өдөр
А	1	2	3	4	5	6	7	8	9	10
1										
2										
3										
4										
5										
6										
7										
8										
9										
10										
11										

Б-НД-2

..... ОНЫ ..... -Р САРЫН ТЭТГЭВЭР ОЛГОЛТЫН ЖАГСААЛТ

МД	Тэтгэврийн төрөл	Тэтгэврийн төрлийн код	Тэтгэвэр авагчийн тоо	Нийт мөнгөн дүн (төгрөг)
А	1	2	3	4
1				
2				
3				
4				
5				
6				
7				
8				
9				
10				
....				
	Нийт дүн			

Олголтын жагсаалт бэлтгэсэн:

Нийгмийн даатгалын байцаагч ..... ( )

Хянасан:

Хяналтын байцаагч..... ( )

Тасгийн дарга .....( )

Б-НД-2.1

..... ОНЫ ..... -Р САРЫН ТЭТГЭВЭР ОЛГОЛТЫН ЖАГСААЛТЫГ ХҮЛЭЭЛЦСЭН ТУХАЙ АКТ

.....аймаг /дүүрэг-ийн нийгмийн даатгалын газар:

Харилцагч банк: .....

МД	Тэтгэврийн төрөл	Тэтгэврийн төрлийн код				Сум/хорооны нэр	Тэтгэвэр авагчийн тоо	Нийт мөнгөн дүн (төгрөгөөр)
А	1	2				3	4	5
1								
2								
3								
4								
5								
6								
7								
8								
9								
10								
...								
	Нийт дүн							

Шилжүүлсэн файлын нэр: .....

Шилжүүлсэн файлын хэмжээ: .....

Шилжүүлсэн файлын он, сар, өдөр: .....

Шилжүүлсэн файлын бичлэгийн тоо: .....

Нэгтгэсэн:

Тасгийн дарга .....( )

Хянасан:

Ахлах нягтлан бодогч .....( )

Шилжүүлсэн:

Мэдээллийн технологийн ажилтан.....( )

Хүлээн авсан:

Банкны ажилтан .....( )

20.... оны .... сарын ..... өдөр

Б-НД-3

Архивын газар /хэлтэс
Аж ахуйн нэгж байгууллагын нэр:.....

ЦАЛИН ХӨЛСНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

/1995 оноос өмнөх эсхүл цэргийн алба хаасны тэтгэвэр тогтооход/

Иргэний бүртгэлийн дугаар:.....Эцэг/эх-ийн нэр:.....Нэр:.....

төгрөгөөр

Сар	.....он	.....он	.....он	.....он	.....он	.....он	.....он	.....он	.....он	.....он	Тайлбар
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1											
2											
3											
4											
5											
6											
7											
8											
9											
10											
11											
12											
Дүн											

Нийт цалин: .....(.....) төгрөг

(тоогоор) (үсгээр)

Тайлбар: Тухайн байгууллага нь энэхүү цалингийн тодорхойлолтыг зөвхөн цалингийн үндсэн баримт /цэс-ыг үндэслэн гаргана.

Дарга: ..... ( )

Баталгаажуулалт:

Тодорхойлолт гаргасан: ..... ( )

20.....оны..... сарын..... өдөр

Б-НД-4

ЦЭРГИЙН ТЭТГЭВЭР АВАГЧИЙН ЦАЛИН, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ЗӨРҮҮ ТООЦСОН МАЯГТ/1995 оноос хойш/

Иргэний бүртгэлийн дугаар: ..... Эцэг/эх/-ийн нэр: ..... Нэр: ..... Тэтгэврийн төрөл: .....

1995 оноос хойш цэргийн байгууллагад алба хаасан жил, сар	Цэргийн холбогдох хуулийн дагуу цэргийн жилийг		Нийт цэргийн алба хаасан хугацаа	ЦАХТТТХуулийн 6.3-т заасны дагуу		Нийт шимтгэл тооцсон сар
	Нэмэгдүүлсэн сар	Тооцсон шимтгэл		Нэмэгдүүлсэн сар	Тооцсон шимтгэл	
1	2	3	4	5	6	7

ШИМТГЭЛИЙН ТООЦОО

Сар	.....он			.....он			.....он			.....он			.....он		
	Цалин хөлс	Итгэлцүүр	Итгэлцүүрээр өсгөсөн цалин	Үндсэн цалин	Итгэлцүүр	Итгэлцүүрээр өсгөсөн цалин	Үндсэн цалин	Итгэлцүүр	Итгэлцүүрээр өсгөсөн цалин	Үндсэн цалин	Итгэлцүүр	Итгэлцүүрээр өсгөсөн цалин	Үндсэн цалин	Итгэлцүүр	Итгэлцүүрээр өсгөсөн цалин
1															
2															
3															
4															
5															
6															
7															
8															
9															
10															
11															
12															
Дүн															
Тэтгэврийн	x	x		x	x		x	x		x	x		x	x	
Тэтгэмжийн	x	x		x	x		x	x		x	x		x	x	
Нийт НДШ	x	x		x	x		x	x		x	x		x	x	

Нөхөн төлүүлэх нийт шимтгэлийн дүн (төгрөгөөр):..... Тэтгэврийн даатгалын шимтгэл:..... Тэтгэмжийн даатгалын шимтгэл:.....

Тооцоо хийсэн:

Нийгмийн даатгалын байцаагч ..... ( )

Хянасан:

Хяналтын байцаагч..... ( )

Тасгийн дарга ..... ( )

Зөвшөөрсөн:

Дарга .....( )

Ахлах нягтлан бодогч .....( )

Б-НД-5

АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖ ТОГТООЛТЫН МАЯГТ



QR код:
(Дахин давтагдашгүй дугаар)

1. Эцэг/эх-ийн нэр: ..... Нэр: .....

2. Төрсөн он: ☐☐☐☐сар: ☐☐ өдөр: ☐☐ 3. Нас: ...

4. Хүйс: 1. Эрэгтэй 2. Эмэгтэй

5. Оршин суугаа хаяг: .....аймаг /нийслэл ..... сум /дүүрэг.....баг/хороо.....

Тэтгэмж тогтоолт

1	Ажлаас чөлөөлөгдсөн он, сар, өдөр		
2	Хөдөлмөрийн эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагад		
3	Нийгмийн даатгалын байгууллагад бүртгүүлсэн он, сар, өдөр		
4	Шимтгэл төлсөн нийт сар		
5	Үүнээс: Ажлаас халагдахаас өмнө тасралтгүй шимтгэл төлсөн		
6	Өмнөх тэтгэмж дуусан он, сар, өдөр		
7	Өмнөх ажилгүйдлийн тэтгэмж авч дуусснаас хойш тасралтгүй		
8	Нийгмийн даатгалын шимтгэл төлж ажилласан сүүлийн 9 сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлого (төгрөгөөр)	....-р сар	
		....-р сар	
		....-р сар	
		....-р сар	
		....-р сар	
		....-р сар	
		....-р сар	
		....-р сар	
		....-р сар	
9	Сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлого (төгрөгөөр)		
10	Тэтгэмж бодох хувь		
11	Нэг сард ногдох тэтгэмж (төгрөгөөр)		
12	Нэг өдөрт олговол зохих тэтгэмж (төгрөгөөр)		
13	Өргөдөл гаргах хугацаа хоцроосон өдөр		
14	Нийт тэтгэмж олгох ажлын өдөр		
15	Нийт олговол зохих тэтгэмж (төгрөгөөр)		
16	Тэтгэмж авч байх хугацаанд ажилд орсон он, сар, өдөр		
17	Ажлаас чөлөөлөгдсөн он, сар, өдөр		
18	Нийт олговол зохих үлдсэн тэтгэмж (төгрөгөөр)		
19	Тэтгэмж авч эхлэх он, сар, өдөр		
20	Тэтгэмж авч дуусах он, сар, өдөр		

Тогтоолт хийсэн

Нийгмийн даатгалын байцаагч.....( )

Хянасан

Хяналтын байцаагч.....( )

Тасгийн дарга .....( )

Зөвшөөрсөн

Дарга.....( )

Ахлах нягтлан бодогч.....( )

Б-НД-5.1

АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖ ОЛГОХ ХУВААРЬ

МД	Эхлэх он, сар, өдөр	Дуусах он, сар, өдөр	Тэтгэмж олгох ажлын өдөр	Олгох тэтгэмж (төгрөгөөр)	Олгосон он, сар, өдөр
А	1	2	3	4	5
1					
2					
3					
4					
5					
6					
...					
	Нийт дүн				

Б-НД-6-ын үргэлжлэл-1

Тэтгэмж олгох хоног			Олгох тэтгэмж			Тэмдэглэл
Бүгд	Ажил олгогчоос	Нийгмийн даатгалын сангаас	Бүгд	Ажил олгогчоос	Нийгмийн даатгалын сангаас	
13	14	15	16	17	18	19

Б-НД-7

..... ОНЫ ..... -Р САРЫН ЖИРЭМСНИЙ БОЛОН АМАРЖСАНЫ ТЭТГЭМЖ ОЛГОХ ЖАГСААЛТ

МД	Тэтгэмж авагчийн мэдээлэл			Эмнэлгийн хуудасны			Тэтгэмж олгох хоног	Олгосон тэтгэмж (төгрөг)	Банкны нэр	Дансны дугаар
	Эцэг/эх-ийн нэр	Нэр	Иргэний бүртгэлийн дугаар	Дугаар	Эхлэх он, сар, өдөр	Дуусах он, сар, өдөр				
А	1	2	3	4	5	6	7	8	9	10
1										
2										
3										
4										
5										
6										
7										
8										
9										
10										
...										
	Нийт дүн									

Жагсаалт үйлдсэн нийгмийн даатгалын байцаагч ..... / /

Б-НД-8

.....-НЫ ..... ОНЫ ..... -Р САРЫН ТЭТГЭМЖ ОЛГОХ ЖАГСААЛТ

МД	Эцэг/эх-ийн нэр	Нэр	Иргэний бүртгэлийн дугаар	Тэтгэмжийн төрөл (ХЧТА, ЖА, Ажилгүйдэл, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох)	Даатгуулагчийн төрөл (албан журмаар, сайн дураар)	Олгох тэтгэмж (төгрөгөөр)	Банкны нэр	Дансны дугаар
А	1	2	3	4	5	6	7	8
1								
2								
3								
4								
5								
6								
7								
8								
9								
10								
...								
	Нийт дүн							

Олголтын жагсаалт бэлтгэсэн:

Нийгмийн даатгалын байцаагч .....( )

Хянасан:

Хяналтын байцаагч .....( )

Тасгийн дарга .....( )

Б-НД-8.1

.....-НЫ ..... ОНЫ ..... -Р

САРЫН ТЭТГЭМЖ ОЛГОХ ЖАГСААЛТ

МД	Ажил олгогчийн нэр	Нийгмийн даатгалын бүртгэлийн дугаар	Тэтгэмжийн төрөл	Олгох тэтгэмж (төгрөгөөр)
А	1	2	3	4
1				
2				
3				
4				
5				
6				
7				
8				
9				
10				
...				
	Нийт дүн			

Олголтын жагсаалт бэлтгэсэн:

Нийгмийн даатгалын байцаагч .....( )

Хянасан:

Хяналтын байцаагч .....( )

Тасгийн дарга .....( )

20.... оны .... сарын ..... өдөр

Б-НД-9

МЭДЭГДЭЛ

.....аймаг /дүүрэг
банкны ..... салбар/төвд

НАС БАРСАН ДААТГУУЛАГЧИЙН ГЭР БҮЛИЙН ГИШҮҮНД ТЭТГЭМЖ ОЛГОХ ТУХАЙ

20 ... оны ... дугаар сарын ...-ны өдөр

Дугаар .....

Иргэний бүртгэлийн дугаар .....

..... сум/дүүрэг-ийн ..... –р баг/хороо-ны ..... тоотод оршин сууж байгаад нас барсан эцэг/эх-ийн нэр ..... нэр ..... -ийн нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох..... төгрөг (мөнгөн дүнг үсгээр)-ийн тэтгэмжийг ..... сум/дүүрэг-ийн ..... -р баг/хороо-ны ..... тоотод оршин суугч ..... иргэний бүртгэлийн дугаартай, эцэг/эх-ийн нэр ..... нэр .....-д олгохыг мэдэгдье.

.....аймаг/ дүүрэг -ийн
Нийгмийн даатгалын газрын

Байцаагч: ..... ( )

Олгосон:
Банкны ажилтан.....( )

Баталгаажилт

Тэмдэг

Хянасан:

Тэтгэмж хүлээн авсан .....( )

Тасгийн дарга: ..... ( )
Нягтлан бодогч: ..... ( )

20.... оны .... сарын ..... өдөр

НД-7

.....-НЫ ..... ОНЫ ..... -Р САРЫН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨЛТИЙН ТАЙЛАН

1.Ажил олгогч шимтгэл төлөлтийн тайланг сар бүрийн 5-ны дотор шимтгэлийн цахим системээр тоон гарын үсгээр баталгаажуулан илгээнэ.
2.Ажил олгогч тоон гарын үсгээр баталгаажуулаагүй, цахимаар илгээсэн 1-6 дугаар сарын тайланг 07 дугаар сарын 05, 7-12 дугаар сарын тайланг дараа оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн дотор хэвлэмэл хэлбэрээр баталгаажуулан нийгмийн даатгалын байгууллагад ирүүлнэ.

Байгууллагын регистрийн дугаар:.....
Нийгмийн даатгалын бүртгэлийн дугаар:.....

1. Шимтгэл төлөлт

Үзүүлэлт		МД	Бүгд	Цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос тооцсон даатгуулагчид	Ажил олгогч шимтгэлийг нь хариуцан төлсөн даатгуулагчид	Зөвхөн эрүүл мэндийн даатгал төлсөн даатгуулагчид
А		Б	1	2	3	4
Даатгуулагчийн тоо	Монгол	1				
	Гадаад	2				
Даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлого	Нийт Мөр3=(4+...+10)	3				
	Үндсэн цалин	4			x	
	Нэмэгдэл, нэмэгдэл хөлс	5			x	
	Шагнал урамшуулал	6			x	
	Хоол, унааны үнийн хөнгөлөлт	7			x	
	Түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт, орон сууцны ашиглалтын төлбөр, тэдгээртэй адилтгах бусад орлого	8			x	
	Гэрээт ажилтны цалин	9			x	
	Ажил олгогч шимтгэлийг нь хариуцан төлсөн цалингийн сан	10		x		x
Нийгмийн даатгалын сан	Төлбөл зохих НДШ-ийн дүн	11				
	Төлсөн НДШ-ийн дүн	12		x	x	x
Нийгмийн даатгалын байгууллагаас буцаан олгосон шимтгэлийн дүн		13		x	x	x
Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлтийн дүн		14		x	x	x
ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийн хөнгөлөлтийн дүн		15		x	x	x
ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийн чөлөөлөлтийн дүн		16		x	x	x

2. Шимтгэлийн үлдэгдэл

МД	Үзүүлэлт	Илүү	Дутуу
А	1	2	3
1	..... оны ..... сарын 1-ний үлдэгдэл		
2	..... оны ..... сарын ..... -ний үлдэгдэл		

3. Тухайн сард нийгмийн даатгалын санд төлсөн шимтгэл

МД	Он	сар	өдөр	Дүн
1				
2				
3				
4				
5				
Нийт дүн				

4.ҮОМШӨ-ний даатгалын санд төлсөн шимтгэл

МД	Даатгуулагчийн тоо	Цалингийн сан	Шимтгэлийн хувь хэмжээ	Дүн
А	1	2	3	4
1			0.5	
2			1.5	
3			2.5	
Нийт дүн				

Тайлан гаргасан/хянасан:

Дарга/захирал: ..... ( )
(гарын үсэг) (нэр)

Тамга, тэмдэг

Нягтлан бодогч: ..... ( )
(гарын үсэг) (нэр)

20.... оны .... сарын ..... өдөр

Шалгаж, хүлээн авсан:

Нийгмийн даатгалын
байцаагч (ажилтан): ..... ( )
(гарын үсэг) (нэр)

Тэмдэг

20.... оны .... сарын ..... өдөр

.....- Д АЖИЛЛАЖ БҮЙ ДААТГУУЛАГЧДЫН ..... ОН

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ НОГДУУЛАЛТЫН ТАЙЛАН

Байгууллагын регистрийн дугаар:.....

Нийгмийн даатгалын бүртгэлийн дугаар:.....

МД	Даатгуулагчийн											
	Эцэг/эхийн нэр	Нэр	Иргэний бүртгэлийн дугаар	Даатгуулагчийн төрлийн код	Ажил мэргэжлийн ангилал	Улсын код	Цалин хөлс, түүнтэй адилтгах орлого (төгрөг)	Үндсэн цалин	Нэмэгдэл, нэмэгдэл хөлс	Шагнал урамшуулал	Хоол, унааны үнийн хөнгөлөлт	Т үн төл а
А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	
1												
2												
3												
4												
5												
6												
7												
8												
9												
10												
11												
12												
13												
14												
15												
Дүн												

Балансын шалгалт: багана (7)=багана (8+14), багана (15)=багана (16+17),

Тамга, тэмдэг

Тайлан гаргасан/хянасан:

Дарга/захирал: ..... ( )

(гарын үсэг) (нэр)

Нягтлан бодогч: .....( )

(гарын үсэг) (нэр)

20.... оны .... сарын ..... өдөр

Тэмдэг

Шалгаж, хүлээн авсан:

Нийгмийн даатгалын

байцаагч /ажилтан: ..... (

(гарын үсэг) (нэр)

20.... оны .... сарын ..... өдөр

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/144, А/140 дугаар хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралт

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН АНХАН ШАТНЫ БҮРТГЭЛИЙН МАЯГТ ХӨТЛӨХ АРГАЧЛАЛ

1.ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВЭР ТОГТООЛТЫН МАЯГТ /цалинд үндэслэсэн/ (Б-НД-1.1)

Даатгуулагч шимтгэл төлсөн хугацаа, дараалсан 60 сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас өндөр насны тэтгэвэр тогтоолгосон тохиолдолд цахим болон цаасан маягтыг нийгмийн даатгалын байцаагч хөтөлнө.

Маягтын 1 дүгээр үзүүлэлтэд өндөр насны тэтгэвэр тогтоолгосон нөхцөл, болзол гэсэн мөрийн *хөдөлмөрийн хэвийн* гэсэн хэсэгт даатгуулагчийн шимтгэл төлсөн жилээс хамаарч өндөр насны бүрэн/хувь тэнцүүлсэн тэтгэврийн тохирох хэсгийг сонгоно. *Хөнгөлөлттэй нөхцөл* хэсэгт Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 5 дугаар зүйлийн 5.1.3-5.1.7 дахь хэсэгт заасан, Цэргийн албаа хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу цэргийн албаа хаасны тэтгэвэр тогтоолгох нөхцөл, болзлыг хангасан даатгуулагчид тогтоох тэтгэврээс нэгийг сонгоно.

Маягтын 2-оос 7 дугаар үзүүлэлтэд тэтгэвэр тогтоолгогчийн үндсэн мэдээлэл болох эцэг/эх/-ийн нэр, нэр, төрсөн он, сар, өдөр, нас, хүйс, иргэний бүртгэлийн дугаар, оршин суугаа хаягийн мэдээллийг бичнэ.

Тэтгэвэр тогтоолт хэсэгт даатгуулагчийн тэтгэвэр тогтоолгосон хуулийн зүйл, заалт, төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчилж авсан хүүхдийн тоо, шимтгэл төлсөн нийт хугацаа, тэтгэвэр бодох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дүнг бичиж, бүрэн тэтгэвэр бол 5 дугаар мөрөнд, хувь тэнцүүлсэн тэтгэвэр бол 6 дугаар мөрөнд бодолтыг хийж бичнэ. Мөн Засгийн газраас тогтоосон тэтгэврийн доод хэмжээ, сард ногдох тэтгэврийн хэмжээ, тэтгэвэр тогтоосон, эхэлж олгосон он, сар, өдөр байна.

Тэтгэврийг анх тогтоосон бол тогтоолт, тэтгэврийг өөрчлөн тогтоосон бол өөрчлөлт гэсний доогуур зурж нийгмийн даатгалын байцаагч гарын үсэг зурж, тэмдгээр баталгаажуулна.

Байцаагчийн баталгаажуулсан маягтыг хянаж, хяналтын байцаагч, тасгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулах ба зөвшөөрсөн тохиолдолд ахлан нягтлан бодогч болон дарга гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажуулна.

2.ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВЭР ТОГТООЛТЫН МАЯГТ /нэрийн дансны/ (Б-НД-1.2)

Даатгуулагч нэрийн дансны буюу шимтгэлд суурилсан аргаар өндөр насны тэтгэвэр тогтоолгосон тохиолдолд цахим болон цаасан маягтыг нийгмийн даатгалын байцаагч хөтөлнө.

Маягтын 1 дүгээр үзүүлэлтийн *хөдөлмөрийн хэвийн* гэсэн хэсэгт нэрийн дансанд бүртгэсэн нийт орлогоос хамаарч тохирох хэсгийг сонгоно. *Хөнгөлөлттэй*

нөхцөл хэсэгт Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 5 дугаар зүйлийн 5.1.3-5.1.7 дахь хэсэгт заасан, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгох нөхцөл, болзлыг хангасан даатгуулагчид тогтоох тэтгэврээс нэгийг сонгоно.

Маягтын 2-оос 7 дугаар үзүүлэлтэд тэтгэвэр тогтоолгогчийн үндсэн мэдээлэл болох эцэг/эх/-ийн нэр, нэр, төрсөн он, сар, өдөр, нас, хүйс, иргэний бүртгэлийн дугаар, оршин суугаа хаягийн мэдээллийг бичнэ.

Тэтгэвэр тогтоолт хэсэгт Даатгуулагчийн тэтгэвэр тогтоолгосон хуулийн зүйл, шимтгэл төлсөн нийт хугацаа, тэтгэвэр тогтоолгохын өмнөх нэрийн дансны нийт үлдэгдэл, мөнгөжүүлсэн орлогын нийт үлдэгдэл, тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл, Засгийн газраас тогтоосон тэтгэврийн доод хэмжээ, сард ногдох тэтгэврийн хэмжээ, тэтгэвэр тогтоосон, эхэлж олгосон он, сар, өдөр, байна.

Тэтгэврийг анх тогтоосон бол тогтоолт, тэтгэврийг өөрчлөн тогтоосон бол өөрчлөлт гэсний доогуур зурж нийгмийн даатгалын байцаагч гарын үсэг зурж, тэмдгээр баталгаажуулна.

Байцаагчийн баталгаажуулсан маягтыг хянаж, хяналтын байцаагч, тасгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулах ба зөвшөөрсөн тохиолдолд ахлан нягтлан бодогч болон дарга гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажуулна.

3.ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР АЛДСАНЫ ТЭТГЭВЭР ТОГТООЛТЫН МАЯГТ (Б-НД-1.3)

Хөдөлмөрийн чадвар алдсан даатгуулагчийн тэтгэврийг тогтооход цахим болон цаасан маягтыг нийгмийн даатгалын байцаагч хөтөлнө.

Маягтын 1 дүгээр үзүүлэлт буюу хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан гэсэн хэсэгт Даатгуулагч ердийн өвчний улмаас, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний, цэргийн алба хаагчийн хувьд цэргийн албан үүргээ биелүүлэхтэй холбогдолтой эсхүл цэргийн албан үүргээ биелүүлэхтэй холбогдолгүй улмаас хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоох аль нэг нөхцөлийг сонгоно.

Маягтын 2-оос 7 дугаар үзүүлэлтэд тэтгэвэр тогтоолгогчийн үндсэн мэдээлэл болох эцэг/эх/-ийн нэр, нэр, төрсөн он, сар, өдөр, нас, хүйс, иргэний бүртгэлийн дугаар, оршин суугаа хаягийн мэдээллийг бичнэ.

Маягтын тэтгэвэр тогтоолт хэсэгт даатгуулагчийн тэтгэвэр тогтоолгосон хуулийн зүйл заалт, төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчилж авсан хүүхдийн тоо, Эрүүл мэндийн магадлалын зөвлөлөөс тогтоосон хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, шимтгэл төлсөн нийт хугацаа, сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, бүрэн тэтгэвэр бол 6 дугаарт, хувь тэнцсэн бол 7 дугаарт бодолтыг хийж бичнэ. Мөн Засгийн газраас тогтоосон тэтгэврийн доод хэмжээ, сард олгох тэтгэврийн хэмжээ, тэтгэвэр тогтоолгосон, тэтгэвэр эхэлж олгох он, сар, өдрийг бичнэ.

Тэтгэврийг анх тогтоосон бол тогтоолт, тэтгэврийг өөрчлөн тогтоосон бол өөрчлөлт гэсний доогуур зурж нийгмийн даатгалын байцаагч гарын үсэг зурж, тэмдгээр баталгаажуулна.

Байцаагчийн баталгаажуулсан маягтыг хянаж, хяналтын байцаагч, тасгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулах ба зөвшөөрсөн тохиолдолд ахлан нягтлан бодогч болон дарга гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажуулна.

4. ТЭЖЭЭГЧЭЭ АЛДСАНЫ ТЭТГЭВЭР ТОГТООЛТЫН МАЯГТ

(Б-НД-1.4)

Тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгогчийн мэдээлэл хэсэгт эцэг/эх/-ийн нэр, нэр, нас, хүйс, иргэний бүртгэлийн дугаар, оршин суугаа хаяг, тэжээгчтэй ямар хамааралтай болох, гэрлэлтийн баталгааны дугаарыг бичнэ. Хэрвээ тэжээгчээ алдсаны тэтгэврийг хуваааж тогтоох бол хуваааж тогтоолгох тэтгэвэр тогтоолгогчийн мэдээллийг мөн адил бичнэ.

Маягтын тэжээгчийн мэдээлэл хэсэгт нас барсан тэжээгчийн нас барсан шалтгаан, эцэг/эх/-ийн нэр, нэр, нас, хүйс, иргэний бүртгэлийн дугаарыг бичнэ.

Маягтын тэтгэвэр тогтоолт хэсэгт тэтгэвэр тогтоолгох хуулийн зүйл, төрүүлсэн буюу 3 хүртэл настайд нь үрчилж авсан хүүхдийн тоо, хөдөлмөрийн чадваргүй хүний тоо, тэжээгчийн шимтгэл төлсөн нийт хугацаа, сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, бүрэн тэтгэвэр бол 6 дугаар мөрөнд, хувь тэнцсэн бол 7 дугаар мөрөнд бодолтыг хийж бичнэ. Мөн Засгийн газраас тогтоосон тэтгэврийн доод хэмжээ, сард олгох тэтгэврийн хэмжээ, тэтгэвэр тогтоолгосон, тэтгэвэр эхэлж олгох он, сар, өдөр байна.

Тэтгэврийг анх тогтоосон бол тогтоолт, тэтгэврийг өөрчлөн тогтоосон бол өөрчлөлт гэсний доогуур зурж нийгмийн даатгалын байцаагч гарын үсэг зурж, тэмдгээр баталгаажуулна.

Байцаагчийн баталгаажуулсан маягтыг хянаж, хяналтын байцаагч, тасгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулах ба зөвшөөрсөн тохиолдолд ахлан нягтлан бодогч болон дарга гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажуулна.

5.НАС БАРАГЧИЙН АСРАМЖИД БАЙСАН ГЭР БҮЛИЙН ГИШҮҮДИЙН БҮРТГЭЛ

(Б-НД-1.5)

Тэтгэвэр тогтоолгогчийн мэдээлэл хэсэгт тэтгэвэр тогтоолгогчийн эцэг/эх/-ийн нэр, нэр, иргэний бүртгэлийн дугаарыг бичнэ.

Гэр бүлийн гишүүдийн мэдээлэл хэсэгт нас барагчийн асрамжид байсан гэр бүлийн гишүүдийн эцэг/эх/-ийн нэр, нэр, нас барагчийн хамаарал, төрсөн он, сар, өдөр, хүйс, тэтгэвэр тогтоолгож эхлэх болон дуусах он, сар, өдрийг бичнэ.

6. ..... ОНЫ ..... -Р САРЫН ТЭТГЭВЭР ОЛГОЛТЫН ЖАГСААЛТ

(Б-НД-2)

Тэтгэвэр олголтын жагсаалтыг тэтгэврийн программ, тэтгэврийн тогтоолт, шилжилт хөдөлгөөний өөрчлөлт, зогсоогдсон тэтгэврийн бүртгэлийг тус тус үндэслэн сар бүр гаргаж, хяналт тавина.

Тэтгэврийн төрөл, тэтгэврийн төрлийн код, тэтгэвэр авагчийн тоо, олгох нийт мөнгөн дүнг бичнэ.

Маягтын тэтгэврийн төрөл хэсэг (багана 1)-т Тэтгэвэр авагч ямар тэтгэвэр авахаас хамаарч хамаарах тэтгэврийн төрлийг сонгон тэтгэвэр авагчийн мэдээллийг бичнэ.

Тэтгэврийн төрлийн код хэсэг (багана 2)-т 4 оронтой кодыг бичих ба тухайн даатгуулагч ямар тэтгэврийн төрөлд хамаарахаас шалтгаалж код нь өөр өөр байна.

Тэтгэвэр авагчийн тоо хэсэг (багана 3)-т төрөл тус бүр хамаарах нийт тэтгэвэр авагчийн тоог бичнэ.

Д/д	Тэтгэврийн төрөл	Тэтгэврийн төрлийн код
1	1995 оноос өмнө тогтоосон өндөр насны тэтгэвэр	1362
2	1995 оноос өмнө тогтоосон тэжээгчээ алдсаны тэтгэвэр	1363
3	1995 оноос өмнө тогтоосон хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр	1364
4	1995 оноос хойш тогтоосон өндөр насны тэтгэвэр	2362
5	1995 оноос хойш тогтоосон тэжээгчээ алдсаны тэтгэвэр	2363
6	1995 оноос хойш тогтоосон хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр	2364
7	Цэргийн өндөр насны	3362
8	Цэргийн тэжээгчээ алдсаны	3363
9	Цэргийн хөдөлмөрийн чадвар алдсаны	3364
10	ҮОМШӨ 1995 оноос хойш тогтоосон тэжээгчээ алдсаны тэтгэвэр	4363
11	ҮОМШӨ 1995 оноос хойш тогтоосон хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр	4364
12	ҮОМШӨ 1995 оноос өмнө тогтоосон тэжээгчээ алдсаны тэтгэвэр	5363
13	ҮОМШӨ 1995 оноос өмнө тогтоосон хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр	5364
14	Зарим иргэдийн тэтгэврийн нэмэгдэл	6362

Тэтгэвэр олголтын жагсаалт бэлдсэн нийгмийн даатгалын байцаагч гарын үсэг зурж, тэмдгээр баталгаажуулна.

Байцаагчийн баталгаажуулсан маягтыг хянаж хяналтын байцаагч, тасгийн дарга нэрээ бичиж, гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулна.

7. ..... ОНЫ ..... -Р САРЫН ТЭТГЭВЭР ОЛГОЛТЫН ЖАГСААЛТЫГ ХҮЛЭЭЛЦСЭН ТУХАЙ АКТ

(Б-НД-2.1)

Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газрын нэр, тухайн нийгмийн даатгалын газрын харилцагч банкны нэрийг бичнэ.

Тэтгэврийн төрөл, код, сум, хорооны дугаар, тэтгэвэр авагчийн тоо, олгох нийт мөнгөн дүнг бичнэ. Мөн шилжүүлсэн файлын нэр, хэмжээ, он, сар, өдөр, бичлэгийн тоог бичнэ.

Олголтын жагсаалт нэгтгэсэн тасгийн дарга гарын үсэг зурж, тэмдгээр баталгаажуулна. Тасгийн даргын баталгаажуулсан нэгтгэсэн жагсаалтыг хянасан ахлах нягтлан бодогч, файлыг банк руу шилжүүлсэн мэдээллийн технологийн ажилтан, хүлээн авсан банкны ажилтан тус тус нэрээ бичиж, гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулна.

Тэтгэвэр олголтын жагсаалтыг хүлээлцсэн актыг тэтгэврийн программ, тэтгэвэр тогтоолт, шилжилт хөдөлгөөний өөрчлөлт, зогсоогдсон бүртгэлийг тус тус үндэслэн сар бүр хоёр хувь гаргаж банканд хүргүүлж, нэг хувийг нь банкны байгууллагаар баталгаажуулж авна. Энэхүү жагсаалтыг цахимаар солилцож болно.

8.ЦАЛИН ХӨЛСНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

/1995 оноос өмнөх эсхүл цэргийн албаа хаасны тэтгэвэр тогтооход/

(Б-НД-3)

Даатгуулагч 1995 оноос өмнөх жилийн цалин, хөлсөөр тэтгэвэр тогтоолгох бол уг хугацааны цалин, хөлсийг төрөлжсөн архивын байгууллагад хадгалагдаж буй санхүүгийн үндсэн баримт эсхүл тухайн ажиллаж байсан аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн үндсэн баримтад үндэслэн гаргаж ирүүлнэ. Энэхүү тодорхойлолтыг тухайн байгууллага, архив нь санхүүгийн архивын үндсэн баримтыг үндэслэн гаргах ба уг тодорхойлолтыг цэргийн байгууллага ашиглаж болно.

Цалин хөлсний тодорхойлолт гаргасан архивын нэгж, аж ахуйн нэгж байгууллага нь тодорхойлолт авах гэж буй даатгуулагчийн иргэний бүртгэлийн дугаар, эцэг/эх/-ийн нэр, нэр болон даатгуулагчийн авсан цалин хөлсийг он, сараар нь үнэн зөв тодорхойлж бичнэ. Дүн хэсэгт 1-12 сарын цалин хөлсний нийлбэр дүнг бичнэ.

Нийт цалин хэсэгт цалин, хөлсний тодорхойлолтоор гаргасан нийт цалингийн дүнг бичнэ.

Тодорхойлолтыг гаргасан архивын нэгж, аж ахуйн нэгж байгууллагын ажилтан, дарга, захирал, эзний нэр, тодорхойлолт олгосон он, сар, өдрийг бичиж гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан байна. Энэхүү тодорхойлолтыг цахимаар солилцож болно.

9. ЦЭРГИЙН ТЭТГЭВЭР АВАГЧИЙН ЦАЛИН, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ЗӨРҮҮ ТООЦСОН МАЯГТ/1995 оноос хойш/

(Б-НД-4)

Цэргийн албаа хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 6.3-т зааснаар цэргийн тэтгэвэр авагчийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зөрүүг тооцохдоо энэхүү маягтыг ашиглана. Уг маягтыг цахимаар үйлдэж болно.

Шимтгэлийн зөрүү тооцуулах даатгуулагчийн иргэний бүртгэлийн дугаар, эцэг/эх/-ийн нэр, нэр, тэтгэврийн төрлийг бичнэ.

1-р баганад 1995 оноос хойш цэргийн байгууллагад албаа хаасан цэргийн албаа хаагчийн цэргийн албаа хаасан хугацааг , 2-р баганад цэргийн холбогдох хуулийн дагуу цэргийн жилийг нэмэгдүүлж тооцсон сарыг, 3-р баганад нэмэгдүүлж тооцсон сард ногдох шимтгэлийн тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын санд төлүүлэх дүнг, 4-р баганад нийт цэргийн албаа хаасан хугацааг, 5-р баганад Цэргийн албаа хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 6.3-т заасны дагуу нэмэгдүүлж тооцсон сарыг, 6-р

баганад нэмэгдүүлж тооцсон сард ногдох шимтгэлийн тухай үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын санд төлүүлэх дүнг, 7-р баганад нийт шимтгэл тооцсон сарын тоог бичнэ.

Шимтгэлийн тооцоо хэсэгт цэргийн алба хаагчийн 1995 оноос хойш алба хаасан хугацааны сар бүрийн цалин хөлс, итгэлцүүр, итгэлцүүрээр өсгөсөн цалин, шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээгээр хязгаарласан цалин хөлснөөс тэтгэвэр, тэтгэмжийн шимтгэлийг тооцож, нийт дүнг гаргана.

Дүн хэсэгт 1-12 сарын цалин хөлс, итгэлцүүрээр өсгөсөн цалингийн нийлбэр дүнг бичнэ.

Тэтгэврийн мөрөнд итгэлцүүрээр өсгөсөн цалингийн нийлбэр дүнг ажил олгогчийн төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээгээр үржүүлж бичнэ.

Тэтгэмжийн мөрөнд итгэлцүүрээр өсгөсөн цалингийн нийлбэр дүнг ажил олгогчийн төлөх тэтгэмжийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээгээр үржүүлж бичнэ.

Нийт НДШ мөрөнд тэтгэврийн болон тэтгэмжийн мөрний нийлбэр дүнг бичнэ.

Нөхөн төлүүлэх нийт шимтгэлийн дүн (багана 3-6)-д тооцсон шимтгэл болон шимтгэлийн тооцоо хүснэгтийн нийт нийгмийн даатгалын шимтгэлийн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

Тооцоо хийсэн нийгмийн даатгалын байцаагч нэрээ бичиж, гарын үсэг зурж, тэмдгээр баталгаажуулна.

Байцаагчийн баталгаажуулсан маягтыг хянаж, хяналтын байцаагч, тасгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулах ба зөвшөөрсөн тохиолдолд ахлан нягтлан бодогч болон дарга гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажуулна.

10.АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖ ТОГТООЛТЫН МАЯГТ

(Б-НД-5)

Маягтын 1-ээс 5 дугаар үзүүлэлтэд даатгуулагчийн, дахин давтагдашгүй дугаар, эцэг/эх/-ийн нэр, нэр төрсөн он, сар, өдөр, нас, хүйс, оршин суугаа хаяг, холбоо барих утасны дугаарыг бичнэ.

Тэтгэмж тогтоолт хэсэгт ажлаас чөлөөлөгдсөн он, сар, өдөр, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагад болон нийгмийн даатгалын байгууллагад бүртгүүлсэн он, сар, өдөр, шимтгэл төлсөн нийт хугацааг сараар, ажлаас халагдахаас өмнө тасралтгүй шимтгэл төлсөн хугацааг сараар, даатгуулагч өмнө нь ажилгүйдлийн тэтгэмж авч байсан бол өмнөх тэтгэмж дууссан он, сар, өдөр болон өмнөх ажилгүйдлийн тэтгэмж авч дууссанаас хойш тасралтгүй шимтгэл төлсөн хугацааг сараар, 8 дугаар мөрөнд сүүлийн 9 сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг бичиж, 9 дүгээр мөрөнд сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээг, тэтгэмж бодох хувь, нэг сард ногдох тэтгэмж, нэг өдөрт олговол зохих тэтгэмж, баримт бичиг бүрдүүлж өгөх хугацаа хоцроосон өдөр, нийт тэтгэмж олгох ажлын өдөр, нийт олговол зохих тэтгэмж, тэтгэмж авч байх хугацаанд ажилд орсон он, сар, өдөр, нийт олговол зохих үлдсэн тэтгэмж, тэтгэмж авч эхлэх болон дуусах он, сар, өдрийг бичнэ.

Тэтгэмж тогтоосон нийгмийн даатгалын байцаагч нэрээ бичиж, гарын үсэг зурж, тэмдгээр баталгаажуулна.

Байцаагчийн баталгаажуулсан маягтыг хянасан байцаагч, тасгийн дарга, зөвшөөрсөн дарга, нягтлан бодогч нар нэрээ бичиж, гарын үсгэг зурж, тамга, тэмдгээр баталгаажуулна.

11.АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖ ОЛГОХ ХУВААРЬ

(Б-НД-5.1)

Ажилгүйдлийн тэтгэмжийг хуваарийн дагуу олгоход ашиглана. Ажилгүйдлийн тэтгэмж олгож эхлэх, дуусах он, сар, өдөр, тэтгэмж олгох ажлын өдөр, олгох тэтгэмж, олгосон он, сар, өдрийг бичнэ.

12. .....-НЫ ..... ОНЫ .....-Р САРД ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР ТҮР АЛДСАНЫ ТЭТГЭМЖ ОЛГОСОН ЖАГСААЛТ

(Б-НД-6)

Ажил олгогчоос олгосон хөдөлмөрийн чадвар түр хугацаагаар алдсан ажлын эхний 5 өдрийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн жагсаалтыг ажил олгогчийн дарга/захирал, нягтлан бодогч холбогдох үзүүлэлтийн дагуу сар бүр үнэн зөв гаргаж, нэрээ бичиж, гарын үсэг зурж, баталгаажуулж, нийгмийн даатгалын байгууллагад цаасаар эсвэл цахимаар ирүүлнэ.

Багана (1-11)-д даатгуулагчийн эцэг/эх/-ийн нэр, нэр, иргэний бүртгэлийн дугаар, эмнэлгийн хуудасны дугаар, эхэлсэн болон дууссан он, сар, өдөр, шимтгэл төлсөн нийт сар, хөдөлмөрийн чадвар алдахын өмнөх 3 сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дундаж, ажилласан хоног, тэтгэмж бодох ажлын нэг өдөрт ногдох цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, хувийг тус тус бичнэ.

Ажлын нэг өдөрт ногдох тэтгэмж (багана 12)-д ажлын нэг өдөрт ногдох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дүнг тэтгэмж бодох хувиар үржүүлсэнтэй тэнцүү байна.

Тэтгэмж олгох хоног (багана 13)-т ажил олгогчоос болон нийгмийн даатгалын сангаас тэтгэмж олгох хоногийн нийлбэртэй тэнцүү байна.

Олгох тэтгэмж (багана 16)-д ажил олгогчоос болон нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн нийлбэртэй тэнцүү байна.

Ажил олгогчоос олгох тэтгэмж (багана 17)-д ажлын нэг өдөрт ногдох тэтгэмжийн дүнг ажил олгогчоос тэтгэмж олгох хоногоор үржүүлсэнтэй тэнцүү байна.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмж (багана 18)-д ажлын нэг өдөрт ногдох тэтгэмжийн дүнг нийгмийн даатгалын сангаас олгох хоногоор үржүүлсэнтэй тэнцүү байна.

Жагсаалт гаргасан ажил олгогчийн дарга/захирал, нягтлан бодогч, жагсаалтыг хянаж, хүлээж авсан нийгмийн даатгалын байцаагч нэр, гарын үсэг, он, сар, өдрийг бичнэ.

13. ..... ОНЫ ..... -Р САРЫН ЖИРЭМСНИЙ БОЛОН АМАРЖСАНЫ ТЭТГЭМЖ ОЛГОХ ЖАГСААЛТ

(Б-НД-7)

Нийгмийн даатгалын байгууллага холбогдох хууль тогтоомжийн дагуу цахимаар ирүүлсэн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг даатгуулагч руу шилжүүлэхэд энэхүү маягтыг ашиглана.

Тэтгэмж авагчийн мэдээллийн хэсэг (багана 1-3)-т даатгуулагчийн эцэг/эх/-ийн нэр, нэр, иргэний бүртгэлийн дугаар зэрэг мэдээлэл байна.

Эмнэлгийн хуудас (багана 4-6)-д эмнэлгийн байгууллагаас олгосон жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудасны дугаар, эхлэх он, сар, өдөр, дуусах он, сар, өдөр зэрэг мэдээлэл байна.

Тэтгэмж олгох хэсэг (багана 7-10)-т тэтгэмж олгох хоног, олгосон тэтгэмжийн дүн, банкны нэр, дансны дугаар байна.

Жагсаалтыг үйлдсэн нийгмийн даатгалын байцаагч гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулна.

14. .....-НЫ ..... ОНЫ ..... -Р САРЫН ТЭТГЭМЖ ОЛГОХ ЖАГСААЛТ

(Б-НД-8)

Даатгуулагчийн эцэг/эх/-ийн нэр, нэр, иргэний бүртгэлийн дугаар, тэтгэмжийн төрөл, даатгуулагчийн төрөл, олгох тэтгэмжийн хэмжээ, банкны нэр, дансны дугаарыг бичнэ.

Жагсаалтыг тэтгэмжийн төрөл, даатгуулагчийн төрөл тус бүрээр бэлтгэнэ. Энэхүү жагсаалтыг цахимаар хийж болно.

Тэтгэмж олголтын жагсаалт бэлтгэсэн нийгмийн даатгалын байцаагч нэрээ бичиж, гарын үсэг зурж, тэмдгээр баталгаажуулна.

Байцаагчийн баталгаажуулсан маягтыг хянасан байцаагч, тасгийн дарга нар нэрээ бичиж, гарын үсгэг зурж, тэмдгээр баталгаажуулна.

15. .....-НЫ ..... ОНЫ ..... -Р САРЫН ТЭТГЭМЖ ОЛГОХ ЖАГСААЛТ

(Б-НД-8.1)

Нийгмийн даатгалын байгууллага холбогдох хууль тогтоомжийн дагуу хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг ажил олгогч, холбогдох байгууллагад шилжүүлэхэд энэхүү жагсаалтыг хэрэглэнэ.

Ажил олгогчийн нэр, нийгмийн даатгалын бүртгэлийн дугаар, тэтгэмжийн төрөл, олгох тэтгэмжийн хэмжээг бичнэ.

Тэтгэмж олгох жагсаалт бэлтгэсэн нийгмийн даатгалын байцаагч нэрээ бичиж, гарын үсэг зурж, тэмдгээр баталгаажуулна.

Байцаагчийн баталгаажуулсан маягтыг хянасан байцаагч, тасгийн дарга нар нэрээ бичиж, гарын үсгэг зурж, тэмдгээр баталгаажуулна.

16.НАС БАРСАН ДААТГУУЛАГЧИЙН ГЭР БҮЛИЙН ГИШҮҮНД ТЭТГЭМЖ ОЛГОХ ТУХАЙ МЭДЭГДЭЛ

(Б-НД-9)

Нийгмийн даатгалын байгууллага даатгуулагч нас барсан тохиолдолд нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд тэтгэмж олгох тухай мэдэгдлийг нас барсны гэрчилгээг үндэслэн бичиж, банканд хүргүүлэх бөгөөд тэтгэмж авагчаар дамжуулж болно. Энэхүү мэдэгдлийг цахимаар гаргаж болно.

Банк мэдэгдэл (Б-НД-8)-ийг үндэслэн нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд тэтгэмж олгож, тэмдэглэл хөтөлнө.

Мэдэгдлийн үндсэн хэсэгт мэдэгдэл бичсэн он, сар, өдөр, мэдэгдлийн дугаар, нас барагчийн иргэний бүртгэлийн дугаар, эцэг/эх/-ийн нэр, нэр, оршин сууж байсан

хаяг, тэтгэмжийн мөнгөн дүн, тэтгэмж авагчийн иргэний бүртгэлийн дугаар, эцэг/эх/-ийн нэр, нэр, оршин суугаа хаягийн мэдээллийг бичнэ.

Баталгаажуулалт хэсэгт мэдэгдэл бичсэн нийгмийн даатгалын байцаагч, хянасан тасгийн дарга, нягтлан бодогч, тэтгэмж олгосон банкны ажилтан, тэтгэмж хүлээж авсан хүн гарын үсэг зурж, он, сар, өдрийг бичнэ.

17. "....."-НЫ . . . ОНЫ . . . -Р САРЫН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨЛТИЙН ТАЙЛАН

(НД-7)

Энэ тайлан нь ажил олгогч болон нийгмийн даатгалын байгууллага хоорондын нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалт, төлөлт, тооцооны үндсэн баримт болно.

Ажил олгогч нь "....."-д ажиллаж буй даатгуулагчдын ..... оны .....-р сарын нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалтын тайлан /НД-8/-г үндэслэн .... оны ..... -р сарын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан /НД-7/-г гаргана.

Ажил олгогч шимтгэл төлөлтийн тайланг сар бүр шимтгэлийн цахим системээр тоон гарын үсгээр баталгаажуулж, дараа сарын 5-ны өдрийн дотор багтаан харьяа аймаг/сум/, дүүргийн нийгмийн даатгалын газарт ирүүлнэ. Ажил олгогч тоон гарын үсгээр баталгаажуулаагүй, цахимаар илгээсэн тохиолдолд тухайн оны 1-6 дугаар сарын тайланг 07 дугаар сарын 05, 7-12 дугаар сарын тайланг дараа оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн дотор хэвлэмэл хэлбэрээр дарга /захирал/-ын, нягтлан бодогчийн гарын үсэг, тамга, тэмдгээр баталгаажуулан харьяа аймаг/сум/, дүүргийн нийгмийн даатгалын газарт ирүүлнэ.

Байгууллагын регистрийн дугаар нь Улсын бүртгэлийн байгууллагаас олгосон хуулийн этгээдийн регистрийн дугаар байна.

Нийгмийн даатгалын бүртгэлийн дугаар нь Нийгмийн даатгалын байгууллагаас олгосон шимтгэл төлөгчийн дугаар байна.

1.Шимтгэл төлөлт

Даатгуулагчийн тоо (мөр 1) тухайн тайлант хугацаанд цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, ажил олгогч шимтгэлийг нь хариуцан төлсөн, зөвхөн эрүүл мэндийн даатгалын төлсөн Монгол даатгуулагчийн тоог бичнэ. Багана (1)=багана (2+3+4) нийт дүнгээр тайлагнагдах бөгөөд шимтгэлийн цахим системийн НД-8 тайлангаас татагдана.

Даатгуулагчийн тоо (мөр 2) тухайн тайлант хугацаанд цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос тооцсон, ажил олгогч шимтгэлийг нь хариуцан төлсөн, зөвхөн эрүүл мэндийн даатгалын төлсөн Гадаад даатгуулагчийн тоог бичнэ. Багана (1)=багана (2+3+4) нийт дүнгээр тайлагнагдах бөгөөд шимтгэлийн цахим системийн НД-8 тайлангаас татагдана.

Даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлого (мөр 3-10) даатгуулагчийн тухайн сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг төгрөгөөр

бүртгэж бичих ба (4-10) мөрний харгалзах (1-4) баганад ангилан тархааж бичнэ. мөр (3)=мөр (4+.....+10), багана (1)=багана (2+3+4).

Ажил олгогч шимтгэлийг нь хариуцан төлсөн цалингийн сан (Мөр 10)-гийн багана (3)-д хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогчийн төлөх хувиар нийгмийн даатгалын шимтгэл төлсөн цалингийн сангийн дүнг бичих ба (мөр) 3-ийн багана (3) дахь дүнтэй тэнцүү байна.

Нийгмийн даатгалын санд төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн дүн (мөр 11) аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж, цалин хөлс, түүнтэй адилтгах орлого авсан 1-ээр төгссөн даатгуулагчийн кодтой даатгуулагчдад ногдуулсан төлбөл зохих нийт нийгмийн даатгалын шимтгэлийн дүнг багана (2)-д, Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван тал Үндэсний хорооноос баталсан тухайн үеийн мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогчийн төлөх хувиар нийгмийн даатгалын санд шимтгэл төлсөн хүүхэд асрах чөлөөтэй байгаа ажилтан эх/эцэг/, хугацаат цэргийн албан хаагч, цэргийн сургуулийн сонсогч, жирэмсний болон амаржсаны амралттай байгаа ажилтан, ажил олгогчийн захиалгаар суралцагч, нэг ба түүнээс дээш сарын хугацаагаар хөдөлмөрийн чадвараа түр алдсан ажилтан, сул зогссон улирлын шинжтэй ажил байнга эрхэлдэг ажилтан, улсын хил дээр ажиллаж байгаа гаалийн улсын байцаагч, алба хааж байгаа офицер, ахлагчийн ажилгүй байгаа эхнэр/нөхөр, дипломат төлөөлөгчийн газрын ажилтны хөдөлмөр эрхлээгүй байгаа эхнэр/нөхөр, дайчилгаагаар ажилласан хүн, тэтгэвэр тогтоолгосны дараа ажиллаж байгаа жирэмсний болон амаржсан амралттай байгаа, хөдөлмөрийн чадвараа 1 сараас дээш хугацаанд алдсан ажилтан, жирэмсний болон амаржсаны амралттай байгаа цэргийн алба хаагч эх, нэг сараас дээш хугацаагаар хөдөлмөрийн чадвараа алдсан цэргийн албан хаагч, шилжин ажилласан цэргийн байгууллагын алба хаагчийн хөдөлмөр эрхлээгүй эхнэр/нөхөр, дагалднаар суралцаж байгаа хөдөлмөрийн гэрээтэй ажилтан буюу 2-оор төгссөн даатгуулагчийн кодтой даатгуулагчид ногдуулсан төлбөл зохих нийт нийгмийн даатгалын шимтгэлийн дүнг багана (3)-д, хилийн цэрэг, дотоодын цэрэг, онцгой байдлын, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүхийн шинжилгээний, тагнуул, цагдаа, төрийн тусгай хамгаалалт, авлигатай тэмцэх, төрийн тусгай хамгаалалтын байгууллагын генерал, комиссар, офицер, ахлагч цолтой цэргийн албан хаагчид ногдуулсан эрүүл мэндийн даатгалын төлбөл зохих нийт шимтгэлийн дүнг багана (4)-д тус тус бичнэ. Багана (1)= багана (2+3+4) нийт төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн дүнг бичих ба НД-8 маягтын багана (15)-ын бүгд дүнтэй тэнцэнэ.

Нийгмийн даатгалын санд төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн дүн (мөр 12)-ний зөвхөн багана (1) нөхөгдөх ба ажил олгогчоос нийгмийн даатгалын санд төлсөн шимтгэлийн дүнг бичнэ. Уг дүн нь тухайн сард нийгмийн даатгалын санд төлсөн шимтгэлийн нийт дүнтэй тэнцэнэ.

Нийгмийн даатгалын байгууллагаас буцаан олгосон шимтгэлийн дүн (мөр 13)-д зөвхөн багана (1) нөхөгдөх ба нийгмийн даатгалын байгууллагаас илүү төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгосон дүнг бичнэ.

Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлтийн дүн (мөр 14)-ний зөвхөн багана (1) нөхөгдөх ба Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай

хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу тооцсон ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлтийн дүнг бичнэ.

Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний шимтгэлийн хөнгөлөлтийн дүн (мөр 15) зөвхөн багана (1) нөхөгдөх ба Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу тооцсон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хөнгөлөлтийн дүнг бичнэ.

Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний шимтгэлийн чөлөөлөлтийн дүн (мөр 16) зөвхөн багана (1) нөхөгдөх ба Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу тооцсон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн чөлөөлөлтийн дүнг бичнэ.

2.Шимтгэлийн үлдэгдэл

Ажил олгогч тайлант хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийн эхний болон эцсийн үеийн авлагыг "илүү", өрийг "дутуу" гэсэн нүдэнд мөнгөн дүнгээр бичнэ.

3.Тухайн сард нийгмийн даатгалын санд төлсөн шимтгэл

Нийгмийн даатгалын санд төлсөн шимтгэлийг он, сар, өдрийн дарааллаар бичиж тэмдэглэнэ. Төлсөн шимтгэлийн нийт дүн "Шимтгэл төлөлт" хүснэгтийн (мөр) 12-ын багана(1)-ын дүнтэй тэнцүү байна.

4.Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд төлсөн шимтгэл

Даатгуулагчийн тоо (багана 1) Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд шимтгэл төлсөн даатгуулагчийн тоог бичнэ.

Цалингийн сан (багана 2) Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэл ногдуулсан цалингийн санг бичнэ.

Шимтгэлийн хувь хэмжээ (багана 3) Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд ажил олгогчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээг бичнэ. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хувь хэмжээ-0.5, 1.5, 2.5

Нийт дүн (багана 4) Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд төлсөн шимтгэлийн нийт дүнг бичнэ.

Тайлан гаргасан/хянасан шалгаж хүлээн авсан хэсэгт Ажил олгогчийн дарга/захирал/, нягтлан бодогч нь нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг тоон гарын үсгээр эсвэл хэвлэмэл хэлбэрээр гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулсан байх бөгөөд уг тайланг нийгмийн даатгалын байцаагч /ажилтан/ цахимаар эсвэл цаасаар хүлээн авч, шалгаж баталгаажуулна.

18. "....."-Д АЖИЛЛАЖ БУЙ ДААТГУУЛАГЧДЫН ... ОНЫ ... -Р САРЫН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ НОГДУУЛАЛТ ТАЙЛАН

(НД-8)

Энэ тайлан нь тухайн ажил олгогчид ажиллаж буй даатгуулагч бүрийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, түүнд ногдуулсан шимтгэлийн талаарх мэдээллийг харуулна.

Ажил олгогч шимтгэл ногдуулалтын тайланг сар бүр шимтгэлийн цахим системээр тоон гарын үсгээр баталгаажуулж, дараа сарын 5-ны өдрийн дотор багтаан харьяа аймаг/сум/, дүүргийн нийгмийн даатгалын газарт ирүүлнэ.

Ажил олгогч тоон гарын үсгээр баталгаажуулаагүй, цахимаар илгээсэн тохиолдолд тухайн оны 1-6 дугаар сарын тайланг 07 дугаар сарын 05, 7-12 дугаар сарын тайланг дараа оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн дотор хэвлэмэл хэлбэрээр дарга /захирал/-ын, нягтлан бодогчийн гарын үсэг, тамга, тэмдгээр баталгаажуулан харьяа аймаг/сум/, дүүргийн нийгмийн даатгалын газарт ирүүлнэ.

Байгууллагын регистрийн дугаар нь Улсын бүртгэлийн байгууллагаас олгосон хуулийн этгээдийн регистрийн дугаар байна.

Нийгмийн даатгалын бүртгэлийн дугаар нь Нийгмийн даатгалын байгууллагаас олгосон шимтгэл төлөгчийн дугаар байна.

Даатгуулагчийн эцэг/эхийн нэр, өөрийн нэр, иргэний бүртгэлийн дугаар (багана 1-3) Даатгуулагчийн эцэг/эхийн нэр, өөрийн нэр, иргэний бүртгэлийн дугаар /гадаад бол бүртгэлийн дугаар/-ыг бичнэ.

Даатгуулагчийн төрлийн код (багана 4) Даатгуулагчийн төрлийн 5 оронтой кодыг бичих ба тухайн даатгуулагч ямар төрөлд хамаарахаас шалтгаалж код нь өөр өөр байна.

Ажил мэргэжлийн ангилал (багана 5) Даатгуулагчийн Үндэсний ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолт YAMAT-08 хувилбараас тохирох ангиллыг тодорхойлж, тохирох кодыг 7 оронгийн түвшинд ажил олгогчийн хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтан нөхөж бичнэ.

Улсын код (багана 6) Гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн бол Нийгмийн даатгалын ерөнхий газраас тодорхойлсон кодоор ангилна.

Цалин хөлс, түүнтэй адилтгах орлого (багана 7) Даатгуулагчийн тухайн сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг төгрөгөөр бүртгэж бичих ба 8-14-р баганад ангилан тархааж бичнэ. Багана (7)=Багана (8+...+14). Энэ баганын нийлбэр дүн нь НД-7 маягтын шимтгэл төлөлт хэсгийн мөр (3)-ийн багана (1)-д бичигдсэн тоотой тэнцүү байна.

Гэрээт ажилтны цалин (багана 13) Иргэний хуульд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон бусад гэрээгээр ажиллагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг бичнэ.

Ажил олгогч шимтгэлийг нь хариуцан төлсөн цалингийн сан (багана 14) НД-7 маягтын шимтгэл төлөлт хэсгийн мөр (10)-ийн багана(3) дахь даатгуулагчийн

ажил олгогчоос хариуцан төлсөн шимтгэлийг тооцсон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг бичнэ.

Нийт дүн (багана 15) Даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогод ногдуулсан шимтгэлийн нийт дүнг төгрөгөөр бичнэ. багана (15)=багана (16+17)

Ажил олгогч (багана 16) Даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос даатгуулагчийн төрлийн код, ажил мэргэжлийн ангиллын дагуу ажил олгогчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээгээр тооцсон шимтгэлийн дүнг бичнэ.

Даатгуулагч (багана 17) Даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос даатгуулагчийн төрлийн кодын дагуу даатгуулагчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээгээр тооцсон шимтгэлийн дүнг бичнэ.

Ажил олгогч нийгмийн даатгалын ногдуулалтын тайлан (НД-8)-гаа тоон гарын үсгээр, цахимаар, хэвлэмэл хэлбэрээр нийгмийн даатгалын байгууллагад илгээн хүргүүлэхэд уг тайлангийн маягтын багана (8-14)-ын мэдээлэл харагдахгүй байхаар хураангуй болгож, зөвхөн багана (7)-ын мэдээлэл харагдах тохиргоогоор цахим системд хийнэ.

Тайлан гаргасан/хянасан шалгаж хүлээн авсан хэсэгт Ажил олгогчийн дарга /захирал/, нягтлан бодогч нь нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг тоон гарын үсгээр эсвэл хэвлэмэл хэлбэрээр гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулсан байх бөгөөд уг тайланг нийгмийн даатгалын байцаагч /ажилтан/ цахимаар эсвэл цаасаар хүлээн авч, шалгаж баталгаажуулна.

Ажил олгогч хэвлэмэл хэлбэрээр гаргасан нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалт, төлөлтийн тайланг хоёр хувь үйлдэх бөгөөд нэг хувийг ажил олгогч, нөгөө хувийг харьяа нийгмийн даатгалын байгууллага тус тус хадгална.

Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд бүртгэх даатгуулагчийн төрөл, код дараах байдалтай байна. Үүнд:

АЖИЛ ОЛГОГЧИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨЛТИЙН ТАЙЛАНД БҮРТГЭХ ДААТГУУЛАГЧИЙН ТӨРЛИЙН КОД

Д/Д	ДААТГУУЛАГЧИЙН ТӨРЛИЙН КОД	ДААТГУУЛАГЧИЙН ТӨРӨЛ	ШИМТГЭЛ ТООЦОХ ЦАЛИН ХӨЛС, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГО	ШИМТГЭЛ ТӨЛӨХ ХЭМЖЭЭ /КОД/										НИЙТ НДШ	ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗААЛТ
				ТЭТГЭВЭР		ТЭТГЭМЖ		АЖИЛГҮЙДЭЛ		ҮОМШӨ		ЭМД			
				АЖИЛ ОЛГОГЧ	ДААТГУУЛАГЧ	АЖИЛ ОЛГОГЧ	ДААТГУУЛАГЧ	АЖИЛ ОЛГОГЧ	ДААТГУУЛАГЧ	АЖИЛ ОЛГОГЧ	ДААТГУУЛАГЧ	АЖИЛ ОЛГОГЧ	ДААТГУУЛАГЧ		
1	01001	Хөдөлмөрийн гэрээний дагуу ажиллаж байгаа үндсэн ажилтан	ЦХТАО	8.5	8.5	1.0	0.8	0.5	0.2	0.5-2.5		2.0	2.0	24.0-26.0	НДЕХ-ийн 7.2, 18.1, 21.2, ЭМДТХ-ийн 6.1.1, 8.2, 8.3
2	02001	Иргэний хуульд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон бусад гэрээгээр ажиллагч	ЦХТАО	8.5	8.5	1.0	0.8					2.0	2.0	22.8	НДЕХ-ийн 7.4.10, 18.1, 21, ЭМДТХ-ийн 6.1.1, 8.2, 8.3
3	06002	Хүүхэд асрах чөлөөтэй байгаа аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан эх/эцэг/	ХХДХ	8.5		1.0								9.5	НДЕХ-ийн 7.4.5, 18.1, 21.14,
4	06012	Хүүхэд асрах чөлөөтэй байгаа аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан эх/эцэг/ тэтгэвэр тогтоолгосон	ХХДХ	8.5		1.0								9.5	НДЕХ-ийн 7.4.5, 18.1, 21.14,
5	08002	Хугацаат цэргийн алба хаагч, цэргийн сургуулийн сонсогч	ХХДХ	8.5		1.0								9.5	НДЕХ-ийн 7.4.9, 18.1, 21.18, ЗГ-ын 2019 оны 137
6	11001	Цэргийн байгууллагын алба хаагч	ЦХТАО									2.0	2.0	4.0	ЦАХТТТХ-ийн 5, ЭМДТХ 4.2
7	14001	Сул зогсолтын үеийн олговор авч байгаа ажилтан	Үндсэн цалингийн 60%-аас багагүй, ХХДХ-ээс багагүй байна	8.5	8.5	1.0	0.8	0.5	0.2	0.5-2.5		2.0	2.0	24.0-26.0	НДЕХ-ийн 7.2.1, 18.1, 21.2, ЭМДТХ-ийн 8.2, 8.3
8	17002	Жирэмсний болон амаржсаны амралттай байгаа ажилтан	ХХДХ	8.5		1.0		0.5		0.5-2.5		2.0		12.5-14.5	НДЕХ-ийн 7.2.4, 18.1, 21.6, ЭМДТХ-ийн 6.1.1, 8.3.1
9	20002	Ажил олгогчийн захиалгаар суралцаж байгаа ажилтан, төрийн албан хаагч	ХХДХ	8.5		1.0								9.5	НДЕХ-ийн 7.4.4, 18.1, 21.13,
10	21002	Нэг ба түүнээс дээш сарын хугацаагаар хөдөлмөрийн чадвараа түр алдсан ажилтан	ХХДХ	8.5		1.0		0.5		0.5-2.5		2.0		12.5-14.5	НДЕХ-ийн 7.2.4, 18.1, 21.6, ЭМДТХ-ийн 8.2, 8.3
11	22001	Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ажилтан (тэтгэврийн даатгалын шимтгэл төлнө)	ЦХТАО	8.5	8.5	1.0	0.8			0.5-2.5				19.3-21.3	НДЕХ-ийн 7.3.4, 18.1, 21,

12	22011	Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ажилтан (тэтгэврийн даатгалын шимтгэл төлөхгүй)	ЦХТАО			1.0	0.8			0.5-2.5			2.3-4.3	НДЕХ-ийн 7.3.4, 7.6, 18.1, 21, Даатгуулагчийн төрсөн онд харгалзах өндөр насны тэтгэвэр тогтоолгох насыг баримтална.
13	22021	Цэргийн албаа хаасны тэтгэвэр тогтоолгосон ажилтан (тэтгэврийн даатгалын шимтгэл төлнө)	ЦХТАО	8.5	8.5	1.0	0.8			0.5-2.5			19.3-21.3	ЦАХТТТХ-ийн 8, НДЕХ-ийн 7.3.4, 18.1,
14	22031	Цэргийн албаа хаасны тэтгэвэр тогтоолгосон ажилтан (тэтгэврийн даатгалын шимтгэл төлөхгүй)	ЦХТАО			1.0	0.8			0.5-2.5			2.3-4.3	ЦАХТТТХ-ийн 8, НДЕХ-ийн 7.3.4, 7.6, 18.1,
15	23001	Эрх бүхий байгууллагаас сетификат аваагүй БНСУ-ын иргэн	ЦХТАО	8.5	8.5	1.0	0.8	0.5	0.2	0.5-2.5		2.0	2.0	24.0-26.0	НДЕХ-ийн 7.2, 18.1, 21.2, ЭМДТХ-ийн 8.2, 8.3
16	24001	Эрх бүхий байгууллагаас сертификат авсан БНСУ-ын иргэн	ЦХТАО			1.0	0.8	0.5	0.2	0.5-2.5		2.0	2.0	7.0-9.0	НДЕХ-ийн 7.2, 18.1, 21.2, ЭМДТХ-ийн 8.2, 8.3
17	25002	Улирлын шинжтэй ажил үүргийг байнга эрхэлдэг ажилтан /ажил зогссон үед/	ХХДХ	8.5		1.0		0.5		0.5-2.5		2.0		12.5-14.5	НДЕХ-ийн 18.1, ЭМДТХ-ийн 8.2, 8.3, ХөдТХ-ийн 116.4
18	28002	Улсын хил дээр ажиллаж байгаа гаалийн улсын байцаагчийн	ХХДХ	17.0		1.8								18.8	НДЕХ-ийн 7.4.1, 18.1, 21.11, ГТХ-ийн 282.7
		ажилгүй байгаа эхнэр/ нөхөр													
19	29002	Улсын хил дээр албаа хааж байгаа офицер, ахлагчийн ажилгүй байгаа эхнэр/нөхөр	ХХДХ	17.0		1.8								18.8	НДЕХ-ийн 7.4.1, 18.1, 21.11, МУХТХ-ийн 39.4
20	30002	Дипломат төлөөлөгчийн газрын ажилтны хөдөлмөр эрхлээгүй, өндөр насны тэтгэвэр тогтоолгоогүй эхнэр/нөхөр	ХХДХ	17.0		1.8								18.8	НДЕХ-ийн 7.4.6, 18.1, 21.15, ДАТХ-ийн 23.2
21	31002	Гамшгаас хамгаалах болон бусад дайчилгаагаар ажилласан хүн	ХХДХ	8.5		1.0								9.5	НДЕХ-ийн 7.4.7, 18.1, 21.16,
22	32001	Хууль бусаар ажлаас халагдсан хүн	ЦХТАО	8.5	8.5	1.0	0.8	0.5	0.2	0.5-2.5		2.0	2.0	24.0-26.0	НДЕХ-ийн 7.2.5, 18.1, 21.7, ЭМДТХ-ийн 8.2, 8.3
23	34001	Сул зогсолтын үеийн олговор авч байгаа тэтгэвэр тогтоолгосон ажилтан (тэтгэврийн	Олговор нь ажилтны үндсэн цалингийн 60%-аас	8.5	8.5	1.0	0.8			0.5-2.5				19.3-21.3	НДЕХ-ийн 18.1, ХөдТХ-ийн 116.1,

		даатгалын шимтгэл төлнө)	багагүй, ХХДХ-ээс багагүй байна												
24	34011	Сул зогсолтын үеийн олговор авч байгаа тэтгэвэр тогтоолгосон ажилтан (тэтгэврийн даатгалын шимтгэл төлөхгүй)	Олговор нь ажилтны үндсэн цалингийн 60%-аас багагүй, ХХДХ-ээс багагүй байна			1.0	0.8			0.5-2.5				2.3-4.3	НДЕХ-ийн 7 18.1, 21, ХөдТ ийн 116 Даатгуулагчийн төрсөн о харгалзах өнд насны тэтгэв тогтоолгох нас баримтална.
25	37001	Шашны байгууллагын лам, санваартан	ЦХТАО	8.5	8.5	1.0	0.8							18.8	НДЕХ-ийн 7.4 18.1, 21.12,
26	38002	Тэтгэвэр тогтоолгосны дараа ажиллаж байгаа жирэмсний болон амаржсаны амралттай ажилтан (тэтгэврийн даатгалын шимтгэл төлнө)	ХХДХ	8.5		1.0				0.5-2.5				10.0-12.0	НДЕХ-ийн 7.3 18.1, 21,
27	39002	Тэтгэвэр тогтоолгосны дараа ажиллаж байгаа хөдөлмөрийн чадвараа 1 сараас дээш хугацаанд түр алдсан ажилтан (тэтгэврийн даатгалын шимтгэл төлнө)	ХХДХ	8.5		1.0				0.5-2.5				10.0-12.0	НДЕХ-ийн 7.3 18.1, 21,
28	39012	Тэтгэвэр тогтоолгосны дараа ажиллаж байгаа хөдөлмөрийн чадвараа 1 сараас дээш хугацаанд түр алдсан ажилтан (тэтгэврийн даатгалын шимтгэл төлөхгүй)	ХХДХ			1.0				0.5-2.5				1.5-3.5	НДЕХ-ийн 7.3 7.6, 18.1, 2 Даатгуулагчийн төрсөн о харгалзах өнд насны тэтгэв тогтоолгох нас баримтална.
29	40001	Үндсэн ажлаас гадуур зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ажилтан	ЦХТАО	8.5	8.5							2.0	2.0	21.0	НДЕХ-ийн 7.5 18.1,
30	41002	Жирэмсний болон амаржсаны амралттай байгаа цэргийн алба хаагч эх	ХХДХ									2.0		2.0	ЦАХТТТХ-ийн ЦАХТТТХ-24, ЭМДТХ-4.2
31	41012	Хүүхэд асрах чөлөөтэй байгаа цэргийн алба хаагч эх	ХХДХ									2.0		2.0	ЦАХТТТХ-ийн ЦАХТТТХ-17[1] ЭМДТХ-4.2
32	42002	Нэг сараас дээш хугацаагаар хөдөлмөрийн чадвараа алдсан цэргийн алба хаагч	ХХДХ									2.0		2.0	ЦАХТТТХ-ийн ЦАХТТТХ-24, ЭМДТХ-4.2
33	50001	Хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээтэй өмгөөлөгч	ЦХТАО	8.5	8.5	1.0	0.8	0.5	0.2	0.5-2.5		2.0	2.0	24.0-26.0	НДЕХ-ийн 7.2 18.1, 21 ЭМДТХ-ийн 8 8.3

34	51002	Шилжин ажилласан Зэвсэгт хүчин, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албаа хаагчийн хөдөлмөр эрхлэзгүй эхнэр/нөхөр	ХХДХ	17.0		1.8								18.8	НДЕХ-ийн 7.4.2, 18.1, 21.11,
35	53001	Цэргийн гэрээт албаа хаагч	ЦХТАО										2.0	2.0	4.0	ЦАХТТТХ-ийн 5, ЭМДТХ 4.2, ЗГ-ын 2018 оны 11-р тогтоолын 5.3, 5.4
36	61001	Цэргийн цолны мөнгө авсан хүүхдээ асрах чөлөөтэй байгаа цэргийн албаа хаагч эх	Олгосон цэргийн цолны мөнгөний хэмжээ										2.0	2.0	4.0	ЦАХТТТХ-ийн 5, ЦАХТТТХ-7.1, ЦАХЭЗБТХ-5.1.2, ЭМДТХ-4.2,
37	68001	Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого авсан хүүхдээ асрах чөлөөтэй байгаа эх/эцэг	ЦХТАО	8.5	8.5	1.0	0.8	0.5	0.2	0.5-2.5			2.0	2.0	24.0-26.0	НДЕХ-ийн 7.2, 18.1, 21.2, ЭМДТХ-ийн 8.2, 8.3
38	69001	Цэргийн албаа хаасны болон хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосны дараа цэргийн цолтой ажиллаж байгаа албаа хаагч	ЦХТАО												0.0	ЦАХТТТХ-ийн 5, ЭМДТХ-ийн 4.2,
39	70001	Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон ажилтан (тэтгэврийн даатгалын шимтгэл төлнө)	ЦХТАО	8.5	8.5	1.0	0.8			0.5-2.5					19.3-21.3	НДЕХ-ийн 7.3.4, 18.1, 21,
40	70011	Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон ажилтан (тэтгэврийн даатгалын шимтгэл төлөхгүй)	ЦХТАО			1.0	0.8			0.5-2.5					2.3-4.3	НДЕХ-ийн 7.6, 18.1, 21, Даатгуулагчийн төрсөн онд харгалзах өндөр насны тэтгэвэр тогтоолгох насыг баримтална.
41	71002	Цэргийн байгууллагын захиалгаар суралцагч цэргийн цолтой албаа хаагч	ХХДХ										2.0		2.0	ЦАХТТТХ-ийн 5, ЦАХЭЗБТХ-4.3.2, ЭМДТХ-ийн 4.2,
42	72001	Хилс хэргээр мөрдөгдсөн, хилс хэргээр хорих ял эдэлсэн хүн	ЦХТАО	8.5	8.5	1.0	0.8	0.5	0.2	0.5-2.5			2.0	2.0	24.0-26.0	НДЕХ-ийн 7.2.6, 18.1, 21.8, ЭМДТХ-ийн 8.2, 8.3
43	74002	Дагалднаар суралцаж байгаа хөдөлмөрийн гэрээтэй ажилтан	ХХДХ	17.0		1.8		0.7		0.5-2.5			4.0		24.0-26.0	НДЕХ-ийн 7.2.1, 18.1, 21.5, ЭМДТХ-ийн 8.2, 8.3
44	75001	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	ЦХТАО	8.5	8.5	1.0	0.8			0.5-2.5			2.0	2.0	23.3-25.3	НДЕХ-ийн 7.3.1, 18.1, 21.9
45	76001	Бүх шатны сонгуулийн хэсэг, хороонд ажиллахаар томилогдсон иргэн	ЦХТАО	8.5	8.5	1.0	0.8			0.5-2.5			2.0	2.0	23.3-25.3	НДЕХ-ийн 7.3.2, 18.1, 21.9,

Товчилсон үгийн тайлбар:

НДЕХ-Нийгмийн даатгалын ерөнхий хууль, ЭМДТХ-Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, ЦХТАО-Цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, ХХДХ-Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, ЦАХТТТХ-Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, ХөдТХ-Хөдөлмөрийн тухай хууль, ГТХ-Гаалийн тухай хууль, НДҮЗ- Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, ЦАХЭЗБТХ-Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, МУХТХ-Монгол Улсын хилийн тухай хууль, ДАТХ-Дипломат албаны тухай хууль, ХЭДТХ-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, БНСУ-Бүгд Найрамдах Солонгос Улс.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ ДААТГУУЛАГЧ ӨӨРӨӨ БОЛОН НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН, УЛСЫ ТӨСВӨӨС ХАРИУЦАН ТӨЛӨХ ДААТГУУЛАГЧИЙН ТӨРӨЛ, КОД

Д/Д	ДААТГУУЛАГЧИЙН ТӨРЛИЙН КОД	ДААТГУУЛАГЧИЙН ТӨРӨЛ	ШИМТГЭЛ ТООЦОХ ЦАЛИН ХӨЛС, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГО	ШИМТГЭЛ ТӨЛӨХ ХЭМЖЭЭ /КОД/							НИЙТ НДШ	ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗААЛТ
				ТЭТГЭВЭР				ТЭТГЭМЖ			ҮОМШӨ		
				УЛСЫН ТӨСВӨӨС	ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛЫН САНГААС	ҮОМШӨ-ИЙН ДААТГАЛЫН САНГААС	ДААТГУУЛАГЧ	УЛСЫН ТӨСВӨӨС	ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛЫН САНГААС	ДААТГУУЛАГЧ	ДААТГУУЛАГЧ		
1	09003	Сайн дураар даатгуулагч	Өөрөө мэдүүлсэн орлого				11.5			1.0	1.0	13.5	НДЕХ-ийн 7.7, 18.3, 21
2	26003	Хөдөлмөрийн гэрээгээр БНСУ-д ажиллаж байгаа Монгол Улсын иргэн	НДҮЗ-ийн тогтоосон хэмжээгээр				8.5					8.5	НДЕХ-ийн 7.3.3, 18.4, 21.10
3	43004	Цаа буга маллан тайгад амьдарч байгаа цаатан	ХХДХ	8.5				0.8				9.3	НДЕХ-ийн 7.4.8, 18.1, 21.17
4	62003	Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлсөн даатгуулагч	1995-1999 оны ХХДХ				10.0					10.0	АЖТДШН ТТХ-1
5	63003	Тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлсөн малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч	420.000 төгрөг				10.0					10.0	МХХЭТДШ НТТХ-4.1, 5.1
6	64004	ЖАТ авсан, хүүхдээ 3 нас хүртэл асарч байгаа сайн дураар даатгуулагч эх-ХХДХ	ХХДХ		5.75		5.75		0.5	0.5	1.0	13.5	НДЕХ-ийн 21.21.1
7	64014	ЖАТ тэтгэмж авсан, хүүхдээ 3 нас хүртэл асарч байгаа сайн дураар даатгуулагч эх ХХДХ-ээс дээш	Өөрөө мэдүүлсэн орлого		ХХДХ-ний 5.75		Мэдүүлсэн орлогын 11.5 хувиас тэтгэмжийн сангаас төлөх дүнг хассан зөрүүгээр		ХХДХ-ний 0.5	Мэдүүлсэн орлогын 1 хувиас тэтгэмжийн сангаас төлөх дүнг хассан зөрүүгээр	1.0	13.5	НДЕХ-ийн 21.21.1, 21.24
8	65004	ЖАТ аваагүй, хүүхдээ 3 нас хүртэл асарч байгаа сайн дураар даатгуулагч эх-ХХДХ	ХХДХ	5.75			5.75	0.5		0.5	1.0	13.5	НДЕХ-ийн 21.21.2
9	65014	ЖАТ аваагүй, хүүхдээ 3 нас хүртэл асарч байгаа сайн дураар даатгуулагч эх ХХДХ-ээс дээш	Өөрөө мэдүүлсэн орлого	ХХДХ-ний 5.75			Мэдүүлсэн орлогын 11.5 хувиас улсын төсвөөс төлөх дүнг хассан зөрүүгээр	ХХДХ-ний 0.5		Мэдүүлсэн орлогын 1 хувиас улсын төсвөөс төлөх дүнг хассан зөрүүгээр	1.0	13.5	НДЕХ-ийн 21.21.2, 21.24

10	66004	ҮОМШӨ-ний даатгалын сангаас ХЧА-ны тэтгэвэр авагч	ХХДХ		8.5						8.5	НДЕХ-ийн 7.5.2, 18.1, 21.25
11	67004	Цэргийн алба хаасан хугацааны шимтгэлийг улсын төсвөөс төлүүлсэн иргэн	ЦХТАО	8.5			1.0				9.5	НДЕХ-ийн 18.1, ЦАХТТТХ-6.3, ЗГ-ын 2019 оны 137
12	67014	Цэргийн алба хаасан хугацааг өсгөн тооцсон хугацааны шимтгэлийг улсын төсвөөс төлүүлсэн иргэн	ХХДХ	8.5			1.0				9.5	НДЕХ-ийн 18.1, ЦАХТТТХ-6.3, ЗГ-ын 2019 оны 137
13	73004	Цаг уурын хүнд нөхцөл бүхий улс дахь ДТГ-т ажилласан жилийг өсгөн тооцуулсан ажилтан	ХХДХ	8.5							8.5	НДЕХ-ийн 18.1, 21.27, ДАТХ-22.4
14	77003	Хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад ажиллаж байгаа Монгол Улсын иргэн	НДҮЗ-ийн тогтоосон хэмжээгээр			8.5			0.8	0.5-2.5	9.8-11.8	НДЕХ-ийн 7.3.3, 18.4, 21.10
15	78004	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч ажил хөдөлмөр эрхлээгүй эх/эцэг/-ХХДХ	ХХДХ	11.5					1.0	1.0	13.5	НДЕХ-ийн 7.7, 18.3, 21.22
16	78014	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч ажил хөдөлмөр эрхлээгүй эх/эцэг-ХХДХ-нээс дээш	Өөрөө мэдүүлсэн орлого	ХХДХ -ний 11.5		Мэдүүлсэн орлогын 11.5 хувиас улсын төсвөөс төлөх дүнг хассан зөрүүгээр			1.0	1.0	13.5	НДЕХ-ийн 7.7, 18.3, 21.24

79004	Сайн дураар даатгуулагч малчин, туслах малчин-ХХДХ	ХХДХ	5.75			5.75			1.0	1.0	13.5	НДЕХ-ийн 7.7, 18.3, 21.23, ХЭДТХ-ийн 3.1.9, ХөдТХ-ийн 71.2	Тухайн мөрд байгаа с ХХДХ ногд тэтгэвр даатга шимтгэ 50 хув улсы төсвөө бүр тө Улсы төсве хариу төлөх ху 5 жил ихгүй б
79014	Сайн дураар даатгуулагч малчин, туслах малчин-ХХДХ-ээс дээш	Өөрөө мэдүүлсэн орлого	ХХДХ-ний 5.75			Мэдүүлсэн орлогын 11.5 хувиас улсын төсвөөс төлөх дүнг хассан зөрүүгээр			1.0	1.0	13.5	НДЕХ-ийн 7.7, 18.3, 21.24, ХЭДТХ-ийн 3.1.9, ХөдТХ-ийн 71.2	Тухайн мөрд байгаа с ХХДХ ногд тэтгэвр даатга шимтгэ 50 хув улсы төсвөө бүр тө Улсы төсве хариу төлөх ху 5 жил ихгүй б

Товчилсон үгийн тайлбар:
НДЕХ-Нийгмийн даатгалын ерөнхий хууль, ХХДХ-Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, ЦАХТТТХ-Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, НДҮЗ-Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, ДАТХ-Дипломат албаны тухай хууль, БНСУ-Бүгд Найрамдах Солонгос Улс, АЖТДШНТТХ-Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хууль, МХХЭТДШНТТХ-Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль, ЖАТ-Жирэмсний болон амаржсаны тэтгэмж, ҮОМШӨ- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин,

Даатгуулагчийн төрлийн ангилалд төрөл, код нэмэх, өөрчлөх шаардлага гарсан тухай бүрт Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж хэрэгжилтийг ханган ажиллана.

Энэхүү аргачлалыг зөрчсөн байгууллага, ажилтан, даатгуулагч, иргэнд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2023.10.16 № 1/5360

танай 2023.10.04 -ны № 01/2484 -т

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД Х.БУЛГАНТУЯА
ТАНАА

Гадаад харилцааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан “Монгол Улсаас хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газрын ажилтны адилтгах албан тушаалын жагсаалт, нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах жишиг цалин хөлсний хэмжээг батлах тухай” 2023 оны А/69, А/132 дугаар тушаалыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзээд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн .....6450.....дугаарт бүртгэж хүргүүлэв.

Б.ЭНХБАЯР

151604852

Doc.yam.a5.2023

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2023 оны 10 сарын 16-ны өдрийн 6450 дугаарт бүртгэв.

ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2023 оны 10 дугаар сарын 02-ны өдөр | Дугаар А/69 / А/132 | Улаанбаатар хот

Монгол Улсаас хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газрын ажилтны адилтгах албан тушаалын жагсаалт, нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах жишиг цалин хөлсний хэмжээг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.29 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Монгол Улсаас хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газрын ажилтны адилтгах албан тушаалын жагсаалт, нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах жишиг цалин хөлсний хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Дипломат төлөөлөгчийн газрын ажилтны нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тооцоход Засгийн газраас тогтоосон төрийн захиргааны төв байгууллагын төрийн захиргааны болон төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээ, төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээ, холбогдох нэмэгдлийг тус тус баримталсугай.

3.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “Адилтгах албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” Гадаад харилцааны сайд, Хөдөлмөрийн нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/48, А/130 дугаар хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэхүү тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД

Б.БАТЦЭЦЭГ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД

Х.БУЛГАНТУЯА

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ ТӨАГУУГ
ХУУЛЬБАР УНЭН
ТӨРИЙН ЗАСГИЙН ГАЗРЫН УДИРДЛАГЫН ДАРГА
Гарын үсэг:
2023 он 10 сар 04 өдөр


Гадаад харилцааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгаллын сайдын 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/69 / А/132 дугаар хамтарсан тушаалын хавсралт


Монгол Улсаас хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газрын ажилтны адилтгах албан тушаалын жагсаалт, нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах жишиг цалин хөлсний хэмжээ

№	Дипломат төлөөлөгчийн газрын албан тушаал	Гадаад харилцааны яамны адилтгах албан тушаал	Жишиг цалин хөлсний хэмжээ
1.	Элчин сайд Байнгын төлөөлөгч Ерөнхий консул	Төрийн нарийн бичгийн дарга	ТЗ-1
2.	Элчин Хэргийг хамаарагч Байнгын төлөөлөгчийн орлогч Элчин зөвлөх	Газрын захирал	ТЗ-2
3.	Цэргийн атташе Консул (Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн) Консулын хэлтсийн дарга	Газрын дэд захирал	ТЗ-3
4.	Зөвлөх	Зөвлөх	ТЗ-4
5.	Нэгдүгээр нарийн бичгийн дарга Консул Худалдааны төлөөлөгч	Нэгдүгээр нарийн бичгийн дарга	ТЗ-5
6.	Хоёрдугаар нарийн бичгийн дарга Дэд консул Консулын төлөөлөгч Цэргийн атташегийн туслах	Хоёрдугаар нарийн бичгийн дарга	ТЗ-6
7.	Гуравдугаар нарийн бичгийн дарга	Гуравдугаар нарийн бичгийн дарга	ТЗ-7
8.	Атташе	Атташе	ТЗ-8
9.	Ахлах нягтлан бодогч	Ахлах мэргэжилтэн	ТЗ-6
		Ахлах нягтлан бодогч	ТУ-9
10.	Консулын техник ажилтан	Мэргэжилтэн	ТЗ-9
11.	Аж ахуйн эрхлэгч-жолооч	-	ТУ-7
	Ажил эрхэлж буй төвийн томилолттой ажилтны гэр бүл	-	
12.	Жолооч, сантехникч, мужаан	-	ТУ-6
13.	Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүний томилсон үйлчилгээ техникийн ажилтан	-	ТУ-5

14.	Төвийн томилолттой ажилтны ажил эрхлээгүй гэр бүл	-	НДЕХ-ийн 7.4.6, 21.15-д зааснаар
15.	Төвийн томилолттой ажилтны дипломат албан тушаалтай гэр бүл	Тухайн ажилтны сүүлд эрхэлж байсан албан тушаалын ангиллаар	

---oOo---





МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2024.07.29 № 03/1600

танай_____-ны №_____-т

АЙМАГ, ДҮҮРГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН МАГАДЛАЛЫН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА НАРТ

Заавар хүргүүлэх тухай

Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн "Заавар батлах тухай" А/293, А/133 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр, зохицуулалт хийхэд баримтлах өвчний заавар"-ыг баталсан.

Захиргааны ерөнхий хуулийн дагуу Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 6901 дугаар бүртгэгдсэн тул даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэх үйл ажиллагаанд уг зааврыг баримтлан, хэрэгжилтийг ханган ажиллана уу.

Хавсралт 436 хуудастай.

ЗАХИРГАА УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА Б.ДАВААХҮҮ

1524072168

МОНГОЛ УЛСЫН
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5, Утас: 26-15-53,
Факс: 32-86-34, Цахим шуудан: info@mlsp.gov.mn
Цахим хуудас: www.mlsp.gov.mn

2024.07.24 № 03/19

танай _____-ны №_____-т

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА Л.МӨНХЗУЛ ТАНАА

Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 6901 дүгээрт бүртгэсэн "Заавар батлах тухай" Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгаалллын сайдын 2024 оны А/293, А/133 дугаар хамтарсан тушаалын хуулбарыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 43 хуудастай.

Хүндэтгэсэн,

ХӨДӨЛМӨРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА
БӨГӨӨД ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.АЛИМАА

ATA12944 9132155 9024070603

Дэлгэрэнгүй тайлбар, хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг хүсье.

157240017

D: 2024 on 07 sar A5

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024.07.08 № 1/3374

танай 2024.07.04-ны № 01/1910 -т

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД Х.БУЛГАНТУЯА
ТАНАА

"Заавар батлах тухай" Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/293, А/133 дугаар хамтарсан тушаалыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянаж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн .6901.. дугаарт бүртгэснийг үүгээр хүргүүлж байна.

Б.ЭНХБАЯР

15160616 Ц.Сувдаа 5.2024

2024 оны 07 сарын 16-ны
өдрийн 6901 дугаарт бүртгэв

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД,
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2024 оны 06 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар А/293 А/133

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.5 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний зааврыг хавсралтаар баталсугай.

2. Энэ зааврыг мөрдөж ажиллахыг Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөл, салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөлд тус тус үүрэг болгосугай.

3. Эрүүл мэндийн магадлалын зөвлөл, Эмнэлэг хяналтын комисс, холбогдох эмч, мэргэжилтэнд энэхүү зааврыг хэрэгжүүлэх талаар сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах, иргэдэд мэдээлэл өгч, сурталчилж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж үйлчилгээний газар /А.Өнөржаргал/, Нийгмийн даатгалын ерөнхий газар /Л.Мөнхзул/, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлд тус тус даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/, Хөдөлмөр, нийгмийн хамгаалллын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Мөнхзул/-т тус тус даалгасугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

С.ЧИНЗОРИГ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД

Х.БУЛГАНТУЯА

https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140908682701

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024.01.09 № 1/94

танай 2023.12.19-ны № 03/3319-т

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД Х.БУЛГАНТУЯА
ТАНАА

“Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний жагсаалт батлах тухай” Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2023 оны А/441, А/192 дугаар тушаалыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзээд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн ..6540.. дугаарт бүртгэж хүргүүлэв.

Б.ЭНХБАЯР

151805753

Doc.yam a5.2023

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2024 оны 01 сарын 09-ны өдрийн 650 дугаарт бүртгэв.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД,
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2023 оны 12 дугаар сарын 15 -ны өдөр

Дугаар А/441/А/892

Улаанбаатар хот

Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний жагсаалт батлах тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хууль (шинэчилсэн найруулга)-ийн 43 дугаар зүйлийн 43.5 дахь хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.7 дахь хэсэг, Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний жагсаалт"-ыг хавсралтаар батлалсугай.

2.Энэ тушаалыг мөрдөж ажиллахыг Эрүүл мэндийн магадлалын төв, салбар, орон нутгийн зөвлөл, эмнэлгийн байгууллагын Эмнэлэг хяналтын комисст тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн магадлалын зөвлөл, Эмнэлэг хяналтын комисс, холбогдох эмч, мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах, даатгуулагч, хүнд мэдээлэл өгч, сурталчилж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар /А.Өнөржаргал/, Нийгмийн даатгалын ерөнхий газар /Л.Мөнхзул/, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлд тус тус даалгасугай.

4.Өвчний жагсаалтаас хасагдсан эсхүл өөрчлөгдсөн өвчний заалтаар урьд нь хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шийдвэрийн хүчин төгөлдөр хугацааг дуусах хүртэл хугацаанд хэвээр үргэлжлүүлсүгэй.

5.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Эмнэлэг тусламж, үйлчилгээний газар /А.Өнөржаргал/, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Батжаргал/-т тус тус даалгасугай.

6.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/758, А/197 дугаар хамтарсан тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.

ТУЗ894
9932155
1119277797

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХУУЛЬ ЗҮЙН ГАЗРЫН ДЭРГЭН

Гарын үсэг: _____
2023 он 12 сар 19 өдөр

7.Энэхүү тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

С.ЧИНЗОРИГ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД

Х.БҮЛГАНТУЯА

ТУЗ394
99332155
1119277797

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ ТӨРИЙН ЗАСАГ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГЫН ХУУЛЬБАР ҮҮРЭГ

Гарын үсэг: _____

2023 он 12 сар 19 өдөр

Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 15 өдрийн А/449, А/1092 дугаар хамтарсан тушаалын хавсралт

ДААТГУУЛАГЧ, ХҮНИЙ ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР АЛДАЛТЫН ХУВЬ, ХУГАЦАА, ШАЛГТААНЫГ МАГАДЛАХ, ХӨДӨЛМӨР ЗОХИЦУУЛАЛТ ХИЙХЭД БАРИМТЛАХ ӨВЧНИЙ ЖАГСААЛТ

№	Өвчний нэр	Үе шат	Өвчний код	Хувь хэмжээ	Хугацаа	Хөдөлмөрийн нөхцөл солих,
А.Ердийн өвчин болон ахуйн осол						
1.ХАЛДВАРТ ӨВЧИН						
Амьсгалын эрхтний сүрьеэ						
1.1	Амьсгалын эрхтний сүрьеэгийн хүнд, хүндэвтэр хэлбэр зүрх судасны дутагдлын II, III үе	А. Амьсгал болон бусад эрхтний сүрьеэгийн шинэ тохиолдлын хүнд, хүндэвтэр хэлбэр, амьсгалын дутагдал II үе	А15	70	2 жил хүртэлх	
		Б. Амьсгал, бусад эрхтний сүрьеэгийн давтан тохиолдлын хүнд, хүндэвтэр хэлбэр, амьсгалын дутагдал III үе		80	2 жил	
1.2	Уушги болон бусад эрхтэнд сүрьеэ өвчний улмаас мэс засал хийлгэсэн	А. Тухайн эрхтний үйл ажиллагааны дутагдалгүй		70	2 хүртэлх жил	
		Б. Тухайн эрхтний үйл ажиллагааны дутагдалтай		80	2 жил	
1.3	Сорвит хөндийт сүрьетэй, сэдрэлийн үе, архаг хордлого, хоёр уушги хамарсан зүрх судасны дутагдлын II, III үе			80	2 жил	
Уушгины бус эрхтний сүрьеэ						
1.4	Сүрьеэгийн мэнэн идэвхтэй үедээ ба өвчилсний дараах үед тэнцвэр, хараа, сонсгол, хөдөлгөөний эрхтний үлдэц өөрчлөлтийн аль нэг илэрсэн бол	Сэдрэлийн ба намжмал үе	А17	80	2 жил	
1.5	Өвдөг, түнх, тохой, мөрний үений сүрьеэгийн хүндрэлийн улмаас үений хөдөлгөөн бүр мөсөн буюу 2/3 нь хязгаарлагдсан бол	Сэдрэлийн ба намжмал үе	А18	70	2 жил	
	Нурууны сүрьеэ (хүзүү, сээр, бүсэлхий, ууцны нугалам)-ын улмаас нурууны үений хөдөлгөөн 2/3-оос дээш хязгаарлагдаж хөдөлгөөнгүй болсон, аль нэг мөчинд саажилт үүссэн бол	Сэдрэлийн ба намжмал үе	А18	70	2 жил	
1.6	Сүрьеэгийн улмаас эрхтэн тогтолцооны талаас дахин сэргэхгүй өөрчлөлтөнд орсон (амьсгал, зүрх судасны архаг дутагдалтай, яс үе мөчний сүрьеэ, менингит)			80	2 жил	
Эмэнд тэсвэртэй сүрьеэ						
1.7	а/Амьсгалын ба бусад эрхтний эмэнд тэсвэртэй сүрьеэ (ЭТС)-ийн улмаас эмчлэгдэж байгаа болон эмчилгээний дараах үе	Сэдрэлийн ба намжмал үе	А15-А19	80	2 жил	
1.8	б/Амьсгалын болон бусад эрхтний маш олон эмэнд тэсвэртэй сүрьеэгийн (МОЭТС) бүх тохиолдол	Сэдрэлийн ба намжмал үе	А15-А19	90	хугацаагүй	
1.9	ДОХ, ХДХВ-ийн халдварын 1-4 дүгээр шат	а/ХДХВ-ийн халдварын эмнэлзүйн I-II үе шат(Ретровирусийн эсрэг эмчилгээнд 12 сар ба түүнээс дээш хугацаанд >95% тууштай хамрагдсан)	В20 В21 В22 В23 В24	60	2 жил	
		б/ ХДХВ-ийн халдварын эмнэлзүйн III үе шат (Ретровирусийн эсрэг эмчилгээнд 6 сар ба түүнээс дээш хугацаанд >95% тууштай хамрагдсан)		70	2 жил	
		в/ ХДХВ-ийн халдварын эмнэлзүйн IV үе шат- ДОХ (Ретровирусийн эсрэг эмчилгээ эхэлсэн байх)		80	2 жил	
1.10	Бруцеллёз	а/Ээнэгшил хагас алдсан өвөртөө үйлчлэх чадвартай (остеоартит, остеоартоз, спондилит) спондилёз, коксартроз)	А23	50	1 жил	
		б/Ээнэгшил бүрэн алдсан, өвөртөө үйлчлэх чадвартай (фиброз, анкилоз, үений хэлбэр, бүтэц алдагдаж эргэшгүй өөрчлөлттэй) бруцеллёзын ийлдсийн шинжилгээ сөрөгжсөн буюу үлдэц хэлбэртэй		70	2 жил	
		в/Ээнэгшил бүрэн алдсан, өвөртөө үйлчлэх чадваргүй		80	Хугацаагүй	
1.11	Хачигт энцафалит	Эрхтэн тогтолцооны саажилт, үлдэц хэлбэр	В88, В94	80	Хугацаагүй	


2.СЭТГЭЦ, ЗАН ҮЙЛИЙН ЭМГЭГ						
Сэтгэцийн органик ба шинж тэмдгийн эмгэг						
2.1	Альцгеймер өвчний тэнэгрэл, судасны гаралтай өвчний тэнэгрэл, пикийн, хантингтон өвчний тэнэгрэл, халдварын шалтгаант, тархины гэмтлийн шалтгаант, эпилепсийн үеийн тэнэгрэл	а/Хэсэгчилсэн тэнэгрэлд орж бусдын асрамж шаардлагатай бол	F00 F01 F02 F02.2 F02.8	80	2 жил	
		б/Бүрэн тэнэгрэлд орж бусдын байнгын асрамж шаардлагатай бол		90	Хугацаагүй	
Тархины гэмтэл ба үйлийн хямрал, бие махбодийн өвчний шалтгаант сэтгэцийн бусад эмгэг						
2.2	Органик галлюциноз, органик кататоник, органик дэмийрэл, органик сэтгэл цочирдлын эмгэг	Хий үзэгдэл, кататони, дэмийрэл, сэтгэл хөдлөлийн шинжүүд илэрч, дахилттай бол	F06.0 F06.1 F06.2 F06.3	70	2 жил	
Тархины өвчин, гэмтэл, үйл ажиллагааны хямралын шалтгаант бие хүний зан үйлийн эмгэг						
2.3	Бие хүний органик эмгэг	а/Зан төрхийн тод өөрчлөлттэй, танин мэдэхүй, сэтгэхүй, хэл ярианы өөрчлөлттэй хавсарсан бол	F07.0	60	1 жил	
		б/Зан төрхийн болон танин мэдэхүй, сэтгэхүй, хэл ярианы гүнзгий өөрчлөлттэй бол		70	2 жил	
2.4	Тархины өвчин, гэмтэл, үйл ажиллагааны шалтгаант бие хүний ба зан төрхийн бусад органик эмгэг	а/Зан төрхийн мэдэгдэхүйц өөрчлөлттэй, эмэнд дарагддаггүй уналт таталттай бол	F07.8	60	1 жил	
		б/Зан төрхийн гүнзгий өөрчлөлттэй, эмэнд дарагддаггүй уналт таталттай бол		70	2 жил	
		в/Зан төрхийн гүнзгий өөрчлөлттэй, ухамсарт ухаан бүрийтэн балартал, солиорол бүхий уналт таталттай бол		80	2 жил	
Сэтгэц идэвхт эм, бодисын шалтгаант сэтгэц, зан үйлийн эмгэг						
2.5	Архи, опиойдын, каннабиноидын, тайвшруулах нойрсуулах бодисын, кокайны, сэргээгч эм бодисын, хий үзэгдэл үүсгэгч эм бодисын, дэгдэмхий уусгагч бодисын, олон төрлийн сэтгэц идэвхт бодисыг хослуулан хэрэглэсний улмаас үүсэх сэтгэцийн болон зан үйлийн эмгэг	Архи, опиойдын, каннабиноидын, тайвшруулах нойрсуулах бодисын, кокайны, сэргээгч эм бодисын, Хий үзэгдэл үүсгэгч эм бодисын, дэгдэмхий уусгагч бодисын, олон төрлийн сэтгэц идэвхт бодисын шалтгаант солиорол (паранойд) хоорондоо богино хугацааны давтамжтай эсвэл тэнэгрэл илэрсэн бол	F10 F11 F12 F13 F14 F15 F16 F18 F19	70	2 жил	
Шизофрени, шизофренийн хэв шинжит ба дэмийрэх эмгэг						

ТУЗ894
9132155
1119277787


2.6	Шизофренийн хий үзэгдэл дэмийрлийн, хүүхдэрхэх, кататоник, үл ялгагдах, шизофренийн дараах сэтгэл гутрал, үлдэц шизофрени, энгийн хэлбэрүүд, бусад шизофрени	а/Солиорол (хий үзэгдэл, дэмийрэл, паранойд, Кандинский-Клеромбо, гебефрени, кататони, сэтгэл гутралын)–ын шинжүүд тод, эмчилгээний үр дүнд засарсан хэдий ч орчиндоо дасан зохицох чадвар буурсан бол	F20.0 F20.1 F20.2 F20.3 F20.4 F20.5 F20.6 F20.8	60	1 жил	
		б/Солиорол (хий үзэгдэл, дэмийрэл, паранойд, Кандинский-Клеромбо, гебефрени, кататони, сэтгэл гутралын) –ын шинжүүд тогтвортой тод илэрч, өвчин дахих бүрт негатив шинжүүд ихэсч байгаа боловч засрал сайжралд ордог бол		70	2 жил	
		в/Солиорол (хий үзэгдэл, дэмийрэл, паранойд, Кандинский-Клеромбо, гебефрени, кататони, сэтгэл гутрал, парафрени)-ын шинжүүд бүдэг буюу үлдэц хэлбэрээр тогтвортой негатив шинжүүдийн суурин дээр илэрч, засрал сайжралд ордоггүй бол		80	2 жил	
		г/Өвчний төгсгөлийн үе буюу шизофренийн негатив, позитив шинжийн аль аль нь арилахгүйгээр илэрч, бие даан амьдрах чадваргүй, бусдын хараа хяналт, асрамж шаардлагатай бол		100	Хугацаагүй	
2.7	Шизофренийн хэв шинжит эмгэг	а/Этгээд төрх, ер бусын итгэл үнэмшил, хачин бодол санаа, сенестопати, дереализаци, деперсонализаци, дисморфофоби, үл ялих зовлонт үзэгдэл шинжүүд тод, солиорлын шинжүүд бүдэг илэрч, орчиндоо дасан зохицох чадвар буурсан бол	F21	60	1 жил	
		б/Этгээд төрх, ер бусын итгэл үнэмшил, хачин бодол санаа, сенестопати, дереализаци, деперсонализаци, дисморфофоби, үл ялих зовлонт үзэгдэл шинжүүд тод, солиорлын шинжүүд тод илэрч байгаа боловч засрал сайжралд ордог бол		70	2 жил	

ТУЗ894
9132155
1119277787

		в/Этгэзд төрх, ер бусын итгэл үнэмшил, хачин бодол санаа, сенестопати, дереализаци, деперсонализаци, дисморфофоби, үл ялих зовлонт үзэгдэл шинжүүд тод, солиорлын шинжүүд бүдэг илэрч байгаа боловч засрал сайжралд ордоггүй бол		80	2 жил	
		г/Өвчний төгсгөлийн үе буюу үлдэц бүхий шинжтэй, бие даан амьдрах чадваргүй, бусдын хараа хяналт, асрамж шаардлагатай бол		90	Хугацаагүй	
2.8	Байнга дэмийрэх эмгэг	а/Солиорол (системчлэгдсэн дэмийрэл)-ын шинжүүд тод илэрч, орчиндоо дасан зохицох чадвар буурсан бол	F22	60	1 жил	
		б/Солиорол (системчлэгдсэн дэмийрэл)-ын тод илэрч байгаа боловч засрал сайжралд ордог бол		70	2 жил	
		в/Солиорол (системчлэгдсэн дэмийрэл)-ын тод илэрч байгаа боловч засрал сайжралд ордоггүй бол		80	2 жил	
		г/Өвчний төгсгөлийн үе буюу солиорол (системчлэгдсэн дэмийрэл) тод илэрч бие даан амьдрах чадваргүй, бусдын хараа хяналт, асрамж шаардлагатай бол		90	Хугацаагүй	
Шизоаффектив эмгэг						
2.9	Шизоаффектив эмгэгийн сэтгэл хөөрөх, гутрах, холимог хэлбэр	а/Шизоаффектив эмгэгийн солиорол (сэтгэл цочирдол, хий үзэгдэл, дэмийрэл, кататоник) бүхий сэтгэл хөөрөх, гутрах, холимог шинжүүд дахин давтагдан илэрч буй бол	F25.0 F25.1 F25.2	60	1 жил	
		б/Шизоаффектив эмгэгийн солиорол (сэтгэл цочирдол, хий үзэгдэл, дэмийрэл, кататоник) бүхий сэтгэл хөөрөх, гутрах, холимог шинжүүд эзлжлэн тасралтгүй илэрч буй бол		70	2 жил	
Сэтгэл цочирдлын хоёр туйлт эмгэг						




2.10	Солиорлын шинж тэмдэгтэй сэтгэл хөөрөл, гутрал, холимог шинж бүхий хоёр туйлт сэтгэл цочирдох эмгэг, сэтгэл гутрах дахилтат үечилсэн эмгэг	а/Сэтгэл цочирдлын хоёр туйлт (сэтгэл хөөрөл, сэтгэл гутрал,холимог шинж) сэтгэл гутралын дахилтат эмгэг 6 сараас дээш хугацаанд дахиж буй бол	F31.2 F31.5 F31.6 F33.1 F33.2 F33.3	60	1 жил	
		б/Сэтгэл цочирдлын хоёр туйлт (сэтгэл хөөрөл, сэтгэл гутрал, холимог шинж) сэтгэл гутралын дахилтат эмгэг 6 сараас доош хугацаанд дахиж, олон жилээр үргэлжилж буй бол		70	2 жил	
Стресстэй холбоотой неврозын болон биеийн хэлбэрийн эмгэгүүд						
2.11	Айдаст сэтгэл түгших, үл ялих зовлонт үзэгдлийн, дасан зохицохуйн, диссоциатив, биеийн хэлбэрийн, мэдрэл сульдах эмгэгүүд	Эмчилгээний үр дүнд сайжрал авдаг боловч мэргэжлийн ажлаа хийх боломжгүй болсон бол	F40 F42 F43 F44 F45 F48	-	-	Хөдөлмөрийн нөхцөл солих
2.12	Бие хүний паранойд, шизойд, диссоциатив, сэтгэлийн хөдөлгөөний тогтворгүй, истерийн, ананкаст,хараат, холимог ба бусад эмгэг	Бие хүний эмгэгүүд эзнэгшил алдагдалт 4-6 сар үргэлжилсэн тохиолдолд	F60.0 F60.1 F60.2 F60.3 F60.4 F60.5 F60.7 F61.0	50	1 жил	
Оюуны хомсдолын эмгэг						
2.13	Оюуны хөнгөн хомсдол	Оюуны хөнгөн хомсдол (IQ-50-69)/Насанд хүрсэн хүний сэтгэл зүйн нас 9-12 насны хүүхдийнхтэй ижил түвшний хөгжилтэй/	F70	60	2 жил	
2.14	Оюуны хүндэвтэр хомсдол	Оюуны хүндэвтэр хомсдол (IQ 35-49) /Насанд хүрсэн хүний сэтгэл зүйн нас 6-9 насны хүүхдийнхтэй ижил түвшний хөгжилтэй/	F71	70	3 жил	
2.15	Оюуны хүнд хомсдол	Оюуны хүнд хомсдол (IQ 20-34) /Насанд хүрсэн хүний сэтгэл зүйн нас 3-6 насны хүүхдийнхтэй ижил түвшний хөгжилтэй/	F72	80	Хугацаагүй	



2.16	Оюуны гүнзгий хомсдол	Оюуны гүнзгий хомсдол (IQ 20 хүртэл) /Насанд хүрсэн хүний сэтгэл зүйн нас 3 наснаас бага хүүхдийнхтэй ижил түвшний хөгжилтэй/, байнгын гардан асаргаа шаардлагатай бол	F73	90	Хугацаагүй	
2.17	Аутизмын хүрээний эмгэгүүд	Нийгмийн харилцаанд оролцох чадвар сул, бусдын хараа хяналт, асрамж шаардлагатай бол	F84.0 F84.2 F84.5	80	3 жил	
		3. ДОТРЫН ӨВЧНҮҮД				
3.1	Зүрхний архаг дутагдал (атеросклероз. зүрхний шигдээс, кардиомиопати, артерийн гипертензи, хэрэх, зүрхний төрөлхийн ба бусад олдмол эмгэг хамаарна)	а/ЗАД-ын "С" шат, диастолын дутагдал, ачаалал даах чадвар буурсан, зүрхний хэт авиан шинжилгээгээр зүрхний бүтцийн өөрчлөлттэй EF=41-49%, A/E<0.9 ба натри хөөгч пептидийн сорилоор NT-pro BNP >450 пг/мл байх	I50	60	2 жил	
		б/ЗАД-ын "D" шат, ЦЭД IV систолын дутагдал ачаалал даах чадвар буурсан, зүрхний хэт авиан шинжилгээгээр зүрхний бүтцийн өөрчлөлттэй EF≤40% ба натри хөөгч пептидийн сорилоор NT-pro BNP >1800 пг/мл байх	I50	80	2 жил	
3.2	Артерийн гипертензи	а/Бөөрний архаг дутагдлын II үе шат тархины цусан хангамжийн архаг дутагдал	I10	60	1 жил	
		б/Бөөрний архаг дутагдлын III үе шат. нүдний үгт торлог бүрхэвчийн хаван, ховхролт үүссэн, тархинд цус харваж, саажилт үлдсэн	I10	70	2 жил	
		в/Хоруу явцтай эмэнд тэсвэртэй артерийн гипертензи	I10	60	1 жил	
3.3	Зүрхний ишеми өвчин, Цэзжний бах	а/Цэзжний тогтвортой бах үйл ажиллагааны III зэрэг: зүрхний ачаалалтай сорилоор үйл ажиллагааны зэрэг нотлогдсон байх, титэм судасны зураг авах шинжилгээгээр титэм судас 50-75%-ийн нарийсалтай байх	I20	60	1 жил	
		б/Цэзжний тогтвортой бах үйл ажиллагааны IV зэрэг: тайван үеийн ЗЦБ-д ишемийн шинж илэрсэн байх, титэм судасны зураг авах шинжилгээгээр олон титэм судас > 75%-ийн нарийсалтай байх, эмийн эмчилгээ үр дүнгүй байх	I20	70	2 жил	

		в/Титэм судсан дотуурх эмчилгээний дараа цэзжний бах дахих: титэм судасны стент тавиулсаны дараа ЗЦБ-т ишемийн өөрчлөлт арилахгүй байх эсвэл шинээр илрэх, титэм судасны зураг авах шинжилгээгээр титэм судасны нарийсал дахин илрэх	I20	70	1 жил	
3.4	Зүрхний шигдээс	а/Хүндрэлгүй, дунд зэргийн эрсдэлтэй: ST сегмент өргөгдсөн шигдээсийн оношЗЦБ, ЗХАШ-р нотлогдох, ST сегмент өргөгдөөгүй шигдээс, шигдээсийн оношЗЦБ ба тропонины сорилоор нотлогдох	I21-I22	55	1 хүртэлх жил	
		б/Хүндрэл илэрсэн эрсдэлийн зэрэг өндөр байх: шигдээсийн хүндрэл маш өндөр эрсдэл нотлогдсон байх	I21-I22	70	2 жил	
3.5	Хүнд хэлбэрийн түр зуурын муужралт (синкопи) өгдөг хэм алдагдлууд	а/Пароксизмал тахикарди, тосгуур ховдлын хориг III зэрэг, синусын зангилааны сулралын хам шинж, эмийн эмчилгээнд үр дүнгүй тосгуурын жирвэгнээ 12 сарын дотор багадаа 3 удаа муужирч унасан	I47 I48 I44 I49 I45	60	1 жил	
		б/Электростимулятор тавигдсаны дараах үе	I47 I48 I44 I49 I45-Z45 Z95	50	1 хүртэлх жил	
3.6	Халдварт эндокардит	Тархи, зүрх бөөр дэлүүнд хүндрэл өгсөн	I33	60	1 жил	
3.7	Зүрхний төрөлхийн ба олдмол гажиг	а/Ачааллын хөхрелттэй: баруунаас зүүн тийш цусны урсгал илэрсэн, ачаалал ≤ 5 МЕТ	I05-I09 Q20-Q28	50	1 жил	
		б/Насанд хүрэгсдийн төрөлхийн гажиг засах мэс заслын эмчилгээний дараа (PASP<45 мм.муб)	Q20-Q28 I05-I09 T82	50	1 хүртэлх жил	
		в/Хиймэл хавхлага суулгах мэс заслын эмчилгээний дараа	T82	50	1 жил	
3.8	Уушгины артерийн анхдагч, хоёрдогч даралт ихсэлт	а/PASP=45-59мм МУБ	I27	70	2 жил	
		б/PASP≥ 60 мм МУБ	I27	80	2 жил	
3.9	Хоёр хавтаст хавхлагын үнжилт	Хүнд зэргийн хавхлага солих мэс заслын эмчилгээ хийлгэх заалттай тохиолдолд	I34	50	1 жил	
3.10	Гол судас. том салааны цулхэн	а/Хууралтгүй цулхэн /5 см дээш/	I71 I72	60	1 жил	


		б/Хууралттай цүлхэн	I71 I72	70	2 жил	
3.11	Захын судасны эмгэг	а/Гүний судасны эмгэг нь босох, суух, өргөх, түлхэх зэрэг ажил хөдөлмөртэй холбоотой үйл ажиллагааны алдагдал үүсгэх	I83	-	-	Хөдөлмөрийн нөхцөл солих
		б/Хөлийн гүний венийн судасны эмгэг багадаа 3 сараас доошгүй хугацаагаар үргэлжилсэн, хөлд байнгын хаван, тэжээлийн өөрчлөлттэй	I83	50	1 жил	
		в/Мөчдийн судасны хагалгааны дараах үе /Гүний артер венийн судас/	I83	50	1 хүртэлх жил	
		г/Хөл эсвэл гарын хурууны үзүүр үхжиж эхлэх үе	I83	70	2 жил	
		д/Энэ өвчнөөр хөл эсвэл гар аль нэг түвшинд тайруулсан	I83	80	Хугацаагүй	
		Ревматологийн өвчнүүд				
3.12	Тогтолцооны улаан чонон яр	а/Өндөр идэвхжилтэй, түгмэлзэр олон эрхтэн тогтолцоог гэмтээсэн боловч аль нэг эрхтний үйл ажиллагааны дутагдал илрээгүй	M32	60	2 жил	
		б/Өндөр идэвхжилтэй, түгмэлзэр олон эрхтэн тогтолцоог гэмтээж, аль нэгэн эрхтний үйл ажиллагааны дутагдал илэрсэн байх	M32	70	3 жил	
3.13	Ревматоид артрит	а/Өндөр идэвхжилтэй, олон үений үйл ажиллагаа алдагдсан, хөдөлгөөний үйл ажиллагааны алдагдал II-III зэрэг	M05 M06	60	1 жил	
		б/Өндөр идэвхжилтэй, хөдөлгөөний үйл ажиллагааны алдагдал IV зэрэг эсвэл түгмэлзэр эрхтэн тогтолцоог гэмтээсэн ба аль нэг эрхтний үйл ажиллагааны дутагдал илэрсэн	M05 M06	80	2 жил	
3.14	Васкулит	а/Өндөр идэвхжилтэй, түгмэлзэр олон эрхтэн тогтолцоог гэмтээсэн боловч аль нэг эрхтний үйл ажиллагааны дутагдал илрээгүй	L95	60	1 жил	




		б/Өндөр идэвхжилтэй, түгмэлзэр олон эрхтэн тогтолцоог гэмтээж, аль нэгэн эрхтний үйл ажиллагааны дутагдал илэрсэн байх	L95	70	2 жил	
3.15	Тогтолцооны хатуурал	а/Өндөр идэвхжилтэй, түгмэлзэр олон эрхтэн тогтолцоог гэмтээсэн боловч аль нэг эрхтний үйл ажиллагааны дутагдал илрээгүй	M34	60	1 жил	
		б/Өндөр идэвхжилтэй, түгмэлзэр олон эрхтэн тогтолцоог гэмтээж, аль нэгэн эрхтний үйл ажиллагааны дутагдал илэрсэн байх	M34	70	2 жил	
3.16	Дерматомиозит, полимиозит	а/Өндөр идэвхжилтэй, түгмэлзэр олон эрхтэн тогтолцоог гэмтээсэн боловч аль нэг эрхтний үйл ажиллагааны дутагдал илрээгүй	M33	60	1 жил	
		б/Өндөр идэвхжилтэй, түгмэлзэр олон эрхтэн тогтолцоог гэмтээж, аль нэгэн эрхтний үйл ажиллагааны дутагдал илэрсэн байх	M33	70	Хугацаагүй	
3.17	Ясны төрөлхийн болон олдмол эмгэгүүд (несовершенный остеогенез, гиперостоз, ясны тэжээл алдагдлын үхжлүүд)	а/Хөдөлгөөний үйл ажиллагааны алдагдал II-III зэрэг	Q78, M90.3-M90.5	60	1 жил	
		б/Хөдөлгөөний үйл ажиллагааны алдагдал IV зэрэг	Q78, M90.3-M90.5	70	Хугацаагүй	
3.18	Нурууны эмгэгүүд (дорсопати, нуруу гулсах, спондилопати барьцалдаат спондилитын хүндэвтэр хэлбэр)	а/Хөдөлгөөний үйл ажиллагааны алдагдал II-III зэрэг	M45-M49	60	1 жил	
		б/Хөдөлгөөний үйл ажиллагааны алдагдал IV зэрэг эсвэл дотор эрхтний үйл ажиллагааны алдагдал	M45-M49	70	Хугацаагүй	
		в/ Энэ өвчний үед гар, хөл тайрах мэс засал хийгдсэн, хөдөлгөөний үйл ажиллагааны алдагдал III-IV зэрэг	M86 M87 M89	80	Хугацаагүй	
3.19	Ясны архаг идээт үрэвсэл (остеомиелит, ясны үхжил, пажетийн өвчин, яс ясны чөмөгний үрэвсэл, гэмтлээс хатуурал, хөндий үүссэн)	а/Мэс заслын эмчилгээ хийгдсэн боловч, биеийн ерөнхий хордлого нэмэгдсэн буюу ясанд эмгэг өөрчлөлт үргэлжилсэн	M86.9	70	1 хүртэлх жил	



		б/Энэ өвчний үлмаас хөл тайрах мэс засал хийгдсэн, хөдөлгөөний үйл ажиллагааны алдагдал III-IV зэрэг		80	хугацаагүй	
3.20	Рейно хам шинж	а/Гарын хуруунд трофик өөрчлөлт гарч, цусгүйдэл болж, байнгын өвдөлттэй	I73	50	1 жил	
		б/Өвчин даамжирч гарын хуруунуудад их хэмжээний үхжил үүсч тайрах мэс засал хийлгэсэн	I73	70	Хугацаагүй	
3.21	Ясны бүтцийн эмгэгүүд (хүнд хэлбэрийн ясны сийрэгжилт, яс зөөлрөлт, остеит педжетийн, реклингхуазен, бехтеровын өвчин)	а/Хөдөлгөөний үйл ажиллагааны алдагдал II-III зэрэг	M81	60	1 жил	
		б/Хөдөлгөөний үйл ажиллагааны алдагдал IV зэрэг	M81 M83 M90.6 M88	70	Хугацаагүй	
3.22	Мөгөөрсний эмгэгүүд (Легга-Кальве-Пертесийн өвчин, остеохондроз, хондродисплазия, остеодисплазия, остеохондропатия)	а/Хөдөлгөөний үйл ажиллагааны алдагдал II-III зэрэг	M81 M83 M90.6 M88	60	1 жил	
		б/Хөдөлгөөний үйл ажиллагааны алдагдал IV зэрэг	M91 M42	70	Хугацаагүй	
3.23	Булчин, шөрмөс, зөөлөн эдийн өвчин	а/Хөдөлгөөний үйл ажиллагааны алдагдал II-III зэрэг	M60 M61 M62 M63 M68 M70-M79 M76 M79.9	60	1 жил	
		б/Хөдөлгөөний үйл ажиллагааны алдагдал IV зэрэг		70	Хугацаагүй	
3.24	Архаг тофустай, өвчний идэвхжилийн өндөр зэрэгтэй, хүндрэлтэй тулай.	а/Хөдөлгөөний үйл ажиллагааны алдагдал II-III		60	1 жил	
		б/Хөдөлгөөний үйл ажиллагааны алдагдал III-IV, бусад эрхтэн тогтолцоонд хүндрэлтэй		70	2 жил	
Амьсгалын эрхтний эмгэгүүд						
Уушгины амьсгалах талбайг хязгаарласан эмгэгүүд						
3.25	Амьсгалын эрхтний гаж хөгжил, дутуу хөгжил, нуруу, цээжний хэнхэрцгийн деформаци, фиброторакс	а/Амьсгалын дутагдал I, цусны эргэлтийн дутагдал "B" үе шат, Спирографи: VC 56-69% MLV 55-58%, FEV1/VC 74-55%. ЭхоКГ: зүрхний баруун ховдлын агших чадвар дунд зэрэг буурч уушгины гемодинамик алдагдах	J96.1 J94.1 M40	60	2 жил	



		б/Амьсгалын дутагдал II, зүрхний архаг дутагдлын "C" үе шат, Спирографи:VC 50-55%, MLV 51- 54%, FEV1/VC 54-40%. ЭхоКГ: зүрхний баруун ховдлын агших чадвар буурч уушгины гемодинамик алдагдах	J96.1 J94.1	70	2 жил	
		в/Амьсгалын дутагдал III, зүрхний архаг дутагдлын "D" үе шат Спирографи: VC≤50%, MLV50%, FEV1/VC< 40%, ЭхоКГ: баруун ховдлын агших чадвар буурч уушгины гемодинамик алдагдах	J96.1 J94.1	90-100	Хугацаагүй	
3.26	Уушигны завсрын эдийн эмгэгүүдийн улмаас үүссэн фиброз, хөндий	а/Уушгины фиброз: зөгийн үүрийн шинж, амьсгалын архаг дутагдлын II-III зэрэг, зүрхний архаг дутагдлын "C" үе шат	J84.1	80	2 жил	
		б/Уушгины фиброз: зөгийн үүрийн шинж, амьсгалын архаг дутагдлын III зэрэг, зүрхний архаг дутагдлын "D" үе шат	J84.1	90	Хугацаагүй	
Агаар дамжуулах зам ба цулцангийн эмгэгүүд						
3.27	Гуурсан хоолой тэлэгдэх өвчин	а/Эмийн эмчилгээнд үр дүнгүй, мэс засал хийлгэх шаардлагатай, амьсгалын дутагдлын II зэрэг, зүрхний дутагдлын "B", "C" үе шат	J47	60	1 жил	
		б/ГХТӨ 2 талыг хамарсан, мэс засал хийлгэсэн буюу давтан хийлгэх шаардлагатай, амьсгалын дутагдлын III зэрэг, зүрхний архаг дутагдлын "C" үе шат илрэх	J47	70	2 жил	
		в/Амьсгалын дутагдлын III зэрэг, уушгины цус алдалтын улмаас цус багадалтын III зэрэг, бөөрний амилоидозын улмаас бөөрний дутагдалын III зэрэг, туураалын III зэрэг, зүрхний архаг дутагдлын "C", "D" үе шатын аль нэг илрэх	J47	80	Хугацаагүй	
3.28	Гуурсан хоолойн багтраа	а/Дунд зэрэг, амьсгалын дутагдлын I-II зэрэг, хөдөлгөөний хязгаарлалт I зэрэг	J45-J46	50	1 жил	



		б/Хүнд зэрэг, амьсгалын дутагдлын II-III зэрэг, зүрхний дутагдлын "B", "C" үе шат, гормон эмчилгээний гаж нөлөөний улмаас дотоод шүүрлийн тогтолцооны үйл ажиллагаа алдагдах (чихрийн шижин, бөөрний дэзд булчирхайн дутагдал)	J45-J46	70	2 жил	
		в/Маш хүнд зэрэг, эмчилгээний үр дүн муу, амьсгалын дутагдлын III зэрэг, зүрхний архаг дутагдлын "D" үе шат, бусад эрхтний талаас органик өөрчлөлт илэрсэн, өөртөө үйлчлэх чадвар алдагдах	J45-J46	80	2 жил	
3.29	Уушигны архаг бөглөрөлт өвчин	а/Амьсгалын дутагдал I зэрэг, зүрхний архаг дутагдлын "B" үе шат, Спирографи: FEV1 50-79%. FEV1/FVC< 0.7, ЭхоКГ: зүрхний баруун ховдлын агших чадвар дунд зэрэг буурч уушгины гемодинамик алдагдах	J44	-	-	Хөдөлмөрийн нөхцөл солих
		б/Амьсгалын дутагдал II зэрэг, цусны эргэлтийн дутагдал "C" үе шат Спирографи: FEV1 31-49%. FEV1/FVC< 0.7 ЭхоКГ: зүрхний баруун ховдлын агших чадвар буурч уушгины гемодинамик алдагдах	J44	70	2 жил	
		в/Амьсгалын дутагдлын III зэрэг, зүрхний архаг дутагдлын "D" үе шат, өөртөө үйлчлэх чадвар алдалт III зэрэг, Спирографи: FEV1≤30%. FEV1/FVC< 0.7. ЭхоКГ: баруун ховдлын агших чадвар буурч уушгины гемодинамик алдагдах	J44	80	2 жил	
3.30	Уушигны артерийн бүлэнт бөглөрөл			70	1 жил	
	Хоол боловсруулах эрхтний эмгэг					
3.31	Улаан хоолойн сорвижилт нарийсал, ахалази зэнэгшил алдагдсан үе		K22	50	2 жил	
3.32	Нарийн бүдүүн гэдэсний эмгэг	а/Кроны өвчний хүнд хэлбэр	K50	70	2 жил	
		б/Бүдүүн гэдэсний шархлаат үрэвслийн хүнд хэлбэр	K51	70	2 жил	

ТУЗ894
9132155
1119277787

		в/Нарийн гэдэсний архаг эмгэг, тэжээлийн хүнд дуталтай: глютены энтеропати, эозинофилт энтеропати, туяа эмчилгээний дараах энтеропати	K90.9 K90 K52	70	2 жил	
3.33	Нойр булчирхайн архаг үрэвслийн дахилтат болон өвдөлттэй хэлбэр		K86	50	1 хүртэлх жил	
3.34	Элэгний эмгэг	а/Элэгний эмгэг Гепатитийн В, Делта вирусын шалтгаант архаг үрэвслийн үед Д вирусийн эсрэг өвөрмөц эмчилгээ (пег-интерферон, булевиртид, лонафарниб) хийх хугацаанд	B18	80	2 жил	
		б/Элэгний цирроз Чайльд-Пьюгийн ангиллаар "A" зэрэг	K74	60	1 жил	
		в/Элэгний цирроз Чайльд-Пьюгийн ангиллаар "B"зэрэг	K74	70	2 жил	
		г/Элэгний цирроз Чайльд-Пьюгийн ангиллаар "C"зэрэг	K74	80	Хугацаагүй	
		д/Порфирины эмгэг, хожуу үеийн арьс, элэгний хэлбэр	E80.1 E80.2	50	1 жил	
		е/Аутоиммуный элэгний эмгэг (аутоиммун гепатит, билиар цирроз гэх мэт бусад эрхтэн тогтолцооны өөрчлөлт илэрсэн байх)	K75.4	80	2 жил	
	Бөөрний эмгэгүүд					
3.35	Бөөрний түүдгэнцэрийн өвчин	а/Архаг гломерулонефрит (цустай шээх хэлбэр), бөөрний биопсийн заалтад нийцсэн үед бөөрний эдийн шинжилгээ хийж онош баталгаажсан байх	N02 N03	50	1 жил	
		алдагдал, өвдөлт, өвдөлт бүхий булчингийн чангарал) • **Шээсний замын тогтолцоо:** шээс хоригдох эсвэл задгайрах • **Зүрх-судасны тогтолцоо:** даралтны зохицуулга алдагдах, амьсгалын дутагдал • **Ходоод-гэдэсний замын тогтолцоо:** өтгөн хатах хоригдох, эсвэл дусагнах задгайрах • **Арьсны өөрчлөгдөх**: өнгө тэжээл өөрчлөгдөх цооролт хумс зузаарах нимгэрэх	тээврийн хэрэгслээр бие даан явах чадвар буурах) • Өөрийгөө арчлах чадвар буурах (хувцаслах, бие засах, ариун цэврийг сахих, хооллох г.м.) • Ахуйн үйлдэл хийх чадвар алдагдах (дэлгүүрээс хүнс цуглуулах, хоол хийх, гэр цэвэрлэх г.м.) • Хүн хоорондын харилцааны чадвар алдагдах (хүнтэй танилцах,Харилцааг хадгалах) • Амьдрахуйн чухал үйлдэл хийх чадвар алдагдах (сурах, ажил хийх, бие даан тооцоо хийх, банкны данс хянах г.м.) • Нийгмийн харилцааны чадвар алдагдах (чөлөөт цагийн арга хэмжээнд идэвхтэй оролцох, ах дүү, найз нөхдийхөөр зочлох г.м.)		б/Бартел-индекс 60-75 оноо, өргөтгөсөн Бартел-индекс 70-80 оноо, эсвэл Үйлдлийн хамаарлын үнэлгээ 72-107 оноо	60	2 жил
					в/Бартел-индекс 40-55 оноо, өргөтгөсөн Бартел-индекс 20-65 оноо, эсвэл Үйлдлийн хамаарлын үнэлгээ 54-71 оноо	70	Хугацаагүй
					г/Бартел-индекс ≤35 оноо, өргөтгөсөн Бартел-индекс ≤15 оноо, эсвэл Үйлдлийн хамаарлын үнэлгээ ≤53 оноо	90	Хугацаагүй
ПОЛИНЕВРОПАТИ, ЗАХЫН МЭДРЭЛИЙН ЭМГЭГ							
1.4.11	Полиневропатийн үлдэц урхаг (удмын [Шарко- Мари-Тут ба бусад], үрэвслийн дараах үлдэц байдал [зостер, боррелиоз, ДОХ- ын халдвар], аутоиммун шалтгаант [Гийен- Барре хамшинж, коллагеноз, васкулит], бодисын солилцооны шалтгаант [чихрийн шижин], хордлогын шалтгаант [архины, хүнд металлын,	• **Мэдрэхүйн өөрчлөлт, өвдөлт** (сенсор тэнцвэргүйдэл, гүн мэдрэхүйн алдагдлын улмаас зогсож чадахгүй байх, мэдээ алдах, бадайрах, температурын мэдрэхүй буурах, хорсож төөнөж өвдөх • **Хөдөлгөөний өөрчлөлт:** (сул саа, саажилт, хөдөлгөөний эвслийн алдагдал, сенсор тэнцвэргүйдэл, алхах муудах) • **Шээсний замын тогтолцоо:** (шээс задгайрах, эрекци сулрах) • **Ходоод-гэдэсний замын тогтолцоо:** (өтгөн хатах, суулгах) • **Арьсны өөрчлөлт:** (арьсны хатангирал, декубитус, "диабетийн хөл", шарх здгэхгүй)	• Хөдлөх чадвараа алдах (алхах зай богиносох, унах хандлага, гэрээс гарахад бэрхшээлтэй байх, машин тэрэг жолоодож чадахгүй байх, тэнцвэр алдагдах, эд зүйлсийг өргөх, хөдөлгөх эвсэл алдагдах) • Өөрийгөө арчлах чадвар муудах (хувцаслах, хоол хийх, бусад өдөр тутмын үйлдэл бэрхшээлтэй байх) • Ахуйн үйлдэл хийх чадвар муудах (дэлгүүрээс хүнс цуглуулах, гэр цэвэрлэх г.м.) • Амьдрахуйн чухал үйлдэл хийх чадвар буурах (хүнд зэргийн	G60 G61 G62 G65 G13	а/Бартел-индекс 80-95 оноо, өргөтгөсөн Бартел-индекс 85-90 оноо, эсвэл Үйлдлийн хамаарлын үнэлгээ 108-119 оноо	50	2 жил хүртэл
					б/Бартел-индекс 60-75 оноо, өргөтгөсөн Бартел-индекс 70-80 оноо, эсвэл Үйлдлийн хамаарлын үнэлгээ 72-107 оноо	60	3 жил

ТУЗ3894
9132155
1119277787

	органик уусмалын], паранеопластик шалтгаант [уушгины карцином])		полинейропатийн үед ачаалал даах чадвар буурах) • Нийгмийн харилцааны чадвар алдагдах (чөлөөт цагийн арга хэмжээнд идэвхтэй оролцох, ах дүү, найз нөхдийхөөр зочлох г.м.)		в/Бартел-индекс 40-55 оноо, өргөтгөсөн Бартел-индекс 20-65 оноо, эсвэл Үйлдлийн хамаарлын үнэлгээ 54-71 оноо	70	Хугацаагүй
					г/Бартел-индекс ≤35 оноо, өргөтгөсөн Бартел-индекс ≤15 оноо, эсвэл Үйлдлийн хамаарлын үнэлгээ ≤53 оноо	90	Хугацаагүй
1.4.12	Захын мэдрэлийн гэмтлийн үлдэц урхаг (мөрний сүлжээний гэмтэл, тохойн сувгийн хамшинж, сарвуу унжих хам шинж, (шууны мэдрэлийн гэмтэл), цээжний нүхнээс гарах хам шинж, мөрний сүлжээний неврит шаантны мэдрэлийн эмгэг, дискэктоми хийлгэсний дараах байдал)	• **Мэдрэхүйн өөрчлөлт:** өвдөлт мэдээ алдах, бадайрах, температурын мэдрэхүй буурах, невромын өвдөлт, каузальги, фантом өвдөлт • **Хөдөлгөөний өөрчлөлт:** сул саажилт, гарын хөдөлгөөн хязгаарлагдах, доголох • **Арьсны өөрчлөлт:** хөлсний илгарал буурах,арьс хуурайших, өнгө өөрчлөгдөх	• Хөдлөх чадвараа алдах (алхах зай богиносох, унах хандлага, гэрээс гарахад бэрхшээлтэй байх, машин тэрэг жолоодох боломжгүй болох, эсвэл туслах хэрэгсэлтэй жолоодох) • Өөрийгөө арчлах чадвар алдагдах (хувцаслах, хоол хийх, өөрийгөө арчлах болон бусад өдөр тутмын ерөнхий үйлдэлд бэрхшээл учрах) • Ахуйн үйлдэл хийх чадвар алдагдах (дэлгүүрээс хүнс цуглуулах, гэр цэвэрлэх г.м.) • Амьдрахуйн чухал үйлдэл хийх чадвар алдагдах (ачаалал даах чадвар буурах) • Нийгмийн харилцааны чадвар алдагдах (чөлөөт цагийн арга хэмжээнд идэвхтэй оролцох, ах дүү, найз нөхдийхөөр зочлох г.м.)	G54 G55 G56 G57	а/Бартел-индекс 80-95 оноо, өргөтгөсөн Бартел-индекс 85-90 оноо, эсвэл Үйлдлийн хамаарлын үнэлгээ 108-119 оноо	50	2 жил хүртэл
					б/Бартел-индекс 60-75 оноо, өргөтгөсөн Бартел-индекс 70-80 оноо, эсвэл Үйлдлийн хамаарлын үнэлгээ 72-107 оноо	60	2 жил
					в/Бартел-индекс 40-55 оноо, өргөтгөсөн Бартел-индекс 20-65 оноо, эсвэл Үйлдлийн хамаарлын үнэлгээ 54-71 оноо	70	Хугацаагүй

ТУЗ3894
9132155
1119277787

					г/Бартел-индекс ≤35 оноо, өргөтгөсөн Бартел-индекс ≤15 оноо, эсвэл Үйлдлийн хамаарлын үнэлгээ ≤53 оноо	90	Хугацаагүй
БУЛЧИН, МЭДРЭЛ-БУЛЧИНГИЙН СИНАПСЫН ЭМГЭГ							
1.4.13	Мэдрэл-булчингийн синапсын ба булчингийн эмгэг (миастени гравис [МГ], миодистрофи [МД], миотонийн эмгэгүүд [МТ], полимиозитийн [ПМ] дараах үлдэц урхаг)	• **Хөдөлгөөний үйл:** МГ – ачааллаас хамаарах булчингийн саажилт, алхах зай богиносох, дизартри, зажлуурын булчингийн сулрал; хахаж цацах нүд хоёрлох хялар харах МД – сул саажилт, контрактур, сколиоз, алхах зай богиносох; ММ– сул саажилт, миотони, алхах зай богиносох, гарын эвсэл алдагдах; ПМ – сул саажилт, булчингийн хатангирал, контрактур; • **Сэтгэцийн өөрчлөлт:** МД – Душенны миодистрофийн үед танин мэдэхүйн өөрчлөлт; ММ – танин мэдэхүйн бууралт, идэвх санаачлага буурах, ядарч сульдах; • **Мэдрэхүйн өөрчлөлт, өвдөлт:** МД– өвдөлт; МТ – өвдөлт, катаракт ын улмаас хараа муудах; Дуу авиа, хэл ярианы өөрчлөлт: МГ – дисфаги, гунших; МТ – гунших, • **Ходоод-гэдэсний ба дотоод шүүрлийн тогтолцооны үйлийн алдагдал:** МГ – дисфаги; МТ – хипогонадизм, чихрийн шижин, хоолны шингэц өөрчлөгдөх, цесний чулуу; • **Зүрх-судас ба амьсгалын тогтолцооны үйлийн алдагдал:** МГ, МД ба МТ – амьсгалын дутагдал, МД – кардиомиопати, МТ – зүрхний хэмнэлийн өөрчлөлт	• Хөдлөх чадвар алдагдах (алхах зай богиносох, шатаар явах, тээврийн хэрэгслээр бие даан явах чадвар буурах, унах хандлага, гэрээс гарах бэрхшээл, эд зүйлсийг өргөх, хөдөлгөх эвсэл алдагдах, хүнд үе шатанд биеийн байрлал өөрчлөх) • Өөрийгөө арчлах чадвар алдагдах (хувцаслах, бие засах, ариун цэвэр сахих, хооллох г.м.) • Ахуйн үйлдэл хийх чадвар алдагдах (дэлгүүрээс хүнс цуглуулах, гэр цэвэрлэх г.м.) • Нийгмийн харилцааны чадвар алдагдах (чөлөөт цагийн арга хэмжээнд идэвхтэй оролцох, ах дүү, найз нөхдийхөөр зочлох г.м.)	G70 G71 G72	а/Бартел-индекс 80-95 оноо, өргөтгөсөн Бартел-индекс 85-90 оноо, эсвэл Үйлдлийн хамаарлын үнэлгээ 108-119 оноо	50	2 жил хүртэл
					б/Бартел-индекс 60-75 оноо,өргөтгөсөн Бартел- индекс 70-80 оноо, эсвэл Үйлдлийн хамаарлын үнэлгээ 72-107 оноо	60	2 жил
					в/Бартел-индекс 40-55 оноо, өргөтгөсөн Бартел-индекс 20-65 оноо, эсвэл Үйлдлийн хамаарлын үнэлгээ 54-71 оноо	70	Хугацаагүй
					г/Бартел-индекс ≤35 оноо, өргөтгөсөн Бартел-индекс ≤15 оноо, эсвэл Үйлдлийн хамаарлын үнэлгээ ≤53 оноо	90	Хугацаагүй

ТУЗ3894
9132155
1119277787

1.4.14.	Органик үлдэц бүхий тархи эмгэгшил (энцефалопат)	• Танин мэдэхүй ба сэтгэл хөдлөлийн өөрчлөлтүүд • Хэлгүйдэл (бүх төрлийн афази) • Төвийн ба захын мэдрэлийн, үений шалтгаант, эмэнд тэсвэртэй өвдөлт • Гүн мэдрэхүйн алдагдал Чангарсан саажилтаас үүдэлтэй контрактур, • Аарцгийн үйл ажиллагаа алдагдах (шээс,өтгөн хоригдох эсвэл задгайрах) • Бульбар (хуурамч бульбар) саатай холбоотой хэл залгиурын өөрчлөлт	• Сурах, мэдлэг ашиглах чадварын алдагдал (шинэ зүйл сурах, асуудлыг шийдвэрлэх) • Харилцааны чадварын алдагдал (мэдээлэл өгөх, мэдээллийн хэрэгслийг ашиглах) • Хөдлөх чадвар алдагдах (биеийн байрлал өөрчлөх, зд зүйлсийг өргөх, хөдөлгөх эвсэл алдагдах, алхах зай богиносох, шатаар явах, тэсвэрийн хэрэгслээр бие даан явах) • Өөрийгөө арчлах чадвар муудах:(хувцаслах, бие засах, ариун цэвэр сахих, хооллох г.м.) • Ахуйн үйлдэл хийх чадвар алдагдах (дэлгүүрээс хүнс цуглуулах, хоол хийх, гэр цэвэрлэх г.м.) • Хүн хоорондын харилцааны чадвар алдагдах (хүнтэй танилцах, харилцааг хадгалах, сэтгэл хөдлөлийг хянах) • Амьдрахуйн чухал үйлдэл хийх чадвар муудах (сурах, ажил хийх, бие даан тооцоо хийх, банкны данс хянах г.м.)	G80 G81 G82	а/Бартел-индекс 60-75 оноо, өргөтгөсөн Бартел-индекс 70-80 оноо, эсвэл Үйлдлийн хамаарлын үнэлгээ 72-107 оноо	50	3 жил
					б/Бартел-индекс 40-55 оноо, өргөтгөсөн Бартел-индекс 20-65 оноо, эсвэл Үйлдлийн хамаарлын үнэлгээ 54-71 оноо	70	Хугацаагүй
					в/Бартел-индекс ≤35 оноо, өргөтгөсөн Бартел-индекс ≤15 оноо, эсвэл Үйлдлийн хамаарлын үнэлгээ ≤53 оноо	90	Хугацаагүй
1.4.15.	Тархи, нугасны гаж хөгжил, гидроцефали, нугас хөндийтөл (сирингомиели) Арнольд-Киарын гажиг, ивэрхий	• **Хөдлөөний өөрчлөлт:** саажилт: талбие, дөрвөн мөч, нүд,хэл залгиур; тэнцвэргүйдэл, хөдлөөний эвсэл эвдүйн өөрчлөлт • **Мэдрэхүйн өөрчлөлт ба өвдөлт:** толгойн эргэлт, сонсголын өөрчлөлт, харах талбайн хязгаарлалт, талласан өвдөлт, ян • **Оюуны чадамжийн бууралт:** эпилепсийн уналт таталт, анхаарал төвлөрөлт ба ой санамжийн бууралт, төрх үйлийн өөрчлөлт, хэлгүйдэл, үйлдэлгүйдэл • **Аарцгийн эрхтний үйлийн алдагдал:** баас шээс задгайрах эсвэл хоригдох	• Сурах, мэдлэг ашиглах чадвар буурах (шинэ зүйл сурах, асуудлыг шийдвэрлэх) • Харилцааны чадвар алдагдах (мэдээлэл өгөх, мэдээллийн хэрэгслийг ашиглах) • Хөдлөх чадвар алдагдах (биеийн байрлалаа өөрчлөх, зд зүйлсийг өргөх, хөдөлгөх эвсэл алдагдах, алхах зай богиносох, шатаар явах, тэсвэрийн хэрэгслээр бие даан явах) • Өөрийгөө арчлах чадвар алдагдах (хувцаслах, бие засах, ариун цэврийг сахих, хооллох г.м.)	G91 Q07.0 G95.0	Бартел-индекс 40-55 оноо, өргөтгөсөн Бартел- индекс 20-65 оноо, эсвэл Үйлдлийн хамаарлын үнэлгээ 54-71 оноо	80	Хугацаагүй

ТУЗ3894
9132155
1119277787

			• Ахуйн үйлдэл хийх чадвар алдагдах (дэлгүүрээс хүнс цуглуулах, хоол хийх, гэр цэвэрлэх г.м.)				

Тайлбар:

"... хүртэлх жил" гэснийг тухайн заалтад заагдсан хүртэлх хугацаагаар энэ жагсаалт мөрдөгдөж эхэлсэн өдрөөс эхэлж хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоож, сунгахыг хэлнэ. Тогтоолт, сунгалт нь 24 сараас хэтрэхгүй хугацаатай байна.

- "...1 жил; 2 жил" гэснийг тухайн заалтад заагдсан хугацаагаар хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоож, сунгахыг хэлнэ.
- Даатгуулагч, хүний ажлын цаг богиносгох асуудлыг уг жагсаалтын заалтуудад үндэслэн шийдвэрлэж болох бөгөөд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоох, сунгах шийдвэр гарсан тохиолдолд давхардуулж ажлын цаг богиносгохгүй.
- Өдөр тутмын үйлдлийн бартел индексийн үнэлгээний хуудас, өргөтгөсөн бартел индексийн үнэлгээний хуудас, үйл ажиллагааны хамаарлын үнэлгээний хуудсаар үнэлнэ.
- Даатгуулагч, хүний өвчний кодын зөрүүтэй байдал нь хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэхгүй байх үндэслэл болохгүй.
- Урьд нь үйлдвэрлэлийн ослын шалтгаанаар хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тухайн заалтаар үргэлжлүүлэн сунгах бөгөөд "хүртэлх жил"-ийг тухайн дуусч буй хугацаагаар дуусгана.

ТУЗ3894
9132155
1119277787


ӨДӨР ТУТМЫН ҮЙЛДЛИЙН БАРТЕЛ ИНДЕКСИЙН
ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Овог _____Нэр_____

_____он_____сар_____ өдөр

Үнэлгээ өгсөн хүний нэр:

Д/д	Идэвхжил	Тайлбар	Оноо
1	**Хооллолт** 0 = бүрэн хамааралтай 5 = тусламж хэрэгтэй (хэрчих, түрхэх, хоолны горим баримтлахад г.м) 10 = хамааралгүй		
2	**Усанд орох** 0 = хамааралтай 5 = хамааралгүй		
3	**Өөрийн арчилгаа** 0 = тусламж хэрэгтэй 5 = нүүр, үс, шүд угаах, сахал хусахад тусламж шаардлагагүй		
4	**Хувцаслалт** 0 = хамааралтай 5 = тусламж хэрэгтэй, гэхдээ тал зүйлсийг өөрөө хийж чадна 10 = хамааралгүй (товчлох, үдэх зэргийг чадна)		
5	**Өтгөний гарц** 0 = хяналтгүй (эсвэл зөвхөн бургуйгаар гарна) 5 = үе үе хяналт алдагдана 10 = хэвийн		
6	**Шээсний гарц** 0 = хяналтгүй (эсвэл катетертай, эсвэл бие даан зохицуулах чадваргүй) 5 = үе үе хяналт алдагдана 10 = хэвийн		
7	**Бие засах** 0 = хамааралтай 5 = зарим зүйлсийг өөрөө хийж чадах хэдий ч тусламж хэрэгтэй 10 = хамааралгүй (суух, босох, бөгсөө арчих, ёмд татах)		
8	**Ор-сандал-ор хоорондын шилжилт** 0 = чадваргүй, суухад тэнцвэр алдана 5 = суух чадах боловч нэг буюу хоёр хүний тусламж шаардлагатай 10 = бага хэмжээний тусламж шаардлагатай 15 = хамааралгүй		
9	**Хөдлөх чадвар (тэгш газар)** 0 = алхах чадваргүй 5 = тэргэнцэртэй бие даан хөдлөнө 10 = нэг хүний тусламжтай хөдлөнө (аман буюу хүчний) 15 = хамааралгүй, гэхдээ таяг мэт туслах хэрэгсэл ашигласан болно		
10	**Шатаар өгсөх /уруудах/** 0 = чадваргүй 5 = тусламж шаардлагатай (аман, хүчний, туслах хэрэгслийн) 10 = хамааралгүй		
11	**Усанд орох /бие угаах/** Бие даана – 1, хамааралтай - 0		
	Нийт оноо (0-100)		




ӨРГӨТГӨСӨН БАРТЕЛ ИНДЕКСИЙН
ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Овог _____Нэр_____

_____он_____сар_____ өдөр

Үнэлгээ өгсөн хүний нэр

Дд	Танин мэдэхүйн үйл	Оноо
1	**Ойлгох** ***0 = чадваргүй*** ***5 = энгийн комманд ойлгоно*** *10 = цөөц ачуулгыг ойлгох болоөч дандаа биш* *15 = алдаадалгүй (зөвхөн бичсэн зүйл ойлгох өөртөнд үүнд хамруулахгүй)*	
2	**Өөрийгөө ойлгуулах** ***0 = чадваргүй*** ***5 = энгийн ачуулгыг ойлгуулна*** *15 = өөрийгөө бүрэн ойлгуулж чадна*	
3	**нийгмийн харилцаа** ***0 = харилцах чадваргүй*** ***5 = үе үе түрэмгий, бс зүйгүй авир гаргаж, нийтийн дүрмийг дагахгүй, эсвэл харьцахгүй*** *15 = бэрхшээлгүй*	
4	**өдөр тутмын асуудлыг шийдвэрлэх** ***0 = Их хэмжээний тусламж шаардлагатай*** ***5 = бага хэмжээний тусламж шаардлагатай*** *15 = тусламж шаардлагагүй*	
5	**ой санамж, сурах чадвар, баримжаа** ***0 = ой санамж ба баримжаа илт алдагдсан, зүгтах, төөрөх хандлагатай*** ***5 = ойр ойр сануулах шаардлагатай*** ***10 = үе үе сануулах шаардлагатай, эсвэл санахад туслах хэрэгсэл ашиглана*** *15 = ихэнхдээ бэрхшээлгүй (асрагчийн нэмэлт туслалцаа шаардлагагүй)*	
6	**харах ба үгүйсгэл (неглект)** ***0 = танил орчинд баримжаагүй (жишээ нь, өөрийн өрөөндөө)*** ***5 = зөвхөн танил орчинд баримжаатай*** ***10 = унших чадвар хүнд зэрэгээр алдагдсан боловч танил ба танил бус орчинд оронзайн баримжаа олно*** *15 = ихэнхдээ бэрхшээлгүй*	
	нийт оноо (0-90)	



Үйл ажиллагааны хамаарлын үнэлгээний хуудас

(Functional Independence Measure)

Овог _____Нэр_____

_____он_____сар_____ өдөр

Үнэлгээ өгсөн хүний нэр

Д/д	*Үйл ажиллагаа*		*Оноо*
1	Өөрийн арчилгаа	Хооллох	
		Биеийн арчилгаа	
		Усанд орох, биеэ угаах	
		Биеийн дээд хэсгийг хувцаслах	
		Биеийн доод хэсгийг хувцаслах	
		Бие засах	
2	Аарцгийн эрхтний үйл	Шээсний хяналт	
		Өтгөний хяналт	
3	Шилжих хөдөлгөөн	Ор – сандал/тэргэнцэр	
		Жорлонд суух босох	
		Душ/ванны орох	
4	Явах чадвар	Алхах, тэргэнцэр	
		Шатаар өгсөх, уруудах	
	Хөдөлгөөний үйлийн нийт үнэлээ		
5	Харилцаа	Ойлгох чадвар	
		Өөрийгөө ойлгуулах чадвар	
6	Нийгмийн танин мэдэхүй	Нийгмийн харилцаа	
		Асуудал шийдвэрлэх чадвар	
		Ой санамж	
	Танин мэдэхүйн нийт оноо		
	Үйл ажиллагааны хамаарлын үнэлгээний нийт оноо		

Оноо өгөх заавар:			
Тусламж шаардлагатай эсэх	*Оноо*	*Түвшин*	*тайлбар*
Хүний тусламж шаардлагагүй	7	Биеэ бүрэн даасан	Бүсдаас бүрэн хамааралгүй
	6	Биеэ бүрэн бус даасан (туслах хэрэгсэлтэй, эсвэл ахуулгүй байдал эргэлзээтэй)	Туслах хэрэгсэл ашиглах боловч хүний тусламж шаардлагагүй
Хүний тусламж шаардлагатай	5	Хяналтан дор хийнэ	Хажуугийн хяналт буюу аман дэмжлэг буюу эхэн үеийн дэмжлэг шаардагдана
	4	Бага хэмжээний тусламж шаардлагатай	Өвчтөн үйлдлийн 75%-иас илүүг гүйцэтгэж чадна, үөн үйлдэлд хүний тусламж шаардлагатай
	3	Дунд хэмжээний тусламж шаардлагатай	Өвчтөн үйлдлийн 50-75%-ийг гүйцэтгэж чадна
	2	Их хэмжээний тусламж шаардлагатай	Өвчтөн үйлдлийн талаас бага хувийг гүйцэтгэж чадна (25-49%)
	1	Бүрэн асаргаа шаардлагатай	Өвчтөн үйлдлийг гүйцэтгэж чадахгүй, эсвэл 25-аас бага хувийг гүйцэтгэж чадна

ТУЗ3894
9132155
1119277787

Гэмтэх эрсдэлийн шалгуур

Үнэлгээ	Шалгуур
O	Ухамсарт ухаан алдагдахгүй, байршлын ба хөдөлгөөний хяналт алдагдахгүй (жишээ нь, богино хугацааны мэдрэхүйн шинжтэй уналт, шинж тэмдэг дуустал ажлыг түр зогсоох чадвартай)
A	Ухамсарт ухаан алдагдахгүй, үйлдэл гүйцэтгэх чадвар буурах боловч байршлын хяналт алдагдахгүй (жишээ нь, татвалзах уналт, бие чангарч хөших, эсвэл зарим булчин сулрах шинжтэй уналт)
B	Ухамсарт ухаан алдагдана, байршлын хяналт алдагдахгүй боловч үйлдэл гүйцэтгэх чадвар алдагдана, хөдөлгөөн хоригдоно (жишээ нь, гэнэт гацах, орчинтой харьцаагүй болох, бичил хөдөлгөөнтэй уналт)
C	Ухамсарт ухаан алдагдана, эсвэл алдагдахгүй, үйлдэл гүйцэтгэх чадвар алдагдана, байршлын хяналт алдагдана (жишээ нь, хамгаалах рефлексгүй гэнэт унах, аажим муужрах маягтай унах, гуйвах, тулж унах)
D	Ухамсарт ухаан алдагдана, байршлын хяналт алдагдаж болно, зохисгүй үйлдэл ажиглагдах (жишээ нь, зохисгүй хяналтгүй нийлмэл хөдөлгөөн, үйлдэл хийх)

№	Өвчний нэр	Үе шат	Өвчний код	Хувь хэмжээ	Хугацаа	Хөдөлмөрийн нөхцөл солих, ажлын цаг хорогдуулах эсэх
Б.Үйлдвэрлэлийн ослын улмаас						
1	Үйлдвэрлэлийн ослын улмаас 3 сараас дээш хугацаагаар хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж авсан		-	20	1 хүртэлх жил	
2	“А.Ердийн өвчин болон ахуйн осол”-ын жагсаалтын шалгуурыг хангаагүй боловч үйлдвэрлэлийн ослын улмаас 6 сар хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авч, түүнээс дээш хугацаагаар эмчийн хяналтад байгаа		-	30-40	1 хүртэлх жил	
3	Айдаст сэтгэл түгших, үл ялих зовлонт үзэгдлийн, дасан зохицохуйн, диссоциатив, биеийн хэлбэрийн, мэдрэл сульдах эмгэгүүд	Эмчилгээний үр дүнд сайжрал авдаг боловч мэргэжлийн ажлаа хийх боломжгүй болсон бол	F40 F42 F43 F44 F45 F48	20	1 хүртэлх жил	

ТУЗ3894
9132155
1119277787

2025 он 12 сар 15 өдөр

4	Уушигны архаг бөглөрөлт өвчин	Амьсгалын дутагдал I зэрэг, зүрхний архаг дутагдлын "B" үе шат, Спирографи: FEV1 50-79%. FEV1/FVC< 0.7, ЭхоКГ: зүрхний баруун ховдлын агших чадвар дунд зэрэг буурч уушгины гемодинамик алдагдах	J44	20	1 хүртэлх жил	
5	Өрөөсөн уушги авахуулсан, биеийн ерөнхий байдал хөнгөн, амьсгалын дутагдалгүй		J95	20	1 хүртэлх жил	
6	Мөрний үеэр байрандаа хөших, мөр эргүүлэгч нударга булчингийн ужиг гэмтэл үйл ажиллагааны алдагдлын 1,2-р зэрэг		S44 S46 M75	20	1 хүртэлх жил	
7	Тархины бяцралт, суурь ясны хугарал /хөнгөн/		S02 S05 S06 S07 S08	20	1 хүртэлх жил	
8	Атгаал чөмөгний толгойн анатомийн хүзүүний хугарал		S42.2	20	1 хүртэлх жил	
9	Сарвууны 1 хурууны нугалагч шөрмөсний гэмтлийн үлдэц		T92.5	10	1 хүртэлх жил	
10	Сарвууны 2 хурууны нугалагч шөрмөсний гэмтлийн үлдэц			20	1 хүртэлх жил	
11	Хөлийн 1 хуруу тайрагдсан	а/ 1 тал	S98.2	10	хугацаагүй	
		б/ 2 тал		20	хугацаагүй	
12	Гарын нэг хуруу тайрагдах	а/ 1 тал	S68 S68.2	10	хугацаагүй	
		б/ 2 тал		20	хугацаагүй	

Тайлбар:

Б.Үйлдвэрлэлийн ослын улмаас" жагсаалтын зааltад эрүүл мэндийн байдал нь тохирохгүй даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг "А.Ердийн өвчин болон ахуйн осол"-ын жагсаалтын зааltаар, үйлдвэрлэлийн ослын шалтгаанаар тогтооно.

нэ жагсаалт мөрдөгдөж эхэлхээс өмнө үйлдвэрлэлийн ослын шалтгаанаар хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг сунгах үндэслэлтэй бол тухайн зааltад заасан хугацаагаар үргэлжлүүлэн сунгах ба "хүртэлх жил" гэсэн хугацаатай бол өмнөх хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон нийт хугацааг оруулан тооцно.

Б.Үйлдвэрлэлийн ослын улмаас" жагсаалтаар ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоохгүй.

ТУЗ894
9132155
1119277757

ХУУЛЬБАР ҮЙЛ
Гарын үсэг: _____
2023 он 12 сар 13 өдөр

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 04 өдөр Дугаар 09 Улаанбаатар хот

Шимтгэлийн хэмжээг тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хооронд байгуулсан нийгмийн хамгааллын тухай хэлэлцээр, Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 7 дугаар зүйлийн 7.3.3 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Бүгд Найрамдах Солонгос Улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй Монгол Улсын иргэдийн нийгмийн даатгалд (тэтгэврийн даатгал) албан журмаар даатгуулах шимтгэлийн хэмжээг сарын 50 000 (тавин мянга) воноор тогтоосугай.

2. Тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Л.Мөнхзул)-т үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба (Г.Банзрагч)-нд даалгасугай.

4. Тогтоол батлагдсантай холбогдуулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн "Шимтгэлийн доод хэмжээг тогтоох тухай" 05 дугаар тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.

5. Энэхүү тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА Х.БУЛГАНТУЯА

1119276367
5284706 СБА1473

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2023 оны 12 сарын 21 өдөр Дугаар 15 Улаанбаатар хот

Нэрийн дансны 2023 оны орлогод
тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай

Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.7 дахь заалт, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлсан "Даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох журам", Үндэсний статистикийн хорооны саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2023 оны орлогод тооцох жилийн хүүгийн хэмжээг 14.3 хувиар батлсугай.

2. Батлсан хүүгийн хэмжээг үндэслэн даатгуулагчдын тэтгэврийн даатгалын шимтгэлийн 2022 оны үлдэгдэл, 2023 оны орлогод тус тус хүү тооцох ажлыг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан зохион байгуулж даатгуулагчдыг шаардлагатай мэдээллээр хангаж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Л.Мөнхзул/-т даалгасугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын алба /Г.Банзрагч/-нд даалгасугай.

ДАРГА Х.БУЛГАНТУЯА

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2024 оны 03 сарын 05 өдөр Дугаар 01 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.10 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Нэрийн дансыг нээх, бүртгэх, хөтлөх, даатгуулагчийн гарааны үлдэгдлийг тооцохтой холбогдсон харилцааг зохицуулах журмыг хавсралтаар баталсугай.

2. Тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Л.Мөнхзул/-т даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба /Г.Банзрагч/-нд үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан "Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны эхний /гарааны/ үлдэгдэл тооцоход баримтлах шимтгэлийн хувь хэмжээ, цалин хөлсний дундаж индекс /итгэлцүүр/-ийг шинэчлэн батлах тухай" Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2010 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 02 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Х.БУЛГАНТУЯА

Нийгмийн даатгалын үндэсний
зөвлөлийн 2024 оны 03 дугаар
сарын 05-ны өдрийн 01 дугаар
тогтоолын хавсралт

НЭРИЙН ДАНСЫГ НЭЭХ, БҮРТГЭХ, ХӨТЛӨХ, ДААТГУУЛАГЧИЙН ГАРААНЫ ҮЛДЭГДЛИЙГ ТООЦОХТОЙ ХОЛБОГДСОН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-д заасны дагуу даатгуулагчид тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс (цаашид "нэрийн данс" гэх) нээх, гарааны болон эхний үлдэгдэл тооцох, ажил олгогч, даатгуулагчийн тэтгэврийн даатгалд төлсөн шимтгэл (цаашид "шимтгэл" гэх)-ийг бүртгэх, нэрийн дансанд хүү тооцох, нэрийн дансанд бүртгэсэн орлогын бодит мөнгөн хэлбэрт шилжүүлсэн хэсэг (цаашид “мөнгөжүүлсэн орлого” гэх)-ийг бүртгэх, даатгуулагчийн хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх, хяналт, хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

Хоёр. Нэрийн дансыг нээх

2.1. Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2 дахь хэсэгт заасны дагуу 1960 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш төрсөн, шимтгэл төлсөн даатгуулагчид нэрийн данс нээнэ.

Гурав. Нэрийн дансны гарааны үлдэгдэл тооцох

3.1. Нэрийн дансны гарааны үлдэгдлийг 2000 оноос өмнө ажил хөдөлмөр эрхэлсэн, албан журмаар эсхүл сайн дураар даатгуулж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагчид тооцно. Гарааны үлдэгдэл нь даатгуулагчийн нэрийн данс нээлгэсэн жилийн эхний үлдэгдэл байна.

3.2. Нэрийн дансны гарааны үлдэгдлийг тооцоход дараах үзүүлэлтүүдийг харгалзана.Үүнд:

3.2.1. Даатгуулагчийн нэрийн данс нээлгэх хүртэл ажилласан болон шимтгэл төлсөн хугацаа;

3.2.2. Даатгуулагчийн 1995-1999 онд шимтгэл төлсөн, итгэлцүүрээр өсгөсөн 5 жилийн дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлого (цаашид “цалин хөлс” гэх);

3.2.3. Сард төлбөл зохих шимтгэлийн хувь хэмжээ;

3.2.4. Сүүлийн 5 жилийн улсын дундаж цалин хөлсний итгэлцүүр.

3.3. Нэрийн дансны гарааны үлдэгдлийг тооцоход энэ журмын 3.2-т заасан

үзүүлэлтүүдийг харгалзан дараах томьёогоор бодно:

3.3.1. Нэрийн дансны гарааны үлдэгдэл:

$$Гс_1=(Б \times Ш_{сар})* 96\%$$

$Гс_1$-нэрийн дансны эхний үлдэгдэл;

Б-сард төлбөл зохих шимтгэлийн хэмжээ;

$Ш_{сар}$-шимтгэл төлсөн нийт сар;

96%-Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 27.3.2, 27.3.3, 27.3.4, 27.3.5, 27.3.6-д заасан шимтгэлийн орлогоос 4 хувийг хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр олгох зориулалтаар тусгайлан бүртгэснийг хассан хувь;

3.3.2. Сард төлбөл зохих шимтгэлийн хэмжээг доорх томьёогоор бодно:

$$Б= Ц_д \times Д_и \times 19.0\%$$

$Ц_д$-даатгуулагчийн 1995-1999 оны сарын цалин хөлсний дундаж хэмжээ;

$Д_и$-1995-1999 оны улсын дундаж цалин хөлснөөс бодсон дундаж итгэлцүүр;

19.0%-1995-1999 онд мөрдөж байсан тэтгэврийн даатгалын шимтгэл /ажил олгогч-13.5, даатгуулагч-5.5/-ийн хувь хэмжээ.

3.4. Энэхүү журмын 3.2.1-д заасан шимтгэл төлсөн хугацааг дараах байдлаар сараар тооцно. Үүнд:

3.4.1. Даатгуулагчийн 1995 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө ажилласан хугацааг хөдөлмөрийн дэвтэр (тушаалын хуулбар, архивын лавлагаа, шүүхийн шийдвэр, цэргийн батлах, цэргийн байгууллагын архивын лавлагаа зэрэг)-ийг үндэслэнэ.

3.4.2. Даатгуулагчийн 1995 оны 01 дүгээр сарын 01-нээс 1999 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал ажиллаж, шимтгэл төлсөн хугацааг нийгмийн даатгалын дэвтэр, мэдээллийн нэгдсэн сан, шимтгэл төлөлтийн тооцооны хуудас, нийгмийн даатгалын байгууллагын архивын баримт зэргийг үндэслэн тооцно.

3.5. Энэхүү журмын 3.2.2-т заасан сарын дундаж цалин хөлсний хэмжээг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

3.5.1. Даатгуулагчийн 1995-1999 онд сар бүр шимтгэл төлж ажилласан 5 жилийн итгэлцүүрээр өсгөсөн цалин хөлсний нийлбэрийг 60-д хуваана.

3.5.2. Даатгуулагч нь 1995-1999 онд тасралттайгаар шимтгэл төлсөн бол түүний мөн онуудад шимтгэл төлсөн саруудын цалин хөлсний нийлбэрийг

шимтгэл төлсөн сарын тоонд нь хувааж дундаж цалин хөлсний хэмжээг тооцно.

3.5.3. 1995 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө ажилласан боловч 1995 оноос нэрийн данс нээлгэх хүртэлх хугацаанд шимтгэл төлөөгүй даатгуулагчийн сарын дундаж цалин хөлсийг Засгийн газрын тогтоосон 1999 онд мөрдөж байсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (12000 төгрөгөөр)-гээр тооцно.

3.5.4. Даатгуулагчийн нэрийн дансны гарааны үлдэгдлийг тооцох итгэлцүүрээр өсгөсөн сарын цалин хөлсний дээд хэмжээ нь 1999 онд мөрдөж байсан даатгуулагчийн шимтгэл төлөх сарын цалин хөлсний дээд хэмжээ (425000 төгрөг)-нээс хэтрэхгүй байна.

3.6. Энэ журмын 3.2.4-т заасан гарааны үлдэгдэл тооцоход баримтлах цалин хөлсийг өсгөн тооцоход баримтлах итгэлцүүрийн хэмжээ:

№	Он	Нэрийн дансны итгэлцүүр
1	1995	10.06
2	1996	4.60
3	1997	3.83
4	1998	3.54
5	1999	3.22

Дөрөв. Нэрийн дансны эхний үлдэгдэл тооцох

4.1. 2000 оноос өмнө шимтгэл төлсөн даатгуулагчдын нэрийн дансны гарааны үлдэгдэл нь түүний нэрийн дансны эхний үлдэгдэл байна.

4.2. 2000 оноос хойш шимтгэл төлсөн даатгуулагч эхний үлдэгдэлгүй бол “0” тэг байхаар тооцож, даатгуулагч тус бүр дээр нэрийн данс нээж бүртгэнэ.

4.3. Нэрийн дансны өмнөх оны эцсийн үлдэгдэл нь тухайн жилийн эхний үлдэгдэл байна.

Тав. Нэрийн дансны орлого, зарлагыг бүртгэх, хөтлөх

5.1. Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд нэрийн дансны орлогыг дараах байдлаар бүртгэж, хөтөлнө. Үүнд:

5.1.1. Даатгуулагчийн төлсөн шимтгэлийг Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 19.4 дэх хэсэгт заасны дагуу албан журмаар даатгуулагчийн хувьд тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин, сайн дураар даатгуулагчийн хувьд 7 дахин нэмэгдүүлсэнтэй тус тус тэнцүү байхаар сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг баримтлан нийгмийн даатгалын байгууллага мэдээллийн нэгдсэн санд;

5.1.2. Ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 18.1 дэх хэсэгт заасан тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээгээр тооцон нийгмийн даатгалын байгууллага даатгуулагч тус бүрээр мэдээллийн нэгдсэн санд;

5.1.3. Нийгмийн даатгалын холбогдох сангаас тэтгэврийн даатгалын санд төлсөн шимтгэлийг даатгуулагч тус бүрээр нэрийн дансанд;

5.1.4. Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 63.3 дахь хэсэгт заасан ажилтны шимтгэлийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас төлсөн шимтгэлийн хэмжээгээр даатгуулагч тус бүрээр;

5.1.5. Төрөөс төлсөн тэтгэврийн даатгалын шимтгэлийг холбогдох журмын дагуу баталгаажуулан даатгуулагч тус бүрээр;

5.1.6. Энэхүү журмын 6.1-д заасан хүүгийн орлогыг даатгуулагч тус бүрээр нэрийн дансанд нь нийгмийн даатгалын байгууллага жилд нэг удаа;

5.1.7. Нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогын хөрөнгө оруулалтын өгөөжийг нийгмийн даатгалын байгууллага даатгуулагч бүрээр нэрийн дансанд тухай бүр.

5.2. Албан журмаар даатгуулагчийн жирэмсний болон амаржсаны амралттай, гурав хүртэлх насны хүүхдээ асрах чөлөөтэй байх хугацааны нэрийн дансны орлогыг жирэмсний болон амаржсаны тэтгэмж бодуулсан сүүлийн 12 сарын цалин хөлсний дунджаас ажил олгогч, даатгуулагчийн төлбөл зохих шимтгэлийн хувь хэмжээгээр тооцож, нэрийн дансанд нь бүртгэж, хүү тооцно.

5.2.1. Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 21.14 дэх хэсэгт заасан эхийн шимтгэл төлсөн хугацаан дээр энэ журмын 5.2-т заасан орлогыг нэмж бүртгэнэ. Мөн даатгуулагч эх хүүхдээ асрах чөлөө дуусахаас өмнө Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 7.2, 7.7 дахь хэсэгт заасан харилцаа үүссэн тохиолдолд энэ журмын 5.2-т заасан харилцааг дуусгавар болгож, төлсөн шимтгэлийн орлогоос нь нэрийн дансанд ногдох хэсгийг бүртгэнэ.

5.2.2. 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш 3 хүртэлх насны хүүхдээ асрах чөлөөтэй хугацааны шимтгэлийг ажил олгогч нь хариуцан төлж байгаа тохиолдолд тухайн даатгуулагчийн шимтгэл төлсөн хугацаан дээр энэ журмын 5.2-т заасан орлогыг нэмж бүртгэнэ.

5.3. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгох даатгуулагчийн 1995 оноос өмнө цэргийн алба хаасан хугацаанд ногдох шимтгэлийг даатгуулагчийн болон ажил олгогчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээгээр дараах орлогоос тооцож нэрийн дансанд нь бүртгэнэ:

5.3.1. Цэргийн алба хаасан хугацааны цалин хөлсөнд Нийгмийн

даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 22.2 дахь хэсэгт заасны дагуу тогтоосон итгэлцүүр хэрэглэсэн дүнгээс тооцно;

Санамж: Итгэлцүүрээр өсгөсөн цалин хөлсийг тодорхойлохдоо Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 19.4 дэх хэсэг, Засгийн газрын холбогдох тогтоолыг баримтална.

5.3.2. Цэргийн алба хаасан хугацааг өсгөн тооцсон хугацааны шимтгэлийг тэтгэвэр тогтоолгох үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож бүртгэнэ.

5.4. Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 10-аас доошгүй жил төлсөн, төрүүлсэн болон гурав хүртэл настайд нь үрчлэн авсан хүүхдээ зургаан нас хүртэл өсгөсөн эхийн төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэд бүрийн тоогоор нэг жил зургаан сараар тооцсон хугацааг даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр тогтоолгох үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогчийн болон даатгуулагчийн төлөх хувь хэмжээгээр тооцож нэрийн дансанд нь нэг удаа бүртгэнэ.

5.5. Хөдөлмөрийн чадвар бүрэн алдсан даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авч байсан хугацааны шимтгэлийг өндөр насны тэтгэвэр тогтоолгох үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогчийн болон даатгуулагчийн төлөх хувь хэмжээгээр тооцож нэрийн дансанд нь нэг удаа бүртгэнэ.

5.6. Энэхүү журмын 5.3, 5.4, 5.5 дахь хэсэгт заасан нэрийн дансны орлогыг тухайн даатгуулагч нэрийн дансны аргаар тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан үед нэрийн дансны эцсийн үлдэгдэл дээр нэмж тооцно.

5.7. Нэрийн дансны зарлагын бүртгэлийг нийгмийн даатгалын байгууллага дараах байдлаар бүртгэнэ:

5.7.1. Нэрийн дансны аргаар тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагчийн нэрийн дансны үлдэгдлээс сар бүр авсан тэтгэврийн хэмжээгээр хасаж;

5.7.2. Нэрийн дансны тухайн жилийн эхний үлдэгдлээс мөнгөжүүлсэн орлогыг хасаж.

Зургаа. Нэрийн дансны орлогод хүү тооцох

6.1. Даатгуулагчийн мөнгөжүүлсэн орлогыг хассан нэрийн дансны эхний үлдэгдэл, тухайн жилийн бүртгэсэн шимтгэлийн орлогод хүү тооцно.

6.2. Нэрийн дансны орлогод тооцох хүүгийн хэмжээг дараах томьёогоор тооцно.

$$X = (И , Д_i)$$ (дундаж, багаар, ихээр) сонголт хийх

И-өмнөх оны инфляцын түвшин;

$Д_i$-Банкны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 3.1.20 дахь хэсэгт заасан арилжааны банкнаас албан ёсоор зарласан иргэдийн мөнгөн хадгаламжийн өмнөх жилийн дундаж хүүгийн хэмжээ.

6.3. Энэхүү журмын 5.3, 5.4, 5.5-д заасан тусгай зохицуулалтаар нэмэгдүүлж буй шимтгэлийн орлогод хүү тооцохгүй.

Долоо. Нэрийн дансны эцсийн үлдэгдэл тооцох

7.1. Даатгуулагчийн нэрийн дансны тухайн жилийн эцсийн үлдэгдлийг дараах томьёогоор тооцно:

$$НД_{с2} = НД_{с1} - М + БШО + Х_0$$

$НД_{с2}$-нэрийн дансны тухайн жилийн эцсийн үлдэгдэл;

$НД_{с1}$-нэрийн дансны тухайн жилийн эхний үлдэгдэл;

М-мөнгөжүүлсэн орлого;

БШО-тухайн жилийн бүртгэсэн шимтгэлийн орлого;

$Х_0$-нэрийн дансны эхний үлдэгдлээс мөнгөжүүлсэн орлогыг хассан дүн, тухайн жилийн бүртгэсэн орлогод тооцсон хүүгийн орлого.

7.2. Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээ, Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээгээр тохирсон цалин хөлснөөс шимтгэл төлж давхар ажил эрхэлдэг даатгуулагчийн нэрийн дансанд бүртгэсэн тухайн жилийн шимтгэлийг тооцохдоо ажил олгогч тус бүрийн төлсөн шимтгэлийн нийлбэр дүнгээс 4 хувьд ногдох хэсгийг хасаж тооцно.

7.3. Даатгуулагчийн өмнөх онуудын шимтгэл төлөлтийн тайланд залруулга хийсэн тохиолдолд тухайн жилийн нэрийн дансны эцсийн үлдэгдлийг шинэчлэн тооцож, өөрчлөгдсөн үлдэгдэлд нь хүү тооцно.

Найм. Нэрийн дансны үлдэгдлийг шалгах, даатгуулагчид мэдээлэх

8.1. Нийгмийн даатгалын байгууллага энэ журмын нэгдүгээр хавсралтаар батлагдсан маягтын дагуу нэрийн дансны тухайн жилийн эцсийн нэгдсэн тайланг дараа оны 1 дүгээр улиралд багтаан шалгаж баталгаажуулна.

8.2. Нийгмийн даатгалын байгууллага энэ журмын хоёрдугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу нэрийн дансны үлдэгдлийг даатгуулагч бүрээр гарган, дараа оны 2 дугаар улиралд багтаан даатгуулагчийг мэдээллээр хангах /цахимаар харах, хэвлэж авах/ нөхцөлийг бүрдүүлнэ.

8.3. Даатгуулагч нийгмийн даатгалын байгууллагын цахим хуудас, нийгмийн даатгал аппликейшн, төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia)-ээр нэрийн дансны лавлагаа авах, мэдээллээ шалгах, хянах, мэдээлэл зөрүүтэй тохиолдолд нийгмийн даатгалын байгууллагад хандан залруулах эрхтэй.

Ес. Даатгуулагчийн хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх

9.1. Даатгуулагч нэрийн дансны мэдээллээ шалгуулах хүсэлтээ харьяалах нийгмийн даатгалын байгууллагад цахимаар эсхүл цаасаар гаргана.

9.2. Нийгмийн даатгалын байгууллага даатгуулагчийн хүсэлтийг нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сантай тулган шалгаж шийдвэрлэнэ.

9.3. Нийгмийн даатгалын байгууллага даатгуулагчийн гаргасан хүсэлтийг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд шийдвэрлэнэ.



Арван. Хяналт, хариуцлага

10.1. Энэ журмын хэрэгжилтэд нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын холбогдох чиг үүрэг бүхий нэгж, нийгмийн даатгалын болон нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч хяналт тавина.

10.2. Энэхүү журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

- - - o O o - - -

Нэрийн дансыг нээх, бүртгэх, хөтлөх,
даатгуулагчийн гарааны үлдэгдлийг
тооцохтой холбогдсон харилцааг
зохицуулах журмын нэгдүгээр хавсралт

1119276367
5284708 СБА1473

ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН
НЭРИЙН ДАНСНЫ ..... ОНЫ НЭГДСЭН ТАЙЛАНГИЙН МАЯГТ

Нийгмийн даатгалын газрын нэр: .....

/төгрөгөөр/

Он	Даатгуулагчийн тоо	Нэрийн дансны эхний үлдэгдэл	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	Мөнгөжүүлсэн орлого	Нэрийн дансны зарлага	Хүүгийн орлого	Нэрийн дансны эцсийн үлдэгдэл /2+3-4-5+6
А	Б	2	3	4	5	6	7
2000							
2001							
2002							
2003							
2004							
2005							
2006							
2007							
2008							
2009							
2010							
2011							
2012							
2013							
2014							
2015							
2016							
2017							
2018							
2019							
2020							
2021							
2022							
2023							
....							

Нэрийн дансыг нээх, бүртгэх, хөтлөх,
даатгуулагчийн гарааны үлдэгдлийг
тооцохтой холбогдсон харилцааг
зохицуулах журмын хоёрдугаар хавсралт

1119276367
5284708 СБА1473

ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН
НЭРИЙН ДАНСНЫ ЛАВЛАГААНЫ МАЯГТ

..... оны ..... сарын ..... өдөр

Даатгуулагчийн:
Эцэг/эхийн нэр:.....Нэр:.....

Дахин давтагдашгүй дугаар: .....

..... оны нэрийн дансны эхний үлдэгдэл: .....

/төгрөгөөр/

Сар	Цалин хөлс	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого		Мөнгөжүүлсэн орлого	Зарлага	Бүртгэсэн шимтгэлийн орлого
		Ажил олгогч	Даатгуулагч			
А	1	2	3	4	5	6
1						
2						
3						
4						
5						
6						
7						
8						
9						
10						
11						
12						
Дүн						

Нэрийн дансны орлогод тооцох хүүгийн хэмжээ: .....

..... оны нэрийн дансны эцсийн үлдэгдэл:.....

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2024.04.05 № 04/705

танай _____-ны № _____-т

АЙМАГ, ДҮҮРГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН
ДАРГА НАРТ

Тушаал хүргүүлэх тухай

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 02-ний өдрийн "Даатгуулагчийн төрлийн код нэмж батлах тухай" А/43 дугаар тушаалыг хүргүүлж байна.

Энэ тушаалаар хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон хугацаат цэргийн алба хаагч, цэргийн сургуулийн сонсогчийг бүртгэх даатгуулагчийн төрлийн кодыг "08012" гэж, ажил олгогчийн захиалгаар суралцаж байгаа хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон ажилтан, төрийн албан хаагчийг бүртгэх даатгуулагчийн төрлийн кодыг "20012" гэж тогтоон ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийг 9.5 хувиар төлүүлэхээр, улсын хил дээр ажиллаж байгаа гаалийн улсын байцаагчийн ажилгүй байгаа хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон эхнэр, нөхрийг бүртгэх даатгуулагчийн төрлийн кодыг "28012" гэж , улсын хил дээр алба хааж байгаа офицер, ахлагчийн ажилгүй байгаа хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон эхнэр, нөхрийг бүртгэх даатгуулагчийн төрлийн кодыг "29012" гэж, дипломат төлөөлөгчийн газрын ажилтны ажил хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон эхнэр, нөхрийг бүртгэх даатгуулагчийн төрлийн кодыг "30012" гэж тус тус тогтоон ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийг 18.8 хувиар төлүүлэхээр, улирлын шинжтэй ажил үүргийг байнга эрхэлдэг өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ажилтан (ажил зогссон үед, тэтгэврийн даатгалын шимтгэл төлнө)-ыг бүртгэх даатгуулагчийн төрлийн кодыг "25012" гэж, улирлын шинжтэй ажил үүргийг байнга эрхэлдэг хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон ажилтан (ажил зогссон үед)-ыг бүртгэх даатгуулагчийн төрлийн кодыг "25032" гэж тогтоон ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийг 10.0-12.0 хувиар төлүүлэхээр, улирлын шинжтэй ажил үүргийг байнга эрхэлдэг хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон ажилтан (ажил зогссон үед)-ыг бүртгэх даатгуулагчийн төрлийн кодыг "25022" гэж тус тус тогтоон ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийг 1.5-3.5 хувиар төлүүлэхээр нэмж баталсан болно.

Иймд энэхүү тушаалыг сайтар судлан, Нийгмийн даатгалын байцаагч, ажилтнуудад танилцуулан, мэргэжил арга зүйгээр, ажил олгогч, даатгуулагчдыг мэдээллээр ханган, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана уу.

Хавсралт 2 хуудастай.

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, СУДАЛГААНЫ
ГАЗРЫН ДАРГА Ц.ГАНЦЭЦЭГ

9024020133 CTC4665 9081739

1524070883

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 04 дугаар сарын 02 Дугаар А/43 Улаанбаатар хот

Даатгуулагчийн төрлийн код нэмж батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.1, 7.4.4, 7.4.6, 7.4.9 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8,3 дахь хэсэг, Засгийн газрын 2023 оны 469 дүгээр тогтоолоор батлагдсан "Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм"-ийн 3.2.3 дахь заалт, Хөдөлмөр, нийгмийн хамгаллын сайд, Сангийн сайдын 2024 оны "Маягтын загвар, аргачлал батлах тухай" А44/А/40 дүгээр хамтарсан тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд бүртгэх даатгуулагчийн төрлийн кодуудыг хавсралтаар нэмж батлагдсугай.

Хоёр. Даатгуулагчийн төрлийн батлагдсан кодуудыг мөрдөн ажиллахыг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт, мэргэжил, арга зүйгээр ханган ажиллахыг Бодлогын хэрэгжилт, судалгааны газар (Ц.Ганцэцэг)-т, нийгмийн даатгалын мэдээллийн системд байршуулан, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд хэрэглэх боломж бүрдүүлэхийг Мэдээллийн технологийн төв (Г.Хүрэлбаатар)-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (С.Лхагвадорж)-т тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэ тушаалаар батлагдсан даатгуулагчийн төрлийн кодуудыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ДАРГА Л.МӨНХЗУЛ

152/010230

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн А/43 дугаар тушаалын хавсралт

АЖИЛ ОЛГОГЧИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨЛТИЙН ТАЙЛАНД БҮРТГЭХ ДААТГУУЛАГЧИЙН ТӨРЛИЙН КОД

Д/Д	ДААТГУУЛАГЧИЙН ТӨРӨЛ КОД	ДААТГУУЛАГЧИЙН ТӨРӨЛ	ШИМТГЭЛ ТООЦОХ ЦАЛИН ХӨЛС, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГО	ШИМТГЭЛ ТӨЛӨХ ХЭМЖЭЭ /КОД/										НИЙТ НДШ	ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗААЛТ	ХАРИУЦАН ТӨЛӨХ ГАЗАР
				ТЭТГЭВЭР		ТЭТГЭМЖ		АЖИЛГҮЙДЭЛ		ҮСМШӨ		ЭМД				
				АЖИЛ ОЛГОГЧ	ДААТГУУЛАГЧ	АЖИЛ ОЛГОГЧ	ДААТГУУЛАГЧ	АЖИЛ ОЛГОГЧ	ДААТГУУЛАГЧ	АЖИЛ ОЛГОГЧ	ДААТГУУЛАГЧ	АЖИЛ ОЛГОГЧ	ДААТГУУЛАГЧ			
1	08012	Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон хугацаат цэргийн алба хаагч, цэргийн сургуулийн сонсогч	ХХДоХ	8.5		1.0								**9.5**	НДЕХ-ийн 7.4.9, 18.1, 21.18, ЗГ-ын 2019 оны 137	Цэргийн анги, байгууллага хариуцан сар бүр нийгмийн даатгалын санд төлнө
2	20012	Ажил олгогчийн захиалгаар суралцаж байгаа хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон ажилтан, төрийн албан хаагч	ХХДоХ	8.5		1.0								**9.5**	НДЕХ-ийн 7.4.4, 18.1, 21.13,	Ажил олгогч хариуцан нийгмийн даатгалын санд сар бүр төлнө
3	25012	Улирлын шинжтэй ажил үүргийг байнга эрхэлдэг өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ажилтан /ажил зогссон үед/ тэтгэврийн даатгалын шимтгэл төлөх	ХХДоХ	8.5		1.0				0.5-2.5				**10.0-12.0**	НДЕХ-ийн 18.1, ЭМДТХ-ийн 8.2, 8.3, ХөдТХ-ийн 116.5	Ажил олгогч хариуцан нийгмийн даатгалын санд төлнө
4	25022	Улирлын шинжтэй ажил үүргийг байнга эрхэлдэг өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ажилтан /ажил зогссон үед/ тэтгэврийн даатгалын шимтгэл төлөхгүй	ХХДоХ			1.0				0.5-2.5				**1.5-3.5**	НДЕХ-ийн 7,6, 18.1, ЭМДТХ-ийн 8.2, 8.3, ХөдТХ-ийн 116.5 Тухайн даатгуулагчийн тэрсэн онд хэрэглэх өндөр насны тэтгэвэр тогтоох насыг баримтлана.	Ажил олгогч хариуцан нийгмийн даатгалын санд төлнө
5	25032	Улирлын шинжтэй ажил үүргийг байнга эрхэлдэг хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон ажилтан /ажил зогссон үед/	ХХДоХ	8.5		1.0				0.5-2.5				**10.0-12.0**	НДЕХ-ийн 18.1, ЭМДТХ-ийн 8.2, 8.3, ХөдТХ-ийн 116.5	Ажил олгогч хариуцан нийгмийн даатгалын санд төлнө
6	28012	Улсын хил дээр ажиллаж байгаа гаалийн улсын байцаагчийн ажилгүй байгаа хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон эхнэр/ нөхөр	ХХДоХ	17.0		1.8								**18.8**	НДЕХ-ийн 7.4.1, 18.1, 21.11, ГТХ-ийн 282.7	Нөхөр, эхнэрийн ажиллаж байгаа ажил олгогч хариуцан сар бүр төлнө
7	29012	Улсын хил дээр алба хааж байгаа офицер, ахлагчийн ажилгүй байгаа хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон эхнэр/нөхөр	ХХДоХ	17.0		1.8								**18.8**	НДЕХ-ийн 7.4.1, 18.1, 21.11, МУХТХ-ийн 39.5	Нөхөр, эхнэрийн ажиллаж байгаа ажил олгогч хариуцан сар бүр төлнө
8	30012	Дипломат төлөөлөгчийн газрын ажилтны хөдөлмөр эрхлэгүй, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон эхнэр/нөхөр	ХХДоХ	17.0		1.8								**18.8**	НДЕХ-ийн 7.4.6, 18.1, 21.15, ДАТХ-ийн 23.2	Нөхөр, эхнэрийн ажиллаж байгаа ажил олгогч хариуцан нийгмийн даатгалын санд сар бүр төлнө

Товчилсон үгийн тайлбар:НДЕХ-Нийгмийн даатгалын ерөнхий хууль, ЗГ- Засгийн газар, ЭМДТХ-Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, ХХДоХ-Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, ХөдТХ-Хөдөлмөрийн тухай хууль, ГТХ-Гаалийн тухай хууль, МУХТХ-Монгол Улсын хилийн тухай хууль, ДАТХ-Дипломат албаны тухай хууль.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2023.12.27 № 05/2407

танай _____-ны № _____-т

АЙМАГ (НИЙСЛЭЛ), ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС
(ГАЗАР)-ИЙН ДАРГА НАРТ

Шийдвэр хүргүүлэх тухай

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн "Журам батлах тухай" А/183 дугаар тушаалыг хүргүүлж байна.

Дээрх тушаалаар батлагдсан "Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журам"-аар аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрууд ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн орлогыг хүлээн авах, уг орлогыг Нийгмийн даатгалын ерөнхий газарт төвлөрүүлэх, Нийгмийн даатгалын ерөнхий газраас шимтгэлийн орлогыг хуваарилан, санхүүжилт олгохтой холбоотой харилцааг зохицуулсан.

Энэ журмын 3 дугаар зүйлийн 3.3.2 дахь хэсэгт заасан гүйлгээг арилжааны банктай "Хамтран ажиллах гэрээ"-нд өөрчлөлт орох хүртэлх хугацаанд төлбөрийн даалгавраар хийнэ.

Журмыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөх тул холбогдох ажилтнуудад танилцуулан хэрэгжилтийг ханган ажиллана уу.

Хавсралт 3 хуудастай.

САНХҮҮ БҮРТГЭЛИЙН
ГАЗРЫН ДАРГА Б.ДАВААХҮҮ

My doc.SBG A-4 /23.12/-r sar

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 12 сарын 26 өдөр Дугаар А/183 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийгмийн даатгалын ерөнхий хууль (шинэчилсэн найруулга)-ийн 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэг, 37 дугаар зүйлийн 37.13.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журам”-ыг хавсралтаар батлалсугай.

2.Батлагдсан журмын хэрэгжилтийг хангахыг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт, мэргэжил, арга зүйгээр ханган ажиллахыг Санхүү бүртгэлийн газар (Б.Даваахүү)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

4.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2016 оны “Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн урсгалыг зорицуулах талаар авах арга хэмжээний тухай” А/51, 2019 оны “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” А/121, 2023 оны “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” 170 дугаар тушаалыг тус тус 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүйд тооцсугай.

5.Тушаалын хэрэгжилтэд тавьж ажиллахыг Дотоод аудит, мониторингийн газар (Б.Ганхуяг)-т даалгасугай.

ДАРГА Л.МӨНХЗУЛ

1523010898

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн
А/182 дугаар тушаалын хавсралт

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ОРЛОГЫГ ТӨВЛӨРҮҮЛЭХ, ХУВААРИЛАХ, САНХҮҮЖИЛТ ОЛГОХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Зорилго

1.1. Энэ журмын зорилго нь нийгмийн даатгалын сангийн төвлөрсөн орлогын харилцах дансанд төвлөрсөн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих, нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн урсгалыг зохицуулахад баримтална.

Хоёр. Хамрах хүрээ

2.1. Энэ журам нь Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (цаашид “Нийгмийн даатгалын ерөнхий газар” гэх)-н санхүү бүртгэлийн асуудал хариуцсан нэгж, аймаг, нийслэл, дүүргийн Нийгмийн даатгалын газруудын үйл ажиллагаанд хамаарна.

Гурав. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого болон дансны үлдэгдлийг төвлөрүүлэх

3.1. Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газар нь нийгмийн даатгалын сангийн төвлөрсөн орлогын харилцах дансанд (цаашид “Төвлөрсөн орлогын харилцах данс” гэх) ажил олгогч, даатгуулагчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл, шимтгэл төлөх хугацаа хэтрүүлсэн, цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээг бууруулсан болон нуусан орлогод тооцсон алданги, торгуулийн орлогыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын төвлөрсөн орлогын харилцах дансанд төвлөрүүлнэ.

3.2. Нийслэлийн Нийгмийн даатгалын газар болон сум нь нийгмийн даатгалын сангийн харилцах дансгүй байна.

3.3. Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газар нь энэ журмын 3.1-д заасан орлогыг төвлөрсөн орлогын харилцах дансанд доор дурдсаны дагуу өдөр бүр төвлөрүүлнэ:

3.3.1. Төрийн сан дахь төвлөрсөн орлогын харилцах дансны үлдэгдлийг тухайн ажлын өдрийн 15:00 цагаас өмнө Төрийн сангийн цахим системээр дамжуулан шилжүүлнэ.

3.3.2. Арилжааны банк дахь төвлөрсөн орлогын харилцах дансны үлдэгдлийг төвлөрүүлэх ажлыг тухайн банктай байгуулах “Хамтран ажиллах гэрээ”-ээр зохицуулна.

Дөрөв. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг нийгмийн даатгалын сангуудад хуваарилах

4.1. Нийгмийн даатгалын ерөнхий газар нь төвлөрсөн орлогын харилцах дансанд төвлөрсөн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг нийт ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн ногдуулалтын хувиар 7 хоног бүр нийгмийн даатгалын холбогдох санд хуваарилах буюу сан тус бүрийн харилцах дансанд шилжүүлнэ.

4.1.1. Шимтгэлийн ногдуулалтын хувь нь ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, сайн дурын даатгуулагчийн гэрээний дагуу төлсөн нийгмийн даатгалын шимтгэлд үндэслэх бөгөөд нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн системд автоматаар хуваарилалт хийх боломжийг бүрдүүлсэн байна.

4.1.2. Төвлөрсөн орлогын харилцах дансанд хуваарилагдаагүй үлдсэн үлдэгдлээс шалтгаалан мөнгөн хөрөнгийн хуваарилалтын зөрүү үүсч болох бөгөөд тухайн сард үүссэн зөрүүг дараагийн сард, жилийн эцэст үүссэн зөрүүг нягтлан бодох бүртгэлд бүртгэж, дараа жилд тус тус залруулах арга хэмжээ авна.

Тав. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлын санхүүжилт олгох

5.1 Нийгмийн даатгалын ерөнхий газар нь Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад олгох сан тус бүрийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлын санхүүжилтийг сан тус бүрийн харилцах дансны өмнөх сарын үлдэгдлийг хасаж, дараах байдлаар олгоно:

5.1.1. Дараа сарын тэтгэврийн даатгалын сангийн зардлын санхүүжилтийг тухайн сарын 20-ны өдрөөс хойш;

5.1.2. Бусад сангийн зардлын санхүүжилтийн 50 хүртэлх хувийг тухайн сарын эхний ажлын 2 өдөрт, үлдэгдэл санхүүжилтийг тухайн сарын 10-ны өдрийн дотор багтаан олгоно.

5.1.3. Нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэлийн орлого, зарлагын мэдээний гүйцэтгэлд үндэслэн энэ журмын 5.1-д заасны дагуу хассан, олгогдоогүй санхүүжилтийг олгож болно.

Зургаа. Хяналт тавих

6.1. Энэ журмын хэрэгжилтэд Санхүү бүртгэлийн газар, Дотоод аудит, мониторингийн газар хяналт тавьж ажиллана.

Долоо. Хариуцлага

7.1. Энэ журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 02 дугаар сарын 08 Дугаар А/19 Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 15 дугаар зүйлийн 15.3, 37 дугаар зүйлийн 37.13.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэх маягтыг хэвлүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэхүү журмыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Нийгмийн даатгалын байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү бүртгэлийн газар (Б.Даваахүү), Дотоод аудит, мониторингийн газар (Б.Ганхуяг)-т тус тус даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” А/37 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА А.МӨНХЗУЛ

1524010112

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн
А/19 дугаар тушаалын хавсралт

НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЭРЭГЛЭХ МАЯГТЫГ ХЭВЛҮҮЛЭХ, ЗАРЦУУЛАХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмаар нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэх маягтыг захиалах, хэвлүүлэх, нөөцлөх, хадгалах, хуваарилах, зарцуулах, тооцоо хийх, тэдгээрт хяналт тавих, тайлагнах, акталж данснаас хасахтай холбоотой харилцааг зохицуулна.

Хоёр. Хамрах хүрээ

2.1.Энэ журам нь Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (цаашид "Нийгмийн даатгалын ерөнхий газар" гэх), аймаг, нийслэл, дүүргийн Нийгмийн даатгалын газрын үйл ажиллагаанд хамаарна.

Гурав. Маягтыг захиалах, хэвлүүлэх, нөөцлөх

3.1.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 15.3 дахь хэсэгт заасны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газар болон бусад эрх бүхий байгууллагаас нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд мөрдүүлэхээр баталсан анхан шатны баримтыг маягт гэж ойлгоно.

3.2.Маягтын загварыг Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 15.3 дахь хэсэгт заасны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газар болон эрх бүхий байгууллага батлаж, хүчингүй болгоно.

3.3.Аймаг, нийслэл, дүүргийн Нийгмийн даатгалын газар нь төсвийн төсөв, төсөөлөл боловсруулахдаа дараа жилд шаардагдах нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн анхан шатны маягтын тоог төрөл тус бүрээр тооцож, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү бүртгэл хариуцсан нэгжид 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлэх ба уг нэгж нь 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор төлөвлөлт хариуцсан нэгжид дараа жилийн маягтын зардлын тооцоог тайлбарын хамт хүргүүлнэ.

3.4.Нийгмийн даатгалын ерөнхий газар нь маягтыг нэр, төрлөөр нь багцалж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу гүйцэтгэгч байгууллагыг сонгон шалгаруулж, хэвлүүлэх ажлыг зохион байгуулна.

3.5.Нийгмийн даатгалын ерөнхий газар нь аймаг, нийслэл, дүүргийн Нийгмийн даатгалын газраас ирүүлсэн санал, гүйцэтгэлийг үндэслэн маягтыг гурав буюу түүнээс дээш сарын нөөцтэй байлгана.

3.6.Нийгмийн даатгалын ерөнхий газрын хөрөнгө хариуцсан ажилтан хэвлүүлсэн

маягтыг эх загвар, техникийн тодорхойлолтын дагуу шалган хүлээн авч, хадгалах ажлыг хариуцна.

Дөрөв. Маягтыг хуваарилах, зарцуулах

4.1.Нийгмийн даатгалын ерөнхий газар нь аймаг, нийслэл, дүүргийн Нийгмийн даатгалын газраас ирүүлсэн санал, гүйцэтгэлийг үндэслэн маягт олгох хуваарийг баталж хүргүүлнэ.

4.2.Аймаг, нийслэл, дүүргийн Нийгмийн даатгалын газрын хөрөнгө хариуцсан ажилтан (цаашид "ажилтан" гэх) нь маягт олгохдоо нэр төрөл, тоо хэмжээ, дугаарын бүртгэл хөтөлнө.

4.3.Аймаг, нийслэл, дүүргийн Нийгмийн даатгалын газар нь хүлээн авсан маягтыг олгоход Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын дагуу бүртгэл хөтөлж, зарцуулна.

Тав. Маягтын тооцоо хийх, хяналт тавих

5.1.Ажилтан нь өмнө олгосон маягтыг нэр төрөл, тоо хэмжээгээр тулган зарцуулалтын тооцоог байцаагчтай хийж дахин маягт олгоно. Тооцоо хийгээгүй болон тооцооны зөрүүтэй бол байцаагчид маягт олгохгүй.

5.2.Ажилтан нь маягтын тооцоог улирал бүр хийх бөгөөд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн А/92 тушаалаар батлсан "Нийгмийн даатгалын байгууллагын эд хөрөнгийн тооллого явуулах журам"-ын 4.4.1 дэх хэсэгт заасны дагуу тооллогод хамруулж, тооцоо нийлж баталгаажуулна.

5.3.Ажилтан өөрчлөгдөх бол маягтыг тоолж хүлээлцүүлэн, хадгалалт, зарцуулалтад хяналт тавих үүргийг ахлах нягтлан бодогч, үйл ажиллагааны нягтлан бодогч нар хариуцна.

5.4.Программ хангамж, сүлжээ, техник тоног төхөөрөмжийн саатал, гэмтэл болон эмнэлэгийн хуудас цахимаар бичиж олгох боломжгүй бусад нөхцөл байдал үүссэн тохиолдолд эмнэлгийн хуудсыг эрүүл мэндийн байгууллагад цаасан хэлбэрээр олгоно.

5.5.Эрүүл мэндийн байгууллагаас олгосон эмнэлгийн хуудасны бичилт, олголт, зарцуулалтын тооцоог Нийгмийн даатгалын газрын магадлагч эмч хянаж, хүчингүй болсон эмнэлгийн хуудсыг тулган шалгаж, дахин эмнэлгийн хуудас олгох зөвшөөрөл олгоно.

5.6.Ажилтан нь эрүүл мэндийн байгууллагад өмнө олгосон маягтын зарцуулалтын тооцоог хийсний дараа дахин маягт олгоно. Тооцоо хийгээгүй болон тооцооны зөрүүтэй эрүүл мэндийн байгууллагад маягт олгохгүй.

Зургаа. Тайлагнах

6.1.Ажилтан нь маягтын тайланг улирал бүр гарган үйл ажиллагааны нягтлан

бодогчид хянуулж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын хөрөнгө хариуцсан ажилтан хүргүүлнэ.

6.2.Нийгмийн даатгалын ерөнхий газрын хөрөнгө хариуцсан ажилтан нь улирал бүр ажилтантай маягтын тооцоог хянан, тооцоо нийлж, тайланг нэгтгэн гаргана.

Долоо. Маягтыг акталж данснаас хасах

7.1.Аймаг, нийслэл, дүүргийн Нийгмийн даатгалын газар нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр хүчингүй болсон, шаардлага хангахгүй болсон, загвар өөрчлөгдсөн, цаашид ашиглахгүй болсон маягтуудыг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулж, жагсаалтыг албан бичгийн хамт Нийгмийн даатгалын ерөнхий газрын санхүү бүртгэл хариуцсан нэгжид ирүүлнэ.

7.2.Санхүү бүртгэл хариуцсан нэгж нь энэ журмын 7.1-т заасан саналуудыг нэгтгэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар холбогдох шийдвэр гарна.

7.3.Аймаг, нийслэл, дүүргийн Нийгмийн даатгалын газрууд нь Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалыг үндэслэн маягтыг холбогдох хууль, журмын дагуу акталж, биелэлтийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын санхүү бүртгэл хариуцсан нэгжид ирүүлнэ.

7.4.Байгалийн давагдашгүй хүчин зүйл, гэнэтийн осол, гал, ус, үер, олныг хамарсан үймээн самуун, халдлагад өртөж маягт дутсан нь мэргэжлийн байгууллагаар нотлогдсон тохиолдолд энэ журмын 7 дахь хэсгийн 7.1, 7.2, 7.3-т заасны дагуу шийдвэрлэнэ.

Найм. Хариуцлага

8.1.Энэ журмыг зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, ёс зүйн зөрчил гаргасан нийгмийн даатгалын байцаагч, ажилтанд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 11 сарын 13 өдөр Дугаар А/147 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 37 дугаар зүйлийн 37.13.1, 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг хүлээн авах, хянах, залруулга хийх, баталгаажуулах журам”-ыг хавсралтаар батлагдсугай.

2. Батлагдсан журмыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж ажиллахыг аймаг, дүүрэг (нийслэл)-ийн Нийгмийн даатгалын хэлтэс, (газар), Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба, БНСУ дахь Нийгмийн даатгалын тасгийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү бүртгэлийн газар /Б.Даваахүү/-т даалгасугай.

ДАРГА Л.МӨНХЗУЛ

1523010763

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн
тушаалын хавсралт

Нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг хүлээн авах, хянах, залруулга хийх, баталгаажуулах журам

Нэг. Зорилго

1.1.Нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан (цаашид "тайлан" гэх)-г цахим болон цаасан хэлбэрээр хүлээн авах, хянах, залруулга хийх, баталгаажуулах, холбогдох баримтыг архивт хүлээлгэн өгөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Хамрах хүрээ

2.1.Төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Сангийн сайдын 2020 оны "Журам шинэчлэн батлах тухай" 46 дугаар тушаалаар баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланг хүлээн авах, хянах, нэгтгэл хийх, нэгтгэлийн мэдээллийг ашиглах журам", 2015 оны "Журам шинэчлэн батлах тухай" 341 дүгээр тушаалын хүрээнд нийгмийн даатгалын сангийн тайланг хүлээн авах, хянах, залруулга хийх, баталгаажуулах үйл ажиллагааг хамруулна.

Гурав. Хамаарах талууд

3.1.Энэхүү журамд хамаарах талууд нь аймаг, нийслэл, дүүргийн Нийгмийн даатгалын газар, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба, БНСУ дахь Нийгмийн даатгалын тасаг байна.

Дөрөв. Баримт бичгийн хариуцагч

4.1.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын санхүү бүртгэлийн асуудал хариуцсан нэгж нь энэ журмыг хариуцна.

Тав. Нийтлэг үндэслэл

5.1.Тайлангийн нэгтгэлд нийгмийн даатгалын сан бүрдүүлж, даатгуулагчид тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр, ажил олгогчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал олгох, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх зэрэг үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдийг бүрэн хамруулна.

5.2.Аймгийн Нийгмийн даатгалын газар нь сумдын нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагыг тайланд бүрэн тусгана.

5.3.Нийслэлийн Нийгмийн даатгалын газар (цаашид "дээд шатны төсвийн захирагч" гэх) нь дүүргийн Нийгмийн даатгалын газар (цаашид "төсвийн захирагч" гэх)-ын тайланг нэгтгэнэ.

5.4.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (цаашид "дээд шатны төсвийн захирагч" гэх) нь аймаг, нийслэлийн Нийгмийн даатгалын газар болон тайлагналын зорилгоор хяналтад байгаа байгууллага (цаашид "төсвийн захирагч" гэх)-ын тайланг нэгтгэнэ.

5.5.Санхүүгийн тайланг "Засгийн газрын санхүүгийн Э-Тайлан" цахим системээр хүлээн авч нэгтгэнэ.

5.6.Төсвийн гүйцэтгэлийн тайланг нийгмийн даатгалын цахим системээр хүлээн авч нэгтгэнэ.

5.7.Тайлангийн системд нэвтрэх нэр, нууц үгийг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага олгоно.

5.8.Дээд шатны төсвийн захирагч нь тайлан гаргах арга зүйгээр хангаж ажиллана.

Зургаа. Тайлан хүлээн авах, хянах

6.1.Төсвийн захирагч нь дор дурдсан 2 төрлийн тайланг улирал, хагас жил, жилээр гаргаж, хуваарьт хугацаанд багтаан дээд шатны төсвийн захирагчид цахим хэлбэрээр хүргүүлнэ. Үүнд:

6.1.1.санхүүгийн тайлан

6.1.2.төсвийн гүйцэтгэлийн тайлан

6.2.Дээд шатны төсвийн захирагч нь тайлан хүлээн авах хуваарийг тогтоохдоо төсвийн захирагчийн сум, харилцагчийн тоог харгалзана.

6.3.Тайлан гаргах, нэгтгэх ажлыг төсвийн захирагч болон дээд шатны төсвийн захирагч нь дотооддоо зохион байгуулна.

6.4.Тайлан хүлээн авч, нэгтгэх систем нь хуульд заасан тайлан хүлээн авах хугацааны эхний өдрөөс сүүлийн өдрийн 24:00 цаг хүртэл нээлттэй байна.

6.5.Дээд шатны төсвийн захирагч нь төсвийн захирагчийн улирлын санхүүгийн тайланг нийгмийн даатгалын цахим системээр нэгтгэж болно.

6.6.Дээд шатны төсвийн захирагч нь дараах шаардлагыг хангасан тайланг хүлээн авна. Үүнд:

6.6.1.тухайн шатны төсвийн ахлах нягтлан бодогч бэлтгэсэн байх;

6.6.2.тайлангийн үзүүлэлтүүд Монгол улсын мөнгөн тэмдэгтээр илэрхийлэгдсэн байх;

6.6.3.давхардсан ажил гүйлгээг цэвэрлэсэн байх;

6.6.4.тоон үзүүлэлтүүд тооцооллын алдаагүй байх;

6.6.5.маягтын дагуу бүрэн, алдаагүй зөв бөглөсөн байх;

6.6.6.өмнөх хугацааны тайлантай уялдаж байх;

6.6.7.өмнөх болон тайлант хугацааны төсвийн захирагчийн хоорондын тооцооны устгал хийгдсэн цэвэр дүнгээр тайлагнасан байх;

6.6.8.мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг дансны үлдэгдлийн баталгаагаар баталгаажуулсан байх;

6.6.9.хүү, банкны тэтгэвэр олгосон үйлчилгээний хөлс, төвлөрүүлэлт, санхүүжилт, улсын төсвийн тооцоо болон авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байх;

6.6.10.төсвийн гүйцэтгэлийн хүрсэн үр дүн, хэтрэлт, хэмнэлтийн тайлбар, танилцуулгыг бэлтгэсэн байх;

6.6.11.жилийн тайланд аудит хийлгэсэн байх;

6.6.12.Шаардлагын 6.6.8-6.6.11-ийг албан бичгийн хамт хавсаргаж, дээд шатны төсвийн захирагчид ирүүлсэн байх;

6.7.Энэ журмын 6.6-д заасан шаардлагын аль нэгийг хангаагүй тайланг дээд шатны төсвийн захирагч хүлээн авахгүй.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД
Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024.02.16 № 1/718

танай 2024.01.05 -ны № 01/40 -т

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА
Л.МӨНХЗУЛ ТАНАА

Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзээд “Журам батлах тухай” Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/190 дүгээр тушаалыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн ....6641... дугаарт, “Журам батлах тухай” 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/194 дүгээр тушаалыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн ...6642..... дугаарт тус тус бүртгэж хүргүүлэв.

Б.ЭНХБАЯР

15160051 9

Doc.yam a5.2024

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 12 сарын 27 өдөр Дугаар А/190 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчид бүртгэлийн дугаар олгох, хэрэглэх болон хувийн хэрэг нээх, бүртгэх, хөтлөх, шилжүүлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан журмыг мөрдөж ажиллахыг аймаг, нийслэл, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт, нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд ажил олгогч цахимаар бүртгүүлэх нөхцөлийг бүрдүүлэхийг Мэдээллийн технологийн төв /Г.Хүрэлбаатар/-д, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Бодлогын хэрэгжилт, судалгааны газар /Ц.Ганцэцэг/-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудит, мониторингийн газар /Б.Ганхуяг/-т даалгасугай.

ДАРГА Л.МӨНХЗУЛ

1523010930

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/190 дугаар тушаалын хавсралт.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨГЧИД БҮРТГЭЛИЙН ДУГААР ОЛГОХ, ХЭРЭГЛЭХ БОЛОН ХУВИЙН ХЭРЭГ НЭЭХ, БҮРТГЭХ, ХӨТЛӨХ, ШИЛЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар ажил олгогч, даатгуулагчийг нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгэх, бүртгэлийн дугаар олгох, түүнийг хэрэглэх, хувийн хэрэг нээх, бүртгэх, хөтлөх, шилжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

Хоёр. Ажил олгогчийг шимтгэл төлөгчөөр бүртгэх, бүртгэлийн дугаар олгох

2.1. Ажил олгогчийн үүсгэн байгуулагч, эрх бүхий этгээд нь хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй.

2.2. Ажил олгогч нь шимтгэл төлөгчөөр бүртгүүлэх хүсэлт, холбогдох баримт бичгийг цаасан, эсхүл цахим хэлбэрээр ирүүлнэ.

2.3. Ажил олгогч нь нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгүүлэхэд дараах баримт бичиг, мэдээллийг ирүүлнэ. Үүнд:

2.3.1. Нийгмийн даатгалд шимтгэл төлөгчөөр бүртгүүлэх тухай албан хүсэлт;

2.3.2. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар эсхүл холбогдох байгууллагын шийдвэр;

2.3.3. Үүсгэн байгуулагч, эрх бүхий этгээдийн цахим шуудангийн хаяг, утасны дугаар;

2.3.4. Шаардлагатай тохиолдолд итгэмжлэл;

2.3.5. Банкин дахь харилцах дансны жагсаалт.

2.4. Ажил олгогч цахимаар бүртгүүлэх хүсэлт гаргасан тохиолдолд нийгмийн даатгалын байгууллага энэ журмын 2.3.2-т заасан баримт бичиг, мэдээллийг улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын мэдээллийн сангаас Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 18 дугаар зүйлийн 18.3-т заасан үндсэн систем /цаашид “үндсэн систем” гэх/-ээр дамжуулан авна.

2.5. Хуулийн этгээдийн эрхгүй байгууллага /хуулийн этгээдийн салбар, төлөөлөгч, төлөөний газар, төсөл, хөтөлбөрийн нэгж салбар, нөхөрлөл, сан, сууц өмчлөгчдийн холбоо/ нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгүүлэхэд үүсгэн байгуулагч, гүйцэтгэх удирдлага, төлөөлөх эрх бүхий албан тушаалтны шийдвэр болон энэ журмын 2.3-т заасан баримт бичиг, мэдээллийг ирүүлнэ.

2.6. Нийгмийн даатгалын байгууллага нь ажил олгогчийн хүсэлтийг хүлээн авсан ажлын 3 өдөрт багтаан нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд бүртгэснээр шимтгэл төлөгчид дахин давтагдашгүй дугаар /цаашид “бүртгэлийн дугаар” гэх/-ыг нэг удаа олгоно.

2.7. Хуулийн этгээд нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах замаар шинээр бий болсон хуулийн этгээдэд бүртгэлийн дугаарыг шинээр олгоно.

2.8. Татан буугдсан, дампуурсан тухай шүүхийн шийдвэр гарсан, улсын бүртгэлээс хасагдсан ажил олгогчийн бүртгэлийн дугаарыг өөр ажил олгогчид давхардуулан олгохгүй.

2.9. Ажил олгогчийг бүртгэсэн тухай мэдэгдлийг цахимаар хүргүүлэх бөгөөд мэдэгдэл нь ажил олгогчийн бүртгэлийн дугаар, нийгмийн даатгалд бүртгүүлсэн огноо, шимтгэлийн цахим системд нэвтрэх нэр, нууц үг зэргийг агуулсан байна.

2.10. Ажил олгогчийн бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авахаас татгалзсан тохиолдолд тухай бүр тайлбар хүргүүлэх болон цахимаар мэдэгдэнэ.

2.11. Ажил олгогчийн мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд нийгмийн даатгалын байгууллагад холбогдох баримт бичгийг цаасаар болон цахим хэлбэрээр ирүүлнэ.

2.12. Ажил олгогч нь өөрийн байгууллагын мэдээллийн үнэн бодит байдлыг бүрэн хариуцна.

Гурав. Даатгуулагчийг шимтгэл төлөгчөөр бүртгэх, бүртгэлийн дугаар олгох

3.1. Даатгуулагч нь шимтгэл төлөгчөөр бүртгүүлэх хүсэлтээ цаасан, эсхүл цахим хэлбэрээр ирүүлнэ.

3.2. Даатгуулагчийн бүртгэлийн дугаар нь нийгмийн даатгалын байгууллагаас олгосон дахин давтагдашгүй дугаар байна.

Дөрөв. Бүртгэлийн дугаарыг хэрэглэх

4.1. Нийгмийн даатгалын байгууллага шимтгэл төлөгчийн бүртгэлийн дугаарыг нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, шимтгэл төлөлттэй холбоотой баримт бичиг, сангуудын харилцах дансны орлого, зарлагын гүйлгээ хийх, мэдээ, тайлан гаргахад хэрэглэнэ.

4.2. Ажил олгогч бүртгэлийн дугаарыг нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг нийгмийн даатгалын байгууллагад хүргүүлэх, нийгмийн даатгалын улсын байцаагчийн актаар тогтоосон шимтгэл, алданги, торгууль, төлбөрийн тооцоо хийхэд хэрэглэнэ.

Тав. Хувийн хэрэг нээх, бүртгэх, хөтлөх

5.1. Нийгмийн даатгалын байгууллагад бүртгүүлсэн ажил олгогч, сайн дураар даатгуулагчид цаасан болон цахим хувийн хэрэг нээнэ.

5.2. Хувийн хэрэгт шимтгэл төлөлтийн тайлан, сайн дурын даатгуулын гэрээ, эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалтын удирдамж, тайлан, мэдэгдэл, акт, албан шаардлага, шийтгэлийн хуудас зэрэг баримт бичгүүдийг тухай бүр хавсаргаж, бүртгэнэ.

5.3. Хувийн хэрэг нээх, бүртгэх, хөтлөх үүргийг нийгмийн даатгалын байгууллага, байцаагч хариуцна.

5.4. Нийгмийн даатгалын байцаагч санхүүгийн жил дуусгавар болоход цаасан хувийн хэргийг архивт хүлээлгэн өгнө.

5.5. Цахим хувийн хэрэг нээх, түүний хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах нөхцөлийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Мэдээллийн технологийн төв бүрдүүлнэ.

Зургаа. Шимтгэл төлөгчийн шилжилт хөдөлгөөн

6.1. Ажил олгогчийн улсын бүртгэлийн хаягт өөрчлөлт орж, шилжих хүсэлт гаргасан тохиолдолд дараах баримт бичиг, мэдээллийг үндэслэн шилжилт хөдөлгөөнийг хийнэ. Үүнд:

6.1.1. Өөр аймаг, дүүрэгт шилжих тухай албан хүсэлт;

6.1.2. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

6.1.3. Шаардлагатай тохиолдолд итгэмжлэл;

6.1.4. Тооцоо нийлсэн акт

6.2. Шимтгэл төлөгч нь өөр аймаг, дүүрэгт шилжих, нэр өөрчлөгдөхөд бүртгэлийн дугаар өөрчлөгдөхгүй.

6.3. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөнд эзлэх хувь өндөр ажил олгогч энэ журмын 6.1-д заасны дагуу шилжих хүсэлт гаргасан тохиолдолд тухайн ажил олгогчийн бүртгэлтэй нийгмийн даатгалын байгууллага орлогын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах саналаа холбогдох баримт бичгийн хамт Нийгмийн даатгалын ерөнхий газрын бодлого төлөвлөлт хариуцсан нэгжид хагас жил тутамд нэг удаа ирүүлнэ.

6.4. Шилжих хүсэлтийн дагуу шаардлагатай тохиолдолд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан болон санхүүгийн баримтад хяналт шалгалт хийж болно.

6.5. Хүсэлт гаргасан ажил олгогчийн шилжилт хөдөлгөөнийг нийгмийн даатгалын шимтгэлийн өр, авлагын тооцоог дуусгаж, тооцоо нийлсэн акт үйлдсэний дараа хийнэ. Тооцоо нийлсэн актыг хувийн хэрэгт хадгална.

Долоо. Хариуцлага

7.1. Нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасны дагуу бүртгүүлээгүй болон энэ журмыг зөрчсөн ажил олгогчид холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

7.2. Энэ журмыг зөрчсөн албан тушаалтанд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---o0o---

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 06 дугаар сарын 18 Дугаар А/107 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг, 37 дугаар зүйлийн 37.13.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Илүү төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох журам"-ыг хавсралтаар батлалсугай.

2.Батлалсан журмыг мөрдөн ажиллахыг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт, мэргэжил, арга зүйгээр ханган ажиллахыг Бодлогын хэрэгжилт, судалгааны газар (Ц.Ганцэцэг), Санхүү бүртгэлийн газар (Б.Даваахүү)-т, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (С.Лхагвадорж)-т, холбогдох программ хангамжийг хэрэглэх боломжийг бүрдүүлэхийг Мэдээллийн технологийн төв (Г.Хүрэлбаатар)-д тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2013 оны "Аргачлал шинэчлэн батлах тухай" А/197 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудит, мониторингийн газар (Б.Ганхуяг)-т даалгасугай.

ДАРГА Ж.МӨНХЗУЛ

9024020135 СТС4666 9081739

1524019635

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
2024 оны 06 дугаар сарын 18-ний өдрийн
А/107 дугаар тушаалын хавсралт

ИЛҮҮ ТӨЛСӨН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ БУЦААН ОЛГОХ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1."Илүү төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох журам" /цаашид "журам" гэх/-ын зорилго нь ажил олгогч, даатгуулагчийн тухайн сард төлбөл зохих шимтгэлээс илүү төлсөн шимтгэл (цаашид "илүү төлсөн шимтгэл" гэх)-ийг тооцох, дараагийн сар, улирал, жилийн төлбөл зохих шимтгэлд шилжүүлэн тооцох, буцаан олгох, хяналт тавих, хариуцлага хүлээлгэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР. Нэр томьёоны тодорхойлолт

2.1."цалин хөлс, түүнтэй адилтгах орлого" /цаашид "цалин хөлс" гэх/ гэж Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.17-д заасныг;

2.2."нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сан" /цаашид "мэдээллийн нэгдсэн сан" гэх/ гэж Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7-д заасныг;

2.3."үндсэн ажил" гэж Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.5.1-д заасныг;

2.4."нийгмийн даатгалын шимтгэл төлөх сарын цалин хөлсний дээд хэмжээ" гэж Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4-т заасныг.

ГУРАВ. Илүү төлсөн шимтгэлийг шилжүүлэн тооцох, буцаан авах ажил олгогч, даатгуулагч

3.1.Дараах ажил олгогч, даатгуулагч нь илүү төлсөн шимтгэлээ дараагийн сар, улирал, жилд төлбөл зохих шимтгэлд шилжүүлэн тооцуулах, эсхүл буцаан авна:

3.1.1.Илүү төлсөн шимтгэлээ дараагийн сар, улирал, жилийн төлбөл зохих шимтгэлд шилжүүлэн тооцох, эсхүл буцаан авахаар харьяа аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газарт хүсэлт гаргасан ажил олгогч, сайн дурын даатгуулагч;

3.1.2.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2-т заасан гэрээний дагуу албан журмын болон сайн дурын даатгалын шимтгэлээ давхардуулан төлсөн, давхардсан хугацааны сайн дураар төлсөн шимтгэлээ буцаан авахаар харьяа аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газарт хүсэлт гаргасан сайн дурын даатгуулагч;

3.1.3.Үндсэн ажлаас авсан болон Хөдөлмөрийн тухай хуулийн 57 дугаар зүйлд заасан зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээний дагуу хөдөлмөр эрхэлж авсан сарын цалин хөлсний нийлбэр нь тухайн үед мөрдөж байгаа даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх сарын цалин хөлсний дээд хэмжээнээс хэтэрч, уг хэтэрсэн хэмжээнээс илүү төлсөн шимтгэлээ буцаан авах хүсэлтээ энэ журмын 3.2-т заасан хугацаанд гаргасан албан журмын даатгуулагч;

3.1.4.Сайн дураар нийгмийн даатгалын шимтгэл төлсөн боловч ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу хөдөлмөр эрхэлж авсан цалин хөлс болон сайн дураар даатгуулагчийн өөрөө мэдүүлж, гэрээгээр тохирсон орлогын нийлбэр нь албан журмаар даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх сарын

цалин хөлсний дээд хэмжээнээс хэтэрч, уг хэтэрсэн хэмжээнээс илүү төлсөн шимтгэлээ буцаан авах хүсэлтээ энэ журмын 3.2-т заасан хугацаанд гаргасан даатгуулагч.

3.2.Энэ журмын 3.1.3, 3.1.4-т заасан даатгуулагч нийгмийн даатгалын байгууллагад жил бүрийн 4 дүгээр сарын 01-нээс 06 дугаар сарын 30-ны өдрийн хугацаанд илүү төлсөн шимтгэлээ буцаан авах хүсэлт гаргана.

3.3.Энэ журмын 3.1.3, 3.1.4-т заасан даатгуулагч журмын 3.2-т заасан хугацаанд илүү төлсөн шимтгэлээ буцаан авах хүсэлт гаргаагүй тохиолдолд дараа жилийн журмын 3.2-т заасан хугацаанд хүсэлтээ гаргаж болно.

ДӨРӨВ. Илүү төлсөн шимтгэлийг тооцох

4.1.Энэ журмын 3.1.1-д заасан ажил олгогчийн илүү төлсөн шимтгэлийн дүнг Нийгмийн даатгалын байгууллагын баталгаажуулсан ажил олгогчийн шимтгэл төлөлтийн тайлан, сайн дурын даатгуулагчийн илүү төлсөн шимтгэлийн дүнг мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн шимтгэл төлөлтийн мэдээллийг тус тус үндэслэн тооцно.

4.2.Энэ журмын 3.1.2-т заасан сайн дурын даатгуулагчийн илүү төлсөн шимтгэлийн буцаалтыг албан журмын болон сайн дурын даатгуулагчийн давхардсан хугацааны сайн дураар төлсөн шимтгэлийн дүнгээр тооцно.

4.3.Энэ журмын 3.1.3-т заасан даатгуулагчид Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2, 6.1.3-т заасан сангаас буцаан олгох илүү төлсөн шимтгэлийн дүнг дараах байдлаар тооцно:

4.3.1. Даатгуулагч нэг төрлийн кодоор хоёр ба түүнээс дээш ажил олгогчид зэрэг ажиллан шимтгэл төлсөн бол илүү төлсөн шимтгэлийн буцаалтыг төлсөн шимтгэлээс төлбөл зохих шимтгэлийг хасч, зөрүү дүнгээр дараах байдлаар тооцно:

Илүү төлсөн шимтгэл тооцох аргачлал 1.

А) Төлсөн шимтгэл:

Ажил	*Цалин*	*төлсөн шимтгэл /даатгуулагч/*
А ажил /40001код/	*5 000 000₮*	*5 000 000 * 8.5% = 425 000₮*
Б ажил /40001код/	*3 000 000₮*	*3 000 000 * 8.5% = 255 000₮*
Нийт	*8 000 000₮*	*680 000₮*

Б) Төлбөл зохих шимтгэл:

Ажил	*Цалин*	*төлбөл зохих шимтгэл /даатгуулагч/*
А ажил	*5 000 000₮*	*5 000 000 * 8.5% = 425 000₮*
Б ажил	*3 000 000₮*	*(6 600 000 – 5 000 000) * 8.5% = 136 000₮*
Нийт	*8 000 000₮*	*561 000₮*

В) Буцаан олгох илүү төлсөн шимтгэл:

680 000 – 561 000 = 119 000₮

4.3.2.Даатгуулагч хоёр ба түүнээс дээш төрлийн кодоор зэрэг шимтгэл төлсөн бол илүү төлсөн шимтгэлийн буцаалтыг зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээтэй байгууллагаас авсан цалин хөлснөөс тооцсон шимтгэлээс дараах байдлаар тооцно:

Илүү төлсөн шимтгэл тооцох аргачлал 2.

А) Төлсөн шимтгэл:

Ажил	*Цалин*	*НДШ /даатгуулагч/*
Үндсэн ажил /01001код/	*6 000 000₮*	*6 000 000 * 11.5% = 690 000₮*
Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээтэй ажил /40001код/	*3 000 000₮*	*3 000 000 * 8.5% = 255 000₮*
Нийт	*9 000 000₮*	*945 000₮*

Б) Төлбөл зохих шимтгэл:

Ажил	*Цалин*	*НДШ /даатгуулагч/*
Үндсэн ажил	*6 000 000₮*	*6 000 000 * 11.5% = 690 000₮*
Зэргэцсэн хөдөлмөрийн гэрээтэй ажил	*3 000 000₮*	*(6 600 000 – 6 000 000) * 8.5% = 51 000₮*
Нийт	*9 000 000₮*	*741 000₮*

В) Буцаан олгох илүү төлсөн шимтгэл:

945000 - 741 000 = 204 000 ₮

4.3.3.Энэ журмын 3.1.4-т заасан даатгуулагчид Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2, 6.1.3, 6.1.4-т заасан сангаас буцаан олгох илүү төлсөн шимтгэлийн дүнг албан журмын даатгуулагчийн шимтгэл төлөх сарын цалин хөлсний дээд хэмжээг баримтлан сайн дураар төлсөн шимтгэлээс дараах байдлаар тооцно:

Илүү төлсөн шимтгэл тооцох арга члал 3.

А) Төлсөн шимтгэл:

Ажил	*Цалин*	*НДШ /даатгуулагч/*
Ажил гүйцэтгэх гэрээ /02001код/	*3 500 000₮*	*3 500 000 * 9.3% = 325 500₮*
Сайн дурын даатгал /09003код/	*4 000 000₮*	*4 000 000 * 13.5% = 540 000₮*
Нийт	*7 500 000₮*	*865 500₮*

Б) Төлбөл зохих шимтгэл:

Ажил	*Цалин*	*НДШ /даатгуулагч/*
Ажил гүйцэтгэх гэрээ	*3 500 000₮*	*3 500 000 * 9.3% = 325 500₮*
Сайн дурын даатгал	*4 000 000₮*	*(6 600 000 – 3 500 000) * 13.5% = 418 500₮*
Нийт	*7 500 000₮*	*744 000₮*

В) Буцаан олгох илүү төлсөн шимтгэл:

865 500 – 744 000 = 121 500₮

(арга члалыг 2024 оны шимтгэл төлөх сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ 6.600.000 төгрөгөөр тооцов)

ТАВ. Илүү төлсөн шимтгэлийг буцаан олгох, шилжүүлэн тооцох

5.1.Мэдээллийн нэгдсэн санд ажил олгогч, даатгуулагчийн илүү төлсөн шимтгэлийн дүнг харах, тулгах боломжийг бүрдүүлсэн байна. Ажил олгогч, даатгуулагч нийгмийн даатгалын системд цахимаар хандахад тооцоологдсон илүү төлсөн шимтгэлийн дүнг харуулна.

5.2.Илүү төлсөн шимтгэл буцаан авах хүсэлтээ энэ журмын 3.1.1, 3.1.2, 3.1.4-т заасан ажил олгогч, даатгуулагч шимтгэл төлөлтийн тооцоо хийдэг болон сайн дурын даатгалын гэрээ байгуулсан аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газарт, журмын 3.1.3-т заасан даатгуулагч үндсэн ажлын харъяа аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газарт цахимаар эсхүл цаасаар гаргана. Хүсэлтэд илүү төлсөн шимтгэлээ буцаан авах банк, дансны дугаарыг бичсэн байна.

5.3.Хүсэлтийг хамралт, орлого, шимтгэлийн өр хариуцсан байцаагч хүлээн авч, мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн илүү төлсөн шимтгэлийн дүн, тооцооллыг тулган шалгаж баталгаажуулна. Хамралт, орлого, шимтгэлийн өр хариуцсан байцаагч нь тухайн ажил олгогчтой илүү төлсөн шимтгэлийн дүнг тооцоо нийлсэн актаар баталгаажуулна.

5.4.Илүү төлсөн шимтгэлийн баталгаажуулсан дүнг хяналт шалгалтын байцаагч шалган, сангийн нягтлан бодогчид шилжүүлнэ. Сангийн нягтлан бодогч илүү төлсөн шимтгэлийн дүн, тооцооллыг тулган, тухайн ажил олгогч, даатгуулагчийн дансанд шилжүүлэх зөвшөөрөл авахаар ахлах нягтлан бодогчид шилжүүлнэ.

5.5.Ахлах нягтлан бодогч шалгаснаар илүү төлсөн шимтгэлийг тухайн ажил олгогч, даатгуулагчийн дансанд нийгмийн даатгалын сан тус бүрээс тооцсон дүнгээр шилжүүлнэ.

5.6.Нийгмийн даатгалын байгууллага нь ажил олгогч, даатгуулагчийн илүү төлсөн шимтгэлийг авах хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.

5.7.Журмын 3.1.1, 3.1.2-т заасан ажил олгогч, даатгуулагч илүү төлсөн шимтгэлээ буцаан авах хүсэлт гаргаагүй бол шимтгэлийг дараагийн сар, улирал, жилийн төлбөл зохих шимтгэлд шилжүүлэн тооцно.

ЗУРГАА. Хяналт тавих, хариуцлага хүлээлгэх

6.1.Ажил олгогч, даатгуулагчаас ирүүлсэн илүү төлсөн шимтгэлээ дараагийн сар, улирал, жилийн төлбөл зохих шимтгэлд шилжүүлэн тооцох, буцаан авах, олгохтой холбоотой өргөдөл, гомдлыг хяналт шалгалт хариуцсан нэгж тухай бүр шийдвэрлэнэ.

6.2.Нийгмийн даатгалын ерөнхий газрын болон аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын хяналт шалгалт хариуцсан нэгж илүү төлсөн шимтгэлийн буцаан олголт болон энэ журмын хэрэгжилтэд хяналт тавина.

6.3.Илүү төлсөн шимтгэлийг ажил олгогч, даатгуулагчид буцаан олгосноос хойш ажил олгогчийн шимтгэл төлөлтийн тайланд залруулга хийгдэж, тухайн даатгуулагчид олгосон буцаан олголтын дүнд зөрүү үүсвэл зөрүү дүнг даатгуулагчаар холбогдох санд төлүүлэх, эсхүл даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас олгоно.

6.4.Шимтгэл илүү төлөөгүй ажил олгогч, даатгуулагчид шимтгэл буцаан олгосон бол эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр уг шимтгэлийг тухайн шимтгэл авсан этгээдээр холбогдох санд нөхөн төлүүлнэ.

6.5.Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон энэ журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024.01.30 № 1/413

танай 2024.01.04-ны № 01/30-т

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД Х.БУЛГАНТУЯА
ТАНАА

“Жагсаалт, журам батлах тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгаалын сайдын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/221 дүгээр тушаалыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн ...657... дугаарт бүртгэж хүргүүлэв.

Б.ЭНХБАЯР

151600363

Doc.yam.a5.2024

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2024 оны 01 сарын 30 ны өдрийн 657 дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 28 өдөр Дугаар А/221 Улаанбаатар хот

Жагсаалт, журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох "Газрын доор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт"-ыг нэгдүгээр, тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох "Газрын доор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтыг хэрэглэх журам"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Б.Батжаргал), хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Л.Мөнхзул)-т тус тус үүрэг болгосугай.

3.Газрын доор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд ажиллаж байгаа ажилтны ажил, мэргэжлийг энэ тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан жагсаалтад нийцүүлэн түүнийг ажилд томилсон, ажлаас чөлөөлсөн тушаал шийдвэрт тодорхой тусгаж байхыг ажил олгогч нарт зөвлөсүгэй.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан "Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтыг шинэчлэн батлах тухай" Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны А/77 дугаар тушаал, "Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Хөдөлмөр, нийгмийн хамгаалалын сайдын 2019 оны А/296 дугаар тушаал, "Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтад нэмэлт оруулах тухай" 2020 оны А/129 дүгээр тушаал, "Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 2022 оны А/185 дугаар тушаал, "Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтад нэмэлт оруулах тухай" 2022 оны А/186 дугаар тушаал, "Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 2023 оны А/01 дүгээр тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Х.БУЛГАНТУЯА

ТУЗ894 9132155 9119277787

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ТӨВ ХЭСЭГ ХҮЛЭЭН АВСАН

1512400005

D: 2024 on 01 saridushaal

Гарын үсэг

2024 оны 01 сарын 04 өдөр

Хөдөлмөр, нийгмийн хамгаллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/221 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ТЭТГЭВРИЙГ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ТОГТООХ ГАЗРЫН ДООР, ХӨДӨЛМӨРИЙН ХОРТОЙ, ХАЛУУН, ХҮНД НӨХЦӨЛД ХАМААРАХ АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН ЖАГСААЛТ

№	№	Хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоох ажил, мэргэжлийн жагсаалт	Код	Дүйцүүлэн хэрэглэх ажил, мэргэжлийн жагсаалт
Нэг.Газрын доор нөхцөл				
	1.1.Газар доорх уурхайн ажил, мэргэжил:			
1	1	Механикч, уул уурхайн машин, тоног төхөөрөмжийн	7233-17	Тоног төхөөрөмжийн машинч
2	2	Тэсэлгээчин	7542-11	Тэсэлгээчин
3	3	Уурхайчин	8111-24	Уулын ажилчин
4	4	Тэсрэх бодис зөөгч /Тээвэрлэгч/	7542-13	Тэсрэх материал зөөгч
5	5	Маркшейдер /далд уурхайн/	2146-21	Маркшейдерийн ажилчин
6	6	Сорьц авагч, металлургийн үйлдвэрийн	3117-15	Сорьц авагч /геологийн ба уулын үйлдвэрийн/
7	7	Дохиочин, холбогч, шилжүүлэгч	8312-12	Дохиочин
8	8	Насосчин, насосны засварчин	8111-29	Насосны машинч
9	9	Машинч, туслах машинч, уул уурхайн зам, зүтгүүрийн	8311-12	Цахилгаан тэрэгний машинч, түүний туслах
10	10	Цахилгаанчин	7411-11	Цахилгаанчин
11	11	Механикч, уул уурхайн машин, тоног төхөөрөмж	7233-17	Тоног төхөөрөмжийн слесарь
12	12	Цахилгааны механикч	7412-12	Цахилгааны слесарь /газрын дор ажилладаг цахилгаанчин/
13	13	Операторч, өрмийн машины	8113-16	Цооног өрөмдөгч
14	14	Огтлогч, хийн	7212-27	Гагнуурчин хийн огтлогч
15	15	Угсрагч, ган болон угсармал төмөр бетон бүтээцийн	7112-11	Угсрагч
16	16	Хий хэмжигч		Хий хэмжигч
17	17	Гүний бэхэлгээчин		Гүний бэхэлгээчин
18	18	Орлуулагч /уурхайн бэхэлгээний материал/		Орлуулагч /уурхайн бэхэлгээний материал/
19	19	Компрессорчин		Компрессорчин
20	20	Газрын дор эмнэлгийн байртай аваарын эмч		Газрын дор эмнэлгийн байртай аваарын эмч

ТУЗ3034
9132155
1119277787

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ ТӨАГУТУГ
ХУУЛБАЙГНОН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ХЭЛТЭСИЙН ГАЗРЫН ЭДЭТА
Гарын үсэг:
2024 он 01 сар 11 өдөр

	1.2.Газрын дор ажлын өдрийн туршид ажилладаг үндсэн ба бэлтгэл малталт, ашиглалт, агааржуулалт, тээвэр, засвар, монтаж-өрөмдлөг, чигжилт, уулын сэргээлтийн хэсгийн:			
21	1	Ажилтан, далд уурхайн	9311-11	Туслах ажилчин
22	2	Дарга, мастер /менежер/, алба, хэлтэс, тасаг, цех, эзлжийн /ил, далд уурхайн/	1322-11	Эзлжийн мастер
23	3			Гүний уурхайн цехийн дарга
24	4	Инженер, далд уурхайн	2146-12	Инженер
25	5	Засварчин, хөдөлгүүрийн	8111-31	Засварчин
26	6	Инженер, хөдөлмөрийн аюулгүй байдлын	2141-25	Хөдөлмөр хамгааллын инженер
27	7	Уурхайн механикч	8111-23	Хэсгийн механикч
28	8	Геологич, уул уурхайн /ашиглалтын/	2114-20	Геологич
29	9	Маркшейдр, далд уурхайн	2146-21	Маркшейдер
30	10	Технологич, олборлолтын	2146-23	Технологич
31	11	Хэсгийн техникийн удирдагч		Хэсгийн техникийн удирдагч
	1.3.Уул уурхайн аврах албаны ажил, мэргэжил:			
32	1	Аврагч	5411-11	Аврагч байлдагч
33	2			Аврагч жолооч
34	3	Инженер, хөдөлмөрийн аюулгүй байдлын	2141-25	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны инженер
35	4	Уурхайн механикч	8111-23	Механик инженер
36	5	Тасгийн дарга		Тасгийн дарга
37	6	Салаан дарга		Салаан дарга
38	7	Баг аппаратурын слесарь		Баг аппаратурын слесарь
39	8	Ерөнхий инженер		Ерөнхий инженер
	Хоёр. Хөдөлмөрийн хортой нөхцөл			
	2.1.Цацраг идэвхит бодис агуулсан хүдэр, ашигт малтмал зөөдөг илчит тэрэгний:			
40	1	Машинч, туслах машинч, уул уурхайн зам, зүтгүүрийн	8311-12	Жинхэнэ машинч, туслах машинч
41	2	Дохиочин, холбогч, шилжүүлэгч	8312-12	Холбогч
42	3	Галт тэрэгний найруулагч	8312-15	Найруулагч
43	4	Жолооч, зам талбай тэгшилж нягтруулах төхөөрөмжийн	8342-15	Зам засагч
44	5	Пүүлэгч		Пүүлэгч
	2.2.Вагон, машин механизм, нисэх онгоцны эд ангийг бензин, керосин, солярк, хүчил, шүлт зэрэг хортой уусмалд цэвэрлэж засдаг:			
45	1	Засварчин, хөдөлгүүрийн	8111-31	Засварчид
46	2	Тохируулагч, аккумляторын	7412-22	Аккумлятор цэнэглэгч

47	3	батарейны, цахилгаан сүлжээ ба цахилгааны тоног төхөөрөмжийн, цахилгаан машины, цахилгаан хуваарилалтын байгууламжийн		Аккумлятор цутгагч засварчин
48	4	Дарга, мастер /менежер/, алба, хэлтэс, тасаг, цех, эзлжийн/ ил, далд уурхайн/	1322-11	Цехийн дарга
49	5	Операторын, резин шахах машины	8141-12	Резин хуванцар шахагч
50	6	Технологич, резиний	2145-16	Технологич
51	7	Инженер, техник засварын	2141-17	Мастер
52	8	Металл бүтээгдэхүүн угсрагч	8219-11	Үе угсрах
53	9	Металл зүлгэгч, өнгөлөгч, багаж ирлэгч	7224-21	Металл өнгөлөгч
54	10	Инженер, химийн	2145-13	Инженер химич
55	11	Шүүлт угаагч-техникч		Шүүлт угаагч-техникч
56	12	Батерейн гагнуурчин		Батерейн гагнуурчин
	2.3.Авто засвар, үйлдвэрлэлийн резинэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн:			
57	1	Операторч, резин бүтээгдэхүүний машины	8141-14	Резинэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх суурь машинч
58	2			Техникч
59	3	Операторч, дугуйны хаймар үйлдвэрлэх, резин боловсруулах	8141-11	Резинэн дугуй нөхөх суурь машинч
60	4			Үе задлах, угсрах машины операторч
61	5	Дарга, мастер /менежер/, алба, хэлтэс, тасаг, цех, эзлжийн /үйлдвэрлэлийн ба үйл ажиллагааны менежер боловсруулах үйлдвэрлэлийн/	1321-13	Мастер
62	6			Бригадын дарга
63	7	Резинэн бүтээгдэхүүн угсрагч	8219-13	Үе угсрах баазын замчин
64	8	Резинэн цавуу бэлтгэгч		Резинэн цавуу бэлтгэгч
	2.4.Сумт ба гүүрэн краны:			
65	1	Операторч конвейрын гүүрэн краны, агуулахын, өргүүр сагстай өргөгчийн	8343-11	Кранчин
66	2			Кранчны туслагч
67	3	Оосорлогч	7215-11	Оосорлогч
	2.5.Модонд үл ялзруулах бэхжүүлэх:			
68	1	Дарга, мастер /менежер/, алба, хэлтэс, тасаг, цех, эзлжийн /үйлдвэрлэлийн ба үйл ажиллагааны менежер	1321-13	Мастер

		боловсруулах үйлдвэрлэлийн/		
69	2	Бодис түрхэгч		Бодис түрхэгч
	2.6.Сэргээн засварлах цехийн:			
70	1	Операторч, төмөрлөгийн үйлдвэрийн цехийн	8121-18	Операторчин
71	2	Инженер, техник засварын	2141-17	Мастер
	2.7.Дэр модонд химийн бодисоор нэвчрүүлэлт хийдэг үйлдвэрийн:			
72	1	Модонд идээлэгч бодис нэвчүүлэгч	7522-38	Мод нэвчүүлэн идээлэгч
73	2	Мод зөөгч, цагаалагч, оосорлогч, тайрагч	7521-17	Оосорлогч
74	3	Лаборант, химийн боловсруулалтын	3116-12	Лаборант
75	4	Технологич, модны	2141-37	Технологич
76	5	Механикч, модон эдлэлийн машин, тоног төхөөрөмжийн	7233-14	Механикч
77	6	Шалгагч, гал тэрэгний үйлчилгээний	4323-24	Соронзон орны үйлчлэлээр төмөр замын хос дугуйн далд гэмтлийг шалгагч
78	7	Засварчин, хөдөлгүүрийн	8111-31	Илчит тэрэгний түлш шүүрийн цехийн засварчин
79	8	Будагчин, галт тэрэгний	7131-19	Вагон будагч
80	9	Үе угсрах баазын мастер		Үе угсрах баазын мастер
	2.8.Цемент үйлдвэрлэлийн:			
81	1	Операторч, эргэх зуух, тээрмийн, хөргөх төхөөрөмжийн	8114-23	Зуухан дамжлагын үйлчлэгч (операторч)
82	2			Тээрмийн дамжлагын үйлчлэгч(операторч)
83	3	Насосчин, насосны засварчин	8111-29	Цемент шахах насосны машинч
84	4	Цемент савлагч, түүний туслах		Цемент савлагч, түүний туслах
85	5	Тоосны камер цэвэрлэгч		Тоосны камер цэвэрлэгч
86	6	Бутлуурын дамжлагын үйлчлэгч (операторч)		Бутлуурын дамжлагын үйлчлэгч (операторч)
87	7	Туузан дамжлагын үйлчлэгч (операторч)		Туузан дамжлагын үйлчлэгч (операторч)
	2.9.Карьерийн аж ахуйн:			
88	1	Операторч, өрмийн машины	8113-16	Уулын цехийн өрөмдөгч
89	2	Операторч, чулуу боловсруулах, бутлах, зүсэх, өрөмдөх, тээрэмдэх машины	8112-14	Бутлуурын машинч
90	3	Операторч, өрмийн машины	8111-11	Өрмийн машинч, түүний туслах
91	4	Туузан дамжлагын операторч		Туузан дамжлагын операторч
92	5	Шигшүүрийн машинч		Шигшүүрийн машинч
	2.10.Байшин үйлдвэрлэлийн:			
93	1	Бэлтгэгч, хэвний хольц	7211-16	Хольц бэлтгэгч

94	2			Түүхий эд бэлтгэлийн хуурай материал бэлтгэгч
95	3	Техникч, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн	3119-13	Тоног төхөөрөмжийн засварчин
96	4	Техникч, засварын	3115-21	Засварчин
97	5	Татагч		Татагч
98	6	Хийн зүсэгч		Хийн зүсэгч
	2.11.Барилгын бетон үйлдвэрлэлийн:			
99	1	Операторч, бетон үйлдвэрлэлийн машины	8114-21	Бункерын машинч
100	2	Эмульс, цавуу бэлтгэгч	7132-15	Химийн хольц бэлтгэгч
101	3	Асфальт бетончин, бетончин	7114-12	Асфальт бэлтгэгч
102	4	Дарга, мастер/менежер/, алба, хэлтэс, тасаг, цех, эзлжийн /үйлдвэрийн ба үйл ажиллагааны менежер/ боловсруулах үйлдвэрлэлийн	1321-13	Зуурмагийн цехийн мастер
103	5			Зуурмагийн цехийн дарга
104	6	Операторч конвейрын гүүрэн краны, агуулахын, өргүүр сагстай өргөгчийн	8343-11	Конвейерын машинч
105	7	Тос найруулагч		Тос найруулагч
	2.12.Зоос, гоёлын зүйлийн үйлдвэрлэлийн:			
106	1	Пааландагч, металл эдлэлийн	7316-22	Металл хучигч, тэмдэг (одон медаль) гоёлын зүйлийг пааландагч
107	2	Дархан, үнэт эдлэлийн	7313-15	Үнэт чулуун эдлэл хийгч
108	3	Сийлбэрчин, эрдэнийн зүйлийн	7313-29	Ган сийлбэрчин
109	4	Механик ба химийн аргаар металл өнгөлөгч		Механик ба химийн аргаар металл өнгөлөгч
	2.13.Арьс шир, үслэг эдлэлийн үйлдвэрлэлийн:			
110	1	Дарга, мастер/менежер/, алба, хэлтэс, тасаг, цех, эзлжийн /үйлдвэрийн менежер/ боловсруулах үйлдвэрлэлийн	1321-13	Химийн боловсруулалтын цехийн мастер
111	2	Арьс ширэн түүхий эд дэвтээгч	7535-37	Арьс дэвтээгч
112	3	Уусмал түрхэгч	7535-38	Намаз түрхэгч
113	4			Үслэг арьсыг органик уусмалаар угаагч
114	5			Уусмал түрхэгч
115	6	Самнагч, нэхийний үс	7535-25	Үс авагч
116	7			Самнагч
117	8	Хуваагч,шир	7535-31	Арьс тайрагч
118	9	Арьс шир, үс, түүхий эд ариутгагч	7535-11	Бүх төрлийн уусмалаар арьс угаагч
119	10	Шахах машинч,арьс шир	7535-41	Арьс шахагч
120	11	Сунгагч, арьс,савхи	7535-27	Арьс сунгагч

121	12	Арьс, шир, нэхий идээлэгч, элдэгч	7535-13	Арьс идээлэгч, элдэгч
122	13	Будагч, арьс шир, нэхий, савхи	7535-15	Арьс будагч
123	14			Өнгө, будагч
124	15	Операторч конвейрын гүүрэн краны, агуулахын, өргүүр сагстай өргөгчийн	8343-11	Гүүрэн кранч
125	16	Химичин-цэвэрлэгээчин	0310-38	Хими цэвэрлэгээний машинч
126	17	Лак, будаг найруулагч	7522-36	Будаг найруулагч
127	18	Химич, арьс ширний	2113-14	Хүхэрт натри хайлагч
128	19	Индүүдэгч машинч, арьс шир	7535-44	Индүү машин баригч
129	20	Бэлтгэгч, химийн будаг	7535-16	Химийн материал бэлтгэгч
130	21	Ачигч, агуулахын	9333-15	Ачиж буулгагч
131	22	Арьс шир давслагч	7535-17	Нойтон арьс давслагч
132	23	Нярав, материал нийлүүлэлтийн	4322-12	Химийн материалын нярав
133	24	Туршилтын эх хянагч	4413-15	Туршилтын цехийн туршигч
134	25	Шүршигч буу, төхөөрөмжөөр будагч	7535-42	Эмульс лак шүршигч
135	26	Шүршиж будах машины операторч	7535-48	Шүрших машины операторчин
136	27	Захлагч, годлогч	7535-39	Арьс годлогч
137	28	Арьс хусагч		Арьс хусагч
138	29	Бункерийн цэвэрлэгч		Бункерийн цэвэрлэгч
139	30	Шуудуу цэвэрлэгч		Шуудуу цэвэрлэгч
140	31	Химийн уусмал найруулагч		Химийн уусмал найруулагч
	2.14.Гутлын үйлдвэрлэлийн:			
141	1	Наагч,эд ангиуд	7536-35	Ул наагч
142	2	Лак, будаг найруулагч	7522-36	Гутлын будаг найруулагч
143	3	Цавуудагч, эд анги эдэлхүүний	7536-48	Хлорпрен, полуратан суурьтай болон резинэн цавуугаар цавуудагч
144	4	Бэлтгэгч, гутлын эд анги	7536-17	Түүхий эд бэлтгэгч
145	5	Зүлгэж өнгөлөгч	7536-32	Үрэлжүүлэгч
146	6	Савлагч,/гараар/	9321-12	Савлагч
147	7	Шүршигч буу, төхөөрөмжөөр будагч	7535-42	Өнгө будаг шүршигч
148	8	Дарга, мастер /менежер/, алба, хэлтэс, тасаг, цех, эзлжийн /үйлдвэрийн ба үйл ажиллагааны менежер/	1321-13	Мастер
149	9	Лаборант, химийн боловсруулалтын	3116-12	Лаборант
150	10	Захлагч, ул, өсгий	7536-31	Хэрчигч
151	11	Компрессорчин		Компрессорчин
	2.15. Цахилгаан химийн цаасаар цаг агаарын мэдээлэл авч боловсруулалт хийдэг:			
152	1	Инженер, синоптикийн	2112-17	Синоптик инженер


153	2	Инженер, радарын	2112-14	Хиймэл дагуулын станцын инженер
154	3	Операторч, фото зураг буулгах,хальс үйлдвэрлэх угаах	8132-11	Операторч
	2.16.Мөнгөн устай багаж шулуутгагч, ил задгай мөнгөн устай хэмжүүрийг засах, цэнэглэх ажил дээр ажлын өдөр туршид ажилладаг:			
155	1	Инженер, химийн	2145-13	Инженер
156	2	Техникч, хэмжүүрийн	3114-29	Техникч
157	3	Дарга, мастер /менежер/, алба, хэлтэс, тасаг, цех, ээлжийн /үйлдвэрийн ба үйл ажиллагааны менежер/	1321-13	Мастер
158	4	Слесарь		Слесарь
159	5	Плояриграфчик		Плояриграфчик
	2.17.Малын боом, бруцеллёз, галзуу, сүрьеэ, ям зэрэг өвчний вакцин, вирус, ийлдэс, гаммоглобулин, антибиотик, оношзүй, утил бэлтгэн савлах, хатаах, омог хайрцаглах, вивар, химийн цехийн:			
160	1	Малын эмч, биохимийн	2250-24	Их эмч
161	2	Биотехнологич	2131-43	Технологич
162	3	Химич	2113-13	Химич
163	4	Микробиологич	2131-21	Микробиологич
164	5	Лаборант, хими, бактериологийн	3116-11	Лаборант
165	6	Ферментч	2250-26	Ферментч
166	7	Ариутгагч	3259-04	Био бэлдмэлийн ариутгагч
167	8	Техникч, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн	3119-13	Хөлдөөх төхөөрөмжийн техникч
168	9	Сантехникч, салхивчны хоолойн	7126-15	Хорт хий зайлуулах төхөөрөмжийн жижүүр
169	10	Сантехникч, хоолой засварчин	7126-12	Сантехникийн слесарьч
170	11			Бохирын слесарьч
171	12	Гагнуурчин	7212-14	Гагнуурчин
172	13	Хатаах төхөөрөмжийн техникч		Хатаах төхөөрөмжийн техникч
173	14	Бага эмч		Бага эмч
174	15	Аппаратчин		Аппаратчин
175	16	Бэлдмэл савлагч		Бэлдмэл савлагч
176	17	Машинч		Машинч
177	18	Бутлагч		Бутлагч
178	19	Хатаах машинч		Хатаах машинч
179	20	Жигдрүүлэгч		Жигдрүүлэгч
180	21	Компрессорчин		Компрессорчин
181	22	Засварын слесарьч		Засварын слесарьч
	2.18.Малын эм бэлдмэл шалгах лабораторийн:			
182	1	Малын эмч	2250-11	Малын их эмч
183	2	Ариутгагч	3259-04	Ариутгагч
184	3	Лаборант, хими бактериологийн	3116-11	Лаборант
185	4	Химич	2113-13	Химич

186	5	Бага эмч		Бага эмч
187	6	Биобэлдмэлчин		Биобэлдмэлчин
	2.19. Нефть боловсруулах үйлдвэрийн:			
188	1	Техникч, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн	3119-13	КИПА засварчин
189	2			Тоног төхөөрөмжийн засварчин
190	3	Лаборант, хими бактериологийн	3116-11	Лаборант /боловсруулах үйлдвэрийн/
191	4	Гагнуурчин	7212-14	Гагнуурчин
192	5	Сантехникч, хоолой засварчин	7126-12	Сантехникийн засварчин
193	6	Гагнуурчин, цахилгаан-хийн	7212-19	Цистерн, банк, резервуар, худаг дотор цахилгаан хийн гагнуур хийдэг гагнуурчин
194	7	Сантехникч, хоолой засварчин	7126-12	Шугам хоолойн засварчин
195	8	Операторчин, нефть боловсруулах, цэвэрлэх төхөөргийн	8131-13	Нефть хангамжийн операторчин
196	9	Жолооч, цистерний	8332-16	Цэнэглэх машины жолооч
197	10	Операторч, нэрэх төхөөрөмжийн	3134-12	Бензин, нефть зэрэг хортой шингэний резервуарын дотрыг уураар утан цэвэрлэх, засварлах ажил хийдэг резервуар цэвэрлэгч
198	11	Шалгагч, төмөр замын үйлчилгээний /ачааны/	4323-25	Ачаа шалгагч
981	27	Лаборант хими, бактерологийн	3141-11	Лаборант
982	28	Дарга, мастер /менежер/, алба, хэлтэс, тасаг, цех, эзлжийн /үйлдвэрлэлийн ба үйл ажиллагааны менежер боловсруулах үйлдвэрлэлийн/	1321-13	Хэвлэх хэсгийн мастер
983	29			Шороон хэсгийн мастер
984	30	Аккумлятор цэнэглэгч		Аккумлятор цэнэглэгч
	4.13.Азот, хүчилтөрөгчийн станцын:			
985	1	Зуухны операторч, ган боловсруулах /хүчилтөрөгчийн зуухны/	8121-13	Машинч
986	2	Техникч, хийн хоолойн тоног төхөөрөмжийн	3115-30	Тоног төхөөрөмжийн засварчин
987	3	Сантехникч, хоолой угсрагч	7126-11	Слесарь /тоног төхөөрөмжийн/
988	4	Операторч, нефть, байгалийн хий, химийн бүтээгдэхүүний машин, тоног төхөөрөмжийн	8131-14	Тээх ажиллах төхөөрөмжийн машинч
989	5	Дарга, мастер /менежер/, алба, хэлтэс, тасаг, цех, эзлжийн /боловсруулах үйлдвэрлэлийн менежер/	1321-12	Мастер /тээх ажилллах төхөөрөмжийн/
990	6	Генераторчин		Генераторчин
991	7	Компрессорчин		Компрессорчин
992	8	Цэнэглэгч		Цэнэглэгч
993	9	Аппаратчин		Аппаратчин
	4.14.Гурил, тэжээл үйлдвэрлэлийн:			
994	1	Тээрэмдэх машины гол ирлэгч		Тээрэмдэх машины гол ирлэгч
	4.15.Хөдөө аж ахуйн:			
995	1	Малын эмч	2250-11	Малын их эмч
996	2	Жолооч, мод зөөгч, чирэгч, комбайн, трактерын	8341-17	Тракторчин, комбайнч
	4.16.Бохир усны төвлөрсөн цэвэрлэх байгууламжийн:			

997	1	Операторч/ Машинч, шингэн хог хаягдал боловсруулах, ус цэвэрлэх байгууламжийн, төхөөрөмжийн	3132-14	Биошүүлтүүр, заротанк, насос, шүүх талбайн оператор
998	2			Лаг ачиж түрэх механизмын оператор
999	3			КУ-гийн машинч
1000	4	Сантехникч- ариутгах татуургын	7126-16	Узель,бойлерын засварчин /слесарь/
1001	5	Сантехникч- ариутгах татуургын	7126-16	Засварчин /слесарь/
1002	6	Жолооч, ариутгах татуургын машины	8332-20	Лаг зөөврийн машины жолооч
1003	7	Инженер, цэвэрлэх байгууламжийн технологич	2142-44	Механик, технологийн инженер
1004	8	Операторч/Машинч, бохир усны насос станцын	3132-13	Машинт заалны машинч
1005	9	Автомашины хөдөлгүүрийн засварчин, моторчин	7231-19	Автын засварчин
1006	10	Инженер, ус хангамж, ариутгах татуургын	2142-32	Автоматик, хянах, хэмжих хэрэгслийн инженер
1007	11	Техникч ус хангамж, ариутгах татуургын	3112-13	Техникч
1008	12	Инженер, цахилгааны	2151-11	Цахилгааны инженер
1009	13	Цахилгаанчин	7411-11	Цахилгаанчин, монтёр
1010	14	Гараар угаагч, индүүдэгч, хатаагч	9121-17	Хувцас угаагч
1011	15	Машинч засварчин		Машинч засварчин
	4.17.Зоос гоёлын зүйлийн үйлдвэрлэлийн:			
1012	1	Загварчин, эрдэний зүйлийн	7313-20	Резин ба воскон хэвчин
1013	2	Гинж, хэлхэгч, үнэт металлын	7313-13	Гинж нэхэгч
1014	3	Дархан, үнэт эдлэлийн	7313-15	Алт мөнгөн эдлэлийн дархан
	4.18.Ноос, ноолуур, хивсний боловсруулах үйлдвэрлэлийн:			
1015	1	Арьс, нэхий, үс, үслэг эдлэлийн зэрэглэл тогтоогч, ангилагч /ялгагч/	7535-12	Ялгагч, зөөгч
1016	2	Операторч, сэмлэх, сэгсрэх машины	8152-21	Сэгсрэх машин баригч
1017	3	Операторч, арьснаас үс цэвэрлэх машины	8155-15	Хялгас ялгах цехийн машин баригч
1018	4	Операторч, угаах машины	8154-19	Угаах машин баригч
1019	5	Бэлтгэгч, химийн будаг	7535-16	Будаг найруулагч
1020	6	Операторч, хатаах машины	8154-22	Хатаах машинч
1021	7	Техникч, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн	3119-13	Тоног төхөөрөмжийн засварчин
1022	8	Операторч, ферезерийн суурь машины /ферезерчин/	7223-22	Фрезерчин

1023	9	Гагнуурчин, цахилгаан ба хийн	7212-19	Цахилгаан ба хийн гагнуурчин
1024	10	Сантехникч, хоолой засварчин	7126-12	Сантехникийн засварчин
1025	11	Инженер, химийн	2145-13	Хими цехийн инженер
1026	12	Будагч, арьс шир, нэхий, нэхийний үс, савхины	7535-15	Будагчин
1027	13	Будаг хэмжигч		Будаг хэмжигч
1028	14	Токарьчин		Токарьчин
1029	15	Лаборант		Лаборант
1030	16	Цардагч		Цардагч
1031	17	Мотор ороогч.		Мотор ороогч
1032	18	Баглах машинч		Баглах машинч
1033	19	Нүүрсжүүлэх машинч		Нүүрсжүүлэх машинч
	4.19.Арьс шир, үслэг эдлэлийн:			
1034	1	Арьс шир, үс, түүхий эд ариутгагч	7535-11	Арьс хүлээн авч чанарын хамгаалалт хийгч, оруулагч
1035	2	Чийглэх машины операторч	7535-46	Арьс чийглэгч
1036	3	Арьс, шир, нэхий идээлэгч, элдэгч	7535-13	Зүлгэгч
1037	4			Талхигч
1038	5			Зөөлрүүлэгч
1039	6			Тэнийлгэгч
1040	7	Сунгагч, арьс, савхи	7535-27	Сунгагч
1041	8	Үс авагч, үс захлагч, халимлагч	7535-30	Захлагч
1042	9	Хэмжигч, арьс ширний талбай	7535-32	Арьс хэмжигч
1043	10	Баглагч, боогч	7535-43	Баглаа боодлын ажилчин
1044	11	Техникч, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн	3119-13	Тоног төхөөрөмжийн засварчин
1045	12	Цахилгаанчин	7411-11	Цахилгаанчин
1046	13	Гагнуурчин, цахилгаан-хийн	7212-19	Цахилгаан ба хийн гагнуурчин
1047	14	Сантехникч, хоолой засварчин	7126-12	Сантехникийн слесарь
1048	15	Тусгаарлагч ажилчин, бойлер ба хоолойн	7124-14	Бойлерын жижүүр
1049	16	Зуухны машинч		Зуухны машинч
	4.20.Эсгий, эсгий гутал үйлдвэрлэлийн:			
1050	1	Операторч, сэмлэх, сэгсрэх машины	8152-21	Самнах, сэмлэх машин баригч
1051	2			Хаягдал цэвэрлэх, сэгсрэх машин баригч
1052	3			Ноос цэвэрлэх, холих, баглаа задлах машинч
1053	4	Техникч, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн	3119-13	Засварчин
1054	5	Давтаж хэвшрүүлэгч	7536-25	Эсгий гутал чангаруулагч
1055	6	Улалгаачин	7536-44	Резинээр гутал уллагч
1056	7	Хүчлийн машинч		Хүчлийн машинч
1057	8	Резин холио бэлтгэгч		Резин холио бэлтгэгч

1058	9	Даахь урах машин баригч		Даахь урах машин баригч
1059	10	Эсгий гутал хатаагч		Эсгий гутал хатаагч
	4.21.Гутлын үйлдвэрлэлийн:			
1060	1	Дарга, мастер /менежер/, алба, хэлтэс, тасаг, цех, ээлжийн /үйлдвэрлэлийн ба үйл ажиллагааны менежер боловсруулах үйлдвэрлэлийн/	1321-13	Мастер
1061	2	Компрессорчин		Компрессорчин
	4.22.Чулуу үйлдвэрлэлийн:			
1062	1	Хөрөөчин, чулууны	7113-27	Чулуу хөрөөдөгч
1063	2	Бутлагч-үйрүүлэгч	7113-15	Хагалагч
1064	3	Өнгөлөгч, боржин Өнгөлөгч, гантиг	7113-20 7113-21	Өнгөлөгч
1065	4	Бутлагч, чулуу	7113-14	Бутлагч
1066	5	Засагч, чулуу	7113-16	Гараар засагч
	4.23.Зам гүүрийн барилга, засвар, арчлалтын:			
1067	1	Асфальт, бетончин, бетончин	7114-12	Асфальт-бетончин: тос чанагч, форсункчин, галарейчин
1068	2	Арматурчин	7114-11	Арматурчин
1069	3	Операторч, токарийн суурь машины /токарьчин/	7223-20	Токарьчин
1070	4	Операторч, ферезерийн суурь машины /ферезерчин/	7223-22	Фрезерчин
1071	5	Гагнуурчин	7212-14	Гагнуурчин
		Технологийн зориулалттай машин механизмын жолооч:		
1072	6	Машинч, эксковарторын /цахилгаан, гидро/	8342-18	Экскаваторчин
1073	7	Жолооч, зам индүүдэх машины	8342-14	Индүүчин
1074	8	Операторч, бульдозерийн	8342-13	Бульдозерчин
1075	9	Газар шороо, зам засварын болон түүнтэй адилтгах машины операторч	8342-11	Ачигчийн жолооч
1076	10	Операторч, асфальт дэвсэх төхөөрөмжийн	8342-20	Асфальт дэвсэгчийн жолооч
1077	11	Операторч, автогрейдерийн	8342-26	Автогрейдерчин
1078	12	Техникч, засварын	3115-21	Засварчин
1079	13	Компрессорчин		Компрессорчин
1080	14	Битум зөөгч		Битум зөөгч
1081	15	Битум цацагч		Битум цацагч
1082	16	Скейлерчин		Скейлерчин
1083	17	Чулуу бутлуурчин		Чулуу бутлуурчин
	4.24.Химийн урвалж, реактивийн төвлөрсөн агуулахын:			

1084	1	Нярав, агуулахын	4321-12	Нярав
1085	2	Ачигч, агуулахын	9333-15	Ачигч-буулгагч
1086	3	Насосчин, насосны засварчин	8111-29	Насосны станцын машинч
1087	4	Сантехникч, ариутгах татуургын	7126-16	Засварчин
1088	5	Гагнуурчин	7212-14	Гагнуурчин
1089	6	Цахилгаанчин	7411-11	Цахилгаанчин
	4.25.Байгалийн голомтот халдварт өвчнийг эсэргүүцэн судлах төвийн:			
1090	1	Жолооч, түргэн тусламжийн тэрэгний	8322-16	Ажлын түргэн тусламжийн жолооч
1091	2	Жолооч, бүхээгт машины	8322-14	Хээрийн шинжилгээний жолооч
1092	3			Авто лабораторийн жолооч
1093	4	Механикч инженер, автомашины	2144-30	Автын механикч
1094	5	Сувилагч, халдварт өвчний сувилахуйн	2221-15	Сувилагч
1095	6	Техникч, багаж хэрэгслийн	3115-17	Тоног төхөөрөмжийн засварчин
1096	7	Цахилгаанчин	7411-11	Цахилгаанчин
1097	8	Малын эмч, ерөнхий мэргэжлийн	2250-21	Ерөнхий эмч
1098	9	Амьтан маллагч		Амьтан маллагч
1099	10	Халдвартын механик		Халдвартын механик
1100	11	Тарваган тахлын голомт хяналтын бага эмч		Тарваган тахлын голомт хяналтын бага эмч
1101	12	Тасгийн эрхлэгч		Тасгийн эрхлэгч
1102	13	Ганан бэлтгэгч		Ганан бэлтгэгч
1103	14	Халдвар судлалын их эмч		Халдвар судлалын их эмч
1104	15	Тусгаарлах байрны тарилгын сувилагч		Тусгаарлах байрны тарилгын сувилагч
	4.26.Биохими, бактериологи, иммунологи, гистологи, мөөгөнцөр, нян, вирус, шимэгч, ийлдэс, халдвар, шавьж судлал, эсийн өсгөвөр, хор, хөгц, ургамлын хими, эм судлал, эмийн хими, технологи, клиник лаборатори, эмгэг, анатомийн лабораторийн:			
1105	1	Хүний их эмч, лабораторийн	2212-32	Хүний их эмч
1106	2	Мал, амьтаны эмгэг зүйч	2250-12	Малын их эмч
1107	3	Хүний бага эмч	2212-116	Хүний бага эмч
1108	4	Химич	2113-13	Химич
1109	5	Биохимич	2113-12	Биохимич
1110	6	Бактериологич, вирусологич	2131-51	Бактерлогич
1111	7	Гистологич, цитологич, эмбриологич	2131-16	Гистологич
1112	8	Иммунологич	2131-17	Иммунологич
1113	9	Паразитологич	2131-30	Шимэгч судлагч
1114	10	Гидробиологич	2131-15	Гидробиологич
1115	11	Микробиологич, биофизикч	2131-52	Микробиологич

1116	12	Лаборант, хими бактериологийн	3116-11	Лаборант
1117	13	Ариутгагч	3259-04	Шил сав угаагч
1118	14			Ариутгагч
1119	15	Эрдэм шинжилгээний жинхэнэ ажилтан,		Эрдэм шинжилгээний жинхэнэ ажилтан
1120	16	Эрдэм шинжилгээний туслах ажилтан,		Эрдэм шинжилгээний туслах ажилтан
1121	17	Амьтан маллагч		Амьтан маллагч
1122	18	Автоклавчин		Автоклавчин
1123	19	Халдвар судлагч		Халдвар судлагч
1124	20	Биобэлдмэлчин		Биобэлдмэлчин
1125	21	Гинелогич (малын)		Гинелогич (малын)
	4.27.Тархи, мэдрэл, зүрх, хэвлийн хөндий, ясны мэс заслыг байнга хийдэг:			
1126	1	Хүний их эмч, гар сарвууны нөхөн сэргээх бичил мэс засал судлалын	2212-10	Их эмч
1127	2	Хүний их эмч, доод мөчний нөхөн сэргээх бичил мэс засал судлалын	2212-11	
1128	3	Хүний их эмч, нурууны мэс засал судлалын	2212-12	
1129	4	Хүний их эмч, үе бүтээх, солих мэс засал судлалын	2212-14	
1130	5	Хүний их эмч, хавсарсан гэмтлийн мэс засал судлалын	2212-15	
1131	6	Хүний их эмч, мэс засал судлалын	2212-47	
1132	7	Хүний их эмч, бөөрний мэс засал судлалын	2212-48	
1133	8	Хүний их эмч, бүдүүн, шулуун гэдэсний мэс засал судлалын	2212-49	
1134	9	Хүний их эмч, дотоод шүүрлийн мэс засал судлалын	2212-51	
1135	10	Хүний их эмч, зүрх судасны мэс засал судлалын	2212-52	
1136	11	Хүний их эмч, мэдрэлийн мэс засал судлалын	2212-53	
1137	12	Хүний их эмч/Шүдний их эмч,толгой хүзүүний мэс засал судлалын	2212-54	
1138	13	Хүний их эмч, хүүхдийн мэс засал судлалын	2212-55	
1139	14	Хүний их эмч, хэвлийн мэс засал судлалын	2212-56	
1140	15	Хүний их эмч, цээжний мэс засал судлалын	2212-57	

1141	16	Хүний их эмч, эрэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд, мэс засал судлалын	2212-58	
1142	17	Хүний их эмч, эмэгтэйчүүдийн аарцгийн хөндий судлал, нөхөн сэргээх мэс заслын судлалын	2212-104	
1143	18	Хүний бага эмч	2212-116	Бага эмч
1144	19	Сувилагч, мэс заслын сувилахуйн	2221-08	Сувилагч
1145	20	Асрагч, эмнэлгийн	5329-13	Асрагч
		Нойрсуулагч ба сэхээн амьдруулахын:		
1146	21	Хүний их эмч, мэдээгүйжүүлэг судлалын	2212-45	Их эмч
1147	22	Хүний их эмч, эрчимт эмчилгээ судлалын	2212-101	
1148	23	Хүний бага эмч	2212-116	Бага эмч
1149	24	Сувилагч, мэдээгүйжүүлгийн сувилахуйн	2221-07	Сувилагч
1150	25	Сувилагч, эрчимт эмчилгээний сувилахуйн	2221-20	
		Патоанатомийн задлан шинжилгээний:		
1151	26	Их эмч		Их эмч
1152	27	Бага эмч		Бага эмч
1153	28	Сувилагч		Сувилагч
1154	29	Асрагч		Асрагч
		Цус бэлтгэх үйлдвэрлэлийн		
1155	30	Хүний их эмч, цус сэлбэлт судлалын	2212-100	Их эмч
1156	31	Бага эмч		Бага эмч
1157	32	Сувилагч		Сувилагч
1158	33	Асрагч		Асрагч
1159	34	Цогцос ажиллагч		Цогцос ажиллагч
		4.28.Хурц, архаг халдварт өвчин болон сэтгэцийн эмгэгтэй өвчтөнийг эмчлэн сувилах ажлыг байнга гардан гүйцэтгэдэг:		
1160	1	Хүний их эмч, сэтгэц судлалын	2212-21	Их эмч
1161	2	Хүний их эмч, халдварт өвчин судлалын	2212-76	
1162	3	Хүний их эмч, бэлгийн замаар дамжих халдвар, хүний дархлал хомсдлын вирус/дархлалын олдмол хомсдол судлалын	2212-77	
1163	4	Хүний их эмч, хүүхдийн халдварт өвчин судлалын	2212-79	


1164	5	Хүний бага эмч	2212-116	Бага эмч
1165	6	Сувилагч, сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн	2221-14	Сувилагч
1166	7	Сувилагч, халдварт өвчний сувилахуйн	2221-15	
1167	8	Асрагч, эмнэлгийн	5329-13	Асрагч
1168	9	Ариутгагч	3259-04	Ариутгагч
1169	10	Эмнэлгийн туслах /дэд ажилтан	3256-11	Цагаан хэрэглэл угаагч
1170	11	Сантехникч, хоолой засварчин	7126-12	Бохирын слесарь
1171	12	Рашаан сувиллын шавар тавигч		Рашаан сувиллын шавар тавигч
1172	13	Шавар бэлтгэгч		Шавар бэлтгэгч
1173	14	Зөвлөх эмч		Зөвлөх эмч
	4.29.Өдөр бүр тогтмол химийн материалаар гардан ажиллаж ус, хөрс, агаар, ургамал, амьтны гаралтай бүтээгдэхүүн, хүнсний бүтээгдэхүүн, химийн ба барилгын материал, эрдэс бордоо, эм, нүүрс, занар, нефть бүтээгдэхүүнтэй харьцдаг:			
1174	1	Геологич, микропалентологийн	2114-19	Палентилогийн шинжээч
1175	2	Геохимич	2114-33	Геохимийн шинжээч
1176	3	Химич	2113-13	Химич
1177	4	Биохимич	2113-12	Биохимич
1178	5	Эм найруулагч	3213-01	Эм найруулагч
1179	6	Инженер, химийн	2145-13	Инженер
1180	7	Шинжээч төмөрлөгийн хүдрийн	2146-30	Металлургич
1181	8	Биотехнологич	2131-43	Технологич
1182	9	Эрдэс судлаач	2114-32	Минералогич
1183	10	Чанарын хяналтын лабораторын шинжээч	2131-57	Шинжээч
1184	11	Лаборант, хими бактериологийн	3116-11	Лаборант
1185	12	Техникч химийн	3111-26	Техникч
1186	13	Ариутгагч	3259-04	Ариутгагч
1187	14	Гараар аяга таваг угаагч		Шил сав угаагч
1188	15	Криминалистикийн шинжээч		Криминалистикийн шинжээч
1189	16	Үнэт металлд сорьц тавигч		Үнэт металлд сорьц тавигч
		Хортон шавьжид шинжилгээ хийдэг эрдэм шинжилгээний:		
1190	17	Тэргүүлэх ажилтан		Тэргүүлэх ажилтан
1191	18	Ахлах ажилтан		Ахлах ажилтан
1192	19	Жинхэнэ ажилтан,		Жинхэнэ ажилтан,
1193	20	Туслах ажилтан		Туслах ажилтан
1194	21	Бэлдмэлчин		Бэлдмэлчин
1195	22	Металл судлагч		Металл судлагч
1196	23	Энтомологич		Энтомологич
1197	24	Физиологич		Физиологич

	4.30.Хүдрийн бус ашигт малтмал, баяжуулалт, палентологийн:			
1198	1	Инженер, спекторийн	2146-32	Инженер
1199	2	Чулуу зүсэгч	7113-12	Чулуу зүсэгч
1200	3	Лаборант	3521-26	Гүйцэтгэгч болон техник лаборант
1201	4			Лаборант
1202	5	Үлээгч, шилний	7315-21	Шил үлээлгийн мастер
1203	6	Судалгаа-шинжилгээний фото зурагч	3431-13	Фото зургийн мастер,
1204	7	Инженер, цахилгаан автоматикийн	2141-26	Агааржуулалт, электроник, автоматикийн инженер
1205	8	Сантехникч, хянах хэмжүүр, автоматикийн	7126-21	Агааржуулалт, электроник, автоматикийн слесарь
1206	9	Засварчин, багажны /шинжилгээ судалгааны/	7311-21	Тоног төхөөрөмжийн засварчин
1207	10	Шинжилгээний гүйцэтгэгч		Шинжилгээний гүйцэтгэгч
1208	11	Дархан		Дархан
1209	12	Аргачлал, стандарт, хяналтын лаборант		Аргачлал, стандарт, хяналтын лаборант
	4.31.Нийслэлийн нийтийн тээврийн том оврын зорчигч тээврийн:			
1210	1	Жолооч, автобусны	8331-11	Автобусны жолооч
1211	2	Жолооч, троллейбусны	8331-13	Цахилгаан тээврийн хэрэгслийн жолооч
1212	3	Дугуй засварчин	8141-16	Дугуй нөхөгч
1213	4	Гагнуурчин, цахилгаан-хийн	7212-19	Цахилгаан, хийн гагнуурчин
1214	5	Гагнуурчин, цахилгаан-хийн	7212-20	Цахилгаан ба хийн гагнуурчин
1215	6	Гагнуурчин, тугалгаар /хүйтэн/ гагнах	7212-17	Тугалган гагнуурчин
1216	7			Хүйтэн гагнуурчин
1217	8	Нимгэн төмөрчин, автомашин ба өөрөө явагч бусад хэрэгслийн	7213-11	Нимгэн төмөрчин
1218	9	Цахилгаанчин	7411-11	Цахилгаанчин
1219	10	Автомашины хөдөлгүүрийн засварчин, моторчин	7231-19	Мотор ороогч
1220	11	Техникч, дотоод шаталтат хөдөлгүүрийн	3115-20	Хортой шингэн ба нефть бүтээгдэхүүнээр машины эд ангийг угааж засдаг агрегатийн засварчин
1221	12	Тээврийн хэрэгсэл будагч	7132-17	Будагчин
1222	13	Техникч, засварын	3115-21	Урсгал засварын засварчид
1223	14	Операторч, токарийн суурь машины /токарьчин/	7223-20	Засвар үйлдвэрлэлийн токарьчин
1224	15	Операторч, ферезерийн суурь машины /ферезерчин/	7223-22	Фрезерчин
1225	16	Тохируулагч, аккумляторын батарейны, цахилгаан	7412-22	Аккумляторчин


		сүлжээ ба цахилгааны тоног төхөөрөмжийн, цахилгаан машины, цахилгаан хуваарилалтын байгууламжийн		
1226	17	Өнгөлгөөчин		Өнгөлгөөчин
1227	18	Кузов засварчин		Кузов засварчин
	4.32.Эм биобэлдмэлийн үйлдвэрлэлийн:			
1228	1	Боогч /гараар/	9321-13	Эм боогч
1229	2	Савлагч /гараар/	9321-12	Савлагч
1230	3	Эм найруулагч	3213-01	Эм найруулагч
1231	4	Эм зүйч, эмийн технологи судлалын /эмийн үйлдвэр/ цацраг идэвхит амийн бодисын үйлдвэрлэлийн	2262-03	Технологич
1232	5	Чанарын хяналтын лабораторийн шинжээч	2131-57	Шинжээч,
1233	6	Хүний их эмч, эмнэл зүйн эм судлалын	2212-31	Хүний эмч
1234	7	Малын эмч биохимийн	2250-24	Малын эмч
1235	8	Биохимич	2113-12	Биохимич
1236	9	Эм зүйч	2262-08	Эм зүйч
1237	10	Химич	2113-13	Химич
1238	11	Биологич	2131-13	Биологич
1239	12	Лаборант, хими, бактериологийн	3116-11	Лаборант
1240	13	Лабораторийн техникч /лаборант/	3212-01	Техникч
1241	14	Шил угаагч		Шил угаагч
1242	15	Амьтан маллагч		Амьтан маллагч
1243	16	Аппаратчин		Аппаратчин
1244	17	Ургамал нунтаглагч		Ургамал нунтаглагч
1245	18	Гарнульчин		Гарнульчин
1246	19	Амбегийн машинч		Амбегийн машинч
1247	20	Пропон-компрессорчин,		Пропон-компрессорчин
1248	21	Вакцин ийлдэс, тэжээлт орчин бэлтгэгч		Вакцин ийлдэс, тэжээлт орчин бэлтгэгч
	4.33.Цэргийн зориулалттай танк, хуяг, их буу, хүнд механизмын:			
1249	1	Хуягт танкийн техникийн цахилгаанчин-засварчин	0210-41	Засварчин
1250	2	Лакдагч	7132-18	Лак будагчин
1251	3	Машины операторч, ороогч	8212-16	Цахилгаан хөдөлгүүр ороогч
1252	4	Техникч, засварын	3115-21	Шатахуун тоноглолын засварчин
1253	5	Гагнуурчин, цахилгаан-хийн	7212-19	Цахилгаан ба хийн гагнуурчин
1254	6	Өнгөлөгч, металл	7224-21	Тахир гол өнгөлөгч
1255	7	Өнгөлөгч, металл		Клапан билүүдэгч
1256	8	Металл хучигч		Металл хучигч

1257	9	Цэргийн зэвсэглэлийн засварчин-нярав		Лакатор засагч.
1258	10	Мотор туршигч		Мотор туршигч
	4.34.Гэрэлтүүлэг чимэглэлийн үйлдвэрийн:			
1259	1	Гагнуурчин	7212-14	Гагнуурчин
1260	2	Цахилгаанчин	7411-11	Цахилгаанчин
1261	3	Шүршиж будагчид, лакдагчид	7131-15	Будагчин
1262	4	Нимгэн төмөрчин, хээлэгч	7213-16	Төмөрчин
1263	5	Ваакумчин		Ваакумчин
1264	6	Органик шилчин		Органик шилчин
	4.35.Нийтийн аж ахуйн, орон сууц тохижилт үйлчилгээ:			
1265	1	Сантехникч, хоолой засварчин	7126-12	Бохир усны слесарь
1266	2	Гагнуурчин	7212-14	Гагнуурчин
1267	3	Цэвэрлэгч/үйлчлэгч, угаалгын өрөө, бие засах газрын	9112-12	Нийтийн бие засах газрын үйлчлэгч
1268	4	Будагчин барилгын	7131-11	Будагчин
1269	5	Засалчин, шаварчин	7123-11	Засалчин
1270	6	Гудамж, зам, талбайн цэвэрлэгч	9613-12	Зам талбайн үйлчлэгч
1271	7	Хортон шавьж устгагч	7544-12	Ургамлын хортон шавьж устгагч
1272	8	Техникийн ажилтан, ургамал судлалын	3141-21	Ургамал хамгааллын мэргэжилтэн
1273	9	Операторч, бульдозерийн	8342-13	Хог түрдэг бульдозерчин
1274	10	Жолооч, хогны машины	8332-15	Хог тээврийн жолооч
1275	11	Машинч, экскоторын /цахилгаан, гидро/	8342-18	Экскоторчин
1276	12	Хог асгах цэгийн диспетчер		Хог асгах цэгийн диспетчер
1277	13	Үл хамаарах системтэй дулаан хуваарилах төвийн машинч		Үл хамаарах системтэй дулаан хуваарилах төвийн машинч
1278	14	Хор найруулагч		Хор найруулагч
1279	15	Хүлэмжийн хор цацагч		Хүлэмжийн хор цацагч
1280	16	Засварчин		Засварчин
1281	17	Хог ачигч		Хог ачигч
	4.36.Шохой үйлдвэрлэлийн:			
1282	1	Тэсэлгээчин	7542-11	Тэсэлгээчин, түүний туслах
1283	2	Нярав, хангамжийн	4321-17	Тэсрэх бодисын нярав
1284	3	Нярав, хангамжийн	4321-17	Нүүрс, шохой, шатах тослох материалын нярав
1285	4	Өрөмдөгч, чулуу	7113-19	Өрөмдөгч
1286	5	Операторч, хүнд даацын авто машины	8332-12	Хүнд даацын машины жолооч
1287	6	Карьерийн хянагч	3121-12	Хянагч
1288	7	Жолооч, ачааны тэрэгний	8332-13	Жолооч
1289	8	Эмч		Эмч

1290	9	Сувилагч		Сувилагч
1291	10	Асрагч		Асрагч
1292	11	Цүнхчин		Цүнхчин
1293	12	Шохой шатаагч		Шохой шатаагч
1294	13	Бутлагч		Бутлагч
1295	14	Шохой гаргагч		Шохой гаргагч
1296	15	Үнс, нурам зөөгч		Үнс, нурам зөөгч
	4.37.Тогтмол, байнгын ажиллагаатай аммиакын хөргөгч, аммиакын хөргөх байгууламжийн:			
1297	1	Автомашины хөдөлгүүрийн засварчин, моторчин	7231-19	Моторчин
1298	2	Сантехникч, хоолой засварчин	7126-12	Бохирын слесарь /махны үйлдвэрийн/
1299	3	Цахилгаанчин	7411-11	Цахилгаанчин
1300	4	Техникч, хийн хоолойн тоног төхөөрөмжийн	3115-30	Техникч /махны үйлдвэрийн/
1301	5	Инженер, аж үйлдвэрийн	2141-11	Инженер /махны үйлдвэрийн/
1302	6	Ариутгагч	7544-11	Ариутгагч
1303	7	Нядлагч	7511-36	Мал нядлагч
1304	8	Толгой, шийр зумлагч		Толгой, шийр зумлагч
1305	9	Машинч		Машинч
1306	10	Компрессорчин		Компрессорчин
1307	11	Устгагч		Устгагч
1308	12	Ариутгалын группын мастер		Ариутгалын группын мастер
	4.38.Спиртийн үйлдвэрийн:			
1309	1	Үр тариа боловсруулах үйлдвэрлэлийн операторч /аппаратчин/	8161-11	Аппаратчин,
1310	2	Технологич, исгэлтийн	2145-19	Эх хөрөнгөчин
1311	3			Хөрөнгөчин
1312	4	Ариутгагч	7544-11	Ариутгагч
1313	5	Сантехникч, хоолой засварчин	7126-12	Бохирын слесарь
1314	6	Хольц бэлтгэгч	7512-22	Хольц бэлтгэгч
1315	7	Эльваторын цехийн тээрэмдэгч		Эльваторын цехийн тээрэмдэгч
1316	8	Туузан дамжуулагч		Туузан дамжуулагч
1317	9	Нүүрсхүчлийн хий савлагч,		Нүүрсхүчлийн хий савлагч,
1318	10	Баллон засварлагч		Баллон засварлагч
1319	11	Чанагч		Чанагч
1320	12	Мөөгөнцөрийн цехийн нормчин		Мөөгөнцөрийн цехийн нормчин
	4.39.Кино үйлдвэрийн:			
1321	1	Фото зурагч	3431-14	Геодези зураг зүйн газрын фото зурагчин
1322	2	Фото зураг угаагч, хэвлэгч, томруулагч, зураг авагч	8132-13	Хэвлэгч



1323	3	Хэв бэлтгэгч		Хэв бэлтгэгч
	4.40.Түүх, ШУТ, бариматат кино, батлан хамгаалахын төв архивын ажлын өдрийн турш архивын материал дээр ажилладаг:			
1324	1	Архивч	2621-12	Архивч
1325	2	Каталогич	2622-13	Фондоч
1326	3	Фото зурагч	3521-12	Фото зурагчин
1327	4	Лаборант	3521-26	Лаборант
1328	5	Сэлбэн засагч		Сэлбэн засагч
	4.41.Төмөрлөгийн үйлдвэрийн:			
1329	1	Үйгч	7211-27	Сараалж үйгч (бэлдэц бэлтгэгч)
1330	2	Слесарь, металл хийц угсралтын	7214-16	Тоног төхөөрөмжийн засварын слесарь
1331	3	Цахилгааны механикч	7412-12	Цахилгааны слесарь
1332	4	Техникч, дулаан салхивч, агаар сэлгэлтийн төхөөрөмжийн	3115-31	Агааржуулалтын системийн засварын слесарь
1333	5	Усаар цэвэрлэгээ хийгч	7211-26	Цахилгаан, усаар нэвчүүлж цэвэрлэгч
1334	6	Энэ ангилалд ороогүй суурь машин, төхөөрөг ажиллуулагч бусад операторч	8189-11	Операторч
1335	7	Бэлтгэгч, хэвний хольц	7211-16	Хольц бэлтгэгч
1336	8	Гол бэлтгэгч, металл хайлшийн	7211-19	Гол бэлтгэгч
1337	9	Оосорлогч	7215-11	Оосорлогч
1338	10	Тохируулагч, металл боловсруулах машин, тоног төхөөрөмжийн	7233-29	Бул голд тохируулагч
1339	11	Хэв угсрагч	7211-29	Бул угсрагч
1340	12	Бусад кранч	8343-13	Цувих болон талбайн краны машинч
1341	13	Чанар шалгагч	7543-11	Эд шалгагч
1342	14	Механикч инженер, хийн хоолойн	2144-40	Тоос, хий барих төхөөрөмжийн засварчин
1343	15	Операторч, металл өнгөлөх машины	8122-21	Металл өнгөлөгч
1344	16	Ирлэгч, металл	7224-17	Ирлэгч
1345	17	Операторч, токарийн суурь машины /токарьчин/	7223-20	Ширмэн эд анги боловсруулахын токарьчин
1346	18	Операторч, өргөгч цамхаг, татах төхөөрөмж, элеваторын	8343-12	Тоноглол өргөгч
1347	19	Засварчин, багажны /нарийн/	7311-21	Багажны засварчин
1348	20	Эзрч-ороогч, төмөр утасны	7215-25	Тросс сүлжигч
1349	21	Ачигч, агуулахын	9333-15	Төмөр ачигч
1350	22	Ачигч, агуулахын	9333-15	Ачигч
1351	23	Хэв загвар хийгч, металл цутгах	7222-18	Чулуу металлаар гоёл чимэглэл хийгч



1352	24	Операторч/Машинч, бохир усны насос станцын	3132-13	Насосны станцын машинч
1353	25	Монтёр цахилгааны /диспетчерийн тоног төхөөрөмж/	7412-19	Цувих болон дэд станцын монтёр
1354	26	Төмөрлөгийн үйлдвэрийн мастер, цувигч, бусад ажилтан	3117-21	Төмөр бэлтгэх цехийн мастер
1355	27	Төмөрлөгийн үйлдвэрийн мастер, цувигч, бусад ажилтан	3117-21	Мастер
1356	28	Бутлагч, металлын	7211-14	Ширэм бутлагч
1357	29	Операторч, нүүрс бутлах машины	8112-12	Кокс бутлагч
1358	30	Техникч, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн	3119-13	Цувих тоног төхөөрөмжийн засварчин
1359	31	Техникч, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн	3119-13	Бэлдэцийн тоног төхөөрөмжийн засварчин
1360	32	Дарга, мастер /менежер/, алба, хэлтэс, тасаг, цех, эзлжийн /үйлдвэрлэлийн ба үйл ажиллагааны менежер боловсруулах үйлдвэрлэлийн/	1321-13	Цехийн дарга
1361	33	Инженер, төмөр бэлтгэх талбайн	2146-35	Инженер
1362	34	Операторч, хуванцар зүсэх машины	8142-12	Төмрийн заводын хуванцарын цехийн прессчин
1363	35	Өнгөлөгч, металл	7224-21	Ширэм өнгөлөгч
1364	36	Операторч, төмөр хайлагч машины	3135-15	Ширэм хайлагч
1365	37	Хэвчин	7314-22	Хэвчин
1366	38	Операторч, металл бүрэх машины	8122-19	Металл хучигч
1367	39	Цахилгаан хэрэгслийн нэвтрүүлэгч		Цахилгаан хэрэгслийн нэвтрүүлэгч
1368	40	Эмульс чанагч		Эмульс чанагч
1369	41	Засварчин		Засварчин
1370	42	Буулгагч		Буулгагч
1371	43	Ахлах засварчин		Ахлах засварчин
1372	44	Сэв засагч		Сэв засагч
1373	45	Бул зорогч		Бул зорогч
1374	46	Хамгаалалтын системийн засварын слесарь		Хамгаалалтын системийн засварын слесарь
	4.42.Сорьцын улсын хяналтын албаны:			
1375	1	Химич	2113-13	Химич
1376	2	Лаборант, чанарын шинжилгээний	3117-14	Лаборант
1377	3	Чулуу судлаач	2114-31	Чулуу шинжээч
1378	4	Алтны дархан	7313-12	Алт хайлагч

1379	5	Технологий, хайлахын	2146-24	Технологич
1380	6	Инженер, төмөрлөгийн, хяналт-туршилтын	2146-31	Инженер
1381	7	Лабораторийн эрхлэгч		Лабораторийн эрхлэгч
1382	8	Сорьц тавигч		Сорьц тавигч
	4.43.Савангийн үйлдвэрийн:			
1383	1	Саван чанагч		Саван чанагч /1995 оноос өмнөх орно/
1384	2	Найруулагч		Найруулагч /1995 оноос өмнөх орно/
	4.44.Хүнд нөхцөлд хамаарах түгээмэл ажил мэргэжил:			
1385	1	Цахилгаанчин /слесарь/	7411-11	Эрчим хүчний үйлдвэрлэл, Цахилгаан шугам сүлжээ, Уул уурхайн үйлдвэрлэл, Төмөр зам, Цементийн үйлдвэрлэл, Эрдэс хөвөнгийн үйлдвэрлэл, Карьерын аж ахуй, Барилгын үйлдвэрлэл, Тоосго үйлдвэрлэл, Бохир усны төвлөрсөн систем, Арьс, шир үслэг эдлэл, Химийн урвалж, реактивийн төвлөрсөн агуулах, ЗООНОЗ-ын төв, Нийслэлийн нийтийн тээвэр, Шил, шаазангийн үйлдвэр, Аммиакийн хөргөх байгууламж
1386	2	Цахилгааны техникч		Эрчим хүчний үйлдвэрлэл, Цахилгаан шугам сүлжээ, Уул уурхайн үйлдвэрлэл, Төмөр зам, Карьерын аж ахуй, Барилгын үйлдвэрлэл, Тоосго үйлдвэрлэл
1387	3	Гагнуурчин, цэгэн	7212-24	Эрчим хүч, Цахилгаан шугам сүлжээ
1388	4	Гагнуурчин	7212-14	Азот, хүчилтөрөгч, Ноос, ноолуур, хивсний үйлдвэрлэл, Арьс, шир үслэг эдлэл, ЗООНОЗ-ын төв, Хүдрийн бус ашигт малтмал баяжуулалт, Шил, шаазангийн үйлдвэр, НАА, орон сууц
1389	5	Гагнуурчин, цахилгаан	7212-19	Эрчим хүчний үйлдвэрлэл, Уул уурхайн үйлдвэрлэл, Төмөр зам, Цементийн үйлдвэрлэл, Эрдэс хөвөнгийн үйлдвэрлэл, Карьерын аж ахуй, Барилгын үйлдвэрлэл, Тоосго үйлдвэрлэл
1390	6	Гагнуурчин, цахилгаан ба хийн	7212-19	Эрчим хүчний үйлдвэрлэл, Уул уурхайн үйлдвэрлэл, Төмөр зам, Цементийн үйлдвэрлэл, Эрдэс хөвөнгийн үйлдвэрлэл, Карьерын аж ахуй, Барилгын үйлдвэрлэл, Тоосго үйлдвэрлэл, Спиртийн үйлдвэр, Төмөрлөгийн үйлдвэр
1391	7	Операторч, хүнд даацын авто машины	8332-12	Уул уурхайн үйлдвэрлэл, Мод бэлтгэл, Карьерын аж ахуй, Барилгын үйлдвэрлэл, Шохойн үйлдвэрлэл

1392	8	Операторч, бульдозерийн	8342-13	Тоосго үйлдвэрлэл, ам гуурийн барилга, засвар, арчлалт, НАА, орон сууц
1393	9	Жолооч, цемент зуурагч, тээвэрлэгч машины	8332-11	Барилгын үйлдвэрлэл, Замын барилга, засвар арчлалт, Бетон үйлдвэрлэл
1394	10	Операторч, ферезерийн суурь машины /ферезерчин/	7223-22	Эрчим хүчний үйлдвэрлэл, ам гуурийн барилга, засвар, арчлалт, Нийслэлийн нийтийн тээвэр
1395	11	Операторч, токарийн суурь машины /токарьчин/	7223-20	Эрчим хүчний үйлдвэрлэл, Нийслэлийн нийтийн тээвэр
1396	12	Машинч, экскаторын /цахилгаан, гидро/ /Экскаторчин/	8342-18	Эрчим хүч үйлдвэрлэл, Карьерын аж ахуй, Барилгын үйлдвэрлэл, ам гуурийн барилга, засвар, арчлалт
1397	13	Ариутгагч	7544-11	Хүн, мал эмнэлгийн, хортон шавьж устгалын, өвчин тахлын ариутгал, халдваргүйжүүлэлтийн
1398	14	Техникч, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн	3119-13	Эрчим хүчний үйлдвэрлэл, Уул уурхайн үйлдвэрлэл, Төмөр зам, Цементийн үйлдвэрлэл, Эрдэс хөвөнгийн үйлдвэрлэл, Карьерын аж ахуй, Барилгын үйлдвэрлэл, Тоосго үйлдвэрлэл, Азот, хүчилтөрөгч, Ноос, ноолуур, хивсний үйлдвэрлэл, Арьс, шир үслэг эдлэл, ЗОНОЗ-ын төв, Хүдрийн бус ашигт малтмал баяжуулалт, Шил, шаазангийн үйлдвэр, НАА, орон сууц, Спиртийн үйлдвэр, Төмөрлөгийн үйлдвэр
1399	15	Техникч, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн /Тоног төхөөрөмжийн засварчин/		
1400	16	Сантехникч, технологийн дамжуулах хоолойн эд анги, зангилааг бэлтгэх	7126-20	Эрчим хүчний үйлдвэрлэл, Уул уурхайн үйлдвэрлэл, Цементийн үйлдвэрлэл, Барилгын үйлдвэрлэл, Спиртийн үйлдвэрлэл
1401	17	Сантехникч, хоолойн засварчин	7126-12	Хурц, архаг халдварт өвчин, сэтгэцийн өвчний эмнэлэг, НАА, орон сууцны
1402	18	Бохир усны слесарь,		
1403	19	Гудамж, зам талбайн цэвэрлэгч	9613-12	НАА, орон сууцны
1404	20	Нийтийн бие засах газрын үйлчлэгч	9112-12	
1405	21	Жолооч, хогны машины	8332-15	Эрчим хүчний үйлдвэрлэл, НАА, орон сууцны
1406	22	Жолооч, машины /Бохирын тээврийн машины жолооч/	8322-11	Эрчим хүчний үйлдвэрлэл, Бохир усны төвлөхсөн систем
1407	23	Хог ачигч /Хог хаягдал ангилагч, ялгагч/	9612-11	НАА, орон сууцны
1408	24	Компрессорчин		Эрчим хүч үйлдвэрлэл, Гутлын үйлдвэрлэл, Малын халдварт өвчний вакцин үйлдпвэрлэл, ам

				гүүрийн барилга, засвар, арчлалт, Аммиакийн хөргөх байгууламж, Шил, шаазангийн үйлдвэрлэл, Аммиакийн хөргөх байгууламж
1409	25	Авто ба гүүрэн кранчин		Эрчим хүчний үйлдвэрлэл, Уул уурхайн үйлдвэрлэл, Төмөр зам, Мод боловсруулах үйлдвэрлэл
1410	26	Галч /Байнгын ажилллагаатай уурын зуухны машинч, галч/, /Улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг уурын зуухны галч/	8182-13	Эрчим хүч үйлдвэрлэлийн
1411	27	Үнс, нурам зөөгч		Эрчим хүчний үйлдвэрлэл, Тоосго үйлдвэрлэл, Шохой үйлдвэрлэл, НАА, орон сууцны
1412	28	Лаборант		Клиник, эмгэг анотомын лаборатори, Химийн материалаар шинжилгээ хийх ажил, Эм, биобэлдмэлийн үйлдвэрлэл, Хүдрийн бус ашигт малтмал баяжуулалт, Шил, шаазангийн үйлдвэр
1413	29	Шил сав угаагч		Шинжилгээ, туршилтын лабораторийн, хүн, мал эмнэлгийн, хортон шавьж устгалын, ариутгалын
1414	30	Хүнд машин механизмын засварчин /слесарь/		Уул уурхайн үйлдвэрлэл, Төмөр зам, Мод бэлтгэл, Карьерын аж ахуй, Барилгын үйлдвэрлэл, Тоосго үйлдвэрлэл
1415	31	Засварчин /машин техник, хөдөлгүүр, багаж хэрэгсэл,		Эрчим хүчний үйлдвэрлэл, Уул уурхайн үйлдвэрлэл, Химийн урвалж, реактивийн төвлөрсөн агуулах, Цэргийн техник

---oOo---





Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/221 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ТЭТГЭВРИЙГ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ТОГТООХ ГАЗРЫН ДООР, ХӨДӨЛМӨРИЙН ХОРТОЙ, ХАЛУУН, ХҮНД НӨХЦӨЛД ХАМААРАХ АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН ЖАГСААЛТЫГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмаар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д заасны дагуу тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтыг хэрэглэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2.Ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээ, тушаал, хөлсөөр ажиллах болон ажил гүйцэтгэх гэрээ, түүнтэй адилтгах бусад гэрээ, албан тушаалын тодорхойлолтод заасан ажил, мэргэжил нь даатгуулагчийг газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд ажилласныг нотлох үндсэн баримт болно.

Хоёр. Жагсаалтыг хэрэглэх

2.1.Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох “Газрын доор хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт” /цаашид “жагсаалт” гэх/-ыг хэрэглэхдээ хөдөлмөр, нийгмийн хамгаллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан “Үндэсний ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолт (ҮАМАТ-08)”-ыг баримтална.

2.2.Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох жагсаалтыг хэрэглэхдээ энэ журмын 2.1-д зааснаас гадна дүйцүүлэн хэрэглэх ажил, мэргэжлийн жагсаалтыг харгалзана.

2.3.Хөдөлмөр, нийгмийн хамгаллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан “Үндэсний ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолт (ҮАМАТ-08)”-д байхгүйгээс дангаар баталсан тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох жагсаалтыг мөн хэрэглэнэ. Энэ тохиолдолд ажил олгогч энэ жагсаалтад заасан ажил, мэргэжлийг холбогдох журмын дагуу “Үндэсний ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолт (ҮАМАТ-08)”-д нэмэх асуудлыг холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.

2.4.Улирлын чанартай уурын зууханд нийгмийн даатгалын шимтгэл төлж ажилласан галчийн хэвийн бус нөхцөлд ажилласан хугацааг тухайн улирлын ажлын үргэлжлэх хугацаагаар тооцно.

Жишээ-1: Жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны өдрөөс дараа оны 5 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд уурын зуухны галчаар /машинчаар/ ажилладаг даатгуулагчийн хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилласан хугацааг жил бүр 8 сараар тооцно.

2.5.Ажил олгогчоос тухайн улирлын чанартай ажилтны ажиллаагүй хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож төлсөн, эсхүл хөдөлмөрийн хэвийн нөхцөлтэй ажлыг

ТҮЗ894
9132155
1119277787

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ТАМГЫГ ХУУЛЬЛАХ ҮНЭН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ЭРХ БҮХИЙ ДАРГА
Гарын үсэг:
2024 оны 01 сарын 04 өдөр

хариуцуулан ажиллуулж шимтгэл төлсөн бол уг хугацааг хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилласнаар тооцохгүй.

2.6.Жагсаалтыг шинэчлэн баталсантай холбогдуулан даатгуулагчийн урьд ажиллаж байсан ажил, мэргэжил нь Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны А/77 дугаар тушаалаар батлаж мөрдөж байсан тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох жагсаалтад дурдсан газрын доор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлийн ажил, мэргэжилд хамаарагдаж, зохих болзол хангасан тохиолдолд өндөр насны тэтгэврийг хөнгөлөлттэй нөхцөлөөр тогтооно.

2.7.Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох жагсаалтын хөдөлмөрийн хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжилд заасан ажил, мэргэжлээр ажиллаж, шимтгэл төлсөн даатгуулагч аль салбар, үйлдвэрлэл, байгууллагад хамаарахаас үл хамааран хөдөлмөрийн хүнд нөхцөлд ажилласан байвал зохих нөхцөл болзлыг хангасан бол тэтгэврийг хөнгөлөлттэй нөхцөлөөр тогтооно.

Жишээ-2: Хөдөлмөрийн хүнд нөхцөлд хамаарах түгээмэл ажил, мэргэжлийн жагсаалтад дурдсан “8332-12” код бүхий хүнд даацын авто машины операторч нь технологийн зориулалттай ажил үүрэг гүйцэтгэдэг тул уул уурхай, барилга, эрчим хүч, ой мод, авто зам зэрэг аль салбар, үйлдвэрлэл, байгууллагад ажиллаж байгаагаас үл хамаарч хөдөлмөрийн хүнд нөхцөлөөр ажилласнаар тооцож тэтгэвэр тогтооно.

2.8.Даатгуулагч жагсаалтад дурдсан хөдөлмөрийн хүнд нөхцөлийн ажил, мэргэжилд ажиллаж шимтгэл төлсөн хугацаа нь хуульд заасан өндөр насны тэтгэвэр тогтоолгох болзлыг хангахгүй бол түүний жагсаалтад дурдсан газрын доор, хөдөлмөрийн хортой, халуун нөхцөлийн ажил, мэргэжил, албан тушаалд ажилласан хугацааг оруулан хуульд заасан болзлыг хангаж байвал түүнд хүнд нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоож болно.

Жишээ-3: Нийтдээ 25 жил шимтгэл төлж ажилласан 55 настай даатгуулагч эрэгтэй хүн жагсаалтад дурдсан газрын доорх ажилд 6 жил, хөдөлмөрийн хүнд нөхцөлийн ажилд 8 жил, хэвийн нөхцөлд 11 жил ажилласан гэж үзвэл газрын доор ажил, хөдөлмөрийн хүнд нөхцөлийн ажил тус бүр дээр ажилласан хугацаа нь тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоолгох болзлыг хангаагүй боловч дээрх хоёр нөхцөлд ажилласан хугацааны нийлбэр нь 14 жил болж хөдөлмөрийн хүнд нөхцөлд ажилласан хугацааг хангасан тул түүнд өндөр насны тэтгэврийг хөдөлмөрийн хүнд нөхцөлөөр тогтооно.

2.9.Жагсаалтад дурдсан газрын доор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил мэргэжилд ажилласан хугацаанд даатгуулагчийн жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхдээ асарсан, сул зогссон, ажил олгогчийн захиалгаар суралцсан, цэргийн алба хаасан, хууль бусаар ажлаас халагдсан, хилс хэргээр хорих ял эдэлсэн, 1 сараас дээш хугацаагаар хөдөлмөрийн чадвараа түр алдсан хугацаа зэргийг хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилласан хугацаанд оруулахгүй.

Гурав. Бусад

3.1.Энэ журмыг хэрэгжүүлэхтэй холбоотой үүссэн маргааныг Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлөөр хэлэлцүүлж шийдвэрлэнэ.

3.2.Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 21 өдөр Дугаар 20 Улаанбаатар хот

Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл тогтоох тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг, Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 01/1091 дүгээр албан бичгээр ирүүлсэн саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн дагуу нэрийн дансны аргаар өндөр насны тэтгэвэр бодоход баримтлах тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл (“К”)-ийг 2024 онд эмэгтэй даатгуулагчид 22 жил, эрэгтэй даатгуулагчид 15 жилээр тус тус тогтоосугай.

2. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 20 дугаар тогтоолын 1 дэх заалтыг “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн дагуу өндөр насны тэтгэвэр бодоход баримтлах тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл (“К”)-ийг 2022-2023 онд эмэгтэй даатгуулагчид 22 жил, эрэгтэй даатгуулагчид 15 жилээр тус тус тогтоосугай” гэж өөрчилсүгэй.

3. Энэ тогтоолоор баталсан тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийллийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн дагуу нэрийн дансны аргаар өндөр насны тэтгэвэр бодоход баримталж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Л.Мөнхзул/-т даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын алба /Г.Банзрагч/-нд үүрэг болгосугай.

5. Энэхүү тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ДАРГА Х.БУЛГАНТУЯА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 20 өдөр Дугаар 450 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 22.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Тэтгэвэр тогтоолгох, тэтгэврийн хэмжээг өөрчлөхөд бүрдүүлэх баримт бичиг, тэтгэвэр олгох журам”-ыг хавсралт ёсоор батлагдсугай.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяад, хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Л.Мөнхзул)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор тэтгэвэр тогтоолгоход шаардлагатай мэдээллийг нийгмийн даатгалын байгууллагатай цахимаар солилцох ажлыг зохион байгуулахыг холбогдох байгууллагуудад үүрэг болгосугай.

4.Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД Х.БУЛГАНТУЯА

Засгийн газрын 2023 оны 12 дугаар
сарын 20 -ны өдрийн 450 дугаар
тогтоолын хавсралт

ТЭТГЭВЭР ТОГТООЛГОХ, ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭГ ӨӨРЧЛӨХӨД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ, ТЭТГЭВЭР ОЛГОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль (шинэчилсэн найруулга), Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу тэтгэвэр тогтоолгох болон тэтгэврийн хэмжээг өөрчлөн тогтооход бүрдүүлэх баримт бичгийг цаасан, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлэх, тэтгэвэр тогтоож олгоход энэ журмыг баримтална.

1.2.Тэтгэвэр тогтоолгох өргөдөл гаргасан даатгуулагчийн шаардлагатай лавлагаа, тодорхойлолт, үрэгдүүлсэн баримт бичгийн мэдээлэл нь нийгмийн даатгалын байгууллагын архив, мэдээллийн нэгдсэн санд байгаа тохиолдолд холбогдох нийгмийн даатгалын газраас гаргуулж, харилцан солилцох зарчмыг баримтална.

Хоёр.Тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлэх баримт бичиг

2.1.Нийгмийн даатгалын байгууллага нь даатгуулагчид тогтоох тэтгэврийн төрлөөс хамаарч доор дурдсан шаардлагатай мэдээллийг нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сан, нийгмийн даатгалын байгууллагын архив болон төрийн мэдээлэл солилцох үндсэн системээс тодорхойлно:

2.1.1.иргэний үнэмлэх, гадаадын иргэн, харьяалалгүй хүний эрх бүхий байгууллагаас олгосон Монгол Улсад байнга оршин суух үнэмлэх;

2.1.2.ажил олгогчийн 1991-1994 онд нийгмийн даатгалын шимтгэл төлсөн тодорхойлолт;

2.1.3.нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт;

2.1.4.ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлсөн тухай мэдээлэл;

2.1.5.малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлсөн тухай мэдээлэл;

2.1.6.Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн тогтоол;

2.1.7.Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шийдвэр, акт;

2.1.8.нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр тогтоолгоогүй тухай хөдөлмөр, нийгмийн халамжийн байгууллагын тодорхойлолт;

2.1.9.тэжээгчийн нас барсны гэрчилгээ;

2.1.10.гэрлэлт бүртгэсэн лавлагаа;

2.1.11.хүүхдийн төрсний гэрчилгээ;

2.1.12.үрчлэлтийн талаарх лавлагаа;

2.1.13.ургийн овог, овог нэр, регистр, ажил олгогчийн нэр, өмчийн хэлбэр өөрчилсөн лавлагаа.

2.2.Даатгуулагч өндөр насны тэтгэвэр тогтоолгоход доор дурдсан баримт бичгийг цаасан, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлнэ:

2.2.1.ажилд томилсон, ажлаас чөлөөлөгдсөн тухай тушаал, шийдвэр;

2.2.2.1995 оноос өмнө ажилласан хугацааг нотлох хөдөлмөрийн дэвтэр, архивын лавлагаа, ажилласан хугацааг сэргээн тогтоосон тухай шүүхийн шийдвэр;

2.2.3.цэргийн батлах, эсхүл тусгай архивын лавлагаа;

2.2.4.тэтгэвэр тогтоолгох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын лавлагаа (1995 оноос өмнөх хугацааны);

2.2.5.итгэмжлэгдсэн төлөөлөгчийн иргэний үнэмлэх, итгэмжлэл;

2.2.6.ургийн овог, овог нэр, регистр, ажил олгогчийн нэр, өмчийн хэлбэр өөрчилсөн лавлагаа.

2.3.Малчин даатгуулагчид өндөр насны тэтгэвэр тогтооход энэ журмын 2.2-т заасан баримт бичгээс гадна доор дурдсан баримт, бичгийг цаасан, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлнэ:

2.3.1.1995 оноос хойших хугацаанд мал маллаж, шимтгэл төлж байсан хугацааг нь нотлох боломжгүй бол Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн тогтоол;

2.3.2.ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг 1990-1994 оныг нөхөн тооцуулсан бол тухайн орон нутагт мал маллан оршин сууж байсан тухай баг, хорооны Засаг даргын тодорхойлолт;

2.3.3.Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллогын бүртгэл “А” данс малчны гэр бүлийн гишүүдийн мэдээллийг “А” дансны 2 дугаар бүлэг дэх “Малчны мэдээлэл” хэсэгт бүртгэгдсэн хүний мэдээлэлтэй тулган гаргасан лавлагаа (ХААТР 11);

2.3.4.тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан эмэгтэй малчин даатгуулагчийн гэрлэсэн эсэх тухай шүүхийн шийдвэр.

2.4.Даатгуулагч хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгох бол энэ журмын 2.2-т заасан баримт бичгээс өөрт холбогдох баримт бичгийг цаасан, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлнэ.

2.5.Даатгуулагч тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгоход *энэ журмын 2.2-т* заасан баримт бичгээс гадна доор дурдсан баримт бичгийг цаасан, эсхүл цахим *хэлбэрээр б*үрдүүлнэ:

2.5.1.гэрлэсэн эсэх тухай шүүхийн шийдвэр;

2.5.2.асран хамгаалагчаар тогтоосон тухай харьяа аймаг, сум, дүүргийн Засаг даргын захирамж;

2.5.3.тэжээгчээ алдсаны тэтгэврийг хөдөлмөрийн чадваргүй гишүүдэд хуваан олгох тохиолдолд холбогдох хүсэлт, шүүхийн шийдвэр.

2.6.Даатгуулагч нэрийн дансны аргаар өндөр насны тэтгэвэр тогтоолгох бол энэ журмын 2.2-т заасан өөрт холбогдох баримт бичгийг цаасан, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлэх бөгөөд тухайн даатгуулагчийн тэтгэвэр тогтоолгох тухайн жилийн нэрийн дансны эцсийн үлдэгдэл болон мөнгөжүүлсэн орлогын нийлбэр дүнгийн мэдээллийг нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сангаас тодорхойлно.

2.7.Даатгуулагч тэтгэврийн төрлөөс хамааран энэ журмын 2.2, 2.3, 2.5-д заасан баримт бичгээс өөрт шаардлагатай баримт бичгийг цаасан, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлнэ.

Гурав.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлэх баримт бичиг

3.1.Цэргийн алба хаагч цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгоход доор дурдсан баримт бичгийг цаасан, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлнэ:

3.1.1.энэ журмын 2.2-т заасан өөрт холбогдох баримт бичиг;

3.1.2.цэргийн албанд татагдсан, элссэн, албан тушаалд томилогдсон, цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр цэргийн албанаас чөлөөлсөн тухай цэргийн анги, байгууллагын тушаал, шийдвэр, цэргийн алба хаасан хугацааны талаарх цэргийн байгууллагын архивын лавлагаа;

3.1.3.цэргийн батлах, хэрэв засвартай тохиолдолд цэргийн байгууллагын архивын лавлагаа;

3.1.4.цэргийн алба хаагчийн цэргийн жинхэнэ алба хаасан хугацаа сэргээн тогтоосон бол шүүхийн шийдвэр;

3.1.5.холбогдох хуулийн дагуу цэргийн алба хаасан хугацааг нэмэгдүүлэн тооцох тохиолдолд тухайн цэргийн байгууллагын цэргийн алба хаасан хугацаа нэмэгдүүлэн тооцсон тодорхойлолт;

3.1.6.цэргийн алба хаагчийн далд орон тоонд, эсхүл нууцалбал зохих албанд алба хаасан хугацааны лавлагаа, тэтгэвэр тогтоолгох цалин хөлсний тодорхойлолтыг Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан нөхцөлийн дагуу хүлээн авч, нууцыг хамгаалах нөхцөл, шаардлагыг хангасан нөхцөлд тэтгэврийн хувийн хэрэгт хадгална.

3.2.Цэргийн алба хаагч хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгоход доор дурдсан баримт бичгийг цаасан, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлнэ:

3.2.1.энэ журмын 3.1-д заасан баримт бичиг;

3.2.2.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан нөхцөл, шалтгаанаар гарсан ослыг мөн

хуулийн 1 дүгээр зүйлд заасан байгууллагын дэргэдэх комиссоос судлан бүртгэж, тогтоосон, хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчийн хянан баталгаажуулсан "Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэсэн акт".

3.3.Тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгоход доор дурдсан баримт бичгийг цаасан эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлнэ:

3.3.1.энэ журмын 3.1, 3.2.2-т заасан баримт бичиг;

3.3.2.хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн тоо, ам бүлийн тодорхойлолт.

Дөрөв.Тэтгэврийн хэмжээг өөрчлөн тогтооход бүрдүүлэх баримт бичиг

4.1.Тэтгэврийн хэмжээг өөрчлөн тогтоохдоо Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 25.1-д заасан үндэслэлийг баталгаажуулж, дараах баримт бичгийг цаасан, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлнэ:

4.1.1.тэтгэвэр тогтооход баримталсан шимтгэл төлсөн хугацаа цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээ өөрчлөгдсөнийг нотлох баримт, архивын лавлагаа, тодорхойлолт;

4.1.2.тэтгэвэр тогтоолгоход баримталсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлого нь өөрчлөгдөх үндэслэлтэйг нотлох баримт, архивын лавлагаа, тодорхойлолт;

4.1.3.нас барсан тэжээгчийн асрамжид байсан хөдөлмөрийн чадваргүй гишүүний тоонд өөрчлөлт орсон бол ам бүлийн тодорхойлолт.

4.2.Энэ журмын 4.1.1, 4.1.2-т заасан 1995 оноос хойших хугацааны цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг нийгмийн даатгалын байгууллага тодорхойлно.

Тав.Тэтгэвэр олгох

5.1.Нийгмийн даатгалын байгууллага энэ журамд заасны дагуу даатгуулагчийн бүрдүүлсэн баримт бичгийг хүлээн авч Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан хугацаанд тэтгэвэр тогтоож, мөн хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу олгоно.

5.2.Тэтгэвэр авагчийн тэтгэврийг түүний сонгосон арилжааны банкаар дамжуулан сар бүр олгох бөгөөд сонгосон арилжааны банкны нэр, дансны дугаарыг тэтгэвэр тогтоолгох өргөдлийн маягтаар авч нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

5.3.Тэтгэвэр авагч тэтгэвэр тогтоолгосноос хойш 6 сараас доошгүй хугацаанд тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн тохиолдолд нийгмийн даатгалын байгууллага шимтгэл төлөлтийг нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сангаас шалгаж, тэтгэврийг өөрчлөн тогтоож олгоно. Хэрэв Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 7.2, 7.3-т зааснаар нэмэгдүүлэх бол хүсэлтээ харьяалах нийгмийн даатгалын байгууллагад цаасан, эсхүл цахим хэлбэрээр хүргүүлнэ.

5.4.Тэтгэвэр авагч Монгол Улсын харьяатаас гарч Нийгмийн хамгааллын хэлэлцээргүй гадаад улсын иргэншил авсан бол Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 24.2.3-т заасан хугацаанаас эхлэн тэтгэвэр олголтыг зогсооно.

5.5.Тэтгэвэр авагч Монгол Улсын харьяатаас гарч Нийгмийн хамгааллын хэлэлцээртэй улсын иргэншил авсан бол тухайн улстай байгуулсан нийгмийн хамгааллын хэлэлцээрийн дагуу шийдвэрлэнэ.

5.6.Монгол Улсын тэтгэвэр авагч иргэн гадаад улсад удаан хугацаагаар амьдарч байгааг тухайн улсын нотлох баримтыг үндэслэн гаргасан Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газрын тодорхойлолтыг үндэслэн олгоно.

Зургаа. Хариуцлага

6.1.Хуурамч баримт бичиг бүрдүүлэх, худал мэдүүлэх зэргээр тэтгэврийг үндэслэлгүй, эсхүл илүү тогтоолгож авсан бол үндэслэлгүй буюу илүү авсан тэтгэврийг буруутай этгээдээр хуульд заасны дагуу бүрэн төлүүлж, тэтгэврийн даатгалын санг хохиролгүй болгох, буруутай этгээдэд Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.2.Нийгмийн даатгалын хууль тогтоомж болон бусад хууль тогтоомж, энэ журмыг зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, ёс зүйн зөрчил гаргасан нийгмийн даатгалын байцаагч, ажилтанд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2023.10.16 № 1/5363

танай 2023.10.06-ны № 03/2525 -т

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД Х.БУЛГАНТУЯА
ТАНАА

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Зардлын норматив шинэчлэн батлах тухай” 2023 оны А/130 дугаар тушаалыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзээд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн .6448..... дугаарт, “Тэтгэвэр тогтоолгох үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалин батлах тухай” 2023 оны А/136 дугаар тушаалыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн ..6449.....дугаарт тус тус бүртгэж хүргүүлэв.

Б.ЭНХБАЯР

15160855

Д.Доржсүрэн, 7855 2023

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2023 оны 10 сарын 16-ны өдрийн 6479 дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ

2023 оны 10 сарын 05 өдөр Дугаар А/136 Улаанбаатар хот

Тэтгэвэр тогтоолгох үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалин батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсэг, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тэтгэвэр тогтооход баримтлах “Тэтгэвэр тогтоолгох үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалин”-г хавсралтаар баталсугай.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Батжаргал/-т, хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газарт тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн А/136 дугаар тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэхүү тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

САЙД Х.БУЛГАНТУЯА

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ ТЕАГУТУГ ХУУЛБАР ҮНЭН ТӨРИЙН ЗАСАГ ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Гарын үсэг: 2023 он 10 сар 05 өдөр

151230353

D: 2023 on 09 sar tushaal

Хөдөлмөр, нийгмийн хамгаалллын сайдын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/136 дугаар тушаалын хавсралт

ТЭТГЭВЭР ТОГТООЛГОХ ҮНДЭСНИЙ АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН ЖИШИГ ЦАЛИН

(төгрөгөөр)

№	Үндсэн бүлэг	1990 он ба түүнээс өмнөх	1991 он	1992 он	1993 он	1994 он
1	Менежер	800	1600	2800	7100	12600
2	Мэргэжилтэн	650	1300	2250	5700	10200
3	Техникч болон туслах, дэд мэргэжилтэн	580	1160	2000	5060	9050
4	Контор, үйлчилгээний ажилтан	450	900	1540	3850	7850
5	Худалдаа, үйлчилгээний ажилтан	430	860	1470	3650	6500
6	Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан	420	840	1430	3550	6350
7	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	510	1020	1750	4400	7850
8	Машин механизм, төхөөргийн операторч, угсрагч	550	1100	1900	4800	8500
9	Энгийн ажил, мэргэжил	350	700	1200	2900	5150
10	Зэвсэгт хүчний ажил мэргэжил	600	1200	2080	5250	9350

---oOo---

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ ТЕАГУУТГ
ХУУЛЬ ЗҮЙН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УРЛАЛЛАГИЙН
ГАРЫН ДЭЭ
Гарын үсэг
2023 он 10 сар 06 өдөр

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2023.10.16 № 1/5360

танай 2023.10.04 -ны № 01/2484 -т

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД Х.БУЛГАНТУЯА
ТАНАА

Гадаад харилцааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан “Монгол Улсаас хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газрын ажилтны адилтгах албан тушаалын жагсаалт, нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах жишиг цалин хөлсний хэмжээг батлах тухай” 2023 оны А/69, А/132 дугаар тушаалыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзээд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн .....6450.....дугаарт бүртгэж хүргүүлэв.

Б.ЭНХБАЯР

151604852

Documenta 5.2023

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2023 оны 10 сарын 16-ны өдрийн 6450 дугаарт бүртгэв.

ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2023 оны 10 дугаар сарын 02-ны өдөр | Дугаар А/69 / А/132 | Улаанбаатар хот

Монгол Улсаас хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газрын ажилтны адилтгах албан тушаалын жагсаалт, нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах жишиг цалин хөлсний хэмжээг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.29 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Монгол Улсаас хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газрын ажилтны адилтгах албан тушаалын жагсаалт, нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах жишиг цалин хөлсний хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Дипломат төлөөлөгчийн газрын ажилтны нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тооцоход Засгийн газраас тогтоосон төрийн захиргааны төв байгууллагын төрийн захиргааны болон төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээ, төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээ, холбогдох нэмэгдлийг тус тус баримталсугай.

3.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “Адилтгах албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” Гадаад харилцааны сайд, Хөдөлмөрийн нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/48, А/130 дугаар хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэхүү тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД Б.БАТЦЭЦЭГ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД Х.БУЛГАНТУЯА

ГУЗ894 9132155 1119277757

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ ТӨАГУУТУГ ХУУЛЬАР ҮНЭН ТӨРИЙН ЗАСГИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ДАРГА

Гарын үсэг

2023 он 10 сар 04 өдөр


Гадаад харилцааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/69 / А/132 дугаар хамтарсан тушаалын хавсралт


Монгол Улсаас хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газрын ажилтны адилтгах албан тушаалын жагсаалт, нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах жишиг цалин хөлсний хэмжээ

№	Дипломат төлөөлөгчийн газрын албан тушаал	Гадаад харилцааны яамны адилтгах албан тушаал	Жишиг цалин хөлсний хэмжээ
1.	Элчин сайд Байнгын төлөөлөгч Ерөнхий консул	Төрийн нарийн бичгийн дарга	ТЗ-1
2.	Элчин Хэргийг хамаарагч Байнгын төлөөлөгчийн орлогч Элчин зөвлөх	Газрын захирал	ТЗ-2
3.	Цэргийн атташе Консул (Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн) Консулын хэлтсийн дарга	Газрын дэд захирал	ТЗ-3
4.	Зөвлөх	Зөвлөх	ТЗ-4
5.	Нэгдүгээр нарийн бичгийн дарга Консул Худалдааны төлөөлөгч	Нэгдүгээр нарийн бичгийн дарга	ТЗ-5
6.	Хоёрдугаар нарийн бичгийн дарга Дэд консул Консулын төлөөлөгч Цэргийн атташегийн туслах	Хоёрдугаар нарийн бичгийн дарга	ТЗ-6
7.	Гуравдугаар нарийн бичгийн дарга	Гуравдугаар нарийн бичгийн дарга	ТЗ-7
8.	Атташе	Атташе	ТЗ-8
9.	Ахлах нягтлан бодогч	Ахлах мэргэжилтэн	ТЗ-6
		Ахлах нягтлан бодогч	ТҮ-9
10.	Консулын техник ажилтан	Мэргэжилтэн	ТЗ-9
11.	Аж ахуйн эрхлэгч-жолооч	-	ТҮ-7
	Ажил эрхэлж буй төвийн томилолттой ажилтны гэр бүл	-	
12.	Жолооч, сантехникч, мужаан	-	ТҮ-6
13.	Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүний томилсон үйлчилгээ техникийн ажилтан	-	ТҮ-5

14.	Төвийн томилолттой ажилтны ажил эрхлээгүй гэр бүл	-	НДЕХ-ийн 7.4.6, 21.15-д зааснаар
15.	Төвийн томилолттой ажилтны дипломат албан тушаалтай гэр бүл	Тухайн ажилтны сүүлд эрхэлж байсан албан тушаалын ангиллаар	

---oOo---





МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2023.12.28 № 2/6628

танай 2023.1211 -ны № 01/2271 -т

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА
Л.МӨНХЗУЛ ТАНАА

"Журам батлах тухай" Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/139 дүгээр тушаалыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзээд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 6519..... дугаарт бүртгэж хүргүүлэв.

ДЭД САЙД Б.СОЛОНГОО

Дэс дарга 3.2023

13150437

27.01.04

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2023 оны 12 сарын 28-ны өдрийн 6514 дугаарт бүртгэв.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 10 сарын 24 өдөр Дугаар А/139 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 37 дугаар зүйлийн 37.13.1, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 20 дугаар зүйлийн 20.7, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 5 дугаар зүйлийн 5.4, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны "Тэтгэвэр тогтоолгох үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалин батлах тухай" А/136 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. "Тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох, хэрэглэх журам"-ыг шинэчлэн баталж, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

Хоёр. Батлагдсан журмыг мөрдөн ажиллахыг аймаг, дүүрэг (нийслэл)-ийн нийгмийн даатгалын хэлтсийн дарга нарт, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг Бодлогын хэрэгжилт, судалгааны газар, програм хангамжийг даалгаврын дагуу боловсруулж 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлэхийг Мэдээллийн технологийн төв (Г.Хүрэлбаатар), хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Д.Ганзориг)-т тус тус үүрэг болгосугай.

Гурав. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны "Журам батлах тухай" А/132 дугаар тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.

Дөрөв.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (Б.Батсүх)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ц.ГАНЦЭЦЭГ

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

ТЭТГЭВЭР ТОГТООЛГОХ САРЫН ДУНДАЖ ЦАЛИН ХӨЛС, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГЫГ ТОДОРХОЙЛОХ, ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

Баримт бичгийн дугаар: ЖРМ-БХСГ -2023

Батлсан: НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ц.ГАНЦЭЦЭГ

Боловсруулсан: БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, СУДАЛГААНЫ ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН С.ЛХАГВАДОРЖ

Эх хувь
Хяналттай хувь
Хуулбар ба хяналттай хувь
Хүчингүй хувь
Хяналтгүй хувь

Дардас

АГУУЛГА

1. Зорилго
2. Хамрах хүрээ
3. Хамаарах талууд
4. Баримт бичгийн хариуцагч
5. Нэр томьёоны тодорхойлолт
6. Тэтгэвэр тогтоох дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох, хянах, хэрэглэх
7. Үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалингаар тэтгэвэр тогтоох
8. Тэтгэвэр тогтоосон дундаж цалинг өөрчлөх
9. Хяналт, хариуцлага

Нийгмийн даатгалын ерөнхий газрын
даргын 2023 оны 10 дугаар сарын 24 -ны
өдрийн А/139 дугаар тушаалын хавсралт

ТЭТГЭВЭР ТОГТООЛГОХ САРЫН ДУНДАЖ ЦАЛИН ХӨЛС, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГЫГ ТОДОРХОЙЛОХ, ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

НЭГ. Зорилго

Даатгуулагчийн тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох, хэрэглэх, 1995 оноос өмнөх үеийн цалин хөлс нь архивын, эсхүл санхүүгийн баримтаар нотлогдох боломжгүй тохиолдолд үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалинг баримтлан тэтгэвэр тогтоолгох харилцааг зохицуулахад энэ журмыг мөрдөнө.

ХОЁР. Хамрах хүрээ

Энэхүү журмаар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай /шинэчилсэн найруулга/, Цэргийн албаа хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох, итгэлцүүр хэрэглэх, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн "Тэтгэвэр тогтоолгох үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалин батлах тухай" А/136 дугаар тушаалаар баталсан 1995 оноос өмнөх хугацааны ажил, мэргэжлийн жишиг цалинг хэрэглэх, тэтгэвэр тогтоох, хяналт тавих, хариуцлага хүлээлгэхтэй холбогдох харилцааг зохицуулна.

ГУРАВ. Хамаарах талууд

Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, судалгааны газар, Хяналт шалгалтын газар, Мэдээллийн технологийн төв, аймаг, нийслэл, дүүргийн Нийгмийн даатгалын газар, тасаг, сумын байцаагч, архивын байгууллага, ажил олгогч, даатгуулагч, иргэн, тэтгэвэр авагч.

ДӨРӨВ. Баримт бичгийн хариуцагч

Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, судалгааны газар.

ТАВ. Нэр томьёоны тодорхойлолт

5.1."Цалин хөлс, түүнтэй адилтгах орлого" /цаашид "цалин хөлс" гэх/ Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.17-д заасныг хэлнэ.

5.2."Итгэлцүүр" гэж Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т заасныг хэлнэ.

5.3."Үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалин" гэж Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэрийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсэгт заасны дагуу хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан цалингийн хэмжээг ойлгоно.

5.4."Ажил, мэргэжил" гэж тэтгэвэр авагч, даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн дэвтэр, архивын лавлагаа, шүүхийн шийдвэрт бичигдсэн ажил, албан тушаалыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2010 оны 16 дугаар тушаалаар батлагдсан "Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт "УАМАТ"-08"-ыг баримтлан тодорхойлсныг хэлнэ.

ЗУРГАА. Тэтгэвэр тогтоолгох цалин хөлсийг тодорхойлох, хянах

6.1.Даатгуулагч (иргэн)-ийн тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлсийг тодорхойлохдоо Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай /шинэчилсэн найруулга/-ийн 5 дугаар зүйлийн 5.4, 7 дугаар зүйлийн 7.4, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу шимтгэл төлсөн цалин хөлсний нийлбэрийг тухайн хугацаанд шимтгэл төлсөн сарын тоонд хуваах замаар тодорхойлно.

Санамж[1]. Даатгуулагч (иргэн) 5-аас доош жил шимтгэл төлсөн байх нөхцөлөөр хөдөлмөрийн чадвараа алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн болоч уг даатгуулагч нь нийтдээ 60 сараас дээш шимтгэл төлсөн бол 60 сарын цалин хөлсний нийлбэрийг 60 сард хуваах замаар сарын дундаж цалин хөлсийг тодорхойлно.

6.2.Даатгуулагч (иргэн) 1995 оноос өмнө ажилласан хугацаанд авсан цалин хөлснөөс тэтгэвэр тогтоолгохыг хүссэн тохиолдолд түүний тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 20 жилийн доторх өөрт нь ашигтай дараалсан 5 жилийн цалин хөлсний талаар зөвлөж уг хугацаанд авч байсан цалин хөлсний тодорхойлолтыг маягт (Б-НД-5)-аар ажил олгогчийн санхүүгийн баримтыг үндэслэн гаргуулан авна.

Санамж[2].Энэ тохиолдолд ажил олгогч нь татан буугдсан зэрэг шалтгаанаар тодорхойлох боломжгүй бол архивын лавлагаа гаргуулан авна.

Санамж[3]. Нийгмийн даатгалын улсын байцаагч нь даатгуулагч, ажилтны цалин хөлсний тодорхойлолт, архивын лавлагааны үндэслэлийг аж, ахуйн нэгж байгууллагын санхүүгийн бариммтад болон Нийгмийн даатгалын өрөнхий газар, Архивын өрөнхий газрын хооронд байгуулсан 2023 оны ХАГ/2023-07,НД-74/23 дугаар "Хамтран ажиллах гэрээ"-нд заасны дагуу архивын бариммтад тулгуурлан шалгаж болно.

6.3.Энэ журмын 6.2-т заасан даатгуулагч (иргэн)-ийн 1995 оноос өмнөх цалин хөлс нь архивын баримтаар нотлогдох боломжгүй тохиолдолд энэ журмын 7.1-д заасны дагуу жишиг цалинг баримтална.

Санамж[4]. 2024 оноос эхлэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/136 дугаар тушаалаар батлагдсан "Тэтгэвэр тогтоолгох үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалин"-д заасан холбогдох ажил мэргэжил, албан тушаалд харгалзсан жишиг цалинг баримтална.

6.4.Даатгуулагч (иргэн) нь 1995 оноос хойш ажилласан хугацаанд шимтгэл төлсөн цалин хөлснөөс тэтгэвэр тогтоолгохыг хүссэн тохиолдолд нийгмийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 20 жилийн доторх өөрт нь ашигтай дараалсан 5 жилийн цалин хөлсний талаар зөвлөж тухайн хугацааны шимтгэл төлсөн цалин хөлсийг сонгож болно.

Санамж[5]. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.4, 7.4.1, 7.4.2, 7.4.4-7.4.9, 7.5.2-т заасан даатгуулагч нь нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогч, улсын төсөв эсхүл нийгмийн даатгалын сангаас төлөгдсөн хугацаанд шимтгэл тооцон төлсөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тэтгэвэр тогтоолгох дундаж цалин хөлсөнд оруулан тооцуулах хүсэлт гаргасан тохиолдолд уг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дундаж цалин хөлсний бүрэлдэхүүнд оруулж болно.

Санамж[6]. Ажил олгогч нь ажилтныхаа цалин хөлс, ээлжийн амралтын олговор зэрэг хоёр ба түүнээс дээш сарын цалин хөлсийг нэгтгэн нэг сард тайлагнасан нь тухайн үед мөрдсөн даатгуулагчийн шимтгэл төлөх сарын цалин хөлсний дээд хэмжээнээс давсны улмаас уг цалин хөлсийг зөвхөн нэг сард тооцох нөхцөл үүссэн тохиолдолд ажил олгогчийн хүсэлт, залруулгын тайлан, цалин хөлсний санхүүгийн бариимтыг үндэслэн нэгтгэн тайлагнасан цалин хөлсийг холбогдох саруудад нь залруулан, үүссэн шимтгэлийн зөрүүг нөхөн төлүүлснээр дундаж цалин хөлсийг тодорхойлж болно.

6.5.Даатгуулагч (иргэн) нь үндсэн ажлын цагаасаа бусад цагт Хөдөлмөрийн тухай хуулийн 57 дугаар зүйлд заасан зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээний дагуу хэд хэдэн ажил давхар эрхэлж авсан цалин хөлсийг дундаж цалин хөлсөнд оруулах тохиолдолд "Үндсэн ажлаас гадуур гүйцэтгэсэн ажил үйлчилгээний орлогод шимтгэл ногдуулах хуудас"-ыг эсхүл нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааг хавсаргана.

6.6.Даатгуулагч (иргэн)-ийн тэтгэвэр тогтоолгох дундаж цалин хөлсийг тодорхойлох 5 жилийн буюу 60 сарын хугацаанд Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн дагуу шимтгэл нөхөн төлсөн хугацаа орохоор бол уг хугацааны сар бүрийн цалин хөлсийг 420.0 мян.төгрөгөөр тооцож тэтгэвэр тогтоолгох дундаж цалин хөлсийг тодорхойлно.

6.7.Даатгуулагч (иргэн)-ийн тэтгэвэр тогтоолгох дундаж цалин хөлсийг тодорхойлох 5 жилийн буюу 60 сарын хугацаанд Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн дагуу шимтгэл нөхөн төлсөн хугацаа орохоор бол уг хугацааны хөдөлмөрийн хөлсийг тухайн үед мөрдөж байсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцон тэтгэвэр тогтоолгох дундаж цалин хөлсийг тодорхойлно.

6.8.Ажил олгогч нь шимтгэл төлөлтийн тайланд "даатгуулагчийн төрлийн код"-ыг буруу тайлагнасан нь тэтгэврийн даатгалд төлсөн шимтгэлийн хэмжээнд өөрчлөлт орохоргүй бол тухайн даатгуулагчийн төрлийг залруулахгүй.

Санамж[7].Үндсэн ажлын цагаасаа бусад цагт Хөдөлмөрийн тухай хуулийн 57 зүйлд заасан зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээний дагуу хэд хэдэн ажил давхар эрхэлсэн эсхүл тэтгэвэр тогтоолгосны дараа ажил хөдөлмөр эрхэлсэн зэрэг

даатгуулагчийн тухайн сарын цалин хөлсний хэмжээ нь өөрчлөгдөхгүй тохиолдолд уг цалин хөлсийг бүртгэсэн "даатгуулагчийн төрлийн код"-ыг өөрчлөхийг шаардахгүй байж болно.

6.9.Тэтгэвэр тогтоолгох дундаж цалин хөлсийг тодорхойлохдоо Засгийн газрын 2023 оны 238 дугаар тогтоолоор баталсан "Тэтгэвэр бодоход баримтлах цалингийн итгэлцүүр"-ийг хэрэглэнэ.

Санамж[8].Тэтгэвэр бодох сар бүрийн цалинд шинэ итгэлцүүр хэрэглэхдээ сарын цалингийн дээд хэмжээг Засгийн газрын 2023 оны "Итгэлцүүр шинэчлэн тогтоох, тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 238 дугаар тогтоолын 3 дахь хэсэгт заасныг баримтална.

Санамж[9]. Даатгуулагчийн энэ журмын 6.6-д заасны дагуу шимтгэл нөхөн төлсөн хугацааны хөдөлмөрийн хөлс (420.000 төг)-нд Засгийн газрын 2023 оны 238 дугаар тогтоолоор баталсан "Тэтгэвэр бодоход бариmтлах цалингийн итгэлцүүр"-ийг хэрэглэхгүй.

Санамж[10]. Даатгуулагчийн энэ журмын 6.7-д заасны дагуу шимтгэл нөхөн төлсөн хугацааны хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд Засгийн газрын 2023 оны 238 дугаар тогтоолоор баталсан "Тэтгэвэр бодоход бариmтлах цалингийн итгэлцүүр"-ийг хэрэглэнэ.

ДОЛОО.Үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалин хэрэглэх

7.1.Дараах тохиолдолд үндэсний ажил мэргэжлийн жишиг цалин /цаашид "жишиг цалин" гэх/-г үндэслэн даатгуулагчийн тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлсийг тодорхойлно:

7.1.1.Энэ журмын 6.3-т заасны дагуу тэтгэвэр тогтоолгосон иргэний сонгосон нийт онуудын эсхүл зарим саруудын 1995 оноос өмнөх цалин хөлсийг тодорхойлох баримт нь архивын сан хөмрөгт байхгүй, олдохгүй байснаас шалтгаалан сарын дундаж цалин хөлсийг тодорхойлохгүйгээр тэтгэврийг нь тэтгэврийн доод хэмжээгээр тогтоосон бол тэтгэвэр авагчийн хүсэлтийн дагуу жишиг цалинг баримтлан тэтгэврийг нь өөрчлөн тогтоож болно;

7.1.2.Даатгуулагч 1995 оноос өмнө авч байсан цалин хөлсөө сонгон шинээр тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан боловч тухайн сонгосон онуудын нийт эсхүл зарим саруудын цалин хөлсний хэмжээ нь архивын баримтаар нотлогдохгүй, архивын сан хөмрөгт байхгүй, олдохгүй байгаа бол тухайн саруудын цалин хөлсийг жишиг цалингаар орлуулан тооцож болно.

7.2.Тэтгэвэр авагч, даатгуулагч, иргэн Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн дагуу 1995 он хүртэлх хугацааны ажилласан жилээ нөхөн тооцуулсан тохиолдолд түүний тэтгэвэр тогтоолгох цалин хөлсийг тодорхойлоход жишиг цалинг хэрэглэхгүй.

Санамж[11].Даатгуулагч (иргэн) өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар 1990-1994 онд ажил, хөдөлмөр эрхлээгүй буюу эрхлэх боломжгүй байсан хугацаанд

ажилласан жил нь тасарсны улмаас уг хугацааг ажилласнаар нөхөн тооцуулсан бол энэхүү хугацааны дундаж цалин хөлсийг тооцоход жишиг цалинг хэрэглэ хүй.

7.3.Тэтгэврийг нь сарын дундаж цалин хөлсийг үндэслэн тогтоосон тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг жишиг цалинг хэрэглэн дахин өөрчлөн тогтоохгүй.

НАЙМ. Тэтгэвэр тогтоосон дундаж цалин хөлсийг өөрчлөх

8.1.Тэтгэвэр тогтооход баримталсан дундаж цалин хөлсийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1, 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд өөрчлөхгүй. Өөрөөр хэлбэл тэтгэвэр бодуулсан дундаж цалинг өөр онуудын цалингаар солихгүй.

8.2. Дараалсан зургаа, долоон жилийн дундаж цалин хөлснөөс тэтгэвэр бодуулсан тэтгэвэр авагчийн тэтгэврийг тэтгэвэр авагчийн хүсэлтэд үндэслэн нэг удаа өөрчлөн тогтооно. Энэ тохиолдолд тэтгэвэр авагч шимтгэл төлсөн сүүлийн 20 жил доторх дараалсан өөр 5 жилийн шимтгэл төлсөн цалинг сонгож болно.

8.3.Энэ журмын дагуу тэтгэвэр авагчийн тэтгэврийг өөрчлөн тогтоохдоо Засгийн газрын 2023 оны оны 238 дугаар тогтоолоор баталсан "Тэтгэвэр бодоход баримтлах цалингийн итгэлцүүр"-ийг хэрэглэнэ.

ЕС. Хяналт, хариуцлага

9.1.Ажил олгогч нь ажилтан, иргэний энэ журмын 6.2-т заасан цалин хөлсний тодорхойлолтыг санхүүгийн баримтаас үнэн зөв гаргаж тодорхойлох үүрэг хүлээнэ.

9.2.Цалин хөлсний тодорхойлолт, бусад баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсний улмаас тэтгэврийг үндэслэлгүй эсхүл илүү тогтоолгон авсан бол буруутай этгээдээр тэтгэврийг нөхөн төлүүлж холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

9.3.Энэхүү журмын хэрэгжилтэд нийгмийн даатгалын байгууллага болон хуулиар тогтоосон чиг үүргийн бусад байгууллага хяналт тавина.

9.4.Энэ журмыг зөрчсөн тохиолдолд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 09 сарын 11 өдөр Дугаар 75 Улаанбаатар хот

Аргачлал батлах тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 27.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх аргачлал”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Ц.Ганцэцэг)-т, хяналт тавьж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгаланд тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД Л.ЭНХ-АМГАЛАН

ЗГҮТ
Хэрэгжүүлэх
Улаанбаатар 2024.09.19

Засгийн газрын 2024 оны 09 дүгээр
сарын 11-ний өдрийн 75 дугаар
тогтоолын хавсралт

ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГАЧЛАЛ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгон авч буй тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэхэд энэ аргачлалыг мөрдөнө.

Хоёр.Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх

2.1.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 27.1-д заасны дагуу тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж түвшинтэй уялдуулан дараах томьёог ашиглан нэмэгдүүлнэ:

$$Т_i=Т_{i-1}+Т_{i-1}*(ХҮӨТ_{i-1}+(И_{i-2}-ХҮӨТ_{i-2}))$$

$Т_i$-тухайн онд нэмэгдсэн тэтгэврийн хэмжээ;

$Т_{i-1}$-өмнөх оны тэтгэврийн хэмжээ;

$ХҮӨТ_{i-1}$-Монгол Улсын нэгдсэн төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийг баталсан хуулийн төсвийн хүрээний мэдэгдэлд заасан өмнөх оны хэрэглээний үнийн өсөлтийн түвшин;

$ХҮӨТ_{i-2}$-Монгол Улсын нэгдсэн төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийг баталсан хуулийн төсвийн хүрээний мэдэгдэлд заасан 2 жилийн өмнөх хэрэглээний үнийн өсөлтийн түвшин;

$И_{i-2}$-Үндэсний статистикийн хорооноос зарласан 2 жилийн өмнөх инфляцын жилийн дундаж түвшин;

i-тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлж байгаа он.

Тайлбар: Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх томьёоны $(И_{i-2}-ХҮӨТ_{i-2})$ үзүүлэлтийг 2025 онд тэг, 2026 оноос эхлэн өмнөх онд шинээр тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагчдын хувьд тэг байхаар тус тус тооцно.

2.2.Энэ аргачлалын 2.1-д заасны дагуу тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлсэн дүн дээр Зарим иргэний тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасны дагуу олгосон нэмэгдэл (50,000 төгрөг)-ийг нэмж бодно.

2.3.Тэтгэвэр бодох цалинд хэрэглэх итгэлцүүрээр тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ энэ аргачлалд хамаарахгүй.

Гурав.Хяналт, хариуцлага

3.1.Энэ аргачлалын хэрэгжилтэд нийгмийн даатгалын байгууллага, нийгмийн даатгалын болон нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч хяналт тавина.

3.2.Энэ аргачлалыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

----o0o----

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН ЯАМ**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2023.12.28 № 2/6624

танай 2023.12.12-ны № 03/3240-т

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД
Х.БУЛГАНТУЯА ТАНАА

"Журам, маягтын загвар батлах тухай" Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2023 оны А/177, А/433 дугаар тушаалыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзээд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн .....6516..... дугаарт бүртгэж хүргүүлэв.

ДЭД САЙД Б.СОЛОНГОО

Дасгал: Б.2023

15130445

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2023 оны 12 сарын 27-ны өдрийн ... дугаарт бүртгэв.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД,
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ 65/6

2023 оны 12 дүгээр сарын 07-ны өдөр

Дугаар А/177 А/433

Улаанбаатар хот

Журам, маягтын загвар
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэг, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, ”Эмнэлгийн хуудасны маягтын загвар”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэхүү тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Л.Мөнхзул/, эрүүл мэндийн байгууллагад тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Б.Батжаргал), Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж үйлчилгээний газар (А.Өнөржаргал)-т тус тус даалгасугай.

4.Энэхүү тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД

Х.БУЛГАНТУЯА

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

С.ЧИНЗОРИГ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/177 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ДААТГУУЛАГЧИД ЭМНЭЛГИЙН ХУУДАС ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль (шинэчилсэн найруулга), Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-д заасны дагуу даатгуулагч, хүнд эмнэлгийн хуудас олгох, хяналт тавих харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.Эмнэлгийн хуудас бичих, олгох, бүртгэх, хяналт тавих үйл ажиллагааг цаасан болон цахим хэлбэрээр зохион байгуулна.

1.3.Эмнэлгийн хуудас нь нэгдсэн дугаартай байх ба цахим эмнэлгийн хуудасны дугаарыг програмаас шууд олгоно.

1.4.Энэ журмын 2.1-т заасан эрүүл мэндийн байгууллагаас олгосон эмнэлгийн хуудас нь хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгох үндсэн баримт болно.

1.5.Эмнэлгийн хуудсыг эрүүл мэндийн байгууллагын болон улсын бүртгэл, эрүүл мэндийн даатгалын байгууллагын цахим мэдээллийн сангийн бүртгэл, өвчний түүх, амбулаторийн карт, үзлэг, шинжилгээ, оношийн үндэслэл, явцын болон төгсгөлийн дүгнэлт, эрүүл мэндийн байгууллагын эмнэлэг хяналтын комиссын хурлын шийдвэр, үйлдвэрлэлийн ослын акт (зөвхөн үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн тохиолдолд)-ыг тус тус үндэслэн олгоно.

1.6.Эмнэлгийн хуудсыг бичиж, олгож байгаа эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтэн, хяналт, шалгалт хийх эрх бүхий төрийн байгууллагын албан тушаалтан нь авилга, ашиг сонирхлоос ангид байж, эмнэлгийн мэргэжилтний болон төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ажиллана.

Хоёр. Эмнэлгийн хуудас бичих эрүүл мэндийн байгууллага

2.1.Даатгуулагчийн эмнэлгийн хуудсыг эмнэлгийн хуудас бичих эрхтэй дараах төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага (цаашид “эрүүл мэндийн байгууллага” гэх) олгоно. Үүнд:

2.1.1. өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв;

2.1.2. амаржих газар;

2.1.3. нэгдсэн эмнэлэг;

2.1.4. тусгай эмнэлэг;

2.1.5. тусгай мэргэжлийн төв;

2.1.6. төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг;

2.1.7.бүсийн оношилгоо эмчилгээний төв;

2.1.8.уламжлалт анагаах ухааны эмнэлэг;

2.1.9. сувиллын клиник тасаг.

2.2.Ердийн өвчин, ахуйн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөний улмаас энэхүү журмын 2.1-т заасан эрүүл мэндийн байгууллагаас эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан даатгуулагчид хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудсыг дараах байдлаар бичиж олгоно. Үүнд:

2.2.1.ердийн өвчнөөр өвчилсөн, ахуйн осолд өртсөн, жирэмсний 28 долоо хоногоос дотогш хугацаанд амьдрах чадваргүй хүүхэд төрүүлсэн болон Эрүүл мэндийн тухай хуулийн 32.1-д заасан үндэслэлээр үр хөндүүлсэн даатгуулагчид хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудсыг тусламж, үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагаас ажлын 66 өдөр хүртэл хугацаагаар;

2.2.2.мэргэжлээс шалтгаалсан өвчин, хорт хавдар, сүрьеэгээр анх өвчилсөн, бөөрний хүнд хэлбэрийн дутагдал, эрхтэн шилжүүлэн суулгах мэс засалд орсон, эрхтний донор болсон, үйлдвэрлэлийн осол болон хурц хордлогод өртсөн даатгуулагчид хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудсыг мэргэжлээс шалтгаалсан өвчний төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг эсхүл тусламж, үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагаас ажлын 132 өдөр хүртэл хугацаагаар;

2.2.3.гадаад оронд эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан даатгуулагчид тусламж, үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт, эмнэлэг хяналтын комиссын шийдвэрийг үндэслэн түүний байнга оршин суугаа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагаас энэ журмын 2.2.1, 2.2.2-т заасан хугацаагаар;

2.2.4.албан томилолтоор ажиллах эсхүл ээлжийн амралт эдэлж байх хугацаандаа өвчилсөн даатгуулагчид эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагаас амбулаториор ажлын 5 өдрөөс илүүгүй, хэвтэн эмчлүүлсэн болон өдрийн эмчилгээ хийлгэсэн бол тусламж үйлчилгээ үзүүлсэн хугацаагаар;

2.3.Жирэмсэн, амаржсан даатгуулагч эхэд жирэмсэн болон төрөлтийн үеийн эх барихын тусламж, үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагаас дараах байдлаар эмнэлгийн хуудас олгоно. Үүнд:

2.3.1.жирэмсэн, хүүхдээ 196-аас доошгүй хоног тээж төрүүлсэн эх, хүүхдээ 196 хоног хүртэл тээгээгүй боловч амьдрах чадвартай хүүхэд төрүүлсэн эх, хүүхдээ 196-аас доошгүй хоног тээсэн боловч Эрүүл мэндийн тухай хуулийн 32.1-д заасан үндэслэлээр үр хөндүүлсэн даатгуулагч эхэд эх барихын тусламж, үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагаас жирэмсний эмнэлгийн хуудсыг жирэмсний амралт эхэлсэн өдрөөс, амаржсаны эмнэлгийн хуудсыг тухайн эхийн амаржсан өдрөөс эхлэн тус бүр 60 хоног (ихэр бол нийт 140 хоног)-ийн хугацаагаар;

2.3.2.гадаад оронд байгаа жирэмсэн, амаржсан даатгуулагч эхэд жирэмсний болон төрөлтийн үеийн эх барихын тусламж, үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт, эмнэлэг хяналтын комиссын хурлын

шийдвэрийг үндэслэн түүний байнга оршин суугаа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагаас энэ журмын 2.3.1-т заасан хугацаагаар;

2.3.3.төрөх хугацаанаас өмнө амаржсан даатгуулагчид жирэмсний эмнэлгийн хуудсыг хяналтад авсан эрүүл мэндийн байгууллага, амаржсаны эмнэлгийн хуудсыг тухайн даатгуулагчийн амаржсан эрүүл мэндийн байгууллагаас энэ журмын 2.3.1-т заасан хугацаагаар.

2.4.Даатгуулагч эхэд жирэмсний эмнэлгийн хуудас авсан эсэхээс үл хамааран амаржсаны эмнэлгийн хуудсыг олгоно.

Гурав. Эмнэлгийн хуудас олгох хугацаа

3.1.Амбулаториор эмчлүүлсэн даатгуулагчид хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудсыг эмчлэгч эмчийн шийдвэрээр 14 хүртэл хоногоор, хэвтэн эмчлүүлсэн, өдрийн эмчилгээ хийлгэсэн тохиолдолд тусламж, үйлчилгээ үзүүлсэн хоногоор тус тус олгоно.

3.2.Энэ журмын 2.2.1-д заасны дагуу хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудас авч байх хугацаандаа үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хорт хавдар, сүрьеэ анх оношлогдсон, бөөрний хүнд хэлбэрийн дутагдал, эрхтэн шилжүүлэн суулгах мэс засалд орсон, эрхтний донор болсон даатгуулагчид хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудсыг ажлын 132 өдөр хүртэл хугацаагаар үргэлжлүүлэн олгож болно. Энэ тохиолдолд ердийн өвчин, ахуйн ослын шалтгаанаар эмнэлгийн хуудас бичүүлсэн хугацааг ажлын 132 өдрөөс хасаж тооцно.

3.3.Амбулаторийн тусламж, үйлчилгээг 14 хоногоос дээш хугацаагаар үргэлжлүүлэн үзүүлэх шаардлагатай тохиолдолд хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудас олгох хугацааг Эмнэлэг хяналтын комиссын хурлын шийдвэрээр дараах байдлаар сунгана. Үүнд:

3.3.1.энэ журмын 2.2.1-д заасан эмнэлгийн хуудасны хугацааг 14 хүртэл хоногоор;

3.3.2.энэ журмын 2.2.2-т заасан эмнэлгийн хуудасны хугацааг 30 хүртэл хоногоор.

3.4.Эмнэлэг хяналтын комиссгүй алслагдсан сумын эрүүл мэндийн төв нь эмч нарын хамтарсан үзлэгийн шийдвэрээр эмнэлгийн хуудасны хугацааг сунгаж болно.

3.5.Эмчлэгч эмч болон эрүүл мэндийн байгууллагын холбогдох албан тушаалтан нь даатгуулагчийн эмнэлгийн хуудсыг энэ журамд заасан хугацаанд багтаан бичиж, баталгаажуулан, хавсралт мэдээллийн хамт илгээнэ.

Дөрөв. Эмнэлгийн хуудас олгох

4.1.Даатгуулагч эмнэлгийн тусламж, үйлчилгээ авч байх хугацаанд эмнэлгийн хуудас авах эсэх талаар эмчлэгч эмчид мэдэгдэнэ. Эмнэлгийн хуудсыг эмнэлгийн тусламж, үйлчилгээ авч дууссан болон жирэмсний амралт эхэлсэн эсхүл амаржсан өдрөөс хойш доорх хугацаанд багтаан цахимаар эсхүл цаасан хэлбэрээр бичнэ. Үүнд:

үйлчилгээ авч дууссан өдрөөс хойш ажлын 10 өдөрт;

4.1.2.жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудсыг жирэмсний амралт эхэлсэн болон амаржсан өдрөөс хойш хуанлийн 30 хоногт;

4.1.3.энэ журмын 2.2.3, 2.3.2-т заасан даатгуулагчийн эмнэлгийн хуудсыг эмнэлгийн тусламж, үйлчилгээ авч дууссан болон жирэмсний амралт эхэлсэн, амаржсан өдрөөс хойш хуанлийн 60 хоногт.

4.2.Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ журмын 4.1 дэх хэсэгт заасан хугацаа хэтэрсэн тохиолдолд эмнэлгийн хуудас бичих хугацаа дууссан өдрөөс хойш хуанлийн 30 хоногт багтаан энэ журмын 1.5-д заасан болон хүндэтгэн үзэх шалтгааныг нотлох баримт бичиг, эмнэлэг хяналтын комиссын хурлын шийдвэрийг тус тус үндэслэн олгоно.

4.3.Эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага "Цахим эмнэлгийн хуудасны программ"-ыг хамтран ашиглах гэрээ байгуулна. Гэрээнд "Цахим эмнэлгийн хуудасны программ" ашиглах эрх олгох, нууцлалын гэрээ байгуулах, цахим мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээлэл солилцох, хяналт тавих зэргийг тусгасан байна.

4.4.Цахим эмнэлгийн хуудас бичих эрхийг холбогдох программ хөгжүүлэгч байгууллагад нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага олгоно. Эрх олгохдоо эмнэлгийн хуудасны холбогдох мэдээллийг үнэн зөв, бүрэн бөглөж илгээж буй байдал, эмнэлгийн хуудсыг цахимаар хянах боломжийг бүрдүүлсэн эсэх зэрэг мэдээллийг шалгана.

4.5.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэдэх Мэдээллийн технологийн төв нь цахим эмнэлгийн хуудас олгосон жагсаалтын түүхчилсэн архив үүсгэн хадгалах, мэдээллийн аюулгүй байдлыг хариуцан ажиллана.

4.6.Программ хангамж, сүлжээ, техник тоног төхөөрөмжийн саатал, гэмтэл болон холбогдох бусад шалтгааны улмаас эрүүл мэндийн байгууллагаас эмнэлгийн хуудсыг энэхүү журамд заасан хугацаанд багтаан цахимаар илгээх боломжгүй нөхцөл байдал үүссэн талаар программ хөгжүүлэгч байгууллага цахим эмнэлгийн хуудасны програмд мэдээлэл оруулж шийдвэрлүүлнэ.

4.7.Программ хангамж, сүлжээ, техник тоног төхөөрөмжийн саатал, гэмтэл болон эмнэлгийн хуудас цахимаар бичиж олгох боломжгүй бусад нөхцөл байдал үүссэн тохиолдолд эмнэлгийн хуудсыг цаасан хэлбэрээр дараах байдлаар бичнэ. Үүнд:

4.7.1.даатгуулагчийн болон эрүүл мэндийн байгууллагын мэдээллийг хэвлэмэл хуудасны асуумжийн дагуу үнэн зөв, бүрэн бичиж, тэмдэглэх;

4.7.2.оношийг өвчний олон улсын ангиллын кодоор бичих;

4.7.3.эмнэлгийн хуудсыг засваргүй, гаргацтай бичих.

4.8.Эрүүл мэндийн байгууллагын дарга, ерөнхий эмч (захирал, эрхлэгч) эмнэлгийн хуудасны үндэслэлийг шалгаж баталгаажуулна.

4.9.Эрүүл мэндийн байгууллага “Эмнэлгийн хуудас олгосон тухай бүртгэл” хөтлөн харьяа нийгмийн даатгалын байгууллагад сар бүр цахим хэлбэрээр илгээнэ.

4.10.Эмнэлгийн хуудасны мэдээллийг алдаатай, дутуу бичсэн, засварласан, үрэгдүүлсэн бол хүчингүйд тооцно. Уг эмнэлгийн хуудасны дагуу тэтгэмж олгоогүй тухай ажил олгогчийн тодорхойлолтыг үндэслэн эмнэлгийн хуудас анх бичсэн эрүүл мэндийн байгууллага өмнөх эмнэлгийн хуудас бичигдсэн өдрөөс хойш 28 хоногийн дотор дахин олгоно. Нийгмийн даатгалын байгууллага хүчингүйд тооцсон эмнэлгийн хуудсаар тэтгэмж олгосон эсэхийг цахим мэдээллийн сангийн бүртгэлд тулгуурлан хянана.

4.11.Дараах тохиолдолд эмнэлгийн хуудас олгохгүй. Үүнд:

4.11.1.даатгуулагч тухайн эрүүл мэндийн байгууллагаас эмнэлгийн тусламж, үйлчилгээ аваагүй;

4.11.2.даатгуулагч хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэм тогтоосны улмаас тусгаарлагдсан, гоо сайхны мэс засал хийлгэсэн, рашаан сувилалд сувилуулсан;

4.11.3.хүүхэд үрчилж авсан болон тээгч эхээр дамжуулан хүүхэдтэй болсон;

4.11.4.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэг, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсэгт тус тус заасны дагуу хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авч буй даатгуулагчид тухайн тэтгэвэр тогтоолгосон өвчний оношоор.

4.12.Эмнэлгийн хуудсыг тусламж үйлчилгээ үзүүлсэн хугацаанаас илүү хоногоор бичиж олгохгүй бөгөөд энэ журмын 4.13-т зааснаас бусад тохиолдолд урьдчилан бичиж олгохгүй.

4.13.Даатгуулагчид үзүүлж буй эмнэлгийн тусламж, үйлчилгээний дуусах хугацаа амралтын өдөр эсхүл нийтээр амрах баяр ёслолын өдөр таарсан тохиолдолд эмнэлгийн хуудсыг тусламж, үйлчилгээ дуусах хугацааны өмнөх сүүлийн ажлын өдөр бичиж олгож болно.

4.14.Эрүүл мэндийн байгууллага нь магадлагч эмчээс буцаасан эмнэлгийн хуудсыг энэ журмын 4.2-т заасан хугацаанд багтаан дахин илгээнэ.

4.15.Эмнэлгийн хуудас олгох, хяналт тавихдаа улсын бүртгэл, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал, эрүүл мэндийн байгууллагын цахим мэдээллийн сан зэрэгт үндэслэнэ.

4.16.Хэвтэн эмчлүүлсэн болон өдрийн эмчилгээ хийлгэсэн тохиолдолд өвчний түүхийн, амаржсан тохиолдолд төрөлтийн түүхийн дугаарыг “Цахим эмнэлгийн хуудасны програм”-д тус тус бүртгэнэ.

4.17.Хүндэтгэн үзэх шалтгааныг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 2.1.5-д зааснаар ойлгоно.

Тав. Хяналт тавих

5.1.Эмнэлгийн хуудасны бичилт, олголттой холбоотой маргааныг эрүүл мэндийн байгууллага, тэтгэмж олголттой холбоотой маргааныг нийгмийн даатгалын байгууллага тус тус хянан шийдвэрлэнэ.

5.2.Нийгмийн даатгалын байгууллага эмнэлгийн хуудас бичих олгохтой холбоотой асуудлаар даатгуулагч, хүн, аж ахуйн нэгж байгууллагад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах зэрэг бусад холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллана.

5.3.Эрүүл мэндийн байгууллага эмнэлгийн хуудасны бичилт, олголтын үндэслэл, цахим бүртгэл хөтлөлтөд улирал тутамд дотоодын хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч ажиллана.

5.4.Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагын магадлагч эмч эмнэлгийн хуудасны бичилт, олголтод тавих хяналт шалгалтын хуваарийг нийгмийн даатгалын газрын даргаар батлуулан хэрэгжүүлж, тайланг Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлд хагас, бүтэн жилээр хүргүүлнэ.

5.5.Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөл нь энэ журмын 5.4-т заасан тайланг хүлээн авч дүн шинжилгээ хийж, саналыг хөдөлмөр, нийгмийн хамгаллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

5.6.Төв болон орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагын магадлагч эмч эмнэлгийн хуудасны бичилт олголтын үндэслэлд цахим хяналт хийхдээ тэтгэмжийн програмын цахим мэдээллийн сангийн бүртгэлээс дараах шалгууруар түүвэрлэн шалгана. Үүнд:

5.6.1.хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг нэг жилд 3-аас дээш удаа авсан;

5.6.2.хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг 30 хоногоос дээш хугацаагаар авсан;

5.6.3.тэтгэмж олгосон хугацаа давхацсан;

5.6.4.нэг өдөр ижил мөнгөн дүнгээр 2 ба түүнээс дээш удаа тэтгэмж авсан.

5.7.Орон нутгийн өвчлөлийн байдал, төрөлтийн тоо, хүн амын хөдөлгөөн, тэтгэмж авсан даатгуулагчийн тооны өсөлт, бууралт зэрэг нөхцөл байдалтай уялдуулан бусад шалгуур үзүүлэлтийг боловсруулан хяналт шалгалт хийж болно.

Зургаа. Хариуцлага

6.1.Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

....oOo....

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд,
Эрүүл мэндийн сайдын 2023 оны 12 дугаар сарын
...07...-ны өдрийн А/177 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

ЭМНЭЛГИЙН ХУУДАС №

1. QR код: Регистрийн дугаар / Дахин давтагдашгүй дугаар/

2.Ургийн овог:.....Эцэг /эх/-ийн нэр .....Нэр.....

3.Оршин суугаа хаяг:.....аймаг, /нийслэл/.....сум/дүүрэг/..... .....баг/хороо/.....

4.Аж ахуйн нэгж, байгууллагын нэр:.....

5. Хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан: /доогуур нь зурах/	6. Тохирохыг сонгох / доогуур нь зурах/
1.Ердийн өвчин 2.Ахуйн осол 3.Мэргэжлээс шалтгаалах өвчин 4.Үйлдвэрлэлийн осол	1. Жирэмсний 2. Амаржсаны

7.Оношийн шифр /Өвчний олон улсын ангилал-ICD/.....

8. Эмчлүүлсэн/ Чөлөө олгосон/ хугацаа:
Эхэлсэн.....он.....сар.....өдөр Дууссан.....он.....сар.....өдөр

9. Эмчлүүлсэн/ Чөлөө олгосон/ хоног:.....
1. Амбулатороор: ..... 2.Хэвтэн эмчлүүлсэн: .....

10. Эмнэлгийн хуудас олгосон эмнэлгийн нэр.....

Ерөнхий эмч / Эмчийн код/ .... / / (гарын үсэг) (нэр) Баталгаажуулалт	Эмчлэгч эмч /Эмчийн код/..... ..... / / (гарын үсэг) (нэр) Эмнэлгийн хуудас бичсэн 20...он...сар...өдөр

11.Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт:

Эмнэлгийн хуудас хүлээн авсан:
20...он...сар...өдөр
Хянасан:
20...он...сар...өдөр

Тэтгэмж авах эрх үүссэн эсэх: 1.Тийм 2.Үгүй

.....аймаг,(дүүрэг)-ийн Нийгмийн даатгалын газрын магадлагч эмч ...../ / (гарын үсэг) (нэр)

ТЭТГЭМЖИЙН ТООЦОО

	Сар	Ажлын хоног	Тэтгэмж бодох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого	Нэг сарын дундаж хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого	Нэг өдрийн дундаж хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого	Тэтгэмж бодох хувь	Нэг өдөрт ногдох тэтгэмжийн хэмжээ (3*4)	Тэтгэмж олгох хоног			Олговол зохих тэтгэмж (төгрөгөөр)		
								Бүгд (7+8)	Ажил олгогчоос	Нийгмийн даатгалын сангаас	Бүгд (10+11)	Ажил олгогчоос (5х7)	Нийгмийн даатгалын сангаас(5 х 8)
	А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	...-р сар												
2	...-р сар												
3	...-р сар												
4	...-р сар												
5	...-р сар												
6	...-р сар												
7	...-р сар												
8	...-р сар												
9	...-р сар												
10	...-р сар												
11	...-р сар												
12	....-р сар												
13	Дүн												

Даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан хугацаа.....жил.....сарыг тодорхойлсон:

Аж ахуйн нэгж, байгууллагын хүний нөөцийн ажилтан: ..... / /
(гарын үсэг) (нэр

Аж ахуйн нэгж, байгууллагын: Дарга ..... / / (гарын үсэг) (нэр) Баталгаажуулалт: Нягтлан бодогч ..... / / (гарын үсэг) (нэр) 20...оны ....сарын....өдөр	Нийгмийн даатгалын байгууллагын: байцаагч (ажилтан)..... / / (гарын үсэг) (нэр) Баталгаажуулалт: Хянасан байцаагч: ..... / / (гарын үсэг) (нэр) 20..оны ....сарын....өдөр

ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР ТҮР АЛДСАНЫ

ЭМНЭЛГИЙН ХУУДАС №

1. 

QR код:
Регистрийн дугаар
Дахин давтагдашгүй дугаар

2. Ургийн овог:.....Эцэг /эх/-ийн нэр .....Нэр.....
3. Оршин суугаа хаяг:.....аймаг, /нийслэл/.....сум/дүүрэг/.....
.....баг/хороо/.....
4.Аж ахуйн нэгж, байгууллагын нэр:.....
5. Хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан:
1.Ердийн өвчин
2.Ахуйн осол
3.Мэргэжлээс шалтгаалах өвчин
4.Үйлдвэрлэлийн осол
6.Оношийн шифр /Өвчний олон улсын ангилал-ICD/.....
7.Хугацаа:
Эхэлсэн.....он.....сар.....өдөр
Дууссан.....он.....сар.....өдөр
8. Эмчлүүлсэн хоног:.....
1. Амбулатороор:.....
2.Хэвтэн эмчлүүлсэн:.....
9. Эмнэлгийн хуудас олгосон эмнэлгийн нэр.....

Ерөнхий эмч / Эмчийн код/...../ /
(гарын үсэг) (нэр)
Баталгаажуулалт

Эмчлэгч эмч /Эмчийн код/...../ /
(гарын үсэг) (нэр)

Эмнэлгийн хуудас бичсэн 20...он...сар...өдөр

10.Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт:
Эмнэлгийн хуудас хүлээн авсан: 20...он...сар...өдөр
Хянасан: 20...он...сар...өдөр
Тэтгэмж авах эрх үүссэн эсэх: 1.Тийм 2.Үгүй

.....аймаг,(дүүрэг)-ийн Нийгмийн
даатгалын газрын магадлагч эмч...../ /
(гарын үсэг) (нэр)

ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР ТҮР АЛДСАНЫ ТЭТГЭМЖИЙН ТООЦОО

Сар	МД	Хөдөлмөрийн чадвараа түр алдахын өмнөх бүтэн ажилласан 3 сарын		Тэтгэмж бодох		Нэг өдөрт ногдох тэтгэмж (3х4) /төгрөгөөр/	Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгох хоног			Олговол зохих тэтгэмж (төгрөгөөр)		
		Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого	Ажлын хоног	Нэг өдөрт ногдох хөдөлмөрийн хөлс,	Хувь		Бүгд (7+8)	Ажил олгогчоос	Нийгмийн даатгалын сангаас	Бүгд (5х6)	Ажил олгогчоос (5х7)	Нийгмийн даатгалын сангаас(5 х 8)
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
...-р сар	1											
...-р сар	2			х	х	х	х	х	х	х	х	х
....-р сар	3											
Дүн (1+2+3)	4											
Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) хянасан дүн	5											

Даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан хугацаа.....жил.....сарыг тодорхойлсон:

Аж ахуйн нэгж, байгууллагын хүний нөөцийн ажилтан:...../ /

Аж ахуйн нэгж, байгууллагын: Нийгмийн даатгалын байгууллагын:

Дарга...../ / байцаагч (ажилтан)...../ / (гарын үсэг) (нэр)
(гарын үсэг) (нэр)

Баталгаажуулалт: Баталгаажуулалт:

Нягтлан бодогч...../ / Хянасан байцаагч:...../ /

(гарын үсэг) (нэр) (гарын үсэг) (нэр)

20...оны ....сарын....өдөр 20..оны ....сарын....өдөр

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2023 оны 12 сарын 04 өдөр Дугаар 08. Улаанбаатар хот

Тэтгэмжийн хэмжээ тогтоох тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэгт заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1. Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг 2 000 000 /хоёр сая/ төгрөгөөр тогтоосугай.

2. Амьгүй донор болж эс, эд, эрхтнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг 3 500 000 /гурван сая таван зуун мянга/ төгрөгөөр тогтоосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба /Г.Банзрагч/-нд үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн “Оршуулгын тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 04 дүгээр тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

5. Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ДАРГА Х.БУЛГАНТУЯА

1119276367
5284708 СБА1473

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 13 өдөр Дугаар 438 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 15.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Даатгуулагч тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэмж олгох журам”-ыг хавсралт ёсоор батлсугай.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяад, хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Л.Мөнхзул)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД Х.БУЛГАНТУЯА

Засгийн газрын 2023 оны 12 дугаар
сарын 13 -ны өдрийн 438 дугаар
тогтоолын хавсралт

ДААТГУУЛАГЧ ТЭТГЭМЖ АВАХАД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ, ТЭТГЭМЖ ОЛГОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмаар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-д заасны дагуу хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох болон ажилгүйдлийн тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, даатгуулагчид тэтгэмж олгох харилцааг зохицуулна.

Хоёр.Тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичиг

2.1.Нийгмийн даатгалд сайн дурын хэлбэрээр даатгуулсан даатгуулагч ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдсан бол хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авахад эрүүл мэндийн байгууллагаас олгосон эмнэлгийн хуудсыг цаасан, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлнэ.

2.2.Нийгмийн даатгалд албан журмын хэлбэрээр даатгуулсан даатгуулагч ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдсан бол ажил олгогч дараах баримт бичгийг цаасан, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлнэ:

2.2.1.эрүүл мэндийн байгууллагаас олгосон эмнэлгийн хуудас;

2.2.2.тэтгэмж авах даатгуулагчийн мэдээлэл (овог, нэр, регистр, банкин дахь дансны дугаар).

2.3.Даатгуулагч жирэмсний болон амаржсаны тэтгэмж авахад эрүүл мэндийн байгууллагаас олгосон эмнэлгийн хуудсыг цаасан, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлнэ.

2.4.Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж авахад дараах баримт бичгийг цаасан, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлнэ:

2.4.1.даатгуулагчийн нас барсны гэрчилгээний хуулбар, эсхүл эрх бүхий байгууллагын лавлагаа, шүүхийн шийдвэр;

2.4.2. гэр бүлийн гишүүний иргэний үнэмлэхийн хуулбар, эсхүл эрх бүхий байгууллагын лавлагаа;

2.4.3.амьгүй донор болсон тухай эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт.

2.5.Даатгуулагч ажилгүйдлийн тэтгэмж авахад дараах баримт бичгийг цаасан, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлнэ:

2.5.1.даатгуулагчийг ажлаас чөлөөлсөн тухай ажил олгогчийн шийдвэр, шийдвэрт хамаарах хугацаа нь дуусгавар болж буй ажил гүйцэтгэх гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ болон эдгээртэй адилтгах бусад гэрээний хамт;

2.5.2.хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагад бүртгүүлсэн тухай тодорхойлолт.

2.6.Даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах бол энэ журмын 2.1, 2.3-т заасан баримт бичгийг өргөдлийн хамт нийгмийн даатгалын байгууллагад цаасан, эсхүл цахим хэлбэрээр эмнэлгийн хуудас авснаас хойш 4 долоо хоногийн дотор, хүндэтгэн үзэх шалтгаантай бол 6 сарын дотор хүсэлт гаргана.

2.7.Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж авах бол энэ журмын 2.4-т заасан баримт бичгийг өргөдлийн хамт нийгмийн даатгалын байгууллагад цаасан, эсхүл цахим хэлбэрээр даатгуулагчийг нас барснаас хойш 6 долоо хоногийн дотор, хэрэв хүндэтгэн үзэх шалтгаантай бол 6 сарын дотор хүсэлт гаргана.

2.8.Даатгуулагч ажилгүйдлийн тэтгэмж авах бол энэ журмын 2.5-д заасан баримт бичгийг өргөдлийн хамт нийгмийн даатгалын байгууллагад цаасан, эсхүл цахим хэлбэрээр ажлаас чөлөөлсөн тухай ажил олгогчийн шийдвэр гарсан өдрөөс хойш 4 долоо хоногийн дотор, хүндэтгэн үзэх шалтгаантай бол 3 сарын дотор хүсэлт гаргана.

2.9.Ажил олгогч энэ журмын 2.2-т заасан баримт бичгийг өргөдлийн хамт нийгмийн даатгалын байгууллагад цаасан, эсхүл цахим хэлбэрээр эмнэлгийн хуудас авснаас хойш 4 долоо хоногийн дотор хянаж хүргүүлнэ.

2.10.Энэ журмын 2.6, 2.7, 2.8, 2.9-д заасан хүндэтгэн үзэх шалтгаан гэж Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 2.1.5-д заасныг ойлгоно.

2.11.Ажил олгогч, даатгуулагч тэтгэмж авах цахим өргөдөл, баримт бичгийг нийгмийн даатгалын байгууллагад холбогдох цахим системээр илгээнэ.

2.12.Нийгмийн даатгалын байгууллага даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээллийг нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санг үндэслэн, энэ журмын 2.4.1-д заасан даатгуулагчийн нас барсны гэрчилгээ, 2.5.2-т заасан хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагад бүртгүүлсэн тухай тодорхойлолтыг холбогдох байгууллагын мэдээллийн санд үндэслэн тодорхойлно.

Гурав.Хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд тэтгэмж олгох

3.1.Нийгмийн даатгалын байгууллага даатгуулагчаас, энэ журмын 2.1, 2.3-т заасан баримт бичгийг хүлээж авснаас хойш 14 хоногийн дотор шийдвэрлэж, даатгуулагчийн арилжааны банкин дахь дансаар дамжуулан олгоно.

3.2.Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийг нийгмийн даатгалын байгууллага энэ журмын 2.4-т заасан баримт бичгийг хүлээж авснаас хойш 24 цагийн дотор шийдвэрлэж, гэр бүлийн гишүүнд арилжааны банкин дахь дансаар дамжуулан олгоно.

3.3.Даатгуулагчид ажил олгогчоос олгох хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийг ажил олгогч, нийгмийн даатгалын сангаас олгох хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийг нийгмийн даатгалын байгууллага даатгуулагчид арилжааны банкин дахь дансаар дамжуулан олгоно.

3.4.Даатгуулагч жирэмсний болон амаржсаны тэтгэмж авахад нийгмийн даатгалын байгууллагад дахин хүсэлт гаргахгүй, эрүүл мэндийн байгууллагаас олгосон эмнэлгийн хуудсыг үндэслэн олгоно.

3.5.Даатгуулагчид хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон өвчний оношоор хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгохгүй.

3.6.Энэ журмын 2.6, 2.7, 2.8, 2.9-д заасан хугацаа хэтэрсэн тохиолдолд даатгуулагчид тэтгэмж олгохгүй.

Дөрөв.Ажилгүйдлийн тэтгэмж олгох

4.1.Нийгмийн даатгалын байгууллага энэ журмын 2.5-д заасан баримт бичгийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шийдвэрлэж, даатгуулагчийн арилжааны банкин дахь дансаар дамжуулан сар бүр олгоно.

4.2.Үндсэн ажлаас гадуур байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу давхар ажил эрхэлж байгаа даатгуулагчид зөвхөн үндсэн ажлаасаа халагдсан тохиолдолд ажилгүйдлийн тэтгэмж олгоно.

4.3.Даатгуулагч ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа ажилд орсон боловч анх тэтгэмж олгохоор тогтоосон хугацаа дуусахаас өмнө ажлаас халагдсан тохиолдолд түүнд үлдэх хугацаанд ногдох тэтгэмжийг урьд авч байсан хэмжээгээр нь үргэлжлүүлэн ажлын 76 өдөр дуустал хугацаанд олгоно.

4.4.Даатгуулагч нь ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа ажилд орсон бол нийгмийн даатгалын байгууллагад мэдэгдэж, тэтгэмж олголтыг зогсооно.

4.5.Даатгуулагч үндсэн ажлаас халагдсаны дараагийн өдрөөс эхлэн давхар ажиллаж байгаа аль нэг байгууллагын үндсэн даатгуулагчаар шилжин шимтгэл төлж, ажилласан тохиолдолд түүнд ажилгүйдлийн тэтгэмж олгохгүй.

Тав.Бусад

5.1.Нийгмийн даатгалын байгууллага даатгуулагчид тэтгэмжийн хэмжээ, олгох хугацаа, олгосон дүн зэрэг мэдээллийг цахим үйлчилгээний нэгдсэн систем, даатгуулагчийн веб систем, нийгмийн даатгалын аппликейшн зэрэг системээр цахимаар хүргэнэ.

5.2.Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

----o0o----

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2024 оны 09 сарын 06 өдөр Дугаар 06 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэг, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Ажил олгогчид ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх журам"-ыг нэгдүгээр хавсралтаар, "Ажил олгогчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, хяналт тавих журам"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус батлалсугай.

2.Тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Ц.Ганцэцэг)-т даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба (Г.Банзрагч)-нд үүрэг болгосугай.

4.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан "Журам шинэчлэн батлах тухай" Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2011 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 16 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Л.ЭНХ-АМГАЛАН

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн
2024 оны 09 дугаар сарын 06-ны өдрийн
06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

АЖИЛ ОЛГОГЧИД АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ХӨНГӨЛӨЛТ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмаар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 13 дугаар зүйлд заасны дагуу ажил олгогчид шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулна.

Хоёр.Шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх ажил олгогчийг тодорхойлох

2.1.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт /цаашид "шимтгэлийн хөнгөлөлт" гэх/ үзүүлэх дараах шалгуур хангасан ажил олгогчийн мэдээллийг нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд үндэслэн гаргана. Үүнд:

2.1.1.ажил олгогч тухайн сарын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасан хугацаанд ирүүлсэн байх;

2.1.2.ажил олгогчийн цалин хөлсний санд ногдуулсан нийгмийн даатгалын шимтгэлийг Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 32 дугаар зүйлийн 32.2.2 дахь заалтад заасан хугацаанд төлсөн байх;

2.1.3.тухайн ажил олгогчид ажиллаж буй даатгуулагч 3 жил дараалан ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж гаргуулаагүй байх.

2.2.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ журмын 2.1-д заасан ажил олгогчийн мэдээллийг аймаг, дүүрэг бүрээр гарган аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газарт хүргүүлнэ.

2.3.Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.34 дэх заалтад заасан байгууллагад шимтгэлийн хөнгөлөлт хамаарахгүй.

Гурав.Шимтгэлийн хөнгөлөлтийн хэмжээг тооцох, хөнгөлөлт үзүүлэх

3.1.Энэ журмын 2.1-д заасан ажил олгогчид үзүүлэх шимтгэлийн хөнгөлөлтийн хэмжээг тухайн ажил олгогчийн сүүлийн жилд төлсөн нийт ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн 15 хувиар тооцож баталгаажуулан, дараагийн жилд төлөх шимтгэлээс нь хасаж тооцно.

3.2.Ажил олгогчид шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэхээр тооцсон нийт шимтгэлийг дараа оны 1-12 сард ногдох хэмжээгээр нь хуваарилан тооцож, тухайн ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн сар бүрийн тайланд тусгана.

3.3.Шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх ажил олгогчийг мэдээллээр хангах, олон нийтэд сурталчлах ажлыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газар хариуцан зохион байгуулна.

3.4.Шимтгэлийн хөнгөлөлтөд хамрагдсан ажил олгогчид Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт заасан нөхцлийг хангасан тохиолдолд дахин шимтгэлийн хөнгөлөлт үзүүлнэ.

Дөрөв.Шимтгэлийн хөнгөлөлтийг бүртгэх, тайлагнах

4.1.Ажил олгогчид үзүүлсэн шимтгэлийн хөнгөлөлтийн хэмжээг ажил олгогч тус бүрээр нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

4.2.Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газар нь ажил олгогчид шимтгэлийн хөнгөлөлт үзүүлсэн тооцоо, ажлын тайланг хагас жил тутам Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлж, тооцоо нийлнэ.

Тав.Хяналт тавих

5.1.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газар ажил олгогчийг ажилгүйдлийн даатгалын шимтгэлээс хөнгөлөх, бүртгэх, ногдуулалт хийх, тайлагнах үйл ажиллагаанд хяналт тавина.

Зургаа.Бусад

6.1.Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн
2024 оны 09 дугаар сарын 06-ны өдрийн
06 дугаар тогтоолын хөёрдугаар хавсралт

АЖИЛ ОЛГОГЧИД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ХӨНГӨЛӨЛТ, ЧӨЛӨӨЛӨЛТ ҮЗҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмаар Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 15 дугаар зүйлд заасны дагуу ажил олгогчид шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулна.

Хоёр.Шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх ажил олгогчийг тодорхойлох

2.1.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх дараах шалгуур хангасан ажил олгогчийн мэдээллийг гаргана.

2.1.1.ажил олгогч тухайн сарын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасан хугацаанд ирүүлсэн байх;

2.1.2.ажил олгогчийн цалин хөлсний санд ногдуулсан нийгмийн даатгалын шимтгэлийг Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 32 дугаар зүйлийн 32.2.2 дахь заалтад заасан хугацаанд төлсөн байх;

2.1.3.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр гаргуулаагүй байх;

2.1.4.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, шинэ техник, технологи, инновац нэвтрүүлэхэд хөрөнгө оруулсан, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний тайлан, түүнд үндэслэн эрсдэлийг арилгасан талаар баримтыг хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар эрх бүхий байгууллагаас шийдвэр гаргуулсан байх.

2.2.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь шимтгэлийн чөлөөлөлт үзүүлэх дараах шалгуур хангасан ажил олгогчийн мэдээллийг дараах байдлаар гаргана. Үүнд:

2.2.1.энэ журмын 2.1-д заасныг хангасан;

2.2.2.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас сул зогссон болон хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон ажилтныг тохирох ажлын байраар хангасан.

2.3.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ журмын 2.1, 2.2-т заасан ажил олгогчийн мэдээллийг аймаг, дүүрэг бүрээр гарган аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газарт хүргүүлнэ.

2.4.Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.34 дэх заалтад заасан байгууллагад шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт хамаарахгүй.

Гурав.Шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэмжээг тооцох, хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх

3.1.Энэ журмын 2.1-д заасан ажил олгогчид үзүүлэх шимтгэлийн хөнгөлөлтийн хэмжээг тухайн ажил олгогчийн сүүлийн жилд төлсөн нийт үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн 15 хувиар тооцож баталгаажуулан, дараагийн жилд төлөх шимтгэлээс нь хасаж тооцно.

3.2.Энэ журмын 2.2-т заасан ажил олгогчид үзүүлэх шимтгэлийн чөлөөлөлтийн хэмжээг тохирсон ажлын байраар хангагдсан ажилтны цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос ажил олгогчоос хариуцан төлөх шимтгэлийг 12 хүртэлх сарын хугацаанд чөлөөлнө.

3.3.Үйлдвэрлэлийн ослын улмаас учирсан хохирлыг арилгах, хэвийн үйл ажиллагааг сэргээх зорилгоор сул зогссон бол даатгуулагчийн зөвхөн сул зогссон ажлын байранд ажилладаг даатгуулагчийн сул зогссон хугацааны үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг чөлөөлнө.

3.4.Ажил олгогчид шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэхээр тооцсон нийт шимтгэлийн хэмжээг сар тутамд ногдох хэмжээгээр тооцож, тухайн ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн сарын тайланд тусгана.

3.5.Шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх ажил олгогчийг мэдээллээр хангах, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх тухай мэдэгдэх, олон нийтэд сурталчлах үйл ажиллагааг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцан зохион байгуулна.

3.6.Шимтгэлийн хөнгөлөлтөд хамрагдсан ажил олгогчид Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт заасан нөхцөл болзлыг үргэлжлүүлэн хангасан тохиолдолд дахин шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлнэ.

3.7.Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг буруу тооцсон ажил олгогч шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдахгүй бөгөөд шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн нийт хэмжээ нь тухайн жилд ажил олгогчийн төлөх үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн 50 хувиас хэтрэхгүй байна.

Дөрөв.Шимтгэлийн хөнгөлөлтийг бүртгэх, тайлагнах

4.1.Ажил олгогчид үзүүлсэн шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэмжээг ажил олгогч тус бүрээр нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

4.2.Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газар нь ажил олгогчид шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлсэн тооцоо, ажлын тайланг хагас жил тутамд Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлж, тооцоо нийлнэ.

Тав.Хяналт тавих

5.1.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газар ажил олгогчийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын шимтгэлээс хөнгөлөх, чөлөөлөх, бүртгэх, ногдуулах, тайлагнах үйл ажиллагаанд хяналт тавина.

Зургаа.Бусад

6.1. Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД
Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024.02.16 № 1/718

танай 2024.01.05 -ны № 01/40 -т

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА
Л.МӨНХЗУЛ ТАНАА

Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзээд “Журам батлах тухай” Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/190 дүгээр тушаалыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн ....6641... дугаарт, “Журам батлах тухай” 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/194 дүгээр тушаалыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн ...6642... дугаарт тус тус бүртгэж хүргүүлэв.

Б.ЭНХБАЯР

151600519

Doc.yam a5.2024

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 12 дугаар сарын 28 Дугаар А/194 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн бүрдэлд хяналт тавих журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Ажилгүйдлийн тэтгэмж авах өргөдлийн маягт (цахим)”-ыг хоёрдугаар хавсралтаар, “Ажилгүйдлийн тэтгэмж авах өргөдлийн маягт (цаасан)”-ыг гуравдугаар хавсралтаар, “Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах өргөдлийн маягт (цахим)”-ыг дөрөвдүгээр хавсралтаар, “Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах өргөдлийн маягт (цаасан)”-ыг тавдугаар хавсралтаар, “Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах өргөдлийн маягт (цахим)”-ыг зургаадугаар хавсралтаар, “Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах өргөдлийн маягт (цаасан)”-ыг долоодугаар хавсралтаар, “Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн өргөдлийн маягт”-ыг наймдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Батлагдсан журмыг мөрдөж ажиллахыг аймаг (нийслэл), дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Бодлогын хэрэгжилт, судалгааны газар (Ц.Ганцэцэг)-т тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудит, мониторингийн газар /Б.Ганхуяг/-т даалгасугай.

ДАРГА Л.МӨНХЗУЛ

1523010931

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

ТЭТГЭМЖ АВАХАД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН БҮРДЭЛД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Баримт бичгийн дугаар: ЖРМ-ДАМГ-2023

Батлсан: Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.МӨНХЗУЛ

Хянасан: Дотоод аудит, мониторингийн газрын дарга Б.ГАНХУЯГ

Боловсруулсан: Дотоод аудит, мониторингийн газрын мэргэжилтэн Н.БОЛОРМАА

Эх хувь	Дардас
Хяналттай хувь	
Хуулбар хувь	
Хүчингүй хувь	
Хяналтгүй хувь	

АГУУЛГА

1. Нийтлэг үндэслэл
2. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах баримт бичгийг хүлээн авах, хянах
3. Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн баримт бичгийг хүлээн авах, хянах
4. Ажилгүйдлийн тэтгэмж олгох баримт бичгийг хүлээн авах, хянах
5. Бусад зохицуулалт
6. Хариуцлага

--- oOo ---

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
2023 оны 12 дугаар сарын 28 ны өдрийн А/194
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ТЭТГЭМЖ АВАХАД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН БҮРДЭЛД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд заасны дагуу ажил олгогч, даатгуулагч, иргэн тэтгэмж авах баримт бичгийг хуульд заасан хугацаанд цаасан, эсхүл цахим хэлбэрээр нийгмийн даатгалын байгууллагад ирүүлсэн хугацаа болон баримт бичгийг хүлээн авч хянан баталгаажуулах харилцааг зохицуулна.

Хоёр. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах баримт бичгийг хүлээн авах, хянах

2.1. Ажил олгогч, даатгуулагч, иргэн тэтгэмж авах баримт бичгийг хуульд заасан хугацаанд харилцагч нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)-д (цаашид "байцаагч" гэх) цаасан, эсхүл цахим хэлбэрээр ирүүлнэ.

2.2. Нийгмийн даатгалын байцаагч ажил олгогч, даатгуулагч, эрүүл мэндийн байгууллагаас цахимаар илгээсэн, эсхүл цаасаар ирүүлсэн эмнэлгийн хуудас, тэтгэмж авах баримт бичгийг дараах байдлаар хүлээн авч хяналт тавина. Үүнд:

2.2.1. Ажил хөдөлмөр эрхэлж байгаа даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж тооцуулах бол ажил олгогч нь тэтгэмж авах даатгуулагчийн жагсаалт (нэхэмжлэх)-ыг цахимаар илгээсэн, эсхүл цаасаар ирүүлсэн эсэхэд;

2.2.2. Ажил хөдөлмөр эрхэлж байгаа даатгуулагч жирэмсний болон амаржсаны тэтгэмж, сайн дурын даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны тэтгэмж тооцуулах бол өргөдлийн мэдээллийг бүрэн бичиж цахимаар илгээсэн, эсхүл цаасаар ирүүлсэн эсэхэд;

2.3. Ажил олгогч нь тэтгэмж авах жагсаалт (нэхэмжлэх)-ыг цахимаар, эсхүл гарын үсэг, тамга, тэмдгээр баталгаажуулан цаасаар Нийгмийн даатгалын байгууллагад ирүүлнэ.

2.4. Ажил олгогч нь даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн

хуудасны холбогдох хэсэгт заасан тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн жил, сар, тэтгэмж тогтоох цалин хөлс, түүнтэй адилтгах орлого (цаашид "цалин хөлс" гэх)-ыг тодорхойлно.

2.5. Ажил олгогч, даатгуулагчийн тэтгэмж авах баримт бичгийг ирүүлсэн хугацааг цаасан, эсхүл цахим хэлбэрээр бичиж илгээсэн он, сар, өдрөөр, эмнэлгийн хуудас бичиж олгосон хугацааг эрүүл мэндийн байгууллагаас нийгмийн даатгалын байгууллагад цаасан, эсхүл цахим хэлбэрээр бичиж илгээсэн он, сар, өдрөөр тооцно.

2.6. Магадлагч эмч нь даатгуулагчид эмнэлгийн байгууллагаас цаасан, эсхүл цахим хэлбэрээр бичиж илгээсэн эмнэлгийн хуудасны үндэслэлийг хянаж, баталгаажуулан нийгмийн даатгалын байцаагчид шилжүүлнэ.

Санамж[1]: Шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн байгууллагын цахим бүртгэл, өвчний түүх, төрөлтийн түүх, иргэний амбулаторийн карт, үзлэг, шинжилгээний дүгнэлт, оношийн үндэслэл, явцын болон төгсгөлийн дүгнэлт, Эмнэлэг хяналтын комиссын хурлын шийдвэр, Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэсэн акт болон холбогдох бусад баримт бичгийг шалгана.

Санамж[2]: Эмнэлгийн хуудас алдаатай буруу бичигдсэн бол шалтгааныг тодорхой бичиж ажил олгогч, даатгуулагч, эрүүл мэндийн байгууллагад буцаана.

2.7. Нийгмийн даатгалын байцаагч ажил хөдөлмөр эрхэлж байгаа даатгуулагчийн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг, мөн сайн дурын даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны тэтгэмж тооцох цалин хөлс, шимтгэл төлсөн хугацаа, тэтгэмж тооцох хувийг нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд үндэслэн хянаж тодорхойлно.

Санамж[3]: Шаардлагатай тохиолдолд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээллийг үндсэн баримт бичигтэй тулган шалгана.

2.8. Нийгмийн даатгалын байцаагч тэтгэмж авах ажил олгогч, даатгуулагчийн мэдээллийг ажил олгогчийн бүртгэлийн, даатгуулагчийн иргэний бүртгэлийн дугаараар мэдээллийн санд бүртгэнэ.

2.9. Нийгмийн даатгалын байцаагч тэтгэмж авах эрх үүсээгүй, эсхүл мэдээлэл нь нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сантай зөрсөн бол шалтгааныг тодорхой бичиж тухайн ажлын өдөрт нь ажил олгогч, даатгуулагчид мэдэгдэнэ.

2.10. Нийгмийн даатгалын байцаагч тэтгэмж олгох даатгуулагчийн жагсаалтыг үйлдэж хяналт шалгалтын байцаагчаар хянуулан, харьяалах нэгжийн даргаар

баталгаажуулна.

2.11. Нийгмийн даатгалын байцаагч ажил олгогчоос цаасан хэлбэрээр ирүүлсэн тэтгэмж авах баримт бичгийг хянуулж, баталгаажуулсаны дараа баримт бичгийн нэг хувийг ажил олгогчид буцаан олгоно.

2.12. Нийгмийн даатгалын байцаагч ажил олгогчоос цахим хэлбэрээр илгээсэн тэтгэмж олгох жагсаалт (нэхэмжлэх)-ыг хянуулж, баталгаажуулсны дараа ажил олгогчид цахимаар хүргүүлнэ.

2.13. Сангийн нягтлан бодогч нь тэтгэмж олгох жагсаалт (нэхэмжлэх)-ыг мэдээллийн санд бүртгэгдсэн мэдээлэлтэй тулган хянаж, зөрчилгүй тохиолдолд жагсаалтыг ахлах нягтлан бодогч, хэлтсийн даргаар хянуулж албажуулна.

Гурав. Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн баримт бичгийг хүлээн авах, хянах

3.1. Нийгмийн даатгалын байгууллага нас барсан иргэний гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн өргөдөл, холбогдох баримт бичгийг хүлээн авч хяналт тавина.

3.2. Нийгмийн даатгалын байгууллага Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд заасан нас барсан иргэний гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийг гэр бүлийн гишүүн болох баримт бичгийг үндэслэн олгоно.

3.3. Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийг энэ журмын 3.2 дахь хэсэгт заасан баримт бичгийг үндэслэн дараах иргэнд олгоно. Үүнд:

3.3.1. Гэр бүлийн тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэн;

3.3.2. Ганц бие, төрлийн болон садангийн хүн байхгүй иргэний хувьд хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч;

3.4. Нийгмийн даатгалын байцаагч тэтгэмж авах баримт бичгийг дараах байдлаар хянаж, албажуулна. Үүнд:

3.4.1. Ажилласан жил, шимтгэл төлсөн хугацаа, мөн тэтгэвэр авагч эсэхийг нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сан болон холбогдох баримт бичгийг үндэслэн хянаж тодорхойлно.

3.4.2. Шаардлагатай тохиолдолд тушаал шийдвэр, архивын баримтын лавлагаа, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээллийг үндсэн баримт бичигтэй тулган шалгана.

3.5. Нийгмийн даатгалын байцаагч тэтгэмж шилжүүлж авах иргэн болон нас барсан иргэний мэдээллийг иргэний бүртгэлийн дугаараар мэдээллийн санд бүртгэнэ.

3.6. Нийгмийн даатгалын байцаагч тэтгэмж олгох даатгуулагчийн жагсаалтыг үйлдэж хяналт шалгалтын байцаагчаар хянуулан, харьяалах нэгжийн даргаар баталгаажуулна.

3.7. Шалгаж баталгаажуулсан баримт бичиг, тэтгэмж олгох жагсаалтыг энэ журмын 2.13-д заасны дагуу хянаж, албажуулна.

3.8. Амьгүй донор болж эс, эд эрхтэнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд тэтгэмж олгоход тэтгэмж авах эрх үүссэн эсэхийг хянаж, Эрүүл мэндийн сайдын баталсан маягтын дагуу олгосон "Даатгуулагчийн донор болж, эс, эд, эрхтэнээ бусдад шилжүүлэхээр болсон талаарх тодорхойлолт"-ыг үндэслэнэ.

3.9. Нийслэлийн нэг цэгийн үйлчилгээний нэгдсэн төвөөр дамжуулан тэтгэмж авах баримт бичгийг хүлээн авсан бол тэтгэмж авах эрх үүссэн эсэхийг мэдээллийн нэгдсэн санд үндэслэн хянаж, тэтгэмжийг олгоно.

Санамж[4]: Нас барсан иргэний гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийг харьяалал харгалзахгүй олгож болно.

Дөрөв. Ажилгүйдлийн тэтгэмж олгох баримт бичгийг хүлээн авах, хянах

4.1. Нийгмийн даатгалын байгууллага даатгуулагчийн ажилгүйдлийн тэтгэмж авах баримт бичгийг цаасан, эсхүл цахим хэлбэрээр хүлээн авч хяналт тавина.

4.2. Нийгмийн даатгалын байцаагч даатгуулагчийн ажилгүйдлийн даатгалын шимтгэл төлсөн жил, сарыг тодорхойлон эрх үүссэн эсэхийг шалгаж, холбогдох мэдээллийг мэдээллийн санд бүртгэнэ.

4.3. Нийгмийн даатгалын байцаагч ажилгүйдлийн тэтгэмж тооцох цалин хөлсийг мэдээллийн нэгдсэн санд үндэслэн хянаж тодорхойлно.

4.4. Нийгмийн даатгалын байцаагч даатгуулагчийн ажил хөдөлмөр идэвхитэй хайж байгаагаа хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагад бүртгүүлсэн эсэхэд хяналт тавина.

4.5. Нийгмийн даатгалын байцаагч тэтгэмж олгох даатгуулагчийн жагсаалтыг үйлдэж хяналт шалгалтын байцаагчаар хянуулан, харьяалах нэгжийн даргаар баталгаажуулна.

4.6. Сангийн нягтлан бодогч тэтгэмж олгох жагсаалтыг мэдээллийн санд бүртгэгдсэн мэдээлэлтэй тулган хянаж, зөрчилгүй тохиолдолд жагсаалтыг ахлах нягтлан бодогч, хэлтсийн даргаар хянуулан албажуулна.

4.7. Нийгмийн даатгалын байцаагч даатгуулагчид олгосон тэтгэмжийг сар бүр тулган хянаж, тэтгэмжийн олголтыг түүний хувийн хэрэгт тэмдэглэнэ.

4.8. Нийгмийн даатгалын байцаагч нь даатгуулагч тэтгэмж авч байх хугацаандаа ажилд орсон боловч тэтгэмж олгоход тогтоосон хугацаа дуусгавар болохоос өмнө ажлаас халагдсан бол ажил олгогчийн шийдвэр, өмнөх баримт бичгийг хянан, тэтгэмж олгох эсэхийг шийдвэрлэнэ.

4.9. Нийгмийн даатгалын байцаагч даатгуулагчийн ажилгүйдлийн тэтгэмж олголтыг зогсоох үндэслэл тогтоогдвол тэтгэмжийг зогсоож, тооцоо нийлнэ.

4.10. Нийгмийн даатгалын байцаагч цахим өргөдлийг хүлээн авч мэдээлэл зөрсөн, эсхүл эрх үүсээгүй тохиолдолд шалтгааныг тодорхой бичиж тухайн ажлын өдөрт багтаан даатгуулагчид мэдэгдэнэ.

Тав. Бусад зохицуулалт

5.1. Нийгмийн даатгалын байгууллага нь олгох тэтгэмжийн хэмжээ, хугацааны мэдээллийг ажил олгогч, даатгуулагч харах боломжийг бүрдүүлнэ.

5.2. Нийгмийн даатгалын байгууллага нь тэтгэмж авах даатгуулагч, иргэний төрд байгаа мэдээллийг түүний зөвшөөрлөөр авна.

5.3. Даатгуулагч тэтгэмж авах өргөдлийг цахимаар болон биечлэн ирж гаргах боломжгүй тохиолдолд түүний гэр бүлийн гишүүн, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь өргөдлийг нийгмийн даатгалын байгууллагад гаргаж болно.

5.4. Нийгмийн даатгалын байгууллага нь даатгуулагчийн тэтгэмж авах баримт бичгийн мэдээлэл зөрсөн, даатгуулагчаас үл хамаарах шалтгаанаар баримт бичиг ирүүлэх хуулийн хугацаа хоцорсон талаарх баримт бичгийг үндэслэн хянан шалгах, мөн эрх бүхий байгууллагаар шалгуулах эрхтэй.

5.5. Энэ журамд баримтлахаар тусгагдсан холбогдох хуулийн зүйл, заалт, дүрэм, журам, заавар шинэчлэгдсэн, нэмэлт, өөрчлөлт орсон тохиолдолд шинэчлэгдсэн, нэмэлт, өөрчлөлт орсон хуулийн зүйл, заалт, дүрэм, журам, зааврыг баримтална.

Зургаа. Хариуцлага

6.1. Энэ журмыг зөрчсөн албан тушаалтан, даатгуулагч, ажил олгогчид холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--- oOo ---

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
2023 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн А/194
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Маягт АЖТ-1

АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖ АВАХ ӨРГӨДӨЛ
/цахимаар/

1. Даатгуулагчийн мэдээлэл

Иргэний бүртгэл /регистр/-ийн дугаар: .....
Эцэг /эх/-ийн нэр: .....
Гэрийн хаяг: .....
Утасны дугаар: .....
Ажлаас чөлөөлөгдсөн огноо: .....

Ургийн овог: .....
Даатгуулагчийн нэр: .....

Цахим шуудан: .....

2. Шимтгэл төлөлтийн мэдээлэл

Тэтгэмжийн даатгалын санд шимтгэл төлсөн нийт .... сар.

Тэтгэмжийн даатгалын санд шимтгэл төлсөн нийт сарыг дэлгэрэнгүй харах бол энд дарна уу.

Тэтгэмж тооцох хувь: Тэтгэмж тооцох хувь хэмжээний мэдээллийг энд дарж харна уу.

- ❖ Таны тэтгэмжийн даатгалын санд шимтгэл төлсөн нийт сар болон тэтгэмж бодох хувь зөрүүтэй бол харьяа Нийгмийн даатгалын газарт нотлох баримт бичигтэйгээ хандана уу.

3. Тэтгэмж авах Нийгмийн даатгалын газар болон банк, дансны мэдээлэл

Харьяалах Нийгмийн даатгалын газар: .....

Банкны нэр: ..... Даатгуулагчийн дансны дугаар: .....

Анхааруулга: Мөнгө хүлээн авах данс нь таны өөрийн нэр дээрх төгрөгийн данс байна.

- ✓ Өргөдөлд дурдсан өөрийн мэдээллийг үнэн зөв бөглөсөн болно.
- ✓ Миний төрд байгаа мэдээллийг ашиглахыг зөвшөөрч байна.
- ✓ Хуурамч баримт бүрдүүлснээс үүсэх үр дагавар, хуулийн хариуцлагыг би өөрөө хүлээнэ.

- ▪ /Өргөдөл илгээх/ Таны тэтгэмжийн талаарх мэдээллийг цахим шуудан болон энэхүү даатгуулагчийн вэбээр буцаан мэдэгдэх болно.

Өргөдөл гаргасан огноо: .....

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/194
дугаар тушаалын гуравдугаар хавсралт

Маягт АЖТ-2

АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖ АВАХ ӨРГӨДӨЛ ГАРГАХ НЬ

1. Даатгуулагчийн мэдээлэл

1.1. Иргэний бүртгэл /регистр/-ийн дугаар: .....
1.2. Ургийн овог: .....
1.3. Эцэг /эх/-ийн нэр: .....
1.4. Өөрийн нэр: .....
1.5. Гэрийн хаяг: .....
1.6. Утасны дугаар: .....
1.7. Цахим шуудан: .....

2. Шимтгэл төлсөн хугацааны мэдээлэл

2.1. Би дараах хугацаанд ажил хөдөлмөр эрхэлж шимтгэл төлсөн болно.

.....-ээс ..... хүртэл буюу нийт ..... сар
.....-ээс ..... хүртэл буюу нийт ..... сар

Ажилгүйдлийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа	Тэтгэмж бодох хэмжээ хувь
24-59 сар	50
60-119 сар	55
120-179 сар	60
180 ба түүнээс дээш сар	70

3. Өргөдөл гаргаж байгаа хугацаа

3.1. Хуулийн хугацаанд буюу 4 долоо хоногийн дотор ☐ Тийм ☐ Үгүй
3.2. Хүндэтгэн үзэх шалтгаан буюу 3 сарын дотор ☐ Тийм ☐ Үгүй

Хэрэв тийм бол өөрт хамаарах хүндэтгэн үзэх шалтгаанаа тодорхойлно уу.

☐ Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн
☐ Эмнэлэгт өвчтөн асарсан
☐ Нийтийг хамарсан дайчилгаанд хамрагдсан
☐ Хорио цээр тогтоосон бүсэд хоригдсон
☐ Галын болон байгалийн гэнэтийн аюул, давагдашгүй хүчин зүйлд өртсөн

Би ... оны ... сарын ...-ны өдрөөс ажлаас чөлөөлөгдсөн тул Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу ажилгүйдлийн тэтгэмж олгож өгнө үү.

4. Би өргөдөлдөө дараах баримт бичгийг хавсаргав. Нийт .... хуудастай. Үүнд:

☐ Ажлаас чөлөөлөгдсөн тушаал
☐ Хүндэтгэх үзэх шалтгааныг нотлох баримт

5. Тэтгэмж авах банк, дансны мэдээлэл

Банкны нэр: ..... Даатгуулагчийн дансны дугаар: .....

Анхааруулга: Мөнгө хүлээн авах данс нь таны өөрийн нэр дээрх төгрөгийн данс байна.

- ✓ Өргөдөлд дурдсан өөрийн мэдээллийг үнэн зөв бөглөсөн болно.
- ✓ Миний төрд байгаа мэдээллийг ашиглахыг зөвшөөрч байна.
- ✓ Хуурамч баримт бүрдүүлснээс үүсэх үр дагавар, хуулийн хариуцлагыг би өөрөө хүлээнэ.

❖ Танд олгох тэтгэмжийн талаарх мэдээллийг цахим шуудангаар мэдэгдэх болно.

Өргөдөл гаргасан: ..... / ..... /
(гарын үсэг) (нэр)

Огноо .....

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
2023 оны 12 дүгээр сарын 28-ны өдрийн А/194
дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

Маяг ХЧТАТ-1

ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР ТҮР АЛДСАНЫ ТЭТГЭМЖ АВАХ ӨРГӨДӨЛ
/цахимаар/

1. Даатгуулагчийн мэдээлэл

Иргэний бүртгэл /регистр/-ийн дугаар: .....
Эцэг /эх/-ийн нэр: .....
Гэрийн хаяг: .....
Утасны дугаар: .....

Ургийн овог: .....
Даатгуулагчийн нэр: .....
Цахим шуудан: .....

2. Шимтгэл төлөлтийн мэдээлэл

Тэтгэмжийн даатгалын санд шимтгэл төлсөн нийт .... сар.

Тэтгэмжийн даатгалын санд шимтгэл төлсөн нийт сарыг дэлгэрэнгүй харах бол энд дарна уу.

Тэтгэмж тооцох хувь: Тэтгэмж тооцох хувь хэмжээний мэдээллийг энд дарж харна уу.

❖ Таны тэтгэмжийн даатгалын санд шимтгэл төлсөн нийт сар болон тэтгэмж бодох хувь зөрүүтэй бол харьяа Нийгмийн даатгалын газарт нотлох баримт бичигтэйгээ хандана уу.

3. Тэтгэмж авах Нийгмийн даатгалын газар болон банк, дансны мэдээлэл

Харьяалах Нийгмийн даатгалын газар: .....

Банкны нэр: ..... Даатгуулагчийн дансны дугаар: .....

Анхааруулга: Мөнгө хүлээн авах данс нь таны өөрийн нэр дээрх төгрөгийн данс байна.

- ✓ Өргөдөлд дурдсан өөрийн мэдээллийг үнэн зөв бөглөсөн болно.
- ✓ Миний төрд байгаа мэдээллийг ашиглахыг зөвшөөрч байна.
- ✓ Хуурамч баримт бүрдүүлснээс үүсэх үр дагавар, хуулийн хариуцлагыг би өөрөө хүлээнэ.

▪ /Өргөдөл илгээх/ Таны тэтгэмжийн талаарх мэдээллийг цахим шуудан болон энэхүү даатгуулагчийн вэбээр буцаан мэдэгдэх болно.

Өргөдөл гаргасан огноо: .....

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
2023 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн А/194
дугаар тушаалын тавдугаар хавсралт

Маягт ХЧТАТ-2

ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР ТҮР АЛДСАНЫ ТЭТГЭМЖ АВАХ ӨРГӨДӨЛ ГАРГАХ НЬ

1. Даатгуулагчийн мэдээлэл

1.1. Иргэний бүртгэл /регистр/-ийн дугаар: .....
1.2. Ургийн овог: .....
1.3. Эцэг /эх/-ийн нэр: .....
1.4. Өөрийн нэр: .....
1.5. Гэрийн хаяг: .....
1.6. Утасны дугаар: .....
1.7. Цахим шуудан: .....

2. Шимтгэл төлсөн хугацааны мэдээлэл

2.1. Би дараах хугацаанд ажил хөдөлмөр эрхэлж шимтгэл төлсөн болно.

.....-ээс ..... хүртэл буюу нийт ..... сар
.....-ээс ..... хүртэл буюу нийт ..... сар

Тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа	Тэтгэмж бодох хэмжээ хувь
3-59 сар	50
60-119 сар	55
120-179 сар	60
180 ба түүнээс дээш сар	75

3. Өргөдөл гаргаж байгаа хугацаа

3.1. Хуулийн хугацаанд буюу 4 долоо хоногийн дотор ☐ Тийм ☐ Үгүй
3.2. Хүндэтгэн үзэх шалтгаан буюу 6 сарын дотор ☐ Тийм ☐ Үгүй

Хэрэв тийм бол өөрт хамаарах хүндэтгэн үзэх шалтгаанаа тодорхойлно уу.

☐ Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн
☐ Эмнэлэгт өвчтөн асарсан
☐ Нийтийг хамарсан дайчилгаанд хамрагдсан
☐ Хорио цээр тогтоосон бүсэд хоригдсон
☐ Галын болон байгалийн гэнэтийн аюул, давагдашгүй хүчин зүйлд өртсөн
/Хүндэтгэх үзэх шалтгааныг нотлох баримтыг хавсаргана уу/

Би ... оны ... сарын ...-ны өдрөөс ... оны ... сарын ... өдөр хүртэл хөдөлмөрийн чадвараа түр алдаж эмчлүүлсэн тул Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж олгож өгнө үү.

4. Тэтгэмж авах банк, дансны мэдээлэл

Банкны нэр: ..... Даатгуулагчийн дансны дугаар: .....

Анхааруулга: Мөнгө хүлээн авах данс нь таны өөрийн нэр дээрх төгрөгийн данс байна.

- ✓ Өргөдөлд дурдсан өөрийн мэдээллийг үнэн зөв бөглөсөн болно.
- ✓ Миний төрд байгаа мэдээллийг ашиглахыг зөвшөөрч байна.
- ✓ Хуурамч баримт бүрдүүлснээс үүсэх үр дагавар, хуулийн хариуцлагыг би өөрөө хүлээнэ.

❖ Танд олгох тэтгэмжийн талаарх мэдээллийг цахим шуудангаар мэдэгдэх болно.

Өргөдөл гаргасан: ..... / ..... /
(гарын үсэг) (нэр)

Огноо .....

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
2023 оны .12 дугаар сарын 28-ны өдрийн А/194
дугаар тушаалын зургаадугаар хавсралт

Маягт ЖАТ-1

ЖИРЭМСНИЙ БОЛОН АМАРЖСАНЫ ТЭТГЭМЖ АВАХ ӨРГӨДӨЛ
/цахимаар/

1. Даатгуулагчийн мэдээлэл

Иргэний бүртгэл /регистр/-ийн дугаар: .....
Эцэг /эх/-ийн нэр: .....
Гэрийн хаяг: .....
Утасны дугаар: .....

Ургийн овог: .....
Даатгуулагчийн нэр: .....

Цахим шуудан: .....

Авах тэтгэмжийн төрөл: ☐ Жирэмсний болон амаржсаны тэтгэмж

2. Тэтгэмж авах Нийгмийн даатгалын газар болон банк, дансны мэдээлэл

Харьяалах Нийгмийн даатгалын газар: .....

Банкны нэр: .....

Даатгуулагчийн дансны дугаар: .....

Анхааруулга: Мөнгө хүлээн авах данс нь таны өөрийн нэр дээрх төгрөгийн данс байна.

- ✓ Өргөдөлд дурдсан өөрийн мэдээллийг үнэн зөв бөглөсөн болно.
- ✓ Миний төрд байгаа мэдээллийг ашиглахыг зөвшөөрч байна.
- ✓ Хуурамч баримт бүрдүүлснээс үүсэх үр дагавар, хуулийн хариуцлагыг би өөрөө хүлээнэ.

- /Өргөдөл илгээх/ Таны тэтгэмжийн талаарх мэдээллийг цахим шуудан болон энэхүү даатгуулагчийн вэбээр буцаан мэдэгдэх болно.

Өргөдөл гаргасан огноо: .....

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/194
дугаар тушаалын долоодугаар хавсралт

Маягт ЖАТ-2

ЖИРЭМСНИЙ БОЛОН АМАРЖСАНЫ ТЭТГЭМЖ АВАХ ӨРГӨДӨЛ ГАРГАХ НЬ

1. Даатгуулагчийн мэдээлэл

1.1. Иргэний бүртгэл /регистр/-ийн дугаар: .....
1.2. Ургийн овог: .....
1.3. Эцэг /эх/-ийн нэр: .....
1.4. Өөрийн нэр: .....
1.5. Гэрийн хаяг: .....
1.6. Утасны дугаар: .....
1.7. Цахим шуудан: .....

2. Шимтгэл төлсөн хугацааны мэдээлэл

2.1. Би дараах хугацаанд ажил хөдөлмөр эрхэлж шимтгэл төлсөн болно.

.....-ээс ..... хүртэл буюу нийт ..... сар
.....-ээс ..... хүртэл буюу нийт ..... сар

3. Өргөдөл гаргаж байгаа хугацаа

3.1. Хуулийн хугацаанд буюу 4 долоо хоногийн дотор ☐ Тийм ☐ Үгүй
3.2. Хүндэтгэн үзэх шалтгаан буюу 6 сарын дотор ☐ Тийм ☐ Үгүй

Хэрэв тийм бол өөрт хамаарах хүндэтгэн үзэх шалтгаанаа тодорхойлно уу.

☐ Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн
☐ Эмнэлэгт өвчтөн асарсан
☐ Нийтийг хамарсан дайчилгаанд хамрагдсан
☐ Хорио цээр тогтоосон бүсэд хоригдсон
☐ Галын болон байгалийн гэнэтийн аюул, давагдашгүй хүчин зүйлд өртсөн
/Хүндэтгэх үзэх шалтгааныг нотлох баримтыг хавсаргана уу/

Би ... оны ... сарын ... өдөр жирэмсний /амаржсаны/ амралт авч эмнэлгийн хуудас бичүүлсэн тул Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгож өгнө үү.

4. Тэтгэмж авах банк, дансны мэдээлэл

Банкны нэр: .....
Даатгуулагчийн дансны дугаар: .....

Анхааруулга: Мөнгө хүлээн авах данс нь таны өөрийн нэр дээрх төгрөгийн данс байна.

✓ Өргөдөлд дурдсан өөрийн мэдээллийг үнэн зөв бөглөсөн болно.

- ✓ Миний төрд байгаа мэдээллийг ашиглахыг зөвшөөрч байна.
- ✓ Хуурамч баримт бүрдүүлснээс үүсэх үр дагавар, хуулийн хариуцлагыг би өөрөө хүлээнэ.

❖ Танд олгох тэтгэмжийн талаарх мэдээллийг цахим шуудангаар мэдэгдэх болно.

Өргөдөл гаргасан: ..... / ..... /
(гарын үсэг) (нэр)

Огноо .....

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/194
дугаар тушаалын наймдугаар хавсралт

Маягт ГБГОТ-1

НАС БАРСАН ДААТГУУЛАГЧИЙН ГЭР БҮЛИЙН ГИШҮҮНД ОЛГОХ ТЭТГЭМЖ АВАХ ӨРГӨДӨЛ ГАРГАХ НЬ

1. Тэтгэмж шилжүүлэн авах иргэний мэдээлэл

1.1. Иргэний бүртгэл /регистр/-ийн дугаар: .....
1.2. Эцэг /эх/-ийн нэр: ..... 1.3. Нэр: .....
1.4. Гэрийн хаяг: .....
1.5. Утасны дугаар: ..... 1.6. Цахим шуудан: .....
1.7. Нас барсан иргэний гэр бүлийн хамаарал: .....

2. Нас барсан даатгуулагчийн мэдээлэл

2.1. Иргэний бүртгэл /регистр/-ийн дугаар: .....
2.2. Эцэг /эх/-ийн нэр: ..... 2.3. Даатгуулагчийн нэр: .....
Тохирох сонголтыг хийнэ үү.

- ☐ 36 сараас доошгүй хугацаанд шимтгэл төлсөн даатгуулагч
- ☐ Тэтгэвэр авагч
- ☐ Бусад

3. Би өргөдөлдөө дараах баримт бичгийг хавсаргав. Нийт .... хуудастай. Үүнд:

☐ Даатгуулагчийн нас барсны гэрчилгээний хуулбар, эсхүл эрх бүхий байгууллагын лавлагаа, шүүхийн шийдвэр

☐ Гэр бүлийн гишүүний иргэний үнэмлэхний хуулбар, эсхүл эрх бүхий байгууллагын лавлагаа

☐ Амьгүй донор болсон тухай эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт

4. Тэтгэмж шилжүүлэн авах банк, дансны мэдээлэл

Банкны нэр: ..... Даатгуулагчийн дансны дугаар: .....

Анхааруулга: Мөнгө хүлээн авах данс нь таны өөрийн нэр дээрх төгрөгийн данс байна.

- ✓ Өргөдөлд дурдсан өөрийн мэдээллийг үнэн зөв бөглөсөн болно.
- ✓ Миний төрд байгаа мэдээллийг ашиглахыг зөвшөөрч байна.
- ✓ Хуурамч баримт бүрдүүлснээс үүсэх үр дагавар, хуулийн хариуцлагыг би өөрөө хүлээнэ.

Өргөдөл гаргасан: ..... / ..... /
(гарын үсэг) (нэр)

Огноо .....

--- oOo ---

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН

ТУШААЛ

2023 оны 11 дугаар сарын 07-ны өдөр | Дугаар А/152, А/388 | Улаанбаатар хот

МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ЖАГСААЛТ, ХУВЬ, ХУГАЦААГ БАТЛАХ ТУХАЙ

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1."Мэргэжлээс шалтгаалсан өвчний жагсаалт, хувь, хугацаа"-г хавсралтаар батлсугай.

2.Энэ тушаалыг мөрдөж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газарт үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Батжаргал/, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйчилгээний газар газар /А.Өнөржаргал/-т тус тус даалгасугай.

4.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан "Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоохоод баримтлах өвчний жагсаалт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хэмжээ, хугацааг шинэчлэн батлах тухай" Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/758, А/197 дугаар хамтарсан тушаалын 2 дугаар хавсралтыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.

5.Энэхүү тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД Х.БУЛГАНТУЯА

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД С.ЧИНЗОРИГ

Хөдөлмөр, нийгмийн хамгаллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн А/152, А/388 дугаар хамтарсан тушаалын

хавсралт

МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ЖАГСААЛТ, ХУВЬ, ХУГАЦАА

	Өвчний нэр	Үе шат	өвчний код	хувь хэмжээ	угацаа	өдөлмөрийн нөхцөл солих
	1.Мэргэжлээс шалтгаалсан амьсгалын замын эмгэг					
	Уушги тоосжих өвчин					
.1	Антракоз /антракосиликоз/	Уушги тоосжих өвчин I үе	60	0-40	жил	өдөлмөрийн нөхцөл солих
	Асбестоз		61			
	Силикоз		62			
	Сидероз, Цементоз		63			
	Пневмоканиоз /холимог тоосоор үүсгэгдсэн/		64			
	Силикотуберкулёз		65			
	Биссиноз		66			
.2	Антракоз /антракосиликоз/	а/ Уушги тоосжих өвчин I үе, Амьсгалын дутагдал I зэрэг /Рентген зураг ОУ-ын ILO ангилалаар жижиг сүүдэр тархалт 1/1/	60	1-50	жил	өдөлмөрийн нөхцөл солих
	Асбестоз		61			
	Силикоз		62			
	Сидероз, Цементоз		63			
	Пневмоканиоз /холимог тоосоор үүсгэгдсэн/	б/ Уушги тоосжих өвчин I үе, Амьсгалын дутагдал I зэрэг /Рентген зураг ОУ-ын ILO ангилалаар жижиг сүүдэр тархалт 1/1, /1/2/	64	1-59	жил	
	Силикотуберкулёз		65			
	Биссиноз		66			
.3	Антракоз /антракосиликоз/	Уушги тоосжих өвчин II үе, Амьсгалын дутагдал I-II зэрэг, уушги тэлэгдэл, уушги зүрхний архаг дутагдал I үе, өөнэгшилтэй үе, хавсарсан сүрьеэ Рентген зураг: ОУ-ын хөдөлмөрийн байгууллагын ILO ангилалаар жижиг сүүдэр+том сүүдэр, А категори+плеврийн зузаарал, Тархалт:2/1, 2/2, 2/3	60	0-69	жил	өдөлмөрийн нөхцөл солих
	Асбестоз		61			
	Силикоз		62			
	Сидероз, Цементоз		63			
	Пневмоканиоз /холимог тоосоор үүсгэгдсэн/		64			
	Силикотуберкулёз		65			
	Биссиноз		66			
.4	Антракоз /антракосиликоз/	Уушги тоосжих өвчин III үе, Амьсгалын дутагдал II зэрэг, уушги тэлэгдэл, уушги зүрхний архаг дутагдал II үе, өөнэгшилээ алдсан үе, зүрхний архаг дутагдал С үе, сүрьеэ, гялтангийн наалдац, гялтангийн зузааралт Рентген зураг: ОУ-ын хөдөлмөрийн байгууллагын ILO ангилалаар: жижиг сүүдэр+том сүүдэр В категори+плеврийн зузаарал, Тархалт: 3/1,3/2	60	0-79	жил	өдөлмөрийн нөхцөл солих
	Асбестоз		61			
	Силикоз		62			
	Сидероз, Цементоз		63			
	Пневмоканиоз /холимог тоосоор үүсгэгдсэн/		64			
	Силикотуберкулёз		65			
	Биссиноз		66			
.5	Антракоз /антракосиликоз/	Уушги тоосжих өвчин III үе, Амьсгалын дутагдал III зэрэг, уушги тэлэгдэл, уушги зүрхний архаг дутагдалII-III үе, өөнэгшилээ алдсан үе, зүрхний архаг дутагдал D үе, сүрьеэ, гялтангийн наалдац, гялтангийн зузааралт Рентген зураг: ОУ-ын хөдөлмөрийн байгууллагын ILO ангилалаар: жижиг сүүдэр+том сүүдэр С категори+плеврийн зузаарал, Тархалт: 3/3, 3/3+	60	0-100	жил	өдөлмөрийн нөхцөл солих
	Асбестоз		61			
	Силикоз		62			
	Сидероз, Цементоз		63			
	Пневмоканиоз /холимог тоосоор үүсгэгдсэн/		64			
	Силикотуберкулёз		65			
	Биссиноз		66			
	Тоосжилтын болон хордлогын шалтгаант гуурсан хоолойн архаг үрэвсэл					
.6	Тоосжилтын болон хордлогын шалтгаант гуурсан хоолойн архаг үрэвсэл	Тоосжилтын болон хордлогын шалтгаант гуурсан хоолойн архаг үрэвсэл хүндрэлгүй	68	0	жил	
.7		Тоосжилтын болон хордлогын шалтгаант гуурсан хоолойн архаг үрэвсэл, Амьсгалын дутагдал I зэрэг	68	0-55	жил	
.8		Тоосжилтын болон хордлогын шалтгаант гуурсан хоолойн архаг үрэвсэл, Амьсгалын дутагдал I зэрэг, Уушги тэлэгдэл	68	6-69	жил	
	Тоосжилтын болон хордлогын					өдөлмөрийн нөхцөл солих

.9	Тооcжилтын болон хордлогын шалтгаант гуурсан хоолойн архаг үрэвсэл	а/ Тооcжилтын болон хордлогын шалтгаант гуурсан хоолойн архаг үрэвсэл, Амьсгалын дутагдал I-II зэрэг, Уушги тэлэгдэл, уушгин ѳрхний архаг дутагдал I үе, ээнэгшилтэй үе ѳрхний архаг дутагдал C үе	68	0-79	жил	
		б/ Тооcжилтын болон хордлогын шалтгаант гуурсан хоолойн архаг үрэвсэл, Амьсгалын дутагдал II-III зэрэг, Уушги тэлэгдэл, уушги ѳрхний архаг дутагдал II-III үе, ээнэгшлээ алдсан үе, ѳрхний архаг дутагдал D үе	68	0-100	жил	
.10	Тооcжилт, харшил, хордлогын шалтгаант багтраа	а/ Тооcжилт, харшил, хордлогын шалтгаант багтраа хөнгөн зэрэг	68.4	0	жил	ѳдөлмөрийн нөхцөл солих
		б/ Тооcжилт, харшил хордлогын шалтгаант багтраа дунд зэрэг	68.4	0-40	жил	
.11		а/ Тооcжилт, харшил, хордлогын шалтгаант багтраа дунд зэрэг, амьсгалын дутагдал I зэрэг	68.4	1-50	жил	
		б/ Тооcжилт, харшил, хордлогын шалтгаант багтраа дунд зэрэг, амьсгалын дутагдал II зэрэг, уушги ѳрхний архаг дутагдал I үе, ээнэгшилтэй үе, ѳрхний архаг дутагдал B үе	68.4	1-69	жил	
.12		Тооcжилт, харшил, хордлогын шалтгаант багтраа хүнд зэрэг, амьсгалын дутагдал II-III зэрэг, уушги ѳрхний архаг дутагдал II үе, ээнэгшлээ алдсан үе, ѳрхний архаг дутагдал C, D үе	68.4	0-80	жил	
	2. Мэргэжлээс шалтгаалсан хордлого					
	Өвчний нэр	Ер өнхий шинж тэмдэг	Үе шат	өвчний код	үвь хэмжээ	угацаа	ѳдөл мөрийн нөхцөл солих
	Химийн бодисын архаг хордлогын улмаас үүсэх эмгэг						
.1	Хүнд металлын хордлого /хар тугалга, хүнцэл, мөнгөн ус, хром, кадми, зэс, цайр, цагаан тугалга, берилли тэдгээрийн нэгдлүүд, бусад металлууд/	а/ Мэдрэлийн хам шинж /Энцефалопати, полиневрит/ б/ Бөөрний гэмтлийн хам шинж /түүдгэн-цэр, сувганцрын үхжилт үрэвсэл, бөөрний архаг дутагдал/ в/ Хоол боловс-руулах замын архаг хямрал /диспепси, бага шимэгдэлтийн хам шинж, гэдэсний хатгаа шинж/ г/ Арьсны үрэвсэл, гиперпигментаци, ширшил, хатингаршил, салстын харлалт/ д/ Нөхөн үржихүйн эмгэгүүд /үргүйдэл зулбалт, тератоген нөлөөлөл/ Анхааруулга: Тухайн хордсон химийн бодисын ХАЛМ /хор аюулын лавлагаа мэдээлэл/-ийг заавал харьцуулж үзнэ	а/ Хөнгөн үе (буйл хөөж хөхөвтөр болох, амны хөндий шархлах, аманд металл амтагдах, хоолой хорсох, хуурай ханиах, дотор муухайрах, бөөлжих, металлын халууралт, шинжилгээнд ретикуло-цитоз 25% хүртэл ихсэх, цус болон биологийн материалд тухайн хордсон металл илрэх)	56	0-40	жил	ѳдөлмөрийн нөхцөл солих
			б/ Дунд үе (Захын мэдрэлийн эмгэгүүд, цус багадалт, толгой эр-гэх, толгой өвдөх, дотор муухайрах, шүд сулрах, сэтгэлээр унах, хараа муудах, амьсгалын замын үрэвсэл, арьсны үрэвсэл, шинжил-гээнд ретикулоцитоз 30% хүртэл ихсэх, цус болон биологийн мате-риалд тухайн хордсон металл илрэх)	56	1-55	жил	
			в/ Хүндэвтэр үе (Нейропати, бөөрний түүдгэнцрийн болон сувганцрын гэмтэл, буйланд хар тугалганы хүрээ үүсэх, хамрын салст, ходоод, гэдэс, ѳрх судасны системийн өвчлөл, мэдрэл, сэтгэ-цийн өөрчлөлтүүд, шинжилгээнд ретикулоцитоз 40% хүртэл ихсэх, цус болон биологийн материалд тухайн хордсон металл зөвшөөрөг-дөх дээд хэмжээнээс өндөр байх)	56	6-69	жил	
			г/ Хүнд үе (Нейропати, бөөрний түүдгэнцрийн болон сувганцрын гэмтэл, үхжлийн гаралтай неф-ропати, арьсны дерматит, хордло-пын шалтгаант энцефалопати, тэнэгрэлийн шинжүүд, бусад эрхт-нүүдийн дагалдах эмгэгүүд, шинжилгээнд ретикулоцитоз 40%-с дээш ихсэх, цус болон биологийн материалд тухайн хордсон металл зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс өндөр байх)	56	0-90	жил	
.2	Идэмхий бодисын хордлого /фенол, фенолын уламжлалууд, бусад идэмхий органик бодисууд, идэмхий хүчил, хүчил төст нэгдлүүд, идэмхий шүлт, шүлт төст нэгдлүүд /	а/ Арьс, салстын эмгэг өөрчлөлтүүд, арьсны үрэвсэл, гиперпигментаци, ширшил, хатингаршил, салстын харлалт/ б/ Амьсгалын эрхтэнй хямрал в/ Хоол боловсруулах замын архаг хямрал /диспепси, бага шимэгдэлтийн хам шинж, гэдэсний хатгаа шинж/ Анхааруулга: Тухайн хордсон химийн бодисын ХАЛМ /хор аюулын лавлагаа мэдээлэл/-ийг заавал харьцуулж үзнэ	а/ Хөнгөн үе (Арьсны загатнаа, уушги болон гуурсан хоолойн үрэвсэл, ѳрх судас, цусны тоттолцооны өөрчлөлтүүд, мэдрэл, хоол боловсруулах эрхтэн тоттолцооны архаг эмгэгүүд, цус болон биологийн материалд тухайн хордсон идэмхий бодис илрэх)	54	0-40	жил	ѳдөлмөрийн нөхцөл солих
			б/ Дунд үе (Дээрх шинжүүд дээр нэмэгдээд арьсны архаг үрэвсэл, тууралт, амьсгал бачуурах, боогдох, амьсгалын дутагдлын шинж илрэх, тураал, шүд суларч буйл үрэвсэх, цус гоожих, ходоод гэдэсний шархлаа үүсэх, цус болон биологийн материалд тухайн хордсон идэмхий бодис илрэх)	54	1-55	жил	
			в/ Хүндэвтэр үе (Арьсны пиперпигментаци, арьс салсты хар-лалт, ширшил, хашингаршил, уушгины пневмосклероз, хордлогын шалтгаант энцефалопати, цус бо-лон биологийн материалд тухайн хордсон идэмхий бодис зөвшөөрөг-дөх дээд хэмжээнээс өндөр байх)	54	6-69	жил	
			г/ Хүнд үе (Олон эрхтний дутмагшил, бодисын солилцооны түгээмэл хямрал, энцефалопати, цусархаг хам шинж, шээсэнд уураг, эпител, улаан эс, чөлөөт гемог-лобин илэрнэ, цус болон биологийн материалд тухайн хордсон идэмхий бодис зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс өндөр байх)	54	0-80	жил	
	Ароматик бодисуудын хордлого						

.3	Ханасан ба үнэрт устөрөгчийн галогены уламжлалын хордлого /тетрахлорт нүүрстөрөгч, хлороформ, трихлорэтилен, тетрахлорэтилен, дихлорметан, хлорфторт нүүрстөрөгч, бусад ханасан нүүрстөрөгчийн галоген, формальдегид/	а/ Тератоген нөлөө-лөл, б/ Генийн мутаци в/ Хавдар г/ Мэдрэл, хоол боловсруулах замын хямрал д/ Зүрх судасны тогтолцооны өөрчлөлтүүд е/ Арьс, салстын өөрчлөлтүүд Анхааруулга: Тухайн хордсон химийн бодисын ХАЛМ /хор аюулын лавлагаа мэдээлэл/-ийг заавал харьцуулж үзнэ	а/ Хөнгөн үе (Ядрах сульдах, толгой өвдөх, нойр муудах, аманд муухай амтагдах, хоолой хатах, буйлаас цус гарах, амьсгаадах, мэдрэл, хоол боловсруулах эрхтэн, зүрх судасны тогтолцооны өөрчлөл-түүд, цус болон биологийн мате-риалд тухайн хордсон ароматик бодис илрэх)	53	0-40	жил	өдөлмерийн нөхцөл солих
			б/ Дунд үе (Дээрх шинжүүд дээр нэмэгдээд олон эрхтний хавсарсан архаг өөрчлөлтүүд илрэх цус болон биологийн материалд тухайн хордсон ароматик бодис илрэх)	53	1-55	жил	
			в/ Хүндэвтэр үе (Арьсны архаг үрэвсэл, тууралт, цусны системийн өөрчлөлтүүд, анеми, зүрх судас, ходоод гэдэс, цуллаг эрхтнүүдийн үйл ажиллагааны архаг дутмагшил, мэдрэл, сэтгэцийн хямрал, поли-невропати энцефалопати, цус бо-лон биологийн материалд тухайн хордсон ароматик бодис зөвшөө-рөгдөх дээд хэмжээнээс өндөр байх)	53	6-69	жил	
			г/ Хүнд үе (Элэг бөөр, зүрх судас олон эрхтэн хавсарсан архаг дутагдал, цусны эсүүдийн гүнзгий өөрчлөлт, мэдрэл, сэтгэцийн хямрал, хордлогын шалтгаант энцефалопати, ком, бодисын солилцооны түгээмэл хямрал, хүнд хэлбэрийн арьсны эмгэгүүд, цус болон биологийн материалд тухайн хордсон ароматик бодис зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс өндөр байх)	53	0-85	жил	
Цочроогч, боогдуулагч бодис /хий, уур/-ын хордлого							
.4	Хий ба ууршимтгай цочроогч, боогдуу-лагч бодисуудын хордлого /азотын исэл, хүхрийн давхар исэл, аммиак, нүлимс асгаруулагч хий, хлор, фтор, фторт устөрөгч, хүхэрт устөрөгч, нүүрсхүч-лийн давхар исэл, бусад хий, утаа, уур/	а/ Амьсгалын эрхтэнний хямрал б/ Арьс, салстын цочролын хам шинжүүд в/ Мэдрэлийн хам шинж /уналт таталт, булчин сулрах/ Анхааруулга: Тухайн хордсон химийн бодисын ХАЛМ /хор аюулын лавлагаа мэдээлэл/-ийг заавал харьцуулж үзнэ	а/ Хөнгөн үе (Амьсгалын дээд зам, арьс, салстын цочролын шинжүүд, хуурай ханиах, хоолой сөөх, хамар залгиур хуурайших, хорсох, цус болон биологийн материалд тухайн хордсон цочроогч, боогдуулагч бодис илрэх)	59	0-40	жил	өдөлмерийн нөхцөл солих
			б/ Дунд үе (Риноларинг-фарингит, трахеобронхит, зүрх судасны архаг өвчнүүд, арьсны загатнаа, ходоод гэдэсний үрэвсэл цус болон биологийн материалд тухайн хордсон цочроогч, боогдуулагч бодис илрэх)	59	1-55	жил	
			в/ Хүндэвтэр үе (Хордлогын шалтгаант бронхит, багтраа, пневмосклероз, амьсгалын дутаг-дал, цусны системийн өөрчлөлтүүд, мэдрэлийн хэсэгчилсэн голомтот шинжүүд, элэг, бөөрний архаг үрэв-сэл цус болон биологийн мате-риалд тухайн хордсон цочроогч, боогдуулагч бодис зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс өндөр байх)	59	6-69	жил	
			г/ Хүнд үе (Энцефалопати, олон эрхтний дутмагшил, бодисын солилцооны түгээмэл хямрал, амьсгал, зүрх судасны үйл ажил-лагаа алдагдаж төв мэдрэлийн систем гипоксид орох, уушги, тар-хины хавдар илэрч болно цус болон биологийн материалд тухайн хорд-сон цочроогч, боогдуулагч бодис зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс өндөр байх)	59	0-85	жил	
Пестицитын хордлого							

.5	Пестицитын хордлого /Органик фосфат ба карбамат, хлорорга-ник, фосфор органик агуулсан шавж уст-гагчууд, гербицид, фунгицид, роденти-цид, бусад дестицитүүд/	шинж өөрчлөлт а/ Мэдрэл сульдлын хам б/ Дотоод шүүрлийн в/ Цусны эмгэг өөрчлөлт	а/ Хөнгөн үе (Толгой эргэх, өвдөх, нойр муудах, ядрах, арьс загатнах, хоол боловсруулах эрхтэн, зүрх судасны хямрал, цусны элементүүдийн өөрчлөлтүүд, цус болон биологийн материалд пестицид илрэх)	60	0-40	жил	өдөлмөрийн нөхцөл солих
			б/ Дунд үе (Дотор муухайрах, аманд төмөр амтагдах, шүлс гоожих, хоолонд дургүй болох, хөлрөх, хүүхэн харааны гэрлийн урвал сулрах, элэг, бөөрний архаг үрэвсэл, арьсны загатнаа, цусны элементүүдийн өөрчлөлтүүд, цус болон биологийн материалд пестицид илрэх)	60	1-55	жил	
			в/ Хүндэвтэр үе (Халуурах, бөөлжих, булчингаар өвдөх, полиневрит, айдас түгшүүртэй болох сандрах, хүүхэн хараа нарийсах, элэгний хатуурал, дотоод шүүрлийн булчирхайн өөрчлөлтүүд, амьсгалын дутагдал, баттраа, цусны элементүүдийн өөрчлөлтүүд, цус болон биологийн материалд пестицид зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс өндөр байх)	60	6-69	жил	
			г/ Хүнд үе (гэдэс хүчтэй базалж өвдөх, гүйлгэх, ухаан муудах, хий юм харах, шизофрени төст шинж, эпилепси төст уналт, энцефалопатийн шинж илрэх, элэгний хатуурлийн эцсийн шат, бөөрний дутагдал, зүрх судасны дутагдал цус болон биологийн материалд пестицид зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс өндөр байх)	60	0-90	жил	
Органик бус бодисын хордлого							
			а/ Хөнгөн үе (Арьсны өнгө хөхрөх, булчингийн хүч сулрах, нүд бүлтийх, шөрмөсний рефлекс сулрах, арьсны зураглал тодрох хоол боловсруулах эрхтэн, зүрх судасны өвчнүүд, цус болон биологийн материалд тухайн хордсон органик бус бодис илрэх)	57	0-40	жил	
			б/ Дунд үе (Нүүрний булчингийн хөдөлгөөн буурах, булчингийн тонус ихсэх, харц гөлийх, хөдөлгөөн удаашрах, тэнцвэр алдах, арьсны тэжээллэгийн өөрчлөлтүүд, цус болон биологийн материалд тухайн хордсон органик бус бодис илрэх)	57	1-55	жил	

.6	Бусад органик бус бодисын хордлого /марганц тэдгээрийн нэгдлүүд, устөрөгчийн цианид, бусад органик бус нэгдлүүд/	а/ Мэдрэлийн хам шинж /энцефалопати, полиневрит/ б/ Бөөрний гэмтлийн хам шинж /түүдгэнцэр, сувганцрын үрэвсэл, бөөрний дутагдал/ в/ Хоол боловсруулах замын хямрал/ г/ Арьсны өөрчлөлт	в/ Хүндэвтэр үе (Хордлогын шалтгаант энцефалопати, поли-невропати, цус багадалт, бамбай, бөөрний дээд булчирхайн ду-тагдлын шинжүүд, нүүрний хувирал багасч баг өмссөн мэт болох, шөрмөсний рефлексүүд өндөрсч клонус илрэх, ходоод гэдэсний шархлаа, элэгний хатуурал, цусны эсүүдийн гүнзгий өөрчлөлтүүд, тархины хэсэгчилсэн голомтот шинжүүд, бодисын солилцооны хүчилшилт, цус болон биологийн материалд тухайн хордсон органик бус бодис зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс өндөр байх)	57	6-69	жил	өдөлмөрийн нөхцөл солих
			г/ Хүнд үе (Паркинсоны хам шинж тод илрэхээс гадна олон эрхтэний хавсарсан дутмагшил, хорт хавдар, цус болон биологийн материалд тухайн хордсон органик бус бодис зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс өндөр байх)	57	0-90	жил	
.7.	Нүүрстөр өгчийн дан ислийн хурц хордлогын үлдэц	Мэдрэлийн хам шинж /энцефалопати, полинейропати, паркинсон, саажилт/ Анхааруулга: Нүүрстөрөгчийн дан ислийн ХАЛМ /хор аюулын лавлагаа мэдээлэл/-ийг заавал харьцуулж үзнэ	а/ Хөнгөн үе (Толгой өвдөх, толгой эргэх, ядрах, тэнцвэр алдагдах, гүйвах, цусанд карбоксигемоглобин 10-20% болох)	58	0-40	жил	өдөлмөрийн нөхцөл солих
			б/ Дунд үе (Хөдөлгөөний эвсэл алдагдах, хөдөлгөөн сулрах, ухаан алдах, үнтамхай болох, нүүрээр ягаан, улаан толбо гарах, бөөлжих нь нэмэгдэх, нүүр, их биеийн булчин жирвэгнэх, цусанд карбоксигемоглобин 21-30% болох)	58	1-55	жил	
			в/ Хүндэвтэр үе (Дээрх шинжүүд хүндрэх, ухаангүй болох, хожуу үеийн энцефалопати, цусанд карбоксигемоглобин 31-35% болох)	58	6-69	жил	
			г/ Хүнд үе (Танин мэдэхүйн гүйцэтгэл буурах, хожуу үеийн энцефалопати, полинейропати, паркинсон, саажилт, цусанп карбоксигемоглобин 36-40% болох)	58	0-79	жил	
			д/ Маш хүнд үе (Ухаан бүрэн алдаж комд орох, энцефалопати хүнд үе, мөчүүд хөхрөх, судасны цохилт 100-120 хүрэх, булчин хөшиж, чангарах, даралт буурах, таталт өгөх, цусанд карбоксигеиоглобин 41%-иас дээш болох)	58	0-90	жил	
Органик хүчлүүд ба түүний нэгдлүүд							

.8	Органик уусгагчууд /шатахууны нэгдлүүд, бензин, бензины нэгдлүүд, толуол, ксилол, нафталинг-ликол, кетон, бусад органик уусгагчууд/	а/ Мэдрэлийн хам шинж /энцефалопати/ б/ Бөөрний гэмтлийн хам шинж в/ Хоол боловсруулах замын хямрал/ г/ Зүрх, судасны өөрчлөлт Анхааруулга: Тухайн хордсон химийн бодисын ХАЛИМ /хор аюулын лавлагаа мэдээлэл/-ийг заавал харьцуулж үзнэ	а/ Хөнгөн үе (Арьс салст хөхөлбөр болох, тэнцвэр алдагдах, шөрмөсний рефлекс өндөрсөх хоол боловсруулах, эрхтний хөнгөн хямрал, элэг бөөрний архаг үрэвсэл, уушги, гуурсан хоолой, арьс салстын үрэвсэл цус болон биологийн материалд тухайн хордсон бодис илрэх)	52	0-40	жил	өдөлмөрийн нөхцөл солих
			б/ Дунд үе (Дээрх шинжүүд дээр нэмээд мэдрэл, сульдал, тураал, цусны тогтолцооны өөрчлөлт ил-рэх, цус болон биологийн материалд тухайн хордсон бодис илрэх)	52	1-55	жил	
			в/ Хүндэвтэр үе (Тремор, сонсгол буурах, анхаарал төвлөрөл буурч богино хугацааны ойн алдагдал, ходоод гэдэсний түгжрэл, сорви-жилтийн эмгэгүүд, тураал, арьс салстын архаг хүндрэлт өвчнүүд, цус болон биологийн материалд тухайн хордсон бодис зөвшөөрөг-дөх дээд хэмжээнээс өндөр байх)	52	6-69	жил	
			г/ Хүнд үе (Тархины хүнд хэлбэрийн өөрчлөлт энцефалопати, уушгины хаван, бодисын солилцооны түгээ-мэл хямрал, олон эрхтний дутмаг-шил, цус болон биологийн материалд тухайн хордсон бодис зөв-шөөрөгдөх дээд хэмжээнээс өндөр байх)	52	0-90	жил	
3. Мэргэжлээс шалтгаалсан арьс, харшлын өвчин							
.1	Мэргэжлээс шалтгаалсан хавьтал, харшлын дерматит		Ажил, мэргэжилтэй холбоотой эм, химийн бодис, будах тослох материал, металл, нефтийн бүтээгдэхүүн, болон бусад бодисын нөлөөгөөр үүссэн хавьтал харшлын дерматит байнгын сэдрэлтэй	23	0-50	жил	өдөлмөрийн нөхцөл солих
.2	Мэргэжлээс шалтгаалсан энгийн хавьтлын цочролт дерматит		а/ Ажил, мэргэжилтэй холбоотой хими, физик, биологи, механик цочроогч хүчин зүйлсийн нөлөөгөөр үүссэн энгийн хавьтлын цочролт дерматит жилд 3 ба түүнээс дээш удаа сэдрэл өгсөн	24	0	жил	өдөлмөрийн нөхцөл солих
			б/ Ажил, мэргэжилтэй холбоотой хими, физик, биологи, механик цочроогч хүчин зүйлсийн нөлөөгөөр үүссэн энгийн хавьтлын цочролт дерматит байнгын сэдрэлтэй	24	0-50	жил	
.3	Мэргэжлээс шалтгаалсан хавьтал харшлын дерматит болон энгийн хавьтлын цочролт дерматит архагшиж хүндрэл үүссэн		а/ Полиаллергийн хэлбэрт шилжсэн, эмчилгээнд засал авахгүй, эмийн эмчилгээ тохирохгүй болсон харшлын өвчин байнгын сэдрэлтэй, хүндрэл өгсөн	23	1-60	жил	өдөлмөрийн нөхцөл солих
			б/ Дархлааны тогтолцооны илэрхий өөрчлөлт үүссэн, харшлын байнгын сэдрэлтэй, хүндрэл өгсөн	23	1-70	жил	
4. Мэргэжлээс шалтгаалсан нүдний өвчин							
.1	Мэргэжлээс шалтгаалсан зовхи салстын хурц болон архаг үрэвсэл /коньюктивит/, нулимс дамжуулах замын эмгэг			10 H11	0	жил	өдөлмөрийн нөхцөл солих
.2	Мэргэжлээс шалтгаалсан эврэвчийн хурц болон архаг үрэвсэл, цагаа унах,		а/ Хоёр нүдний илүү сайн харж байгаа нүдний 0.1-0.3 хараатай /ДЭМБ тодорхойлолтоор дунд зэргийн сул хараатай/	17	0-69	жил	
			б/Зохих эмчилгээ хийлгэсний дараа тохирсон шилээр хоёр нүдний илүү сайн харж байгаа нүд 0.05-0.09 хараатай /ДЭМБ тодорхойлолтоор хүнд зэргийн сул хараатай/	17	0-89	жил	

		в/ Зохих эмчилгээ хийлгэсний дараа тохирсон шилээр хоёр нүдний илүү сайн харж байгаа нүд 0.05-с доош хараатай /ДЭМБ тодорхойлолтоор сохор/	17	0-100	угацаагүй	
.3	Мэргэжлээс шалтгаалсан нүдний болорын эмгэг /катаракта/	Нэг нүдний хараа хэвийн буюу тохирсон шилээр 0.3 ба түүнээс дээш хараатай, нөгөө нүд 0.05-с доош хараатай	26	0-69	жил	
.4	Мэргэжлээс шалтгаалсан харааны мэдрэлийн үрэвсэл, болон хатингаршил	а/ Хоёр нүдний илүү сайн харж байгаа нүд нь 0.1-0.3 хараатай /ДЭМБ тодорхойлолтоор дунд зэргийн сул хараатай/	46 H47	0-69	жил	өдөлмөрийн нөхцөл солих
		б/Зохих эмчилгээ хийлгэсний дараа тохирсон шилээр хоёр нүдний илүү сайн харж байгаа нүд 0.05-0.09 хараатай /ДЭМБ тодорхойлолтоор хүнд зэргийн сул хараатай/	46 H47	0-89	жил	
		в/ Зохих эмчилгээ хийлгэсний дараа тохирсон шилээр хоёр нүдний илүү сайн харж байгаа нүд 0.05-с доош хараатай /ДЭМБ тодорхойлолтоор сохор/	46 H47	0-100	угацаагүй	
.5	Мэргэжлээс шалтгаалсан нүдний даралт ихсэх эмгэг /хоёрдогч глаукома/	а/ Хоёр нүдний илүү сайн харж байгаа нүд нь 0.1-0.3 хараатай /ДЭМБ тодорхойлолтоор дунд зэргийн сул хараатай/ эсвэл харах талбай 2 нүдэнд 40 градус хүртэл нарийссан /төвийн хараа нь хэвийн байж болно/	40	0-69	жил	өдөлмөрийн нөхцөл солих
		б/Зохих эмчилгээ хийлгэсний дараа тохирсон шилээр хоёр нүдний илүү сайн харж байгаа нүд 0.05-0.09 хараатай /ДЭМБ тодорхойлолтоор хүнд зэргийн сул хараатай/ эсвэл харах талбай 2 нүдэнд 20 градус хүртэл нарийссан /төвийн хараа нь хэвийн байж болно/	40	0-89	жил	
		в/ Зохих эмчилгээ хийлгэсний дараа тохирсон шилээр хоёр нүдний илүү сайн харж байгаа нүд 0.05-с доош хараатай /ДЭМБ тодорхойлолтоор сохор/ эсвэл харах талбай 2 нүдэнд 10 градус хүртэл нарийссан /төвийн хараа нь хэвийн байж болно/	40	0-100	угацаа гүй	
.6	Мэргэжлээс шалтгаалсан торовчийн эмгэг /миопия болон бусад/	а/ Хоёр нүдний илүү сайн харж байгаа нүд нь 0.1-0.3 хараатай /ДЭМБ тодорхойлолтоор дунд зэргийн сул хараатай/ эсвэл харах талбай 2 нүдэнд 40 градус хүртэл нарийссан /төвийн хараа нь хэвийн байж болно/	35 H52	0-69	жил	өдөлмөрийн нөхцөл солих
		б/Зохих эмчилгээ хийлгэсний дараа тохирсон шилээр хоёр нүдний илүү сайн харж байгаа нүд 0.05-0.09 хараатай /ДЭМБ тодорхойлолтоор хүнд зэргийн сул хараатай/ эсвэл харах талбай 2 нүдэнд 20 градус хүртэл нарийссан /төвийн хараа нь хэвийн байж болно/	35 H52	0-89	жил	
		в/ Зохих эмчилгээ хийлгэсний дараа тохирсон шилээр хоёр нүдний илүү сайн харж байгаа нүд 0.05-с доош хараатай /ДЭМБ тодорхойлолтоор сохор/ эсвэл харах талбай 2 нүдэнд 10 градус хүртэл нарийссан /төвийн хараа нь хэвийн байж болно/	35 H52	0-100	уга цаагүй	
5. Мэргэжлээс шалтгаалсан мэдрэлийн өвчнүүд						
.1	Хэсгийн, ерөнхий, хавсарсан доргионы өвчин	а/ I үе (дээд мөчний полиневропати, мэдрэхүй, вегетатив өөрчлөлт, дээд мөчний хялгасан судасны тонус алдагдал, ачаалалтай ажиллах буюу даарсан үед гар цайрах, шөнийн өвдөлт илрэх, хүйтний сорил)	75	0-40	жил	өдөлмөрийн нөхцөл солих
		б/II үе (дээд мөчинд өвдөлт мэдрэхүйн шинж байнга илрэх, дунд мэдрэлийн дарагдлын шинж, мэдрэхүйн алдагдал тод илэрч, вегатодистони астени, "Паля" шинж, гарын дулаан буурч, жижиг үений хэлбэр алдагдах, булчингийн хатингаршил, нурууны нугаламуудын остеоартроз, спондилопати үүсэх)	75	1-69	жил	
		в/III үе (судасны агшилт байнгын дахилттай болж, мэдрэхүйн тэжээлийн өөрчлөлт гүнзгий илрэх, мэдрэлийн ёзоор цочрол, дарагдлын хам шинж, Рейно шинж илрэх, гипоталамусын хямрал, ангиодистони хямрал, тархи бо-лон зүрхний хэм судсанд илрэх, хүнд үед дисцир-куляторный энцефалопатийн хам шинж, бэлгийн үйл ажиллагаа сулрах, доргионы мэдрэхүй буурах)	75	0-80	жил	
.2	Цахилгаан соронзон талбай, лазер, радио долгионы нөлөөллөөс үүсэн өвчин	а/ Хөнгөн үе (Вегетатив мэдрэлийн хямрал ихтэй астени, нойргүйдэл, захын мөчний салгалалт, хэт цочромтгой, зүрх судасны тогтолцооны хямрал)	85	0-45	жил	өдөлмөрийн нөхцөл солих
		б/ Дунд үе (Мэдрэлийн системийн голомтот шинжүүд, зүрх судасны дутагдлын хам шинж, энцефалопати, ой санамж эрс муудах, нүдний болор цайх, арьсны уян хатан чанар алдагдах, дерматит үүсэх, хумс хугарамтгай болох)	85	6-69	жил	
		в/ Хүнд үе (Хүнд хэлбэрийн астени, вазопати, диэнцефа-лопатийн хямрал, сэтгэл хөдлөл буурч уналт, бамбай булчирхайн хямралууд илэрсэн гипохромный анеми)	85	0-80	жил	
.3	Нурууны спондилопати /остео-хондроз, спондилёз, ивэрхийн шалтгаант компрессионно-ише-мический синдром, хүзүү сээр, бүсэлхий, ууцны хэсгийн ради-кулопати/ дээд, доод мөчний мэдрэлийн язгуурын өвдөлт дарагдлын хам шинж	а/ Тогтмол биш өвдөх, үе үе хөдөлгөөн хязгаарлагдах, бадайрах, вегетатив өөрчлөлт илрэх	54	0	жил	өдөлмөрийн нөхцөл солих
		б/ Өвдөлтийн шинж жилд 2-3 удаа дахилттай, булчингийн чангарал, өвдөлт болон вегетатив өөрчлөлтүүд байнга илрэх	54	0-55	жил	
		в/ Язгуур мэдрүүлийн дарагдлын шинжтэй, булчингийн зангирал, нурууны муруйлттай, өвдөлт, рефлекс, мэдрэхүйн хүрээний түвшингийн өөрчлөлттэй	54	6-69	жил	

		г/ Мэс заслын эмчилгээний дараах язгуур мэдрэлийн гаралтай саатай, бага аарцгийн эрхтний хүнд зэргийн үйл ажиллагааны алдагдалтай, мэс засал хийх боломжгүй, олон нуруу нугаламыг хамарсан эмгэг	54	0-80	жил	
6. Мэргэжлээс шалтгаалсан чих, хамар, хоолойн өвчин						
.1	Шуугианы нөлөөгөөр үүссэн сонсгол бууралт	а/ сонсгол бууралт II үе	83.3	0	жил	өдөлмөрийн нөхцөл солих
		б/ сонсгол бууралт III үе	83.3	0-69	жил	
		в/ сонсгол бууралт IV үе	83.3	0-80	жил	
.2	Мэргэжлээс шалтгаалсан өгүүлэх эрхтэний эмгэг	а/ Дууны хөвчийн үйл ажиллагааны алдагдалтай	38 J38.0	0	жил	өдөлмөрийн нөхцөл солих
		б/ Дууны хөвчийн хэсэгчилсэн саатай	38 J38.0	0-59	жил	
		в/ Дууны хөвчийн хоёр талын саатай	38 J38.0	0-69	жил	
		г/ Дууны хөвчийн хавдар	38 J38.0	0-90	жил	
.3	Мэргэжлээс шалгаалсан амьсгалын дээд замын эмгэг	а/ Хамар, залгиур, төвөнхийн архаг хатингаршилт үрэвсэл	31	0	жил	өдөлмөрийн нөхцөл солих
		б/ Хамрын таславчид цооролт үүссэн	31 J34.8	0-69	жил	
		в/ Мэргэжлээс шалтгаалсан амьсгалын дээд замын хавдар	31 J34.8	0-90	жил	
7. Мэргэжлээс шалтгаалсан туяаны өвчин						
.1	Мэргэжлээс шалтгаалсан цацраг идэвхит бодис болон рентген туяанаас үүссэн туяаны өвчин	а/ I үе: Астеновегетатив хам шинжүүд, диспепси, ходоодны шүүрэл багасах, эрэгтэй хүнд импотенци, эмэгтэй хүнд өндгөвчний үйл ажиллагаа хямрах, захын цусанд лейкопени 3.0 хүртэл буурах, тромбоцитопени, нейтрофил эсийн хордлогын мөхлөгтэй, цусархаг хам шинж бага зэрэг илрэх	88-91	0-40	жил	өдөлмөрийн нөхцөл солих
		б/ II үе: Судасны дистони, астеновегетатив хам шинжүүд үс унах, хумсны өөрчлөлт, диэнцефалийн криз өгөх, богино хугацаанд ухаан алдах, бүх биеийн гипергидроз, пароксизмал тахикарди, бие чичрэх, цус шүүрэмтгий болох, цусархаг хам шинжүүд, ходоод гэдэсний шүүрэл буурах, хордлогын гепатит, захын цусанд 2,5 г/л хүртэл буурах, нейтропени, лимфоцитопени 3 г/л хүртэл буурах, тромбоцитопени, нейтрофил эс хордлоыг мөхлөгтэй, цусны чөмөгний шинжилгээнд гипоплази илэрсэн	88-91	1-69	жил	
		в/ III-IV: цус төлжилт дарангуйлагдсан, мэдрэлийн тогтолцооны хүнд зэргийн өөрчлөлт их, байнгын нойргүйдэл, толгой эргэх, дотор муухайрах, ой тогтоолт буурах, цусархаг хам шинжүүд, салстат шархлаат некрозын өөрчлөлт, үс халцрах, дотоод шүүрлийн булчирхайн үйл ажиллагаа хямрах, захын цусанд лейкопени 1 г/л хүртэл буурах, нейтропени, лимфоцитопени 3 г/л хүртэл буурах, тромбоцитопени, гиперхромын цус багадалт, сепсис	88-91	0-80	жил	
8. Мэргэжлээс шалтгаалсан мэс заслын өвчин						
.1	Мэргэжлээс шалтгаалсан доод мөч, хэвлий, аарцгийн эрхтний венийн бүдүүрэл	а/ C-1,2: өнгөц венийн судас өргөсөл E-s: ажил мэргэжилтэй холбоотой A-s,p,d: өнгөц, гүний, холбогч венийн судасны бүдүүрэл үүссэн	83	0	жил	өдөлмөрийн нөхцөл солих
		б/ C-1, 2, 3: өнгөц венийн судас өргөссөн, хавагнасан E-s: ажил мэргэжилтэй холбоотой A-s,p,d: өнгөц, гүний, холбогч венийн судасны бүдүүрэл үүссэн P-r, o: цусны буцах урсгал үүссэн, хэсэгчилсэн	83	0-55	жил	
		в/ C-1,2,3,4: өнгөц венийн судас өргөссөн, байнгын хаван, арьсны нөсөө E-s: ажил мэргэжилтэй холбоотой A-s,p,d: өнгөц, гүний, холбогч венийн судасны бүдүүрэл үүссэн, P-r, o: цусны буцах урсгал үүссэн, хэсэгчилсэн	83	6-69	жил	
		г/ C-1,2,3,4,5,6: өнгөц венийн судас өргөссөн, байнгын хаван, арьсны нөсөө, шархлаа, үхжил E-s: ажил мэргэжилтэй холбоотой A-s,p,d: өнгөц, гүний, холбогч венийн судасны бүдүүрэл үүссэн P-r, o: цусны буцах урсгал үүссэн, хэсэгчилсэн	83	0-80	жил	
		а/ 1-2 үений хөдөлгөөн хязгаарлагдсан	21.2	0	жил	

.2	Мэргэжлээс шалтгаалсан тохойн үений хэлбэр хөдөлгөөн алдагдах эмгэг	б/ 1-2 үений хөдөлгөөн хязгаарлагдсан	21.2	0-55	жил	өдөлмөрийн нөхцөл солих
		в/ 3-4 үений хөдөлгөөн хязгаарлагдсан	21.2	6-69	жил	
		г/ 3-4 үений хөдөлгөөн хязгаарлагдсан	21.2	0-80	жил	
.3	Мэргэжлээс шалтгаалсан артерийн судасны олдмол нарийсал ба бөглөрөл	а/ I үе: Томоохон судсууд хэсэгчилсэн байдлаар нарий-	74	0	жил	өдөлмөрийн нөхцөл солих
		б/ I-II үе: Томоохон судсууд хэсэгчилсэн байдлаар нарий-	74	0-55	жил	
		в/ I-II үе: Томоохон судсууд нилэнхүйдээ нарийсах, бөглө-	74	6-69	жил	
		г/ III үе: I, II үеийн өөрчлөлтүүд гүнзгийрч, гар болон	74	0-85	жил	
.4	Мэргэжлээс шалтгаалсан дээд мөчний бичил гэмтэл, давтагдсан ачаалаас үүссэн өвчнүүд / үений холбоосын өвчин, дээд мөчний мэдрүүлийн саа, шөрмөсний ба уутанцрын үрэвсэл/	а/ мөр, бугалга, бугуйн үеэр өвдөх, янгинах, хөдөлгөөний	67.8	0		өдөлмөрийн нөхцөл солих
		б/ дээрх өөрчлөлт дээр нэмэгдэж мөр, бугалга, гарын хатингарт саа, сарвууны саажил, хатингирал,	67.8	0-55	жил	
		в/ дээрх өөрчлөлтүүд гүнзгийрч, хөдөлгөөн бүрэн хязгаарлагдах, эмгэг хугарал үүсэх	67.8	6-69	жил	
.5	Мэргэжлээс шалтгаалсан тавхай хавтгайрах эмгэг	а/ хөлийн шилбэ, тавхай, хурууны өвчнүүд бүлчин шөр-	21.4	0	жил	өдөлмөрийн нөхцөл солих
		б/ хөлийн шилбэ, тавхай, хурууны өвчнүүд бүлчин шөр-	21.4	0-55	жил	
		в/ дээрх өөрчлөлтөөс гадна хөдөлгөөний үйл ажил-	21.4	6-69	жил	
		г/ хөлийн тавхай хуруу тайрагдах, ясны үхжил болох /ос-	21.4	0-80	жил	
9. Мэргэжлээс шалтгаалсан хавдар						
.1	Дурангийн ажилбар, мэс засал, хими, туяа эмчилгээгээр бүрэн эмчлэгдсэн нэн эрт үе (Cancer in situ) болон эрт үеийн (I үе шат) хорт хавдрууд	Тухайн эрхтний хавдрын ICD кодоор ангилна	0-69	хүртэл жил		өдөлмөрийн нөхцөл солих
.2	Оношлогдсон бүрэн батлагдсан II, III үе шатны хорт хавдрууд (Мэс засал, хими, туяа эсвэл хавсарсан эмчилгээ хийгдсэн хавдрууд) (1. Дан мэс засал, хими, туяа эмчилгээ хийгдсэн II, III үе шатны хорт хавдрууд		0-79	хүртэл жил		
.3	Оношлогдсон бүрэн батлагдсан алсын болон ойрын эрхтэндээ үсэрхийлж IV үедээ орсон хорт хавдрууд		00	хүртэл жил		
.4	Хорт хавдрын үе шатнаас үл хамааран хавдрын эмчилгээнүүдийн улмаас биед үүссэн эдгэршгүй өөрчлөлтүүд (индурац, түр хугацаанд болон насан туршид тавигдсан цоргууд, мөч тайрагдсан байдал)		0-100	уга-цаагүй		

Энэхүү жагсаалтаар Мэргэжлээс шалтгаалсан өвчин болон Хурц хордлогын улмаас хөдөлмөрийн чадвар алдсан даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтыг магадлан шийдвэрлэх ба алслагдсан аймгийн болон гадаад оронд эмчлүүлэх шаардлагатай зэрэг шалтгаанаар хүсэлт гаргасан даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтыг 2 жилээр сунгаж болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 13 өдөр Дугаар 439 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 11.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж тогтоолгоход бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэвэр, тэтгэмж олгох журам”-ыг хавсралт ёсоор батлуулсугай.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяад, хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Л.Мөнхзул)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД Х.БУЛГАНТУЯА

ШТА1206 9023100304 5498449

Засгийн газрын 2023 оны 12 дугаар
сарын 13 -ны өдрийн 1139 дүгээр
тогтоолын хавсралт

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ДААТГАЛЫН САНГААС ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ ТОГТООЛГОХОД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ, ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ ОЛГОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-д заасны дагуу үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж тогтоолгоход бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон тэтгэвэр, тэтгэмж олгоход энэ журмыг баримтална.

1.2.Ажил олгогч даатгуулагчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж тогтооход шаардагдах баримт бичгийг хуульд заасан хугацаанд бүрдүүлж өгнө.

Хоёр.Тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт

2.1.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагч хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгоход доор дурдсан баримт бичгийг цаасаар, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлнэ:

2.1.1.хөдөлмөрийн, эсхүл эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчийн баталсан “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэсэн акт”;

2.1.2.даатгуулагчийг ажилд томилсон тухай тушаалын хуулбар;

2.1.3.даатгуулагчийн цалин, хөлсний тодорхойлолт (1 сараас доош хугацаанд ажилласан тохиолдолд).

2.2.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас нас барсан даатгуулагчийн асрамжид байсан хөдөлмөрийн чадваргүй гишүүн тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгоход энэ журмын 2.1-д заасан болон дараах баримт бичгийг цаасаар, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлнэ:

2.2.1.тэжээгчийн нас барсны гэрчилгээ, эсхүл эрх бүхий байгууллагын лавлагаа;

2.2.2.тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүний иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээний хуулбар, эсхүл эрх бүхий байгууллагын лавлагаа, шүүхийн шийдвэр;

2.2.3.гэрлэлтийн гэрчилгээний хуулбар, эсхүл эрх бүхий байгууллагын лавлагаа, шүүхийн шийдвэр.

Гурав.Тэтгэмж тогтоолгоход бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт

3.1.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдсан даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авахад дараах баримт бичгийг цаасаар, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлнэ:

3.1.1.эрүүл мэндийн байгууллагаас олгосон эмнэлгийн хуудас;

3.1.2.хөдөлмөрийн, эсхүл эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчийн баталсан "Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэсэн акт".

3.2.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж авахад дараах баримт бичгийг цаасаар, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлнэ:

3.2.1.даатгуулагчийн нас барсны гэрчилгээний хуулбар, эсхүл эрх бүхий байгууллагын лавлагаа, шүүхийн шийдвэр;

3.2.2.даатгуулагчийн гэр бүлийн гишүүний иргэний үнэмлэхийн хуулбар, эсхүл эрх бүхий байгууллагын лавлагаа;

3.2.3.даатгуулагч амьгүй донор болсон тухай эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт.

Дөрөв.Тэтгэврийн хэмжээг өөрчлөн тогтооход шаардагдах баримт бичиг

4.1.Тэтгэвэр авагч тэтгэврийн хэмжээг өөрчлөн тогтоолгох бол дараах баримт бичгийг өргөдлийн хамт цаасаар, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлнэ:

4.1.1.тэтгэвэр тогтоолгоход баримталсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлого өөрчлөгдөх үндэслэлтэй болсон нь тогтоогдсон тухай баримт;

4.1.2.хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаанд өөрчлөлт орсон тухай эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шийдвэр;

4.1.3.нас барсан тэжээгчийн асрамжид байсан хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн тоонд өөрчлөлт орсон тухай баримт;

4.1.4.тэтгэвэр авагч тэтгэвэр тогтоолгосноос хойш 12 сараас доошгүй хугацаанд тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн тухай баримт.

4.2.Нийгмийн даатгалын байгууллага энэ журмын 4.1.1, 4.1.2, 4.1.4-т заасан баримт бичгийг нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сангаас тодорхойлно.

Тав.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэвэр олгох

5.1.Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгох бол энэ журмын 2.1-д заасан баримт бичгийг өргөдлийн хамт нийгмийн даатгалын байгууллагад хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон өдрөөс хойш

14 хоногийн дотор, хэрэв хүндэтгэн үзэх шалтгаантай бол 3 сарын дотор хүсэлт гаргана.

5.2.Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох бол энэ журмын 2.2-т заасан баримт бичгийг өргөдлийн хамт нийгмийн даатгалын байгууллагад тэжээгч нас барснаас хойш 30 хоногийн дотор, хэрэв хүндэтгэн үзэх шалтгаантай бол 6 сарын дотор хүсэлт гаргана.

5.3.Нийгмийн даатгалын байгууллага даатгуулагчийн тэтгэвэр тогтоолгохыг хүссэн өргөдөл, баримт бичгийг хүлээн авснаас хойш 20 хоногийн дотор шийдвэрлэж үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох тэтгэврийг тэтгэвэр авагчийн сонгосон банкаар дамжуулан сар бүр олгоно.

5.4.Нийгмийн даатгалын байгууллага тэтгэвэр авагчийн нас барсны дараагийн сарын тэтгэврийг энэ журмын 3.2-т заасан баримт бичгийг үндэслэн банкаар дамжуулан тухайн сард нь багтаан олгоно.

5.5.Тэжээгчээ алдсаны тэтгэврийг хөдөлмөрийн чадваргүй гишүүдэд хуваан олгох тохиолдолд холбогдох өргөдөл, шүүхийн шийдвэрийг үндэслэнэ.

5.6.Даатгуулагч энэ журмын 5.1, 5.2-т заасан хугацаанаас хойш тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргаж болно.

5.7.Даатгуулагч тэтгэвэр, тэтгэмж авах цахим өргөдөл, баримт бичгийг нийгмийн даатгалын байгууллагад холбогдох цахим системээр илгээнэ.

Зургаа.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэмж олгох

6.1.Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах бол энэ журмын 3.1-д заасан баримт бичгийг өргөдлийн хамт нийгмийн даатгалын байгууллагад энэ журмын 7.4.3-т заасан баримт бичиг баталгаажсан өдрөөс хойш 4 долоо хоногийн дотор, хэрэв хүндэтгэн үзэх шалтгаантай бол 6 сарын дотор гаргана.

6.2.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж авах иргэн энэ журмын 3.2-т заасан баримт бичгийг өргөдлийн хамт нийгмийн даатгалын байгууллагад тэжээгч нь нас барснаас хойш 6 долоо хоногийн дотор, хэрэв хүндэтгэн үзэх шалтгаантай бол 6 сарын дотор гаргана.

6.3.Нийгмийн даатгалын байгууллага хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг даатгуулагчийн баримт бичиг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шийдвэрлэж үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас даатгуулагчийн сонгосон банкаар дамжуулан олгоно.

6.4.Нийгмийн даатгалын байгууллага нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийг баримт бичиг хүлээн авснаас хойш 24 цагийн дотор шийдвэрлэж үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас банкаар дамжуулан олгоно.

6.5.Хөдөлмөрийн чадвар түр алдсаны нэг сараас дээш хугацааны тэтгэмжийг 14 хоног тутам бодож олгоно.

6.6.Энэ журмын 6.1, 6.2-т заасан хугацаа хэтэрсэн тохиолдолд даатгуулагчид тэтгэмж олгохгүй.

6.7.Нийгмийн даатгалын байгууллага даатгуулагчид тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ, олгох хугацаа, олгосон дүн зэрэг мэдээллийг цахим үйлчилгээний нэгдсэн систем, даатгуулагчийн веб систем, нийгмийн даатгалын аппликейшн зэрэг цахимаар хүргэж болно.

Долоо.Бусад зүйл

7.1.Даатгуулагч нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас тэтгэвэр, тэтгэмж тогтооход шаардагдах баримт бичгийг өөрийн биеэр бүрдүүлэх боломжгүй бол хууль ёсны төлөөлөгч нь дараах баримт бичгийг цаасаар, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлнэ:

7.1.1.тэтгэвэр авагчийн хууль ёсны төлөөлөгч болон тэтгэвэр авагч иргэн эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон, чадамж хязгаарлагдсан бол асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тодорхойлсон шийдвэр;

7.1.2.хууль ёсны төлөөлөгч болон асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн иргэний үнэмлэх.

7.2.Энэ журмын 7.1-д заасан хууль ёсны төлөөлөгч тэтгэвэр авах бол энэ журмын 2.1, 2.2, тэтгэмж авах бол энэ журмын 3.1, 3.2-т заасан баримт бичгийг бүрдүүлнэ.

7.3.Гадаадын иргэн, харьяалалгүй хүн тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох бол энэ журамд заасан баримт бичгээс гадна эрх бүхий байгууллагын олгосон Монгол Улсад байнга оршин суудаг болохыг баталгаажуулсан баримт бичгийг бүрдүүлнэ.

7.4.Нийгмийн даатгалын байгууллага тэтгэвэр, тэтгэмж тогтооход нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сан болон холбогдох цахим мэдээллийн санг үндэслэн дараах мэдээллийг тодорхойлно. Үүнд:

7.4.1.нийгмийн даатгалын шимтгэл төлөлт;

7.4.2.хөдөлмөрийн чадвар алдсан тухай эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шийдвэр;

7.4.3.хөдөлмөрийн, эсхүл эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчийн баталсан “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэсэн акт”;

7.4.4.нас барсны, төрсний, гэрлэлтийн гэрчилгээ.

7.5.Энэ журмын 5.1, 5.2, 6.1, 6.2, 7.1-д заасан хүндэтгэн үзэх шалтгаан гэдгийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 2 дугаар зүйлийн 2.1.5-д зааснаар ойлгоно.

7.6.Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

----o0o----

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2024 оны 09 сарын 06 өдөр Дугаар 07 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1."Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг сонгох, арга хэмжээний зардлын төлбөрийг санхүүжүүлэх, хяналт тавих журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Тогтоолын хэрэгжилтийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хороотой хамтран зохион байгуулж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Ц.Ганцэцэг)-т даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба (Г.Банзрагч)-нд үүрэг болгосугай.

4.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан "Журам шинэчлэн батлах тухай" Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 10 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Л.ЭНХ-АМГАЛАН

1119276387
5284708 СБА1473

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн
2024 оны 09 дугаар сарын 06-ны өдрийн
07 дугаар тогтоолын хавсралт

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ БАЙГУУЛЛАГЫГ СОНГОХ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН ТӨЛБӨРИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа, судалгаа (цаашид "Урьдчилан сэргийлэх арга хэмжээ" гэх)-ны ажлыг зохион байгуулах байгууллагыг сонгох, арга хэмжээний зардлын төлбөрийг санхүүжүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Урьдчилан сэргийлэх арга хэмжээг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хороо, Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газар, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв (цаашид "Байгууллага" гэх) холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулна.

1.3. Байгууллага мэргэжлийн сургалтын байгууллагатай хамтран урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулна. Мэргэжлийн сургалтын байгууллага нь хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт явуулах болон шалгалт авах журам", "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын хөтөлбөр"-т тус тус заасан шаардлагыг хангасан, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сургалт зохион байгуулах гэрчилгээ авсан байна.

1.4. Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараа жилийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө ("цаашид төлөвлөгөө" гэх)-г сүүлийн 2 жилийн үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний тайлан мэдээлэлд үндэслэн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хорооны саналыг авч боловсруулан жил бүрийн 12 дугаар сард багтаан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр батлуулна.

Хоёр.Урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг сонгох

2.1. Байгууллага энэ журмын 1.4-т заасан төлөвлөгөөнд туссан урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулна.

2.2. Байгууллага энэ журмын 2.1-д заасан сонгон шалгаруулалтад тэнцсэн байгууллагатай гэрээ байгуулна. Гэрээнд урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг тусгаж батална.

2.3. Байгууллага Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хуульд заасны дагуу ажил үйлчилгээ, худалдан авах үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллана.

Гурав. Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төлбөрийг санхүүжүүлэх

3.1. Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт заасан арга хэмжээг хамааруулна.

3.2. Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Нийгмийн даатгалын сангийн төсвийн тухай хуулиар батлагдсан урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төсвийн нарийвчилсан хуваарийг баталж, энэ журмын 1.4-т заасан төлөвлөгөө, энэ журмын 2.2-т заасан гэрээг үндэслэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг батлагдсан төсвийн хүрээнд санхүүжүүлнэ.

3.3. Байгууллага урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагад энэ журмын 2.2-т заасан гэрээний дүнгийн 60 хүртэл хувиар тооцон урьдчилгаа олгож болох бөгөөд санхүүжилтийг дараах баримт бичгийг үндэслэн олгоно. Үүнд:

3.3.1. энэ журмын 2.1-д заасан сонгон шалгаруулалтын дүн, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах хүсэлт бүхий албан бичиг, ажил гүйцэтгэх гэрээ, хэрэв сургалт зохион байгуулах бол сургалтын хөтөлбөр, арга хэмжээний удирдамж, холбогдох шийдвэрүүд;

3.3.2. урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан, санхүүгийн анхан шатны баримтууд, төлбөрийн нэхэмжлэх.

3.4. Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын үлдэгдэл санхүүжилтийг урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсвийн гүйцэтгэлийн тайлан, анхан шатны баримт бичиг, арга хэмжээний үр дүнгийн тайлан ажил хүлээлцсэн болон гэрээ дүгнэсэн актад үндэслэн гүйцэтгэлээр санхүүжүүлнэ.

Дөрөв. Урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүн, төсвийн зарцуулалтыг тайлагнах

4.1. Урьдчилан сэргийлэх арга хэмжээг гүйцэтгэсэн байгууллага нь уг арга хэмжээний үр дүн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг тухайн арга хэмжээг зохион байгуулж дууссанаас хойш ажлын 7 өдрийн дотор гэрээ байгуулсан байгууллагад ирүүлнэ.

4.2. Байгууллага арга хэмжээний үр дүн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг хүлээн авснаас хойш ажлын 7 өдрийн дотор Нийгмийн даатгалын асуудал

хариуцсан төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

4.3. Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүн, төсвийн гүйцэтгэлийн тайланг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд хагас жил тутамд нэгтгэн тайлагнаж, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хороонд хүргүүлнэ.

4.4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг дараа жилийн эхний улиралд багтаан дүгнэж Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хороонд тайлагнана.

Тав. Хяналт

5.1. Энэхүү журмын хэрэгжилтэд нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл хяналт тавина.

5.2. Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүн, төсвийн гүйцэтгэлийн тайланг хугацаанд нь ирүүлээгүй байгууллагын энэ журмын 3.4-д заасан үлдэгдэл санхүүжилтийг зогсоох, мөн энэ журмын 2.2-т заасан гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна.

Зургаа. Хариуцлага

6.1. Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---o0o---

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2023 оны 11 сарын 17-ны өдрийн 6474 дугаарт бүртгэв.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

6474

2023 оны 10 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар А/143, А/376

Улаанбаатар хот

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох протез, ортопедийн жишиг үнэ батлах тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох протез, ортопедийн жишиг үнийг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Батжаргал/, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар /А.Өнөржаргал/-т, хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газарт тус тус даалгасугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн А/507, А/112 дугаар хамтарсан тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэхүү тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД

Х.БУЛГАНТУЯА

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

С.ЧИНЗОРИГ

Хөдөлмөр, нийгмийн хамгаалллын сайд,
Эрүүл мэндийн сайдын 2023 оны 10
дугаар сарын 26-ны өдрийн А/143/А/326
дугаар хамтарсан тушаалын хавсралт

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ПРОТЕЗ, ОРТОПЕДИЙН ЖИШИГ ҮНЭ

№	Протез, ортопедийн төрөл	Хэрэглэх заалт	Жишиг үнэ /төгрөгөөр/
01	Гавлын ясны протез	Гэмтлийн шалтгаантай гавал ясны цоорхойг хиймэл ясаар нөхөх	154 000
02	Гавлын ясны протез	Гавлын ясны цоорхойг титан тороор нөхөх	1 200 000
03	Нүдний хиймэл болор /уян, хатуу/	Гэмтлийн шалтгаантай нүдний болрын гэмтэл	460 000
04	Шилэн нүд	Гэмтлийн шалтгаантай нүдний гэмтэл	85 000
05	Нулимсны сувгийн протез	Гэмтлийн шалтгаантай нулимсны сувгийн гэмтэл	121 000
06	Сонсголын ясны протез	Гэмтлийн шалтгаантай чамархай ясны гэмтэл	154 000
07	Дунд чихний титан протез	Гэмтлийн шалтгаантай чихний гэмтэл	350 000
08	Хамрын ясны протез ПМП-01 /зөөлөн пластик/	Гэмтлийн шалтгаантай хамрын ясны гэмтэл	181 500
09	Шанааны ясны протез	Гэмтлийн шалтгаантай шанаан ясны бяцралт	1 452 000
10	Эрүүний ясны протез	Гэмтлийн шалтгаантай эрүүний ясны бяцралт, хугаралт	1 331 000
	Гарын протез:		
11	Нэг гарын протез	Гэмтлийн шалтгаантай мөрний үений тайралт	3 000 000
12	Бугалганы протез	Гэмтлийн шалтгаантай тохойн үений тайралт	1 815 000
13	Бугалганаас урагш хийгдэх протез	Гэмтлийн шалтгаантай тохойн үений тайралт	1 540 000
14	Шуу, сарвууны протез	Гэмтлийн шалтгаантай шууны хэсгийн тайралт	1 100 000
	Хөлийн протез:		
15	Нэг хөлийн протез	Гэмтлийн шалтгаантай түнхний үений тайралт	1 760 000
16	Дунд чөмөгний протез	Гэмтлийн шалтгаантай дунд чөмөгний тайралт	1 705 000

17	Шилбэний протез	Гэмтлийн шалтгаантай шилбэний ясны тайралт	1 210 000
18	Тавхайн протез	Гэмтлийн шалтгаантай шагай, тавхайн тайралт	880 000
	Хиймэл үе:		
19	Нурууны хиймэл үе	Гэмтлийн шалтгаантай нурууны муруйлт	5 500 000
20	Түнхний хиймэл үе	Гэмтлийн шалтгаантай дунд чөмөгний хүзүү, толгойн хугарал, артроз -ил хугарлаас үүссэн үе үүсгэгч яснуудын үрэвсэл -архаг үрэвслийн улмаас үүссэн контрактур, -регидность, -анкелоз /10-15 градус/	4 400 000
21	Өвдөгний хиймэл үе	Гэмтлийн шалтгаантай -II, III, IY зэргийн артроз -үе үүсгэгч яснуудын хиймэл хугарал, -үрэвслийн улмаас үүссэн контрактур, -регидность, -анкелоз /15-30 градус/	5 500 000
22	Тохой, шагайн хиймэл үе	Гэмтлийн шалтгаантай -II, III, IY зэргийн артроз -үе үүсгэгч яснуудын хиймэл хугарал, -үрэвслийн улмаас үүссэн контрактур, -регидность, -анкелоз	3 300 000
23	Хүзүү, нурууны ясны металл бэхэлгээ	Гэмтлийн шалтгаантай хүзүү, нурууны гэмтлийн үед	990 000
24	Хүзүү, нурууны ясны титан бэхэлгээ	Гэмтлийн шалтгаантай хүзүү, нурууны гэмтлийн үед	8 500 000
25	Гэмтэл, түлэгдэлтийн сорви татанхайн үед	Гэмтэл, түлэнхийн шалтгаантай тулгуур, хөдөлгөөний эрхтэний хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан сорви, татанхай, зөөлөн эдийн дутмагшлын сорвижилтын улмаас сарвуу, хуруу, тавхайн идэвхитэй, идэвхигүй хөдөлгөөн алдагдсан /2-3 балл/	11 000 000
26	Гажиг засах бүх төрлийн гутал	Гэмтлийн шалтгаантай тавхайн согог, богиноссон хөлөнд	220 000
	Сонсголын аппарат:		

27	Сонсголын дижитал аппарат /нэг чихний/	Гэмтлийн шалтгаанаар хүлээн авах ба дамжуулах хэлбэрийн сонсгол бууралтын I үе /40-60 дб/, II,III үе /60-80 дб/, IY үе /80 дб-ээс дээш/	2 000 000
28	Сонсголын дижитал аппарат /хоёр чихний/	Гэмтлийн шалтгаанаар хүлээн авах ба дамжуулах хэлбэрийн сонсгол бууралтын I үе /40-60 дб/, II,III үе /60-80 дб/, IY үе /80 дб-ээс дээш/	616 000
	Бусад:		
29	Бионик хиймэл эрхтэн	Гэмтлийн шалтгаантай эрхтэн тайралттай үед	15 000 000

---oOo---

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2023 оны 12 сарын 04 өдөр Дугаар 10 Улаанбаатар хот

Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох хэмжээг тогтоох тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 35 дугаар зүйлийн 35.9.8 дахь заалт, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох хэмжээг нэг ор хоногт 70 000 /далан мянга/ төгрөгөөр тогтоосугай.

2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас сувиллын газарт олгож байгаа санхүүжилт, үйлчилгээний чанарт тогтмол хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Л.Мөнхзул/-т үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба /Г.Банзрагч/-нд үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 16 дугаар тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.

5. Энэхүү тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА Х.БУЛГАНТУЯА

1119276367
5284708 СБА1473

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 11 сарын 29 өдөр Дугаар 422 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 14.10-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас даатгуулагч эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон төлбөрийг олгох, санхүүжүүлэх журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Л.Мөнхзул)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД Х.БУЛГАНТУЯА

Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 322 дугаар тогтоолын хавсралт

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ДААТГАЛЫН САНГААС ДААТГУУЛАГЧ ЭРҮҮЛ МЭНДИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ЗАРДЛЫН ТӨЛБӨР АВАХАД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ БОЛОН ТӨЛБӨРИЙГ ОЛГОХ, САНХҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 14.10-д заасны дагуу даатгуулагчид протез, ортопедийн, сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний, сэргээн засах төв болон сувилалд ирэх, буцах унааны зардлын төлбөр олгох, санхүүжүүлэхэд энэ журмыг баримтална.

1.2.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагч эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн сангаас протез, ортопедийн, сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний, сэргээн засах төв болон сувилалд ирэх, буцах унааны зардлын төлбөрийг гаргуулсан бол үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас зардлын төлбөрийг давхардуулан олгохгүй.

Хоёр.Зардлын төлбөр авахад бүрдүүлэх баримт бичиг

2.1.Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез, ортопедийн зардлын төлбөр авах хүсэлтийг доор дурдсан баримт бичгийн хамт харьяа нийгмийн даатгалын байгууллагад цаасаар, эсхүл цахим хэлбэрээр ирүүлнэ:

2.1.1.төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн дүгнэлт, эсхүл эрүүл мэндийн байгууллагын шийдвэр;

2.1.2.протез, ортопед хийлгэсэн эмнэлгийн байгууллага болон протезийн үйлдвэрээс ирүүлсэн төлбөрийн нэхэмжлэх (харилцагч банкны нэр, дансны дугаар, нэхэмжилсэн төлбөрийн дүн).

2.2.Сэргээн засах төв болон сувиллын тусламж, үйлчилгээний байгууллага нь сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох зардлыг авах хүсэлтийг доор дурдсан баримт бичгийн хамт харьяа нийгмийн даатгалын байгууллагад цаасаар, эсхүл цахим хэлбэрээр ирүүлнэ:

2.2.1.тусламж, үйлчилгээ авсан даатгуулагчийн мэдээлэл (овог, нэр, регистрийн дугаар);

2.2.2.төлбөрийн нэхэмжлэх (харилцагч банкны нэр, дансны дугаар, нэхэмжилсэн төлбөрийн дүн).

2.3.Даатгуулагч сэргээн засах төв болон сувилалд ирэх, буцах унааны зардлын төлбөрийг авах хүсэлтийг унааны зардал төлсөн баримтын хамт харьяа нийгмийн даатгалын байгууллагад цаасаар, эсхүл цахим хэлбэрээр ирүүлнэ.

Гурав.Протез, ортопедийн зардлын төлбөр олгох

3.1.Протез, ортопедийн зардлын төлбөр авах даатгуулагч харьяа нийгмийн даатгалын байгууллагад энэ журмын 2.1-д заасан баримт бичийг бүрдүүлэн энэ журмын 2.1.2-т заасан нэхэмжлэх бичигдсэн өдрөөс хойш 4 долоо хоногийн дотор, хэрэв хүндэтгэн үзэх шалтгаантай байсан бол 3 сарын дотор хүсэлтээ гаргана.

3.2.Нийгмийн даатгалын байгууллага даатгуулагчид энэ журмын 2.1-д заасан баримт бичгийг үндэслэн, жишиг үнийг баримтлан төлбөрийг 3 жил тутамд нэг удаа олгоно.

3.3.Нийгмийн даатгалын байгууллага энэ журмын 2.1-д заасан баримт бичгийг үндэслэн төлбөр олгохдоо хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шийдвэрийг нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сангийн, үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэсэн актын мэдээллийг холбогдох мэдээллийн санд үндэслэн цахимаар шалгана.

3.4.Нийгмийн даатгалын байгууллага даатгуулагчийн баримт бичгийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор протез, ортопедийн зардлын төлбөрийг эмнэлгийн байгууллага болон протезийн үйлдвэрээс ирүүлсэн төлбөрийн нэхэмжлэхийн дагуу үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас бэлэн бусаар шилжүүлнэ.

3.5.Даатгуулагчийн дахин хийлгэсэн протез, ортопедийн төлбөрийг олгохдоо энэ журмыг баримтална.

3.6.Энэ журмын 2.1.2-т заасан нэхэмжилсэн төлбөрийн дүн нь тухайн протез, ортопедийн жишиг үнээс бага бол нэхэмжилсэн үнийн дүнгээр, их бол жишиг үнийг баримтална.

3.7.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас даатгуулагчид протез, ортопедийн засвар, үйлчилгээний төлбөр олгохгүй.

3.8.Даатгуулагч гадаад улсад хийлгэсэн протез, ортопедийн зардлын төлбөрийг авахдаа энэ журмын 2.1-д заасан баримт бичгийг харьяа нийгмийн даатгалын байгууллагад цаасаар, эсхүл цахим хэлбэрээр ирүүлнэ.

3.9.Гадаад улсад хийлгэсэн протез, ортопедийн зардлын төлбөр олгохдоо энэ журмын 3.4-т заасныг баримтална. Хэрэв даатгуулагч төлбөрөө өөрөө төлсөн бол баримтыг үндэслэн даатгуулагчийн дансанд 14 хоногийн дотор бэлэн бусаар шилжүүлнэ.

Дөрөв.Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний зардлын төлбөр олгох

4.1.Сэргээн засах төв болон сувилал нь сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох зардлыг авах хүсэлтийг харьяа нийгмийн даатгалын байгууллагад энэ журмын 2.2-т заасан баримт бичиг бүрдүүлэн сар бүр гаргана.

4.2.Нийгмийн даатгалын байгууллага сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох зардлыг эрх бүхий байгууллагын тогтоосон хэмжээг баримтлан энэ журмын 2.2-т заасан баримт бичгийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор сэргээн засах төв болон сувилалд бэлэн бусаар олгоно.

4.3.Нийгмийн даатгалын байгууллага энэ журмын 4.2-т заасны дагуу зардлын төлбөрийг олгохдоо энэ журмын 3.3, 5.3-т заасны дагуу холбогдох мэдээллийг шалгана.

Тав.Сэргээн засах төв болон сувилалд ирэх, буцах унааны зардлын төлбөр олгох

5.1.Даатгуулагч сэргээн засах төв болон сувилалд сувилуулснаас хойш 4 долоо хоногийн дотор, хэрэв хүндэтгэн үзэх шалтгаантай байсан бол 3 сарын дотор энэ журмын 2.3-т заасан баримт бичиг бүрдүүлэн харьяа нийгмийн даатгалын байгууллагад ирэх, буцах унааны зардлын төлбөр авах хүсэлт гаргана.

5.2.Нийгмийн даатгалын байгууллага сэргээн засах төв болон сувилалд ирэх, буцах унааны зардлын төлбөрийг галт тэрэг, хот хоорондын нийтийн тээврийн тухайн үед мөрдөж байгаа үнийг үндэслэн энэ журмын 2.3-т заасан баримт бичгийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор даатгуулагчид бэлэн бусаар олгоно.

5.3.Энэ журмын 2.3-т заасан баримт бичгийг үндэслэн зардлын төлбөрийг олгохдоо энэ журмын 3.3-т зааснаас гадна нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэлд үндэслэн тухайн даатгуулагчийг сэргээн засах төв болон сувилалд сувилуулсан эсэхийг цахимаар шалгана.

Зургаа.Санхүүжүүлэх, хяналт тавих

6.1.Энэ журмын дагуу олгох төлбөрийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлнэ.

6.2.Сангийн хөрөнгийн зарцуулалтад нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Төв зөвлөл, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газар тус тус хяналт тавьж ажиллана.

Долоо.Тайлагнах

7.1.Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газар даатгуулагчид олгосон протез, ортопедийн зардлын төлбөрийн тайланг сар бүрийн 10-ны өдрийн дотор нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

7.2.Даатгуулагчид олгосон сэргээн засах төв болон сувилалд ирэх, буцах унааны зардлын төлбөр, сэргээн засах төв болон сувилалд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгосон зардлын төлбөрийн тайланг аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газар улирал бүр гаргаж, дараа сарын 10-ны өдрийн дотор нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

Найм.Хариуцлага

8.1.Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

----o0o----

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 04 өдөр Дугаар 11 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 14 дүгээр зүйлийн 14.9 дэх хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Даатгуулагчид тусламж, үйлчилгээ үзүүлэх сэргээн засах төв болон сувиллыг сонгох, гэрээ байгуулах, санхүүжүүлэх, тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих журмыг хавсралтаар батлалсугай.

2. Тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Л.Мөнхзул/-т даалгасугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба /Г.Банзрагч/-нд үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжих сувиллыг сонгон шалгаруулах журам батлах, сувиллын санхүүжилтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 06 дугаар тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

5. Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА Х.БУЛГАНТУЯА

1119276367
5284708 СБА1473

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн
2023 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн
11 дугаар тогтоолын хавсралт

1119276367
5284708 СБА1473

ДААТГУУЛАГЧИД ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ СЭРГЭЭН ЗАСАХ ТӨВ БОЛОН СУВИЛЛЫГ СОНГОХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ, САНХҮҮЖҮҮЛЭХ, ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРТ ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 14 дүгээр зүйлийн 14.9 дэх хэсэгт заасныг үндэслэн даатгуулагчид тусламж, үйлчилгээ үзүүлэх сэргээн засах төв болон сувилал /цаашид "сувилал" гэх/-г сонгох, гэрээ байгуулах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний нийгмийн даатгалын сангаас санхүүжүүлэх, тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих харилцааг зохицуулахад оршино.

1.2. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжих сэргээн засах төв болон сувиллын сонгон шалгаруулалт нь Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/, Эрүүл мэндийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хууль, энэ журмаар зохицуулагдана.

1.3. Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь сэргээн засах төв болон сувиллын сонгон шалгаруулалт явуулах хугацаа, сонгон шалгаруулалтад оролцогч байгууллагад тавигдах шаардлага, оролцогч байгууллагын бүрдүүлэх баримт бичиг, үнэлэх арга, үнэлгээний хуудсаар үнэлж шалгаруулна.

1.4. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжих сэргээн засах төв болон сувиллын сонгон шалгаруулалтыг жил тутамд зохион байгуулна.

1.5. Даатгуулагчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжих сувилал нь Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилттэй давхцахгүй байна.

Хоёр. Сэргээн засах төв болон сувиллыг сонгох

2.1. Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь сэргээн засах төв болон сувиллыг сонгон шалгаруулах ажлын хэсэг /цаашид "ажлын хэсэг" гэх/-ийн бүрэлдэхүүнийг байгуулна.

2.2. Сэргээн засах төв болон сувиллыг сонгон шалгаруулах ажлын хэсгийг жил бүр шинээр байгуулж ажиллана.

2.3. Ажлын хэсэг нь сэргээн засах болон сувиллын сонгон шалгаруулалтыг дараах дэс дарааллаар явуулна:

2.3.1. Сэргээн засах төв болон сувиллын сонгон шалгаруулалт явуулах тухай зарыг төрийн худалдан авах ажиллагааны цахим системд байршуулах, олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, холбогдох хууль тогтоомжийн дагуу ил тод нээлттэй зарлан мэдээлэх;

2.3.2. Сэргээн засах төв болон сувиллын сонгон шалгаруулалтад ирүүлсэн баримт бичгийн бүрдэлтийг шалгаж, ажлын хэсгийн хурлыг хуралдуулж, танилцуулах;

2.3.3. Сэргээн засах төв болон сувиллын сонгон шалгаруулалтад ирүүлсэн баримт бичиг бүртэй танилцаж, сонгон шалгаруулалтад оролцогч байгууллагад тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичгийн бүрдэлт, үнэлэх аргын дагуу үнэлгээний хуудсаар үнэлж үнэлгээ өгөх;

2.3.4. Баримт бичгийн шаардлага хангасан сэргээн засах төв болон сувиллын үйл ажиллагаатай газар дээр нь танилцах, үнэлгээ хийх;

2.3.5. Сэргээн засах төв болон сувиллын сонгон шалгаруулалтыг хууль, тогтоомж, журмыг баримтлан заасан хугацаанд, сонгон шалгаруулалтын нэгдсэн дүнг гаргах;

2.3.6. Сэргээн засах төв болон сувиллын сонгон шалгаруулалтад оролцсон байгууллагуудад мэдэгдэл, албан бичиг хүргүүлэх;

2.3.7. Сэргээн засах төв болон сувиллын сонгон шалгаруулалтын ажлын хэсгийн дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, гишүүд гарын үсэг зурж, баталгаажуулан Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргад танилцуулах.

2.4. Ажлын хэсгийн гишүүдийн 70-аас доошгүй хувийн ирцтэй хурлыг хүчинтэйд тооцох ба хуралдах бүртээ хурлын тэмдэглэл хөтөлж, сонгон шалгаруулалттай холбоотой аливаа асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.

2.5. Сэргээн засах төв болон сувиллын сонгон шалгаруулалтад тэнцэж гэрээ байгуулсан байгууллагын мэдээллийг Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын цахим хуудсанд байршуулж нийтэд мэдээлнэ.

Гурав. Сонгон шалгаруулалтад оролцогч байгууллагад тавигдах шаардлага

3.1. Сонгон шалгаруулалтад өмчийн бүх хэлбэрийн сэргээн засах төв болон сувиллын тусламж, үйлчилгээ үзүүлэх эрх бүхий байгууллага оролцоно.

3.2. Сонгон шалгаруулалтад оролцох сэргээн засах төв болон сувилал нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

3.2.1. Эрх бүхий төрийн байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд сэргээн засах, сувиллын тусламж, үйлчилгээг тогтвортой үзүүлдэг байх;

3.2.2. Сэргээн засах төв болон сувилал нь "Рашаан сувиллын бүтэц үйл ажиллагааны MNS 5232:2019" стандартын А хавсралтад заасан хүний нөөцтэй байх;

3.2.3. Сэргээн засах төв болон сувилал нь "Рашаан сувиллын бүтэц үйл ажиллагаа MNS 5232:2019" стандартын Б хавсралтад заасан эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжөөр хангагдсан байх;

3.2.4. Сэргээн засах төв болон сувилал нь "Рашаан сувиллын бүтэц үйл ажиллагаа MNS 5232:2019" стандартын В хавсралтын 2 дахь хэсэгт заасан сэргээн засах эмчилгээг бүрэн үзүүлдэг байх;

3.2.5. "Барилга, байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх" /БНбД 31-23-22/ MNS 6055:2009 "Иргэний барилгын төлөвлөлт хөгжлийн бэрхшээлтэй иргэний шаардлагыг тооцсон орон зай, орчин" шаардлага хангасан байх;

3.2.6. "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар" MNS 6056:2009 шаардлагыг хангасан байх;

3.2.7. Хяналт шалгалтын эрх бүхий байгууллагаас тавьсан акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлт бүрэн хангагдсан байх;

3.2.8. Сувиллын анхан шатны бүртгэлийн баримт бичиг, статистик мэдээ, мэдээлэл, тайлан гаргах, мэдээлэл дамжуулах, нэхэмжлэх зэрэг үйл ажиллагаа цахим хэлбэрт бүрэн шилжсэн байх;

3.2.9. Өмчлөлийн аль нэг хэлбэрийн ямар нэгэн маргаангүй байх;

3.2.10. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтыг сэргээн засах чиглэлээр үйлчлэх хүрээ, санхүүжих орны тоо, жилд сувилах даатгуулагчийн тоо, санхүүжилтийн хэмжээг урьдчилан тооцож, санхүүжилтийг сэргээн засах тусламж, үйлчилгээнд хэрхэн үр дүнтэй зарцуулах талаар тооцоо, судалгаа, хүрэх үр дүнг урьдчилан төлөвлөсөн байх.

3.3. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр дахин сонгон шалгаруулалтад оролцох эрхийг түдгэлзүүлсэн хугацаа дуусгавар болоогүй сэргээн засах төв болон сувилал сонгон шалгаруулалтад оролцох эрхгүй.

Дөрөв. Сонгон шалгаруулалтад оролцогч байгууллагын бүрдүүлэх баримт бичиг

4.1. Сэргээн засах төв болон сувиллын сонгон шалгаруулалтад оролцогч байгууллага нь дараах баримт бичгийг цаасан эсхүл цахимаар бүрдүүлнэ. Үүнд:

4.1.1. Сонгон шалгаруулалтад оролцох тухай хүсэлт;

4.1.2. Сэргээн засах төв болон сувиллын дэлгэрэнгүй танилцуулга /сувиллын байршил, тусламж, үйлчилгээний нэр төрөл, үндсэн үзүүлэлт, орны фонд ашиглалт, дундаж ор хоног, сувилуулагчдаас авсан сэтгэл ханамжийн судалгааны дүн, авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тусгасан байна/;

4.1.3. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

4.1.4. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;

4.1.5. Магадлан итгэмжлэгдсэн тохиолдолд батламжийн хуулбар;

4.1.6. Сэргээн засах төв болон сувиллын бүтэц, орон тоог баталсан холбогдох байгууллагын шийдвэр;

4.1.7. Сэргээн засах төв болон сувиллын дотоод зохион байгуулалт, байршлын бүдүүвч зураг, гадна, дотор орчны фото зураг эсхүл видео бичлэг;

4.1.8. Хүний нөөцийн дэлгэрэнгүй судалгаа /овог, нэр, албан тушаал, мэргэшлийн байдал, тус сэргээн засах төв болон сувилалд ажилласан жил,

эмчлэх, сувилах тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, мэргэжлийн диплом, үнэмлэхийн дугаар, хуулбарын хамт/;

4.1.9. Сэргээн засах төв болон сувиллын үйл ажиллагааны тайлан, тусламж, үйлчилгээний чанарын албаны төлөвлөгөө,тайлан;

4.1.10. Багаж тоног төхөөрөмжийн жагсаалт, тоног төхөөрөмжийн баталгаажуулалт хийсэн гэрээний хуулбар;

4.1.11. Нийгмийн даатгалын болон татварын өргүй тухай тодорхойлолт /сүүлийн сараар/;

4.1.12. Харьяалах Эрүүл мэндийн газрын тодорхойлолт /сэргээн засах төв болон сувиллын үйл ажиллагааны тогтвортой байдал, тусламж, үйлчилгээний чанар, орны фонд эргэлт, сэргээн засах төв болон сувилалтай холбоотой өргөдөл гомдол гарсан эсэх, түүний үндэслэл, шийдвэрлэлт, гэрээний биелэлт зэргийг тусгасан/;

4.1.13. Нийгмийн даатгалын газар, Эрүүл мэндийн газар, Татвар, аудит зэрэг байгууллагаас хийсэн хяналт шалгалтын дүн, тайлан, тавьсан акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хангаж ажилласан тайлан;

4.1.14. Сонгон шалгаруулалтад оролцогч нь өмчлөлийн маргаангүйг нотолсон Улсын бүртгэлийн газар болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цахим лавлагаа;

4.2. Сэргээн засах төв болон сувилал нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдсан даатгуулагчид хөдөлмөрийн чадвар алдалтыг сэргээн засах чиглэлээр үйлчлэх хүрээ, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжих орны тоо, жилд сувилах даатгуулагчийн тоо, санхүүжилтийг сэргээн засах тусламж, үйлчилгээ хэрхэн үр дүнтэй зарцуулах талаар хийсэн тооцоо, судалгаа, хүрэх үр дүнг урьдчилан төлөвлөсөн байна.

Тав. Сонгон шалгаруулалтад оролцогч байгууллагыг үнэлэх, мэдэгдэх

5.1. Ажлын хэсгийн гишүүн бүр сонгон шалгаруулалтын нээлтийн үед техникийн санал нь дурдагдан, бүртгэгдсэн баримт бичиг бүртэй нэг бүрчлэн танилцаж, үнэлж дүгнэнэ.

5.2. Ажлын хэсгийн гишүүд ерөнхий, тусгай шалгуур үзүүлэлт болон нийт оноог тооцон дүгнэлт хэсэгт тэнцсэн эсэх талаар тэмдэглэж, гарын үсэг зурж баталгаажуулна.

5.3. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нь “Тэнцсэн”, “Тэнцээгүй” гэж дүгнэгдсэн оролцогчдын жагсаалтыг тус тусад нь гарган ажлын хэсгийн дарга, гишүүдэд танилцуулж, гарын үсэг зурж баталгаажуулан сэргээн засах төв болон сувиллын байгууллагад мэдэгдэнэ.

5.4. Сонгон шалгаруулалтад оролцогч нь тэнцээгүй тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногт багтаан нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад гомдлоо бичгээр гаргаж болно. Гомдлыг 14 хоногийн хугацаанд шийдвэрлээгүй, эсхүл гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд гомдол гаргах эрхтэй.

Зургаа. Сонгон шалгаруулалтад тэнцсэн сэргээн засах төв болон сувилалтай гэрээ байгуулах

6.1. Сонгон шалгаруулалтад тэнцсэн сэргээн засах төв болон сувиллын байгууллагатай Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь "Даатгуулагчид сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г нэг жилийн хугацаатай байгуулна.

6.2. Даатгуулагчид сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх гэрээ"-нд даатгуулагчийн эрүүл мэндийн хэрэгцээ шаардлагад нийцсэн чанартай тусламж, үйлчилгээний нэр төрөл, орны дээд хязгаар, жилд сувилуулах даатгуулагчийн тоо, нийт ор хоног, нэг ор хоногийн зардлын хэмжээ, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх зардлын хэмжээ, талуудын хүлээх үүрэг, хариуцлага, гэрээний нөхцөл зэргийг заасан байна.

6.3. Сэргээн засах төв болон сувилал нь зайлшгүй шаардлагаар гэрээнд тусгагдаагүй нэмэлт, тусламж, үйлчилгээ гүйцэтгэх тохиолдолд тухайн үйлчилгээнд нэмэлт гэрээ байгуулж болно.

Долоо. Сонгон шалгаруулалтад тэнцсэн сэргээн засах төв болон сувиллыг санхүүжүүлэх

7.1. Даатгуулагчид сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан байгууллагад үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжих хувьсах зардлын хэмжээгээр тооцож Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага холбогдох журамд заасны дагуу санхүүжүүлнэ.

7.2. Сэргээн засах төв болон сувилал нь батлагдсан төсөвтөө багтаан тухайн жилд үзүүлэх тусламж үйлчилгээг олон нийтэд ил тод мэдээлж, даатгуулагчийг сонголт хийх боломжоор хангана.

Найм. Сэргээн засах төв болон сувиллын тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих

8.1. Нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, бусад мэргэжлийн байгууллага нь сэргээн засах төв болон сувиллын тусламж, үйлчилгээний чанар, орны дээд хязгаар, жилд сувилуулах даатгуулагчийн тоо, нийт ор хоног, нийгмийн даатгалын байгууллагаас санхүүжүүлсэн зардлын хэмжээ зэрэгт холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавина.

8.2. Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага сэргээн засах төв болон сувиллын үйл ажиллагаа, тусламж, үйлчилгээний чанар, сангийн зарцуулалтад хяналт тавьж ажиллана.

8.3. Сэргээн засах төв болон сувиллын ерөнхий эмч, чанарын алба, эмчлэгч эмч нь өдөр тутмын үйл ажиллагаа, тусламж, үйлчилгээний чанарт тавих дотоодын хяналтыг хариуцна. Магадлалын төв зөвлөл болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн магадлагч эмч нь сэргээн засах төв болон сувиллын үйл ажиллагаа, тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавьж ажиллана.

8.4. Нийгмийн даатгалын байгууллага нь эрүүл мэндийн болон бусад мэргэжлийн байгууллагатай хамтарсан хяналт шалгалтыг зохион байгуулна.

зөвлөлийн магадлагч эмч нь сэргээн засах төв болон сувиллын үйл ажиллагаа, тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавьж ажиллана.

8.4. Нийгмийн даатгалын байгууллага нь эрүүл мэндийн болон бусад мэргэжлийн байгууллагатай хамтарсан хяналт шалгалтыг зохион байгуулна.

Ес. Хариуцлага

9.1. Явцын үнэлгээ болон хяналт шалгалтаар ноцтой зөрчил дутагдал илэрсэн, хуурамч баримт бичиг бүрдүүлсэн, худал мэдээлсэн, гэрээнд заасан үүргээ хангалтгүй биелүүлсэн, гэрээний хэрэгжилтийг хангалтгүй дүгнүүлсэн тохиолдолд гэрээг цуцалж, гэрээр цуцалсан өдрөөс хойш нэг жилийн хугацаанд дахин сонгон шалгаруулалтад оролцох эрхийг түдгэлзүүлэх хүртэл арга хэмжээ авна.

9.2. Сонгон шалгаруулалтын ажлын хэсгийн, гишүүдийн хариуцлагагүй байдлын улмаас сонгон шалгаруулалтад алдаа гарсан тохиолдолд Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуулийн хүрээнд хариуцлага тооцно.

9.3. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас үндэслэлгүйгээр санхүүжилт авсан сувиллын газрын албан тушаалтан, хуурамч баримт бичиг бүрдүүлэн үйлчилгээ авсан хүнд холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

9.4. Энэ журмыг зөрчсөн байгууллага, хүнд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 27 өдөр Дугаар 471 Улаанбаатар хот

Жагсаалт, журам батлах тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 18.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг 1.5 хувиар төлөх ажил мэргэжлийн жагсаалт”-ыг 1 дүгээр хавсралт, “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг 2.5 хувиар төлөх ажил мэргэжлийн жагсаалт”-ыг 2 дугаар хавсралт, “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэл төлөх ажил мэргэжлийн жагсаалтыг хэрэглэх журам”-ыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2.Энэ тогтоолд заагаагүй бусад ажил мэргэжлийн төлбөл зохих үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 0.5 хувиар тогтоосугай.

3.Энэ тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Л.Мөнхзул)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяад тус тус үүрэг болгосугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2008 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 142 дугаар тогтоол, “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2017 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 17 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5.Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД Х.БУЛГАНТУЯА

Засгийн газрын 2023 оны 12 дугаар
сарын 27 -ны өдрийн 471 дүгээр
тогтоолын 1... дүгээр хавсралт

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ 1.5 ХУВИАР ТӨЛӨХ АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН ЖАГСААЛТ

№	**ҮНДЭСНИЙ АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН ИНДЕКС/КОД**	Нэгж	бүлэг
	1321 Үйлдвэрийн менежер		
1	Дарга, мастер /менежер/, алба, хэлтэс, тасаг, цех, ээлжийн /боловсруулах үйлдвэрлэлийн менежер/	1321	12
	1323 Барилга угсралтын менежер		
2	Дарга, мастер /менежер/, алба, хэлтэс, тасаг, цех, ээлжийн /барилга угсралтын/	1323	11
	2112 Цаг уурч		
3	Инженер, радарын	2112	14
4	Инженер, КИП автоматикийн	2112	15
5	Инженер, синоптикийн	2112	17
	2113 Химич		
6	Агрохимич	2113	11
7	Биохимич	2113	12
8	Химич, арьс ширний	2113	14
9	Химич, резиний	2113	15
10	Химич, агаар мандлын	2113	16
11	Химич, байгалийн нэгдлийн	2113	17
12	Химич, будгийн	2113	18
13	Химич, задлан шинжилгээний	2113	19
14	Химич, кристаллографын	2113	20
15	Химич, нийлэг материалын	2113	23
16	Химич, нэхмэлийн	2113	24
17	Химич, органик бодисын	2113	25
18	Химич, органик бус бодисын	2113	26
19	Химич, усны	2113	28
20	Химич, физикийн	2113	29
21	Химич, хуванцрын	2113	30
22	Химич, хүнсний	2113	31
23	Химич, чанар шалгалтын	2113	34
24	Химич, шилний	2113	35
25	Химич, экологийн	2113	37
26	Химич, ховор элементийн, технологич	2113	47
27	Химич, сансар судлалын	2113	48
28	Химич, микроэлементийн	2113	49
29	Аналитик химич	2113	51
	2114 Геологич, геофизикч		
30	Галт уул судлаач	2114	14
31	Геологич, инженер	2114	15

32	Геологич, инженер /эрэл зураглалын/	2114	18
33	Геологич, микро палентологийн	2114	19
34	Геологич, гол, мөрөн судлалын	2114	22
35	Геологич, эрдэс судлалын	2114	23
36	Геоморфологич	2114	24
37	Геофизикч	2114	25
38	Геофизикч, геоморфологийн /газрын гадаргуу судлалын/	2114	26
39	Геофизикч, гидрологийн	2114	27
40	Геофизикч, гидрологийн /гол, мөрөн судлалын/	2114	28
41	Гидрогеологич	2114	29
42	Мөс судлаач	2114	30
43	Чулуу судлаач	2114	31
44	Эрдэс судлаач	2114	32
45	Геохимич	2114	33
	2131 Биологич, ботаникч, амьтан судлаач, холбогдох бусад мэргэжилтэн		
46	Биологич	2131	12
47	Биологич, молекулын	2131	13
48	Биологич, хөгжлийн	2131	14
49	Гидробиологич	2131	15
50	Гистологич, цитологич, эмбриологич	2131	16
51	Иммунологич	2131	17
52	Инженер, генетикийн	2131	18
53	Микробиологич	2131	21
54	Нян судлаач	2131	22
55	Нян судлаач, загасны	2131	23
56	Нян судлаач, хөрсний	2131	24
57	Нян судлаач, хөдөө аж ахуйн	2131	25
58	Нян судлаач, үйлдвэрийн	2131	26
59	Нян судлаач, сүү, хүнсний бүтээгдэхүүний	2131	27
60	Нян судлаач, эмнэлгийн	2131	29
61	Паразитологич	2131	30
62	Бактери судлаач	2131	42
63	Биотехнологич	2131	43
64	Эсийн генетикч	2131	44
65	Молекулын генетикч	2131	46
66	Биотехнологич	2131	48
67	Биофизикч	2131	49
68	Биохимич, биотехнологич	2131	50
69	Микробиологич, биофизикч	2131	52
70	Эсийн генетикч	2131	53
71	Молекул генетикч	2131	54
72	Молекул биологич	2131	55
73	Жижиг амьтны эмч, эм зүйч, шинжээч	2131	56
74	Чанарын хяналтын лабораторийн шинжээч	2131	57
	2132 Фермч, ойн болон загасны аж ахуйн зөвлөгч		
75	Ойн инженер	2132	18
76	Ойн инженер, механикч	2132	20
77	Ойжуулагч	2132	23

	2141 Аж үйлдвэрийн инженер		
78	Инженер, аж үйлдвэрийн	2141	11
79	Инженер, байгууламжийн	2141	12
80	Инженер, цаг уурын багажийн	2141	15
81	Инженер, техник засварын	2141	17
82	Инженер, оёмол, сүлжмэл, ээрмэл, нэхмэл эдлэлийн тоног төхөөрөмжийн	2141	20
83	Инженер, нэхий, арьс, үслэг эдлэлийн тоног төхөөрөмжийн	2141	21
84	Инженер, хөдөлмөрийн аюулгүй байдлын	2141	25
85	Инженер, цахилгаан автоматикийн	2141	26
86	Инженер, дизель хөдөлгүүрийн	2141	30
87	Инженер, дотоод шаталтат хөдөлгүүрийн	2141	31
88	Инженер, орчны агаарыг хэмжих тоног төхөөрөмжийн	2141	32
89	Инженер, хэмжил зүй, эталоны, шалгалт, тохируулгын	2141	35
90	Технологич, керамикийн	2141	36
91	Технологич, модны	2141	37
92	Технологич, нэхмэлийн	2141	38
93	Технологич, сав, баглаа боодлын	2141	39
94	Технологич, савхин эдлэлийн	2141	40
95	Технологич, хэвлэлийн	2141	41
96	Технологич, цементийн	2141	42
97	Технологич, шилний	2141	43
98	Технологич, оёдлын	2141	44
99	Инженер, засварын	2141	48
100	Инженер, үйлдвэрлэлийн	2141	49
	2142 Иргэний барилга байгууламжийн инженер		
101	Инженер, барилга байгууламжийн бүтээцийн технологийн	2142	11
102	Инженер, геотехникийн	2142	12
103	Инженер, гидравликийн	2142	14
104	Инженер, гидрогеологийн	2142	15
105	Инженер, иргэний ба үйлдвэрийн барилгын	2142	16
106	Инженер, шугаман хоолойн	2142	21
107	Инженер, гүүр, тунелийн	2142	31
108	Инженер, ус хангамж, ариутгах татуургын	2142	32
109	Инженер, усны барилга байгууламжийн	2142	41
110	Инженер-зохион бүтээгч, барилгын	2142	45
111	Технологич, барилгын материалын	2142	46
112	Инженер, барилгын менежментийн	2142	47
113	Барилгын материал үйлдвэрлэлийн технологич инженер	2142	48
114	Инженер, халаалт, агаар сэлгэлт, агааржуулалтын	2142	52
115	Технологич, инженерийн /иргэний барилгын/	2142	54
116	Инженер, төмөр замын, барилга, замын аж ахуйн	2142	55
117	Инженер, төмөр замын, гүүр хоолой, хиймэл төхөөрөмжийн	2142	56
118	Инженер, төмөр замын, тээвэр зохион байгуулалтын	2142	57
119	Инженер, төмөр замын, дохиолол төвлөрүүлэлт хориглолын	2142	58
120	Инженер, вагоны аж ахуйн	2142	59

121	Инженер, барилга угсралтын мэдээлэл холбоо, дохиоллын	2142	60
122	Инженер, барилгын материалын иж бүрэн автомат удирдлагатай технологийн шугамын	2142	61
	2143 Байгаль орчны инженер		
123	Хаягдал боловсруулах технологийн инженер	2143	17
	2144 Механикч инженер		
124	Инженер, автомашины	2144	15
125	Инженер, орчны агаарыг хэмжих тоног төхөөрөмжийн	2144	20
126	Механикч, инженер, автомашины	2144	30
127	Инженер, хөргөлт, агааржуулалтын	2144	31
128	Механикч, инженер, аэровнатикийн	2144	32
129	Механикч, инженер, дизель хөдөлгүүрийн	2144	33
130	Механикч, инженер, машин механизмын	2144	35
131	Механикч инженер, агаарын хөлгийн	2144	36
132	Механикч инженер, орчны агаар хэмжих тоног төхөөрөмжийн	2144	37
133	Механикч инженер, хөдөлгүүрийн /бусад/	2144	42
134	Механикч инженер, хөдөө аж ахуй	2144	43
	2145 Химийн инженер		
135	Технологич, резиний	2145	16
136	Технологич, будгийн	2145	17
137	Технологич, дугуйн бүрээсийн	2145	18
138	Технологич, нийлэг утасны	2145	20
139	Технологич, полимерийн урвалын	2145	21
140	Технологич, хуванцар эдлэлийн	2145	23
141	Технологич, хүнс, ундааны	2145	24
142	Технологич, цаасны	2145	25
	2149 Энэ ангилалд ороогүй инженер мэргэжилтэн		
143	Биоанагаахын инженер	2149	11
144	Нуур, мөрний хог хаягдлын инженер	2149	13
145	Барилгын материалын мэргэжилтэн	2149	14
146	Оптик инженер	2149	15
147	Хугацаа, хөдөлгөөн судлагч инженер	2149	16
	2152 Цахим зүйн инженер		
148	Инженер, радио холбооны /релейн/	2152	11
149	Инженер, радио холбооны /хөдөлгөөнт/	2152	12
150	Инженер, радио холбооны /сансрын/	2152	13
151	Инженер, технологич, цахим зүйн	2152	15
152	Инженер, дохиоллын системийн	2152	16
153	Инженер, радарын	2152	17
154	Инженер, радиогийн	2152	18
155	Инженер, телевизийн	2152	19
156	Инженер, телеграфын	2152	20
157	Инженер, телефоны	2152	21
158	Инженер, цахилгаан холбооны	2152	22
159	Инженер, цахим зүйн /багаж хэрэгслэлийн/	2152	23
160	Инженер, цахим зүйн /мэдээллийн/	2152	24
161	Инженер, цахим зүйн /кабель шугамын/	2152	25

162	Инженер, цахим зүйн /олон сувгийн/	2152	26
163	Инженер, цахим зүйн /өгөгдлийн/	2152	27
164	Инженер, цахим зүйн /техник хангамжийн/ (компьютерын)	2152	28
165	Инженер, цахим зүйн /хагас дамжуулагчийн/	2152	29
166	Инженер, цахим зүйн /цахилгаан холбооны/	2152	30
167	Инженер, электроник	2152	31
168	Инженер, барилгын материал үйлдвэрлэлийн автоматжуулалтын	2152	32
	2153 Телехолбооны инженер		
169	Телехолбооны инженер	2153	11
170	Инженер, өргөн нэвтрүүлгийн, телехолбооны	2153	12
171	Инженер, өргөн нэвтрүүлгийн, телехолбооны технологич	2153	13
	22 Эрүүл мэндийн мэргэжилтэн		
	2212 Мэргэшсэн их эмч		
172	Хүний их эмч, компьютер томограф/соронзон давтамжит дүрс оношилгоо судлалын	2212	35
173	Хүний их эмч, рентгений	2212	36
174	Хүний их эмч, зоонозын өвчин судлалын	2212	40
175	Хүний их эмч, мэдээгүйжүүлэг судлалын	2212	45
176	Хүний их эмч, хүүхдийн мэдээгүйжүүлэг судлалын	2212	46
177	Хүний их эмч, мэс засал судлалын	2212	47
178	Хүний их эмч, бөөрний мэс засал судлалын	2212	48
179	Хүний их эмч, бүдүүн, шулуун гэдэсний мэс засал судлалын	2212	49
180	Хүний их эмч, дотоод шүүрлийн мэс засал судлалын	2212	51
181	Хүний их эмч, зүрх судасны мэс засал судлалын	2212	52
182	Хүний их эмч, мэдрэлийн мэс засал судлалын	2212	53
183	Хүний их эмч, хэвлийн мэс засал судлалын	2212	56
184	Хүний их эмч, цээжний мэс засал судлалын	2212	57
185	Хүний их эмч, сүрьеэ судлалын	2212	61
186	Хүний их эмч, туяа эмчилгээ судлалын	2212	74
187	Хүний их эмч, халдварт өвчин судлалын	2212	76
188	Хүний их эмч, бэлгийн замаар дамжих халдвар, хүний дархлал хомсдолын вирус/дархлалын олдмол хомсдол судлалын	2212	77
189	Хүний их эмч, хүүхдийн халдварт өвчин судлалын	2212	79
190	Хүний их эмч, гамшгийн үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ/яаралтай тусламжийн	2212	109
	2221 Сувилахуйн мэргэжилтэн		
191	Сувилагч, мэдээгүйжүүлгийн сувилахуйн	2221	07
192	Сувилагч, мэс заслын сувилахуйн	2221	08
193	Сувилагч, халдварт өвчний сувилахуйн	2221	15
194	Сувилагч, эрчимт эмчилгээний сувилахуйн	2221	20
	2240 Яаралтай тусламжийн эмч		
195	Мэс заслын техникч	2240	14
	2250 Малын эмч		
196	Малын эмч	2250	11
197	Мал, амьтны гаралтай өвчний тархалт судлалын	2250	13
198	Малын эмч, мэс заслын	2250	15
199	Үрийн бактерилогич	2250	17

200	Малын үржүүлгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч	2250	20
201	Малын эмч, ерөнхий мэргэжлийн	2250	21
202	Малын эмч, мал зүйч	2250	22
203	Малын эмч, гоц халдварт өвчний	2250	23
204	Малын эмч, биохимийн	2250	24
	2262 Эм зүйн мэргэжилтэн		
205	Эм зүйч	2262	01
206	Эм зүйч, уламжлалт анагаах ухааны эм зүйн	2262	02
207	Эм зүйч, эмийн технологи судлалын /эмийн үйлдвэр/ цацраг идэвхт амийн бодисын үйлдвэрлэлийн	2262	03
208	Эм зүйч, эмийн шинжилгээ судлалын /эмийн химич/	2262	04
209	Эм зүйч, эмнэл зүйн эм зүйн	2262	05
210	Эм зүйч, цацраг идэвхт эмийн бодисын чанарын хяналт, чанарын баталгааны	2262	06
211	Эм зүйч, эм зүйн албаны зохион байгуулалтын	2262	07
212	Эм зүйч, аль ч ангилалд багтаагүй	2262	08
	26 Хууль, нийгэм, соёлын мэргэжилтэн		
	2619 Аль нэг ангилалд ороогүй эрх зүйн бусад мэргэжилтэн		
213	Шинжээч	2619	12
	2621 Архивч, музейн харгалзагч		
214	Архивч	2621	12
215	Мэргэжилтэн, архивын түүхийн баримтын	2621	20
	31 Шинжлэх ухаан, инженерийн туслах /дэд мэргэжилтэн		
	3111 Химийн болон физикийн ухааны техникч		
216	Техникч, физикийн	3111	13
217	Техникч, агро цаг уурын	3111	14
218	Техникч, геологийн	3111	16
219	Техникч, геофизикийн	3111	17
220	Техникч, гедрогеологийн	3111	18
221	Техникч, гедрогеохимийн	3111	19
222	Техникч, радарын	3111	22
223	Техникч, радиолокаторын	3111	23
224	Техникч, хөдөө аж ахуйн цаг уурын	3111	27
225	Техникч, цаг уур судлалын	3111	28
226	Техникч, цаг уурын	3111	29
	3112 Иргэний барилгын инженерийн техникч		
227	Техникч, иргэний ба үйлдвэрийн барилга байгууламжийн	3112	11
228	Техникч, ус хангамж, ариутгах татуургын	3112	13
229	Техникч, хөрс, суурь судалгааны	3112	15
230	Техникч, барилга угсралтын	3112	16
231	Техникч, барилгын машин механизмын	3112	17
232	Техникч, барилгын механикч	3112	18
233	Техникч, байгууламжийн чанар, стандарт, хяналтын	3112	23
234	Техникч, байгууламжийн усан хангамжийн	3112	24
235	Техникч, барилга байгууламжийн хийцийн	3112	25
236	Техникч, галд тэсвэртэй материалын	3112	27
237	Техникч, цахилгаан шатны тоноглолын	3112	33

238	Техникч, төмөр замын, барилга, замын аж ахуйн	3112	37
239	Техникч, гүүр, тунелийн	3112	38
	3114 Цахим инженерийн техникч		
240	Лаборант, радио хэмжилтийн	3114	11
241	Техникч, сансрын холбооны	3114	12
242	Техникч, телехолбооны	3114	13
243	Техникч, цахим холбооны	3114	14
244	Техникч, дохиоллын системийн	3114	15
245	Техникч, олон сувгийн холбооны	3114	16
246	Техникч, өгөгдлийн холбооны	3114	17
247	Техникч, телевизийн	3114	18
248	Техникч, радионы	3114	19
249	Техникч, радарын	3114	20
250	Техникч, радиолокаторын	3114	21
251	Техникч, телефоны	3114	22
252	Техникч, телеграфын	3114	23
253	Техникч, механикч, цахим инженерийн	3114	24
254	Техникч, цахим багаж тоног төхөөрөмжийн	3114	25
255	Техникч, мэдээллийн техник хэрэгслэлийн	3114	27
256	Техникч, хагас дамжуулагчийн	3114	28
257	Техникч, хэмжүүрийн	3114	29
	3115 Механик инженерийн техникч		
258	Мастер, усан онгоцны зогсоолын	3115	11
259	Механик инженерийн техникч	3115	12
260	Механик инженерийн техникч, автомашины	3115	13
261	Механик инженерийн техникч, усан онгоцны	3115	15
262	Техникч, агаарын нөхцөлийг хэмжих тоног төхөөрөмжийн	3115	16
263	Техникч, багаж хэрэгслийн	3115	17
264	Техникч, далайн тээврийн	3115	18
265	Техникч, дизель хөдөлгүүрийн	3115	19
266	Техникч, дотоод шаталтат хөдөлгүүрийн	3115	20
267	Техникч, киноны	3115	22
268	Техникч, кинооператорын	3115	23
269	Техникч, локомотив хөдөлгүүрийн	3115	24
270	Техникч, аэронавтик	3115	25
271	Техникч, дулаан салхивч, агаар сэлгэлтийн төхөөрөмжийн	3115	31
272	Техникч, инженерийн тооцоологч	3115	32
273	Техникч, механик байгууламжийн	3115	34
274	Мастер, төмөр замын, барилга, замын аж ахуйн	3115	36
275	Мастер, галт тэрэгний засварын	3115	37
276	Техникч, төмөр замын, машин механизмын	3115	38
277	Техникч, төмөр замын, ашиглалтын	3115	39
278	Техникч, төмөр замын, зүтгүүрийн	3115	40
279	Техникч, төмөр замын, вагоны	3115	41
	3116 Химийн инженерийн техникч		
280	Химийн инженерийн техникч	3116	16
	3119 Энэ ангилалд ороогүй инженерийн ухааны бусад техникч		
281	Техникч, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн	3119	13

282	Техникч, үйлдвэрлэлийн	3119	14
283	Техникч, шүүх эмнэлгийн	3119	20
	3139 Энэ ангилалд ороогүй процесс хяналтын техникч		
284	Операторч, автомат машины хяналт	3139	11
285	Операторч, цаас жижиглэх төхөөрөмжийн	3139	12
	3141 Амьд байгалийн ухааны техникч (Анагаах ухаанаас бусад)		
286	Техникч, бактериологийн	3141	11
287	Техникч, биохимийн	3141	12
288	Техникч, серологийн	3141	13
289	Лаборант, микробиологийн	3141	14
290	Лаборант, хими биологийн	3141	15
291	Ойжуулагч	3141	27
	3142 Хөдөө аж ахуйн техникч		
292	Агротехникч	3142	13
293	Цаг уурын техникч	3142	14
294	Гидро техникч	3142	15
	3155 Агаарын хөдөлгөөний аюулгүйн цахим техникч		
295	Цахим-техникч, агаарын хөдөлгөөний аюулгүй байдлын	3155	11
296	Радионавигацийн инженер	3155	12
	32 Эрүүл мэндийн туслах /дэд мэргэжилтэн		
	3211 Эмчилгээ оношилгооны төхөөрөмжийн техникч		
297	Дүрс, оношилгоо, эмнэлгийн тоног төхөөрөмжийн техникч	3211	01
298	Дүрс, оношилгоо, эмнэлгийн тоног төхөөрөмжийн техникч, ангиографийн	3211	02
299	Дүрс, оношилгоо, эмнэлгийн тоног төхөөрөмжийн техникч, диалезын	3211	03
300	Дүрс, оношилгоо, эмнэлгийн тоног төхөөрөмжийн техникч, компьютер томограф/рентген туяаны	3211	04
301	Дүрс, оношилгоо, эмнэлгийн тоног төхөөрөмжийн техникч, сонсгол судлалын	3211	05
302	Дүрс, оношилгоо, эмнэлгийн тоног төхөөрөмжийн техникч, соронзон давтамжит дүрс оношилгооны	3211	06
303	Дүрс, оношилгоо, эмнэлгийн тоног төхөөрөмжийн техникч, туяа эмчилгээний	3211	07
304	Дүрс, оношилгоо, эмнэлгийн тоног төхөөрөмжийн техникч, цөмийн оношилгоо, эмчилгээний	3211	08
305	Дүрс, оношилгоо, эмнэлгийн тоног төхөөрөмжийн техникч, аль ч ангилалд багтаагүй	3211	09
	3212 Эмчилгээ, эмгэг судлалын лабораторийн техникч		
306	Лабораторийн техникч /лаборант/	3212	01
307	Лабораторийн техникч, бичил амь судлалын	3212	02
308	Лабораторийн техникч, дархлаа судлалын	3212	03
309	Лабораторийн техникч, клиник биохими судлалын	3212	04
310	Лабораторийн техникч, серологи судлалын	3212	05
311	Лабораторийн техникч, эд судлалын	3212	06
312	Лабораторийн техникч, эс судлалын	3212	07
313	Лабораторийн техникч, аль ч ангилалд багтаагүй	3212	08
	3240 Мал эмнэлгийн техникч, туслах/дэд мэргэжилтэн		
314	Малын сувилагч	3240	13

315	Мал, амьтныг вакцинжуулагч	3240	14
316	Техникч, биотехнологийн үйлдвэрлэлийн нарийн тоног төхөөрөмжийн	3240	15
	3259 Энэ ангилалд ороогүй эрүүл мэндийн туслах /дэд мэргэжилтэн		
317	Ариутгагч	3259	04
	35 Мэдээлэл, холбооны техникч		
	3521 Өргөн нэвтрүүлэг, дуу, дүрс бичлэгийн техникч		
318	Дуу бичлэг эвлүүлэгч	3521	22
319	Лаборант	3521	26
320	Операторч, дуу, дүрс бичлэгийн	3521	27
321	Техникч, дүрс бичлэгийн тоног төхөөрөмжийн /радиогийн/	3521	29
322	Техникч, дүрс бичлэгийн тоног төхөөрөмжийн /дууны/	3521	30
323	Техникч, дүрс бичлэгийн тоног төхөөрөмжийн /дууны эвлүүлгийн/	3521	31
324	Техникч, дүрс бичлэгийн тоног төхөөрөмжийн /дуу хураагчийн/	3521	32
325	Техникч, дүрс бичлэгийн тоног төхөөрөмжийн /дүрс бичлэгийн/	3521	33
326	Техникч, дүрс бичлэгийн тоног төхөөрөмжийн /телевизийн/	3521	34
327	Техникч, дүрс бичлэгийн тоног төхөөрөмжийн /хуурцгийн/	3521	35
328	Техникч, дууны	3521	36
329	Техникч, дууны тоног төхөөрөмжийн /радиогийн/	3521	37
330	Техникч, дууны тоног төхөөрөмжийн /телевизийн/	3521	38
331	Техникч, дүрсний	3521	39
332	Техникч, микрофоны	3521	40
333	Техникч, орчуулгын тоног төхөөрөмжийн	3521	41
334	Техникч, студийн тоног төхөөрөмжийн /радиогийн/	3521	42
335	Техникч, студийн тоног төхөөрөмжийн /телевизийн/	3521	43
336	Техникч, телевизийн киноны	3521	44
337	Техникч, хослол зургийн /фото зургийн/	3521	45
338	Радиомеханикч, радио телевизийн аппаратын засвар үйлчилгээний	3521	46
339	Техникч, дууны /радиогийн студийн/	3521	47
340	Техникч, дууны /телестудийн/	3521	48
341	Техникч, дууны хянагч	3521	49
342	Эвлүүлэгч	3521	50
	3522 Телехолбооны инженерийн техникч		
343	Техникч, нэвтрүүлгийн ба телехолбооны тоног төхөөрөмжийн	3522	11
344	Техникч, дамжуулах /радиогийн/	3522	12
345	Техникч, дамжуулах /телевизийн/	3522	13
346	Техникч, зарлал мэдээллийн	3522	14
347	Техникч, морз бичлэгийн	3522	15
348	Техникч, мэдээллийн /радиогийн/	3522	16
349	Техникч, мэдээллийн /телевизийн/	3522	17
350	Техникч, телеграфын	3522	18
351	Техникч, теле холбооны	3522	19
352	Дроекц буулгагч, киноны	3522	20
353	Телеграфч	3522	21

	42 Хэрэглэгчдэд үйлчлэх ажилтан		
	4222 Холбоо барих төвийн мэдээллийн ажилтан		
354	Залгагч, холбооны	4222	11
355	Операторч, телефон холбооны	4222	12
	4223 Телефон холбоочин		
356	Телефон холбоочин	4223	11
	43 Тооцоолол, материал бүртгэлийн ажилтан		
	4322 Үйлдвэрлэлийн ажилтан		
357	Нярав, материал нийлүүлэлтийн	4322	12
	4323 Тээврийн ажилтан /диспетчер/		
358	Ажилтан, нислэгийн үйл ажиллагааны	4323	18
359	Үйлчлэгч, галт тэрэгний	4323	26
	44 Конторын бусад туслах ажилтан		
	4415 Файлдагч, олшруулагч ажилтан		
360	Архивын ажилтан	4415	12
	51 Хувийн үйлчилгээний ажилтан		
	5112 Нийтийн тээврийн кондуктор		
361	Кондуктор, автобусны	5112	11
362	Тасалбар шалгагч, нийтийн тээврийн	5112	13
363	Кондуктор, галт тэрэгний	5112	14
364	Кондуктор, трамвайны	5112	15
365	Кондуктор, троллейбусны	5112	16
	5163 Оршуулга зохион байгуулагч, занданшуулагч /шарил чандарлагч		
366	Шарил занданшуулагч/чандарлагч	5163	11
	54 Хамгаалах үйлчилгээний ажилтан		
	5414 Хамгаалалтын албаны ажилтан		
367	Төмөр замын ачаа хамгаалагч	5414	13
368	Харуул, төмөр замын	5414	14
	61 Зах зээлд чиглэсэн хөдөө аж ахуйн мэргэшсэн ажилтан		
	6112 Мод, бут тарьж ургуулагч		
369	Мод огтлогч, засагч	6112	11
	62 Зах зээлд чиглэсэн ой, загасны аж ахуй, ан агнуур эрхлэгч		
	6210 Ойн аж ахуй, холбогдох бусад ажилтан		
370	Модны нүүрс шатаагч	6210	11
371	Мод урсагч	6210	12
372	Мод унагаагч	6210	13
373	Гуалин бэлтгэгч	6210	14
374	Мод захлагч	6210	15
375	Мод огтлогч	6210	16
376	Мод холтослогч	6210	17
377	Мод хөрөөдөгч	6210	18
378	Мод цавчигч	6210	20
379	Ойжуулагч	6210	21
380	Сал урсагч	6210	23
	6224 Анчин, урхичин		
381	Анчин	6224	11

	71 Барилга, түүнтэй холбогдох ажил, мэргэжлийн ажилтан (цахилгаанчаас бусад)		
	7111 Барилгачин		
382	Барилгачин	7111	11
	7112 Өрлөгчин, холбогдох бусад ажилтан		
383	Угсрагч, ган болон угсармал төмөр бетон бүтээцийн	7112	11
384	Өрөгч, тоосгон гүүрийн	7112	12
385	Өрөгч, төрөл бүрийн гулдмайгаар	7112	13
386	Өрөгч, үйлдвэрийн ба гидротехникийн байгууламжийн	7112	14
387	Өрөгч, чулуун зам	7112	15
388	Өрөгч, яндан, пийшингийн	7112	16
389	Өрөгч, жигнэх зуухны	7112	17
390	Өрөгч, шатаах зуухны	7112	18
391	Өрөгч, угсрагч, барилгын	7112	19
392	Барилгын хэв хашмал угсрагч	7112	23
	7113 Чулуучин, чулуу зүсэгч, бутлагч, сийлбэрчин		
393	Чулуучин	7113	10
394	Чулуун сийлбэрчин	7113	11
395	Өнгөлөгч, боржин	7113	20
396	Өнгөлөгч, гантиг	7113	21
397	Өнгөлөгч, занар	7113	22
398	Сийлбэрчин, хөшөөний	7113	23
399	Сийлбэрчин, чулууны	7113	24
400	Үрлэн сум цацах аппаратын ажилчин, чулуу зүсэх	7113	26
401	Чулуучин, хөшөөний	7113	28
	7114 Бетончин, бетон гадаргуу өнгөлөгч, түүнтэй холбогдох мэргэжлийн ажилтан		
402	Арматурчин	7114	11
403	Угсрагч, ган бетон бүтээц, үйлдвэрийн төмөр бетон яндан	7114	14
404	Бетон бүтээцийг цутгагч	7114	15
405	Хэв задлагч	7114	16
406	Шал өнгөлөгч	7114	17
407	Бетон хийцийн засалч	7114	18
408	Бетончин	7114	19
	7115 Барилга угсралтын мужаан		
409	Барилга угсралтын мужаан	7115	11
410	Заслын мужаан	7115	12
411	Мужаан, бэхлэлтийн	7115	13
412	Мужаан, гүүрний	7115	14
413	Мужаан, засварын	7115	15
414	Мужаан, нисэх онгоц, галт тэрэгний модон төхөөрөмжийн	7115	16
415	Мужаан, тайзны	7115	17
416	Мужаан, театрын	7115	18
417	Мужаан, хөлөг онгоцны	7115	20
418	Угсрагч, цехийн	7115	21
	7119 Энэ ангилалд ороогүй барилгын араг бүтээц /яс мод/ угсрагч түүнтэй адилтгах бусад ажилтан		
419	Барилгачин, уламжлалт бус материалын	7119	11
420	Буудагч, барилгын бэхлэгч, засварчин	7119	12

421	Тоноглогч, шатны	7119	13
422	Өндөрт угсрагч	7119	14
423	Шат, вандан засагч	7119	15
424	Бэхэлгээчин, угсармал байшин, барилгын	7119	16
425	Засварчин, яндангийн	7119	17
426	Тоноглогч, шатны	7119	18
427	Угсрагч, ариутгах хоолойн	7119	19
428	Угсрагч, зарлалын самбар	7119	20
429	Барилгын гадна дотор хуурай хийц угсрагч	7119	21
430	Угсрагч, барилгын шатны	7119	22
431	Барилгын буулгалт /нураалт/-ын ажилтан	7119	23
	7121 Дээвэрчин		
432	Дээвэрчин, асфальт	7121	11
433	Дээвэрчин, занар /шифер/	7121	12
434	Дээвэрчин, керамик эдлэлээр	7121	13
435	Дээвэрчин, модоор	7121	14
436	Дээвэрчин нийлэг эдээр	7121	15
437	Дээвэрчин, сүрлээр	7121	16
438	Дээвэрчин, төмрөөр	7121	17
439	Дээвэрчин, ширхгийн ба хуйлмал материалаар	7121	18
440	Дээвэрчин, хавтан/плита	7121	19
441	Дээвэр засагч	7121	20
	7122 Шалчин, өнгөлгөөчин		
442	Наагч, шаазан хавтан	7122	11
443	Өнгөлгөөчин, гантигаар, байгалийн болон хиймэл чулуугаар	7122	12
444	Мозаик шал хийгч	7122	13
445	Өнгөлөгч, нийлэг эдээр	7122	14
446	Шал тавигч, зүймэл	7122	15
447	Шал тавигч, модон	7122	16
448	Паркетчин	7122	17
449	Гантиг суулгагч	7122	18
450	Байгалийн болон хиймэл чулуун хавтан суулгагч	7122	19
451	Хивсэн материалаар шаллагч	7122	20
452	Хулдаас, чулуу, плитагаар шаллагч	7122	21
	7123 Шаварчин, засалчин		
453	Засалчин, шаварчин	7123	11
454	Шавардлага өнгөлгөөний ажилтан	7123	12
455	Шаварчин-засалчин, засал чимэглэлийн	7123	14
456	Гадна гадаргууны шавардагч	7123	15
457	Шаварчин, хээ тавигч	7123	16
458	Шаварчин, гадна	7123	17
459	Шаварчин, шөрмөсөн	7123	18
460	Шаварчин, чанаржуулсан	7123	19
461	Тааз суурилуулагч, угсрагч	7123	20
	7124 Тусгаарлагч		
462	Ажилтан, тусгаарлах материал тавигч	7124	11
463	Доторлогч, хүчил төрөгч	7124	12
464	Барилгын ус чийг тусгаарлагч	7124	13

465	Тусгаарлагч ажилчин, бойлер ба хоолойн	7124	14
466	Тусгаарлагч, хальсан /зэврэлтээс хамгаалах/	7124	15
467	Тусгаарлагч хөргөлтийн ба агааржуулалтын тоног төхөөрөмжийн	7124	16
468	Тусгаарлагч ажилчин, чимээ намжаах материал тавигч	7124	17
469	Бойлер, шугам хоолой тусгаарлагч	7124	18
470	Хөргөх болон агааржуулах тоног төхөөрөмж тусгаарлагч	7124	19
471	Угсарч тусгаарлагч	7124	20
	7125 Шилчин /Шиллэгч		
472	Угсрагч, толь	7125	11
473	Шил зүймэлч	7125	12
474	Шил матагч, рекламын	7125	13
475	Шиллэгч, барилгын	7125	14
476	Шиллэгч, давхар шиллэлтийн	7125	15
477	Шиллэгч, дээвэрлэлтийн	7125	16
478	Шиллэгч, өнгөт шилний	7125	17
479	Шиллэгч, толь угсрагч	7125	18
480	Шиллэгч, цайрдсан шилний	7125	19
481	Шиллэгч, тусгай шилний	7125	20
482	Шиллэгч, тээврийн хэрэгслийн	7125	21
483	Шилэн хавтан наагч	7125	22
	7126 Сантехникч, хоолой урсгагч		
484	Сантехникч, барилгын	7126	14
485	Сантехникч, салхивчны хоолойн	7126	15
486	Сантехникч, сантехникийн системийн эд анги, зангилааг бэлтгэх	7126	19
487	Сантехникч, технологийн дамжуулах хоолойн эд анги, зангилааг бэлтгэх	7126	20
488	Сантехникч, яндангийн /хөлөг онгоцны/	7126	23
489	Угсрагч, гадна сантехникийн дамжуулах шугам ба хийн хоолойн	7126	24
490	Угсрагч, дотор сантехникийн систем, угсралтын /халаалт, цэвэр ус, ариутгах татуурга/	7126	26
491	Угсрагч, сантехникийн систем, тоног төхөөрөмжийн /хоолойн/	7126	28
492	Угсрагч, сантехникийн систем, тоног төхөөрөмжийн /усан хангамжийн төвлөрсөн хоолойн/	7126	29
493	Угсрагч, системийн /агаар зохицуулалтын/	7126	31
494	Угсрагч, системийн /салхивчийн/	7126	32
495	Угсрагч, системийн	7126	33
496	Угсрагч, системийн /технологийн дамжуулах хоолойн/	7126	34
	7131 Будагчин, түүнтэй адилтгах бусад ажилтан		
497	Барилгын будагчин	7131	11
498	Цааслагч	7131	12
499	Будагчин, засалч хана, тааз, шалны	7131	13
500	Будагчин-засалч, ханын цаасны	7131	14
501	Шүршиж будагчид, лакдагчид	7131	15
502	Будагчин, металлын	7131	16
503	Будагчин, хөлөг онгоцны	7131	18
504	Будагчин, галт тэрэгний	7131	19

	7132 Будаг шүршигч, лакдагч		
505	Будагчин, шүршигч /барилгын	7132	11
506	Лак будаг арилгагч	7132	12
507	Наагч, ханын цаас	7132	13
508	Шохойдогч	7132	14
509	Эмульс, цавуу бэлтгэгч	7132	15
510	Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн будагч	7132	16
511	Тээврийн хэрэгсэл будагч	7132	17
512	Лакдагч	7132	18
	7133 Барилгын бүтээцийн цэвэрлэгч		
513	Устгагч, хортон шавьж	7133	14
	72 Металл, машин механизм, тэдгээрт холбогдох ажил, мэргэжлийн ажилтан		
	7211 Хэв, голлуур бэлтгэгч		
514	Автоклавч	7211	11
515	Бэлтгэгч, хэвний хольц	7211	16
516	Гар хэвчин	7211	17
517	Гараар тэгшлэгч, металл	7211	18
518	Голч баригч	7211	20
519	Голч баригч, гар хэвийн	7211	21
520	Голч баригч, машин хэвийн	7211	22
521	Голч хэвийг хатаагч	7211	23
522	Металлын хаягдал задлагч	7211	24
523	Үйц ачаалагч	7211	28
524	Шанагчин	7211	37
525	Шуудуучин	7211	38
526	Элс тургигч	7211	39
527	Ялган цуглуулагч, металл хаягдал	7211	40
	7212 Гагнуурчин		
528	Ажилтан, металл халааж хайлуулах зуухны /индукцийн/	7212	12
529	Ажилтан, металл халааж хайлуулах зуухны /хийн/	7212	13
	7213 Нимгэн төмөрчин		
530	Нимгэн төмөрчин	7213	10
531	Нимгэн төмөрчин, автомашин ба өөрөө явагч бусад хэрэгслийн	7213	11
532	Нимгэн төмөрчин, бойлерын зуухны	7213	12
533	Нимгэн төмөрчин, зэсийн	7213	13
534	Нимгэн төмөрчин, онгоцны	7213	14
535	Нимгэн төмөрчин, тоног төхөөрөмж бусад эд материалын	7213	15
536	Нимгэн төмөрчин, хээлэгч	7213	16
537	Нимгэн төмөрчин, цагаан тугалганы	7213	17
538	Төмөр давтагч, машины хянах самбарын	7213	18
539	Төмөр давтагч	7213	19
	7214 Металл хийц бэлтгэгч, угсрагч		
540	Бэлтгэгч, загвар	7214	11
541	Металл хийц бэлтгэгч, угсрагч	7214	12
542	Бэлтгэгч, металл эд анги	7214	13
543	Тавлагч	7214	17
544	Тавлагч, хөлөг онгоцны металл эд анги	7214	18

545	Угсрагч, ган хийцтэй эд анги	7214	19
546	Угсрагч, металл загвар	7214	20
547	Угсрагч, хөлөг онгоцны металл эд анги	7214	21
	7215 Хүнд, овортой эдлэхүүн зөөгч, оосорлогч		
548	Кабель холбогч	7215	12
549	Театрын тайз өргөгч	7215	14
550	Кабельчин	7215	15
551	Тоноглогч, хөлөг онгоцны	7215	23
552	Холбогч, кабель ба олсны	7215	24
553	Ээрч-ороогч, төмөр утасны	7215	25
554	Ээрч-ороогч, кабель утасны	7215	26
	7221 Дархан, гараар давтах болон шахуургын дархан		
555	Хүрэл цутгуурчин	7221	11
556	Дархан, гараар давтах	7221	12
557	Дархан, лантуу шахуургын	7221	14
558	Дархан, морь тахлагч	7221	15
559	Дархан, хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжийн	7221	17
	7223 Металлын машин механизм суурилуулагч /операторч		
560	Операторч, суурилуулагч	7223	12
561	Операторч, зорох суурь машины	7223	13
562	Операторч, зүлгэх суурь машины	7223	14
563	Операторч, зүсэгч суурь машины	7223	15
564	Операторч, металл боловсруулах машины	7223	17
565	Операторч, өнгөлөгч суурь машины	7223	19
566	Операторч, ферезерийн суурь машины /ферезерчин/	7223	22
567	Операторч, ховил гаргах суурь машины	7223	23
568	Операторч, хэв гаргагч суурь машины	7223	24
569	Операторч, хэлбэр гаргагч суурь машины	7223	25
570	Операторч, шахуургын суурь машины	7223	26
571	Операторч, хадаасны үйлдвэрлэлийн машины	7223	27
572	Суурилуулагч, металл тоног төхөөрөмжийн	7223	29
	7224 Металл зүлгэгч, өнгөлөгч, багаж ирлэгч		
573	Зүлгэгч, багаж төхөөрөмжийн	7234	11
574	Зүлгэгч, нэхмэлийн машины	7224	13
575	Ирлэгч, зүү	7224	15
576	Ирлэгч, хөрөө	7224	19
577	Ирлэгч, хутга	7224	20
578	Өнгөлөгч, металл	7224	21
579	Цэвэрлэгч, металл	7224	23
581	**7231 Моторт тээврийн хэрэгслийн механикч, тохируулагч**		
580	Засварчин, дугуйны	7231	11
581	Механикч, автобусны	7231	12
582	Механикч, автомашины	7231	13
583	Механикч, ачааны машины	7231	14
584	Механикч, гараажийн	7231	15
585	Механикч, дизель хөдөлгүүрийн	7231	16
586	Механикч, мотоциклын	7231	17

587	Хүнд машин механизмын механикч	7231	18
588	Автомашины хөдөлгүүрийн засварчин, моторчин	7231	19
589	Механикч, усан замын тээврийн хэрэгслийн	7231	20
	7233 Хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн машин механизмын механикч, тохируулагч		
590	Механикч, барилгын машин, тоног төхөөрөмжийн	7233	11
591	Механикч, конторын машин, тоног төхөөрөмжийн	7233	13
592	Механикч, модон эдлэлийн машин, тоног төхөөрөмжийн	7233	14
593	Механикч, агааржуулалт, агаар сэлгэлтийн тоног төхөөрөмжийн	7233	19
594	Механикч, хөдөлгүүрийн /дизель/	7233	20
595	Механикч, хөдөлгүүрийн /хөлөг онгоцны/	7233	22
596	Механикч, хөдөө аж ахуйн машин тоног төхөөрөмжийн	7233	23
597	Механикч, хэвлэх машин, тоног төхөөрөмжийн	7233	24
598	Механикч, газар, шорооны ажлын машин, тоног төхөөрөмжийн	7233	25
599	Тохируулагч, конторын тоног төхөөрөмжийн	7233	27
600	Тохируулагч, мод боловсруулах тоног төхөөрөмжийн	7233	30
601	Тохируулагч, нэхмэлийн машин, тоног төхөөрөмжийн	7233	31
602	Тохируулагч, хэвлэлийн машин, тоног төхөөрөмжийн	7233	34
603	Тохируулагч, хөдөө аж ахуйн машин, тоног төхөөрөмжийн	7233	35
604	Угсрагч, агааржуулах болон хөргүүрийн тоног төхөөрөмжийн	7233	36
605	Угсрагч-суурилуулагч, хөдөө аж ахуйн машин, тоног төхөөрөмжийн	7233	38
606	Засварчин, зүтгүүрийн	7233	39
	73 Гар урлал ба хэвлэлийн ажилтан		
	7313 Эрдэнийн чулуу, үнэт металлын ажилтан		
607	Алт давтагч	7313	11
608	Алтны дархан	7313	12
609	Гинж, хэлхэгч, үнэт металлын	7313	13
610	Дархан, мөнгөний	7313	14
611	Дархан, үнэт эдлэлийн	7313	15
612	Дархан, эрдэнийн зүүлт чимэглэлийн	7313	17
613	Гоёл, чимэглэлийн зүйл пааландагч	7313	18
614	Загварчин, эрдэнийн зүйлийн	7313	20
615	Зүсэгч-өнгөлөгч, үйлдвэрийн алмаас	7313	22
616	Зүсэгч-өнгөлөгч, үнэт чулууны	7313	23
617	Өнгөлөгч, үйлдвэрийн алмаасны	7313	25
618	Өнгөлөгч, эрдэнийн чулууны	7313	26
619	Сийлбэрчин	7313	28
620	Сийлбэрчин, эрдэнийн зүйлийн	7313	29
621	Хийгч, үнэт металлын цуулт	7313	35
622	Хийгч, эрдэнийн зүүлт чимэглэл	7313	36
623	Цутгуурчин	7313	38
	7314 Ваар, шавар эдлэлийн ажилтан		
624	Будагч, шавар эдлэлийн	7314	11
625	Ваар хийгч	7314	12
626	Загварчин, шавар, шаазан эдлэлийн	7314	13
627	Засагч, шавар эдлэл	7314	14

628	Өнгөлөгч, ваар, шаазан эдлэл	7314	17
629	Өнгөлөгч, шаазан, шавар эдлэлийн	7314	18
630	Пааландагч	7314	19
631	Хэв цутгагч, гипсэн	7314	20
632	Хэвлэгч, шавар, шаазан эдлэл	7314	21
633	Цутгагч, хавтан	7314	23
634	Цутгагч, шаазан шавар эдлэл	7314	24
635	Шаазан эдлэл хийгч	7314	25
636	Шавар эдлэл хийгч	7314	26
637	Шатаагч, шаазан шавар эдлэл	7314	27
	7315 Шилэн эдлэл хийгч, зүсэгч, өнгөлөгч		
638	Өрөмдөгч, шил	7315	16
639	Үлээгч, нарийн хийцтэй шилний	7315	20
640	Үлээгч, шилний	7315	21
641	Хэвчин, шилний	7315	22
	7316 Хаяг, зарлал, гоёл чимэглэлийн зураач, будагч, сийлбэрч, зураг хээ гаргагч		
642	Шилэн эдлэлийн сийлбэрч	7316	11
643	Шилэн эдлэлийн зураг, хээ гаргагч	7316	12
644	Шилэн эдлэл өнгөлөгч, пааландагч	7316	13
645	Чимэглэлийн зураач	7316	14
646	Пааландагч	7316	20
647	Пааландагч, керамик эдлэлийн	7316	21
648	Пааландагч, металл эдлэлийн	7316	22
649	Пааландагч, шилэн эдлэлийн	7316	23
650	Үг бичигч, шил сийлбэрийн	7316	25
651	Шил хээлэгч	7316	26
	7318 Нэхмэл, даавуу, арьс, бусад материалаар гар урлалын зүйлс хийгч		
652	Хивс нэхэгч	7318	15
	7321 Хэвлэхийн өмнөх ажиллагааны техникч		
653	Өндөр хэвлэлийн бэлтгэгч	7321	22
	74 Цахилгаан, цахим техникч		
